



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ХУУЛЬ ДЭЭДЛЭХ ЁС

2018 он, Цуврал 2 (67)

Улаанбаатар хот
2018 он

Хууль зүйн үндэсний хүрээлэн
www.nli.gov.mn

Сэтгүүлд нийтлэсэн бүтээл нь Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн албан ёсны байр суурийг илэрхийлэхгүй болно.

© Сэтгүүлд нийтлэгдсэн бүтээлийн зохиогчийн эрх Сэтгүүлийн редакц болон зохиогчид хадгалагдана.

Хэвлэсэн газар: Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хэвлэх үйлдвэр

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Ж.Амарсанаа	<i>Академич, гавъяат хуульч</i>
Ц.Сарантуяа	<i>Хууль зүйн шинжлэх ухааны доктор, гавъяат хуульч</i>
Б.Баярсайхан	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Гангабаатар	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Зүмбэрэлхам	<i>Хууль зүйн доктор</i>
Ж.Оюунтунгалаг	<i>Хууль зүйн доктор</i>
Д.Сүнжид	<i>Хууль зүйн доктор</i>
П.Амаржаргал	<i>Хууль зүйн доктор</i>
З.Сүхбаатар	<i>Бизнесийн удирдлагын доктор</i>
Ц.Цогт	<i>Хууль зүйн доктор</i>

Эрхлэгч

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал

С.Энхцэцэг

Нарийн бичгийн дарга

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

М.Очирбат

Хэвлэлийн эхийг

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эх бэлтгэгч, дизайнер

Д.Мөнхжаргал

Улсын бүртгэлийн дугаар: 279
ISSN:2226-9185
Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс
эрхлэн гаргав. Жилд 5 дугаар гарна.

Хаяг: Улаанбаатар-46, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Бага тойруу /15160/,
Хуульчдын гудамж 1,
Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн байр
Утас: +(976)-11-315735
Факс: 315735
Вэб хуудас: www.nli.gov.mn
Цахим хаяг: lawjournal@legalinstitute.mn

EDITORIAL BOARD

J.Amarsanaa	<i>Academician, Merited Lawyer of Mongolia</i>
Ts.Sarantuya	<i>(Sc.D), Merited Lawyer of Mongolia</i>
B.Bayarsaikhan	<i>(Ph.D)</i>
D.Gangabaatar	<i>(LL.D)</i>
D.Zumberellkham	<i>(Ph.D)</i>
J.Oyuntungalag	<i>(LL.D)</i>
D.Sunjid	<i>(Dr.jur)</i>
P.Amarjargal	<i>(Ph.D)</i>
Z.Sukhbaatar	<i>(Ph.D)</i>
Ts.Tsogt	<i>(LL.D)</i>

Executive Editor-in-Chief

Director, The National Legal Institute

S.Enkhtsetseg

Acting Assistant Editor

Researcher, The National Legal Institute

M.Ochirbat

Designed by

Designer, The National Legal Institute

D.Munkhjargal

State Registration Number:279
ISSN: 2226-9185
The National Legal Institute
publishes this law review five times
per year.

Address: 4th Khoroo, Chingeltei District,
Lawyer's Street-1, Ulaanbaatar-15160, Mongolia
Phone: +(976)-11-315735
Fax: 315735
Website: www.nli.gov.mn
E-mail: lawjournal@legalinstitute.mn

АГУУЛГА

ХУУЛЬ ТӨРӨХИЙН ӨМНӨ /ОНЦЛОХ ӨГҮҮЛЭЛ, ЯРИЛЦЛАГА/

Үндсэн хуулийн нэр томьёо: Хэрэглээ, шийдэл 9

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн доктор П. Амаржаргал

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн эрдэм
шинжилгээний ажилтан Ц. Оюунчимэг

Богд хаант Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг эрэн сурвалжлах нь 15

Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч,
хуульч Г.Мөнхтулга

ЭРХ ЗҮЙН СЭТГЭЛГЭЭ: ҮЗЭЛ БОДОЛ, ЭРГЭЦҮҮЛЭЛ

Орчин үеийн криминалистикийн нөхцөл байдлын шинжилгээний чиг хандлага, тулгамдаж буй асуудал 23

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш Б.Баяр

Бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн хүрээнд байгуулах асуудал 30

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш Э. Туулайхүү

Ёс зүй ба хуулийн харилцан хамаарал 35

ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын
эрдэм шинжилгээний ажилтан М.Долгорсүрэн

ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

“Public Trust Doctrine” байгалийн баялгийн өмчлөл, ашиглалтын эрх зүйн зохицуулалтын онолын гол баримтлал болох нь 44

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн ахлах багш Д.Батболд

Захиргааны байгууллагын губернатив ба административ үйл ажиллагаа 48

МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,
хууль зүйн ухааны магистр Т. Мөнх-эрдэнэ

ЭРХ ЗҮЙН СУДАЛГАА, ТОЙМ, ҮР ДҮН

Нийгмийн хамгаалал ба эрүүл мэндийн хууль тогтоомжийн харьцуулсан судалгаа	58
<i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш О.Чулуунцэцэг</i>	
Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн шинэтгэл	65
<i>Судлаач Б.Өлзийбаяр</i>	
Үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт, шинжилгээ	89
<i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн докторант С.Номынбаясгалан</i>	
<i>МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Х.Мөнхчимэг</i>	

CONTENT

BEFORE CREATING A LAW /UNDERLINE ARTICLE AND INTERVIEW/

The Constitutional Law Terms: Acceptance and Resolution	9
<i>Amarjargal. P, Ph.D, Scientific Secretary, National Legal Institute</i>	
<i>Oyunchimeg.Ts, LL.M, Researcher, National Legal Institute</i>	

Quest for The Draft of The Constitution of Mongolia During The Bogd Khan's Rule	15
<i>Munkhtulga.D, Judge, Administrative Court of the Capital City</i>	

LEGAL THINKING: VIEWS AND REFLECTIONS

Modern Tendencies on Situational Expertise of Criminalistics, The Challenging Issue	23
<i>Bayr.B, Lecturer of Public Law Department, School of Law, National University of Mongolia.</i>	

Legal Issues on Conclusion of Regional Trade Agreements under the GATT	30
<i>Tuulaikhuu.E, /LL.M/, Lecturer in International Law, School of Law, National University of Mongolia</i>	

Ethical and Legislative Relevance	35
<i>Dolgorsuren.M, /LL.M/ Mongolian Academy of Sciences Institute of Philosophy Department of legal and Political studies</i>	

IMPLEMENTATION AND EFFICIENCY OF LAW

Public trust doctrine is basic theoretical concept for natural resources law	44
<i>Batbold.D, /LL.M/, Senior lecturer of Public Law Department, School of Law, National University of Mongolia</i>	

Public Administration: The Administrative and Gubernative Administration 48
*Munkh-Erdene.T, /LL.M/, Lecturer of Public Law Department,
School of Law, National University of Mongolia*

LEGAL RESEARCHES, SUMMARY, RESULTS

Social Protection and Health Legislation Comparative Research 58
*Chuluuntsetseg.O, Lecturer of Public Law Department, School of Law,
National University of Mongolia*

The Constitutional Reform of Mongolia. /1992/ 65
Ulziibayar.B, Researcher

Analysis and implementation of Constitutional regulation 89
*Nomynbayasgalan S, Ph.D. candidate, School of Law,
National University of Mongolia*
Munkhchimeg Kh, Student, School of Law, National University of Mongolia

ҮНДСЭН ХУУЛИЙН НЭР ТОМЬЁО: ХЭРЭГЛЭЭ, ШИЙДЭЛ¹



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Эрдэмтэн нарийн бичгийн дарга,
Хууль зүйн доктор П. Амаржаргал (Ph.D)



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
эрдэм шинжилгээний ажилтан
Ц. Оюунчимэг (LL.M.)

Үндсэн хууль нь тухайн ард түмний эрхэм үзэл санааг өөртөө агуулдаг эрх зүйн дээд хүчин чадалтай улс төр болоод эдийн засгийн баримт бичиг, улс төрчдийн хүсэл зориг үнэт зүйлээр бүтээгдэн аль ч эрх зүйн тогтолцооноос үл хамааран үндсэн хууль түүний зарчмууд ямагт заавал биелэгдэх шинжтэй байдаг.

Хууль тогтоох эрх мэдлийг нийтлэг хүсэл зоригтой холбон үздэг үзэл баримтлал анх 1789 оны Иргэний болон хүний эрхийн тунхаглалын 6 зүйлд тусгагдсан бөгөөд “*Parliamentary supremacy*” -гэдэг нэр томьёо “хууль тогтоох эрх мэдэл”² гэх ойлголт хууль зүйн шинжлэх ухааны нэгэн чухал институт парламентын үзэл баримтлал бэхжих үндэс болсон юм.

Дэлхийн улсууд эрх зүйн тогтолцооныхоо түүхийн ээдрээ, нөхцлийг агуулсан бусад эрх

зүйн тогтолцоонд адилтгах нэр томьёо байдаггүй зарим өвөрмөц ухагдахуунаар ялгардаг. Тухайлбал: тэдгээрийг орчуулахад хүндрэл үүсдэг болохыг орос орны эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн.³ Манай орны эрх зүйн тэр дундаа Үндсэн хуулийн эрх зүйн олон чухал нэр томьёо социалист эрх зүйн тогтолцоонд орос хэлнээс утгачилагдан дамжуулан орчуулагдаж байсныг эрх зүйн сурах бичгүүд гэрчилнэ. Монгол орны хувьд хууль зүйн шинжлэх ухааны судалгаанд хэрэглэгддэг ухагдахууныг хууль зүйн эрдэмтэн судлаачид тухайн хэл дээрх эх сурвалжаас нь шууд орчуулан хэрэглэж байна. Энэхүү илтгэлийн хүрээнд эрдэмтэн судлаачдын сүүлийн үеийн Үндсэн хуулийн эрх зүйн ном бүтээлд өргөн хэрэглэгдэж, орчуулга нь эргэлзээтэй хэдэн хэдэн хувилбараар тайлбарлаж ирсэн үндсэн хуулийн эрх зүйн судлагдахуун үндсэн гадаад нэр томьёог харьцуулан гаргаж ирэхийг зорьлоо.

¹ 2018 оны 6 дугаар сарын 18-ны өдрийн “Хууль зүйн нэр томьёо: Хэрэглээ, тулгамдсан асуудал” эрдэм шинжилгээний бага хуралд хэлэлцүүлсэн илтгэл.

² П. Амаржаргал. Парламентын бүрэн эрх төлөвшил, хөгжлийн чиг хандлага. Уб., 2016 он. 102 дахь тал.

³ А.К. Романов. Их Британий эрх зүй болон эрх зүйн тогтолцоо. Уб., 2016 он. 29 дэх тал.

1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн⁴ хувьд албан орчуулга хийгдсэн хэдий ч зарим нэр томъёо ялгаатай өөр ойлголтоор орчуулагдан тайлбарлагдсаар байна.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дүгээр зүйл⁵ -д хууль санаачлагч нь хуулийн төсөлд хэрэглэх нэр томъёо, хэл зүйн талаар юуг баримтлах талаар тусгайлан зохицуулжээ.⁶ Эдгээрээс хангах ёстой зайлшгүй шаардлага нь боломжит бүх гадаад үгийг эх хэл дээр буулган хэрэглэх явдал юм. Хуулийн заалтыг нэг мөр ойлгох бус өөр өөрөөр ойлгон хэрэглэх нь хууль тогтоогчийн хүсэл зориг болоод зарим тохиолдолд харилцааг хэт нарийвчлан зохицуулах гэснээс үүдсэн хуулийн зохицуулалт гажуудах мөн хууль тогтоогчоос өөр этгээд хуулийг тайлбарласнаас утга алдагдах, улмаар буруу практик тогтох, хуулийг хэрэглэгч төөрөгдөлд орох, хуулийн нэр томъёо хэт олшрох, олон утга санаа илэрхийлэгдэхэд хүрч үр дагавар нь эрх зүйн харилцаанд оролцогчидод нөхөж барашгүй хор хохирол үүсэх⁷ магадлал юм. Хуульд нийцүүлэн батласан, хэм хэмжээ тогтоосон шийдвэр тухайлбал, тогтоол, захирамж, тушаалыг хууль зүйн арга ажиллагааны тухай ойлголт, зарчим, мэдээлэлтэй байж батлах мөрдүүлэх ёстойг цаг үе биднээс шаардаж байна. Ойлгомжгүй, бичилтийн хувьд алдаатай, утга давхардсан, агуулгаас зөрсөн зүйл, заалт бүхий шийдвэр, журам ихээр ажиглагдах болсон нь үүнийг илтгэнэ.⁸

Тухайлбал: 1992 оны Үндсэн хуулийн “эрх зүйт ёс, эрх зүйд захирагдах” буюу англи хэлнээ “*Rule of law*” нэр томъёог НҮБ-ын цахим хуудаснаа тавигдсан орчуулганд хэрэглэсэн байдаг. Манай Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн судалгааны төвөөс хэвлэн гаргасан орчуулгын хувилбарт⁹ “*respect of law*” хэмээсэн нь бий. Энэ нь хуулийг хүндлэх гэсэн утгаар ойлгогдох бол, “*rule of law*” – нь хуулийг заавал загаж мөрдөх хэрэв дагаж мөрдөөгүй тохиолдолд эрх зүйн үр дагавар үүсгэдэг гэсэн ойлголт юм. Энэ үндсэн нэр томъёог нийт манай орны хорь гаруй эрдэмтэн судлаачид өөрсдийн ойлголтын хувилбараар орчуулан ном бүтээлдээ тайлбарласан байдаг. Тэдгээрийг ангилан үзвэл 3 үндсэн хандлага байна. “*Rule of law*”-г “*эрх зүйт ёс*” гэдэг утгаар дараах судлаачид: Академич Ж. Амарсанаа, В. Оюумаа, Ч.Өнөрбаяр, П. Амаржаргал нар харин “*эрх зүйд захирагдах ёс, ноёрхол*” гэдэг утгаар Проф. Н. Лүндэндорж¹⁰, Г. Банзрагч¹¹ санал нэгддэг бол “хууль дээдлэх ёс, зарчим”- гэж ойлгох хандлагад Ш. Цогтоо¹², Д. Гангабаатар¹³, О. Мөнхсайхан¹⁴ нар багтаж байна.

“*Rule of law*” нь Британий Үндсэн хуулийн суурь зарчим бөгөөд тэр нь мөн чанартай төрийн эрх мэдлийг хуваарилахад харилцан хяналт болон тэнцвэржүүлэлтийн тогтолцоон дах шүүх засаглалын бие даасан байрыг, хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалаас шүүх засаглалыг тусгаар байдлыг бататгаж өгдөг¹⁵

⁴ Англи хэл дээрхи орч. <http://www.unesco.org/education/edurights/media/docs/6a6a23469e136afaa4860bf5869f68f659c6688.pdf>

⁵ Хууль тогтоомжийн тухай хууль, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

⁶ Д. Лүндэжанцан. Хууль бүтээх ажиллагаа ба хууль зүйн техник. УБ., 2016 он. 49 дэх тал.

⁷ “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл УБ., 2016 он.

⁸ Хууль зүйн арга ажиллагаа (эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл), Хянасан Ж. Амарсанаа нар УБ., 2018 он.

⁹ Ж. Амарсанаа нар, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төв, УБ., 2016. 41 дэх тал.

¹⁰ Н. Лүндэндорж. Jurisprudence. УБ., 2001 он. 74 дэх тал.

¹¹ Хууль дээдлэх ёс. УБ., 2017 он. №3, 56 дахь тал.

¹² Хууль дээдлэх ёс. УБ., 2017 он. №3, 56 дахь тал.

¹³ “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл УБ., 2016 он. 75, 76 дахь тал

¹⁴ Эрх зүй сэтгүүл. УБ., 2016 он. № 1, 19 дэх тал.

¹⁵ А.К. Романов. Их Британий эрх зүй болон эрх зүйн тогтолцоо. УБ., 2016 он. 326 дахь тал

гэж тогтолцоотой нь холбон оросын судлаач тайлбарласан байдаг.

Дараагийн нэг чухал ойлголт бол төр, улс буюу “State” гэсэн ойлголт юм. Энэ “State”-гэдэг үгийг Ж. Амарсанаа 1924-1992 онуудын Үндсэн хуулиудын англи хэлний орчуулга номондоо 1924 онд “nation-state”- г “*бүх Монгол Улс*” гэсэн үгийн орчуулгаар хэрэглэн “state”-г “улс”; 1940 онд state-г улс; “nation”-г “улс орноо” гээд 1960 онд мөн “state”- г “улс”, 1992 онд “state” -г *төр*¹⁶ гэж орчуулжээ. Судлаач Проф. Н.Лүндэндорж, Я.Долгоржав¹⁷ Ш. Цогтоо¹⁸, П.Амаржаргал нар “state”-г төр гэхээсээ “улс” гэх; Ж. Амарсанаа¹⁹, Ж.Бямбаа²⁰, Ч. Өнөрбаяр²¹ нар “төр” гэсэн ойлголтоор орчуулсан.

“Төр” гэсэн ойлголт, нэр томьёо нь “rule of law” буюу Үндсэн хуулийн “эрх зүйт ёсны”²² зарчимтай зөрчилдөж байдаг. Тухайлбал: Монгол Улсын Үндсэн хуулийн дөчин зургаа дугаар зүйлийн хоёр-т заасан “*төрийн ашиг сонирхол*” гэдэгт юуг ойлгох, энэ нь *төрийн албан тушаалтны эрх ашиг зөрчигдөж байхад үүсэх үү?* харин *Монгол улсын ашиг сонирхол* юм уу эсвэл *нийт ард түмний ашиг сонирхол* гэж ойлгох уу? Ардчилсан улсад төрийн гэсэн тусгай ойлголт байх ёсгүй. Монгол Улсын Үндсэн хуулийн хорин гурав дугаар зүйлийн нэг дэх хэсэгт “Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд *нийт иргэн, улсын ашиг*

сонирхлыг эрхэмлэн баримтална.” гэж тодорхойлсон байхад дөчин зургаа дугаар зүйлийн хоёр дахь хэсэгт төрийн жинхэнэ албан хаагчдыг *төрийн ашиг сонирхолд захирагдан ажиллана* гэж тусгай ашиг сонирхлын субъект болгосон нь буруу юм. Төрийн алба буюу “public service” гэдгийг ард түмэнд, олон нийтэд зориулан үйлчилгээ үзүүлэх ёстой гэсэн агуулгаар нь *нийтийн алба*²³ гэвэл оновчтой болно. Мөн *төрийн өмч* гэж байдаггүй. Төр эрх мэдлээ хэрэгжүүлэхдээ нийтийн өмчийг ард түмнээс хуулиар эрх олгосон хязгаарлагдмал хүрээнд ашиглаж, эзэмшиж, захиран зарцуулдаг тул дээрх зөрчилдөж байгааг засах нь зүйтэй. Энэ нь дэлхийн хуульчдын нийтлэг хэрэглээний Блэкийн хууль зүйн толь бичигт байх “public property” буюу “засгийн газрын болоод коммуни нийтийн хэрэглээнд зориулагдсан болоод эзэмшлийн өмч”²⁴ гэх тодорхойлолтын ойлголттой нэг бөгөөд монгол хэлнээ орчуулахад “*нийтийн өмч*” болох юм. Нийтийн өмчийг эзэмшин, өмчлөх, хамгаалах субъект нь харин *Засгийн газар* буюу дэлхийн ихэнхи оронд *Government* гэж үздэг. Иймээс *төрийн* гэх дээрхи тодотгол үгийг хасах саналтай байна.

“Магна Харт хүн төрөлхтний төлөөлөгчдийн дээд байгууллага, парламент үүсэж, хөгжих анхны сэдэл санааг өгсөн ..., ... Магна Хартын нэг түүхэн гавъяа – эрх зүйн байх ёстой зарчмуудын (due process of law) эх үндсийг анх тавьсан гэж үздэг. 39 дүгээр зүйл “... шүүхийн шударга шийдвэргүйгээр болон өмч хөрөнгөнөөс нь салгах”, АНУ-ын Үндсэн хуулийн нэмэлтийн 5 дугаар заалт-д “... шүүхийн хүчин төгөлдөр шийдвэргүйгээр .. хувийн ямар ч өмчийг шударга нөхөн олговоргүйгээр нийтийн хэрэгцээнд хураан авч болохгүй...” гэх

¹⁶ Ж. Амарсанаа, О. Батсайхан. Л.Төр-Од. The Constitutions of Mongolia 1924, 1940, 1960, 1992 УБ., 2009он.

¹⁷ Төрийн захиргаа онол арга зүйн сэтгүүл. УБ., 2018 № 01/45, 19 дэх тал.

¹⁸ Эрх зүй сэтгүүл. УБ., 2011 он, Дугаар №1, 30 дахь тал.

¹⁹ Ж. Амарсанаа. Англи Орос Герман Монгол олон улсын эрх зүйн толь. УБ., 2004 он. 710 дахь тал.

²⁰ Монгол Улсын Үндсэн хуулийн байгууллагуудын тогтолцоон дахь Прокурорын байгууллагын үүрэг, тулгамдсан асуудал. 2017 он. 59 – 111 дахь тал.

²¹ Үндсэн хууль ёс ба ерөнхийлөгчийн бүрэн эрх, Олон Улсын онол практикийн бага хурал УБ., 2015 он. 81 дэх тал.

²² П. Амаржаргал. Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал. УБ., 2015 он. 11-15 дахь тал.

²³ Төрийн захиргаа, онол арга зүйн сэтгүүл. УБ., 2018 он, № 01/45, 55 дахь тал.

²⁴ Bryan A. Garner 9th edition *Black's law dictionary*. (West publishing Co.) P.1337.

эрх зүйн байх ёстой шударга зарчмууд тусгалаа олсон.²⁵

“.. Мөн төрөөс нийтлэг эрх ашгийн үүднээс хувийн өмчийг дайчлах нь “эрх зүйн байх ёстой зарчим” буюу “due process of law” гэсэн ойлголттой зөрчилдөж болох юм. Жишээ нь: Монгол Улсын Үндсэн хуулийн зургаа дугаар зүйлийн дөрөв болон арван зургаа дугаар зүйлийн гурав-т зааснаар “...хувийн өмчийг дайчлан авбал нөхөн олговор, үнийг төлнө” гэсэн тул нөхөн олговор, үнэ нь “шударга” байх зарчим²⁶ ямагт хүчинтэй байж, хувь хүний эрх ашиг хохирох явдлаас хамгаалагдах ёстой.

Английн Магна Харт-д анх²⁷ тусгалаа олсон “Due process of law”- (Блэкийн хууль зүйн толь бичигт “хувийн эрхийг хамгаалах, хэрэгжүүлэх зорилгоор хууль зүйн үйл ажиллагааг тогтоосон дүрэм журмын дагуу явуулах”- ыг хэлнэ. орч²⁸) -нь хэргийг шийдвэрлэх эрхтэй шүүгчийн өмнө хэргийг шийдвэрлүүлэх эрх болон мэдэгдэл юм.

“Due process of law”-г дараах эрдэмтэд тухайлбал: Проф. Н. Лүндэндорж болон миний бие “эрх зүйн байх ёстой зарчим”, Академич Ж.Амарсанаа “хууль сахиулах ёс”²⁹, Ө. Жамбалсүрэн “зүй ёсны, зүй ёсны эрх зүйн процесс”³⁰; Академич С.Нарангэрэл “due course of law-той” адил буюу “эрх зүйн зохих ёсны процедур”³¹ гэж орчуулсан.

Парламентын хяналтын чиг үүрэгтэй холбоотой Үндсэн хуулийн эрх

²⁵ Магна Харт. орч. П. Амаржаргал, Хянасан Н. Лүндэндорж. УБ., 2012, 2016он. 11 тал.

²⁶ П. Амаржаргал. Үндсэн хуулийн эрх зүйн Парламентын онол үзэл баримтлалын асуудал. УБ., 2015 он. 11 дэх тал

²⁷ John V. Orth. *Due Process of Law: A Brief History* (University press of Kansas, 2003) P. 6-9. “by the law of the land”

²⁸ П. Амаржаргал. Үндсэн хуулийн эрх зүйн Парламентын онол үзэл баримтлалын асуудал. УБ., 2015 он. 11 дэх тал

²⁹ Хууль дээдлэх ёс сэтгүүл. УБ., 2017 он. №1, 21 дэх тал.

³⁰ Үндсэн хууль ба эрх зүйт ёс. УБ., 2009 он. 74 дэх тал.

³¹ Хууль зүй судлалын англи- монгол тайлбар толь. УБ., 2005 он. 344 дэх тал.

зүйн гадаад эх сурвалжид: парламентын хяналт тавих үйл ажиллагаа, хэн хэрэгжүүлэхийг заасан эрх үүрэг бүхий тогтолцоо, хяналтыг хэрэгжүүлж буй арга хэрэгсэл зэрэг ялгаатай ойлголтууд тусдаа нэр томъёогоор задарч илэрхийлэгддэг. Жишээ нь: *Ad hoc, Specialized parliamentary committees, parliamentary scrutiny, public hearings, parliamentary inquiries, legislative oversight, parliamentary oversight, parliamentary control, Ombudsmen, Committees of Inquiry, Auditing Institutions, interpellations that may end with a vote in the chamber*³² гэсэн тус тусдаа өөр утга агуулсан парламентын хяналтын чиг үүрэгт холбогдох үгсийг “парламентын хяналт” гэсэн нэг үгээр орчуулах эсвэл энэ үгэнд харьяалуулах болон орчуулахгүйгээр хэрэглэх нь хэр оновчтой байх асуудал үүсэн, монгол хэлнээ өнөөг хүртэл бүрэн дүүрэн орчуулагдан эрдэмтэд санал нэгтэй хэрэглээгүй байна.

Парламенттай холбоотой бас нэгэн чухал ойлголт бол түүний эрх мэдлийн тухай нэр томъёо юм. Түүнчилэн Хууль тогтоох байгууллагын тэр дундаа “парламентын бүрэн эрхт байдал” буюу *Parliamentary Sovereignty*³³ гэх, “*Supremacy of parliament*” or “*Sovereignty of parliament*” бол харин хууль тогтоох “дээд бүрэн эрх”³⁴ гэсэн ялгаатай ойлголтууд байна.

Английн философич, хуульч Ж. Бэнтхам нэгэн цагт “The power of the lawyer is in the uncertainty of the law.” буюу утгачилбал “Хуульчийн хүч чадал хуулийн тодорхой бус байдалд оршино” хэмээсэн нь орчин үеийн шаардлагад нийцэхгүй боловч хууль тогтоогчдын үйл ажиллагааны үнэн төрхийг илэрхийлсэн тэдэнд тавих ард түмний хяналтыг хэзээ ч орхигдуулахгүй байхыг

³² Erik Damgaard. *Representation, delegation and parliamentary control.*

<https://ecpr.eu/Filestore/PaperProposal/ba3e3cad-212c-45a0-93b6-76a305e2a577.pdf>

³³ П. Амаржаргал. Үндсэн хуулийн эрх зүйн Парламентын онол үзэл баримтлалын асуудал УБ., 2015 он. 102 дахь тал.

³⁴ Мөн тэнд, 106 дахь тал.

анхааруулан хэлсэн мэт.

Манай орны хууль зүйн эрдэмтэн судлаачид Үндсэн хуулийн эрх зүйн төдийгүй философи, улс төр, хууль зүйн шинжлэх ухаанд хүн төрөлхтний олон зуун жилийн түүхэнд бүтээгдсэн чухал нэр томъёо, гадаад үгнүүд Монгол хэл дээр ер нь орчуулан буулгах боломжтой эсэх, тухайн үгийн жинхэнэ утгыг хэрхэн зөв орчуулан ойлгож ирсэн зэрэг асуудал хууль зүйн эрдэмтэн судлаач, философич, улс төр судлаачдын дунд хэлэлцүүлэгдсээр маргаантай байсаар байна.

Жишээ нь: *Bill of rights, Democracy, Equality, Governance, Community, Freedom, Human dignity, Justice, Liberalism, People* зэрэг үгсийг хэрхэн орчуулах, нэгдсэн ойлголттой болох хэрэгтэй юм. Ингээд улс төр, хууль зүйн шинжлэх ухаанд өргөн хэрэглэгддэг зарим нэр томъёог хэрхэн орчуулан, ойлгож байгааг анхаарч үзвэл:

Үүнд: “*governance*”-г Б. Чимид “*удирдах эрхээ хэрэгжүүлэх байдал*”³⁵; “*Government*”-г Я. Долгоржав “*төр, засгийн газар*”³⁶; “*human dignity*” -г Я. Долгоржав “*хүний сүр сүлд*”³⁷; О. Мөнхсайхан “*хүний эрхэм чанар*”³⁸; “*Justice*” гэдэг үгийг Ч. Өнөрбаяр “*шударга ёс*”³⁹; Ч. Ган- Өлзий “*Шударга*

ёсны эш онол”⁴⁰; “*Check's and balance*” гэсэн үндсэн хуулийн эрх зүйн зарчмыг Ч. Өнөрбаяр “*эрх мэдлийг хянан тэнцвэржүүлэх*”⁴¹ П.Амаржаргал “*харилцан тэнцвэртэй, хяналт бүхий зарчим*”⁴² хэмээн тус тус тайлбарлажээ. Үндсэн хуулийн эрх зүйд байх “*deliberative*” гэдэг ойлголт нь манайд “*зөвлөлдөх*” гэсэн утгаар хэрэглэгдэн, (Зөвлөлдөх санал асуулгын тухай хууль) хүртэл баглагдсан байгаа. Гэтэл энэ үг нь бодит байдал дээр хэлэлцүүлгээр асуудлыг шийдвэрлэх гэсэн утгыг илэрхийлдэг нэр томъёо юм.

ДҮГНЭЛТ:

Ингээд дараах асуудлыг бид шийдвэрлэх хэрэгтэй байна. Үүнд:

- Хууль зүйн нэр томъёоны тайлбарыг улам төгөлдөржүүлэх

- Орчин үеийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн шинэ нэр томъёог нутагшуулах

- Шинжлэх ухааны үндэстэй судлан хоёрдмол утгагүй зохих товч тодорхой нэр томъёо оноох

- Хууль зүйн хэлний салбар зөвлөлийг бэхжүүлэх

- Цахим хууль зүйн үгийн сан байгуулах

³⁵ Б. Чимид Үндсэн хуулийн үзэл баримтлал: нийтлэг асуудал. УБ., 2004 он. 298 дахь тал.

³⁶ Төрийн захиргаа. Онол арга зүйн сэтгүүл УБ., 2018 он. № 01/45, 17 дахь тал.

³⁷ Мөн тэнд, 19 дэх тал.

³⁸ Шүүх эрх мэдэл. УБ., 2015 он. №1 132 дахь тал.

³⁹ Ч.Өнөрбаяр. Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага УБ., 2014 он. 32 дахь тал.

⁴⁰ Монгол Улс дахь ёс зүйн сургалт судалгааны өнөөгийн байдал, тулгамдсан асуудал. УБ., 2014 он. 31 дэх тал.

⁴¹ Үндсэн хуульт ёс ба ерөнхийлөгчийн бүрэн эрх олон улсын онол практикийн бага хурал. УБ., 2015 он. 81 дэх тал.

⁴² П. Амаржаргал. Үндсэн хуулийн эрх зүй Парламентын онол үзэл баримтлалын асуудал. УБ., 2015 он. 50 дахь тал.

.....

RULE OF LAW-ЭРХ ЗҮЙТ ЁСНЫ ИНДЕКСЭЭР МОНГОЛ УЛС ДЭЛХИЙН 113 УЛСААС 51-Т ЖАГСЖЭЭ



Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн удирдлагууд World Justice Project байгууллагын эрх зүйт ёсны индексийн судалгаа хариуцсан захирал Сара Чамнес Лонг /Sarah Chamness Long/, “Нээлттэй нийгэм форум”-ын төслийн зохицуулагч П.Бадамрагчаа нарыг хүлээн авч уулзлаа.


Уулзалтаар World Justice Project байгууллагын эрх зүйт ёсны индексийн судалгаа хариуцсан захирал Сара Чамнес Лонг World Justice Project байгууллагын талаар болон тус байгууллагаас жил бүр хийдэг улс орнуудын Rule of law-эрх зүйт ёсны индексийн талаарх судалгаа, Монгол улсын тус индексийн үзүүлэлтийн талаар танилцууллаа.

World Justice Project байгууллага 2008 оноос эхлэн дэлхийн улс орнуудын эрх зүйт ёсны индекс буюу Rule of law индексийн судалгааг жил бүр гаргаж иржээ. Монгол Улсын хувьд 2012 оноос энэ судалгаанд хамрагддаг болжээ. Дээрх байгууллагын 2017-2018 оны судалгааны үзүүлэлтээр Ази ба Номхон далайн бүс нутгийн үзүүлэлтээр орлогын түвшин ойролцоо дээрх бүс дэх 30 улсаас 4 дүгээрт үзүүлэлтээрээ жагсжээ. Харин дээрх индекст үзүүлэлтийн судалгаанд хамрагдсан 113 орноос 51-д Rule of law индексийн үзүүлэлтээр эрэмбэлэгджээ.

Энэхүү Rule of law индексийн үзүүлэлтийг 2017-2018 оны хувьд 113 улсыг хамруулан нийт 8 үзүүлэлтээр гаргажээ. Үүнд Засгийн эрх мэдлийг хязгаарлах хязгаарлалтууд, авилгагүй байдал, нээлттэй засгийн газар, үндсэн эрх, дэг журам, аюулгүй байдал, хууль дүрэм үйлчилдэг, хэрэгждэг байх, иргэний шүүх, шүүн таслах ажиллагаа, эрүүгийн шүүн таслах ажиллагаа гэсэн үзүүлэлтээр дээрх үзүүлэлт нь дотроо 4-8 дэд үзүүлэлтийн нарийвчлалтайгаар гаргадаг байна. Үзүүлэлтийг гаргахдаа 0-1 хүртэлх онооны үзүүлэлтээр гаргадаг ажээ. World Justice Project байгууллагаас дээрх индексийг гаргахдаа Монголын хувьд үндэсний 23 экспертийн судалгаа болон мэргэжлийн судалгааны байгууллагаар тусгайлсан аргачлалын дагуу иргэдээс судалгааг авч гаргадаг байна.

.....

БОГД ХААНТ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ЭРЭН СУРВАЛЖЛАХ НЬ



*Нийслэл дэх Захиргааны хэргийн
анхан шатны шүүхийн шүүгч,
хуульч Г.Мөнхтулга /LL.M./*

ТҮЛХҮҮР ҮГС

Богд хаан, Богд хаант Монгол Улс, автономит Монголын Үндсэн хуулийн төсөл, Үндсэн хуулийн төсөл, Ост Ллойд, Дальний восток.

ТОВЧ УТГА

Энэхүү өгүүлэл нь түүхэнд тэмдэглэгдэн үлдсэн, Богд Хаант Монгол Улсын Үндсэн Хуулийн төслийн талаарх нэгэн мэдээллийн мөрөөр мөшгөн хөөж, түүний уг эхийг илрүүлэн олж, судалгааны эргэлтэд оруулах ажилд эрдэмтэн, судлаачдыг уриалан дуудах чин зорилго бүхий судлаачийн сэдэмж бичиг болно.

I. ОРШИЛ

Улс бүр өөрийн орны эх түүх, соёл уламжлалаа үнэн мөнөөр нь танин мэдэж, түгээн дэлгэрүүлэх чин эрмэлзэлтэй байдаг бөгөөд энэ ч зорилгын үүднээс эрдэмтэн, мэргэд нь судалгаа шинжилгээний эрэл хайгуулаа цуцалтгүй явуулдаг биз ээ.

Судлаач миний бие ч энэ л зорилгын үүднээс түүхэнд “Автономит Монголын Үндсэн хуулийн” нэгэн төсөл хэмээн тэмдэглэгдэн үлдсэн баримт бичгийн мөрөөр энэхүү сэдэмж бичгийг тэрлэхээр зорьлоо.

Өгүүлэхээр зорьж буй төслийн тухайд монгол судлаачдын ном зохиолд хэрхэн авч үзсэн байдлыг товч дурдвал: “Богд хаант улсын Засгийн газар 1912 оноос номч мэргэн хүмүүст энэ талаар даалгавар өгч, судлуулахын зэрэгцээ тэр үеийн ардчилсан үзэлтнүүд парламентат ёс, Үндсэн хуулийн байгуулал тогтоох эрмэлзэлтэйгээ илэрхийлсэн, эхэлж оролдсон баримтууд цөөнгүй бий.”¹ “Улс орны дотоод байдлыг төвхнүүлэхэд улсын хууль цаазыг тогтоон явуулах явдал чухлыг харгалзан, улсын хууль дүрмийг боловсруулах тусгай хүмүүсийг томилон ажиллуулжээ.”² “Хаант Оросын хэвлэл “Дальний Восток” сэтгүүлийн 1913 оны IX сарын дугаарт Ост Ллойдод бичсэнийг үндэслэн Богд хааны зарлигаар Үндсэн хуулийг боловсруулсан гэжээ.”³ “Түүхийн хуудас сөхвөл, Хаант Оросын “Дальний Восток” сэтгүүлд Богд хааны зарлигаар Үндсэн хуулийг боловсруулсан гээд зарим заалтуудыг бичсэн байдаг.”⁴ “Тэр үед тухайн цагийн дэлхийн боловсон олон улсын жишээгээр улсынхаа хуулийг зохиох оролдлого хийж байв. Тэр үеийн Хаант Орост

¹ Б.Чимид. Уншаад төрсөн бодол, хадгалж явдаг сэтгэл. Ж.Амарсанаа. О.Батсайхан. Монгол Улсын Үндсэн хууль: баримт бичиг. Улаанбаатар. 2004. 22 дахь тал.

² Монгол Улсын түүх. V боть. Улаанбаатар. 2004. 79 дэх тал.

³ Ж.Болдбаатар, Д.Лүндээжанцан. Монголын төр, эрх зүйн түүхэн уламжлал. Улаанбаатар. 2011. 231 дэх тал.

⁴ Ч.Өнөрбаяр. Үндсэн хууль ёсны хөгжил, түүний чиг хандлага. Улаанбаатар. 2014. 108 дахь тал.

хэвлэгдэж байсан “Дальний Восток” сэтгүүлийн 1913 оны 9-р сарын дугаарт “Ост Ллойдод” мэдээлснээр бол Богд хааны зарлигаар үндсэн хуулийг боловсруулсан гээд түүний заалтуудыг бичсэн байдаг.”⁵ гэх зэргээр гол төлөв дурдан өнгөрөх төдийгөөр бичсэн нь нэн чамлалттай санагдсаны үүднээс уг төслийн талаарх мэдээлэлд эрдэмтэн, судлаачдын анхаарлыг татаж, “өдөөх” үүднээс энэхүү өгүүллийг тэрлэв.

II. Монгол газарт өрнийн эрх зүйн соёл, сэтгэлгээ нэвтэрсэн тухайд

Монголчуудын нүүдлийн соёл иргэншил тэднийг эрх зүй, хуульд тийм ч ойр дотно болгоогүй⁶ бөгөөд монгол газарт өрнийн эрх зүйн соёл, сэтгэлгээ хэдий үеэс нэвтэрч эхэлснийг нарийвчлан судлах шаардлагатай хэдий ч профессор Н.Лүндэндоржийн бичсэнчлэн, Манж-чин улсын “Шинэ засгийн бодлого” монголчуудын үндэсний ухамсар, тэмцлийг өрнүүлж, улмаар өрнө рүү харах, тэмүүлэх шинэ орон зайг бий болсон⁷ гэдэгтэй ихэнх судлаачид санал нэгтэй байна.

Тодруулбал, Манж Чин улсын төрөөс хятад газар дахь худалдаа эрхлэх эрхийг хязгаарлах асуудлаар Их Британитай маргалдсанаас үүдэлтэй “хар тамхины” I, II дайны дараа Их Британи, Герман, Америк, Франц зэрэг өрнөдийн аж үйлдвэржсэн орнуудын зүгээс хүч нь суларсан Чингийн засагт газар эзэмших эрх болон чөлөөт худалдааны зэрэг асуудлаар эрх тэгш бус гэрээ хэлэлцээрийг тулган, шаардаж байгуулснаар⁸ Чин улсын ноёрхолд байсан олон угсаатан, ард түмний нуруун дээр хүнддарамт учирсан бөгөөд

үүнийг эсэргүүцсэн олон түмний тэмцэл XIX зууны дунд үеэс тасралтгүй гарах болсон бөгөөд, ... Манж Чин улсын эрх баригчид ...тоймтой өөрчлөлт шинэчлэл гаргахгүйгээр Манжийн төрийг хэвээр хадгалах боломжгүй⁹ болохыг хүлээн зөвшөөрч, 1900 оны эхээр “Шинэ засгийн бодлого”¹⁰ хэмээх эдийн засгийн шинэчлэлийн хөтөлбөрийг зарлан хэрэгжүүлж, “Иргэнийг нүүлгэн суурьшуулж, хязгаарыг бэхжүүлэх” бодлогын хүрээнд монгол газарт хятад тариачин иргэдийг суурьшуулж¹¹, Ар, Өвөр Монголыг муж болгон өөрчлөн, монголчуудыг хүчээр хятадчилах гэж оролдсоныг газар газрын монголчууд эсэргүүцэн тэмцсэн нь явсаар 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгалтай золгожээ.

Улмаар, хятадаас салснаас хойш ... монгол өөрийн гэсэн хэв хэмжээ болсон эрхтэй болохоор шийдэж, энэ зорилгоор засгийн газар хууль зүйн эмхтгэл бичиг зохиох тусгай комисс байгуулжээ.¹² Профессор В.А.Рязановскийн нэгэнтээ бичсэнчлэн манж, хятадын эрх зүйн нөлөө монголчуудын өдөр тутмын амьдралд гэхээс илүүтэйгээр эрүү, эрүүгийн байцаан шийтгэх эрх зүйн / болон төр, захиргааны эрх зүй/ хүрээнд голлон тусгалаа олсон¹³ байсантай

⁹ Supra 2. 41-42 дахь тал.

¹⁰ “Шинь чэн” буюу Шинэ засгийн бодлого нь:

- Эдийн засгийг сэргээхийн тулд газар орны бүхий л нөөц бололцоог дайчлах

- Хятад дахь капиталист харилцааны хөгжилт ба үндэсний аж үйлдвэр хөрөнгөтнүүдийн ашиг сонирхлыг хангах

- Гадаадын худалдаачдыг шахан зайлуулж хятад худалдаачдыг өргөтгөх

- Бослого тэмцэл, үер усны гамшгаас шалтгаалан газаргүй болсон тариачдад газар олгох гэсэн 4 үндсэн хэсгээс бүрдэж байв.

¹¹ Баабар. Монголчууд: нүүдэл суудал. I. 2006. 205 дахь тал. Шинэ засгийн бодлогоос хойш тариаланч хятад зохион байгуулалттайгаар үерийн ус шиг цутган 60-70 мянган десятин газар хагалбарлажээ. Исаевийн тэмдэглэснээр энэ үед монголчуудаас тариаланд зориулж авсан газар 4.905 мянган десятин хүрч, шилжин суугчид 350.000 болжээ.

¹² И.Майский. Орчин үеийн монгол (Автономит монгол XX зууны гараан дээр). Улаанбаатар. 2005. 331 дэх тал.

¹³ В.А.Рязановский. Монгольское право (преимущественно обычное): Исторический очерк. Тип. Н. Е. Чинарева. Харбин. 1931. С.114.

⁵ Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Монгол Улс (1911-1919). Улаанбаатар. 2010. 108 дахь тал.

⁶ В.А.Рязановский. Монголчуудын хууль цаазын дурсгалт бичгийн түүхэн тойм. Их засаг хууль. Улаанбаатар. 2000. 57 дахь тал.

⁷ Н.Лүндэндорж. Төр, эрх зүйн сэтгэлгээний хөгжлийн чиг хандлага. Улаанбаатар. 2002. 224 дэх тал.

⁸ J.M. Zimmerman. China Law Deskbook. A Legal Guide to Foreign-Invested Enterprises. ABA. 2010. 41-42 дахь тал.

холбоотойгоор тусгаар тогтнолоо дахин сэргээсэн Монгол Улс төр, эрх зүйн салбарт үндэсний шинжтэй өөрчлөлт шинэчлэлийг хийж эхэлсэн байдаг.

Энэ хүрээнд шашин төрийг хослон баригч, хэмжээгүй эрхт Богд хааны зарлигаар "...Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг юуны өмнө хөрөнгөтний парламентаризмын үлгэр жишээг харгалзан боловсруулах тухай удирдамж, заалт гарч"¹⁴ европын илүү өндөр соёлыг харьцангуй төвөг багатай хүлээн авах чадвар боломж бүхий¹⁵ монголчууд Америк, Европын зарим нэгэн орнуудын ...Үндсэн хуулийн эрх зүйн үндсэн эх сурвалж болох "Үндсэн хууль", бусад холбогдох эх сурвалжийг 1910 -аад оны эхэн үеэс судалж, орчуулах ажлыг эхлүүлсэн¹⁶ бөгөөд Америкийн хуульч, дипломатч Хенри Витоны туурвисан "Elements of International Law"¹⁷ хэмээх бүтээл 1864 онд хятад хэлнээ орчуулагдан гарсныг монгол хэлэнд хөрвүүлэн¹⁸ "Түмэн улсын ердийн цааз" нэрээр, Англи, Америк, Норвеги, Япон зэрэг орнуудын

Үндсэн хуулийг олж судлан, орчуулж эмхтгэн "Олон улсын үндсэн хуулийн оршил" нэрээр тус тус хэвлэн гаргаж байжээ.

Үүнээс гадна тухайн цаг үед монголчууд хятад хэл дээр орчуулагдан гарч байсан өрнийн эрх зүйн зохиол, бүтээлүүдийг уншиж судлан, олон улсын улс төр, эрх зүй, соёлын чиг хандлагыг танин мэдэж байсан болох нь 1912 оны Монгол-Оросын найрамдлын гэрээг байгуулах ажлын хүрээнд 1912 оны 8 дугаар сараас 1913 оны 5 дугаар сарыг хүртэл хугацаанд Монгол Улсад ажилласан Хаант Орос улсын Бүрэн эрхт элчин сайд И.Я.Коростовецийн 9 дүгээр сарын 30-ны өдрийн тэмдэглэлээс тодорхой харагддаг.

Тодруулбал, И.Я.Коростовецийн 9 дүгээр сарын 30-ны өдрийн тэмдэглэлд: "бидний хүргүүлсэн хэлэлцээрийн төслийн хариуг Монголчууд ирүүлэв. Төсөлд нэлээд их хэмжээний өөрчлөлт оруулсан байсан нь агуулгын хувьд шинэ гэрээ болсон байв. ...хувийн шугамаар авсан мэдээллээр Монголчууд энэхүү төслийг боловсруулахдаа Блюнчлигийн¹⁹ Олон улсын эрх зүйн номны хятад орчуулгыг ашиглан, Хятад газарт сууж, сүүлийн үеийн улс төрийн түүхийн талаарх мэдлэг, мэдээлэлтэй болсон монголчуудын зөвлөгөөнд тулгуурласан ажээ."²⁰ хэмээн тэмдэглэсэн байдаг.

Гэхдээ эдгээр баримт, мэдээлэл нь тухайн цаг үед монголчууд дан ганц гадаад /хятад голдуу/ хэл дээрх

¹⁴ Д.Даш. БНМАУ-ыг тунхагласан түүхээс. Улаанбаатар. 1984. 10, 66 дахь тал. Энэ талаар эрдэмтэн Д.Даш "...хөрөнгөтний бүгд найрамдах улсын үзэл санаа ... монархист үзэлтнүүдийн тусгал байснаас зайлахгүй" хэмээн бичсэн нь бий.

¹⁵ Supra 12. 381 дэх тал

¹⁶ Олон улсын үндсэн хуулийн оршил. Анхдугаар Үндсэн хуулийн судалгааны эх сурвалж. Улаанбаатар. 2009. 1 дэх тал.

¹⁷ Энэхүү зохиол нь анх хэвлэгдсэн цагаас хойш хэд хэдэн удаа дахин хэвлэгдэж, олон орны хэл дээр орчуулагдсан бөгөөд XIX зууны олон улсын эрх зүйн шинжлэх ухааны хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан бүтээлийн нэгд зүй ёсоор ордог /The Cambridge History of English and American Literature in 18 Volumes. VOLUME XVI. Early National Literature, Part II; Later National Literature, Part I. 15 дахь тал. <http://www.bartleby.com/226/0612.html>/ бөгөөд Ютагийн их сургуулийн профессор Энтони Анхэгийн бичсэнээр, тухайн цаг үедээ өргөн хэрэглэгдэж байсан, хүлээн зөвшөөрөгдсөн бүтээлийн нэг юм. Finding the Peripheries: Sovereignty and Colonialism in Nineteenth-Century International Law. Harvard International Law Journal. Volume 40. Number 1. Winter 1999. 8 дахь тал.

¹⁸ БНСУ-ын Хянаанг их сургуулийн Хуулийн сургуулийн профессор И.Жа Мин /Lee Jae min/-ны бичсэнчлэн Америкийн хуульч Хенри Витоны бичсэн "Elements of International Law" хэмээх бүтээл нь 1864 онд японд хэвлэгдсэн бөгөөд тухайн цаг үедээ өндөр албан тушаалтнуудын заавал унших номын нэг болж байсан алдартай зохиол байжээ. <http://www.koreaherald.com/view.php?ud=20100907000976>

¹⁹ Иоанн Каспар Блюнчли /Johann Kaspar Bluntschli 1808-1881/ нь швейцарийн нэрт хуульч, улс төрч бөгөөд түүний 1868 онд бичсэн *Das moderne Völkerrecht* буюу Орчин үеийн олон улсын эрх зүй хэмээх бүтээл нь тухайн цаг үедээ олон орны хэл дээр хөрвүүлэгдэн гарчээ. Түүний тухай дэлгэрэнгүй Johann Kaspar Bluntschli. Proceedings of the American Academy of Arts and Sciences, Vol. 17. 1881-1882. 445-448 дэх талаас үз. Түүний энэхүү бүтээл нь 1880 онд хятад хэлээр гарчээ. R.Svarverud. International Law as a World Order in Late Imperial China: Translation, Reception and Discourse; 1847 – 1911.Brill. Leiden. 2007. 273 дахь тал.

²⁰ И. Я. Коростовец. Девять месяцев в Монголии. Дневник русского уполномоченного в Монголии. Август 1912 — май 1913 г. Адмон. Улаанбаатар.2009. 110 дахь тал.

эрх зүйн эх сурвалж, ном зохиолуудыг ашиглаж байсан гэсэн үг бишээ. Монгол Улсын Ерөнхийлөн захирах сайд, Сайн ноён ханы тушааснаар буриад гүн, эрдэмтэн Жамсрангийн Цэвээн 1912-1914 оны үед “дэлхий дээрх их бага олон улсын хууль дүрмээс засгийн хэргийг ерөнхийлөн шийтгэх зүйл ба ... улсын дээд эрх...энэ хоёр эрх харилцан холбогдох зүйлүүдийг товчлон бичсэн”²¹ “Улсын эрх”²² нэрт харьцуулсан эрх зүйн судалгааны бүтээл болон Цахар сайдын зөвлөн хэлэлцэх түшмэл Дандаа хэмээх Дэмчигдоржийн 1914 онд Их Хурлын сайд түшмэдэд барьсан “Улс төрийг засах гурван зүйлийн ёсны тухай өргөсөн бичиг” хийгээд уг бичгээ дэлгэрүүлэн 1922 онд бичсэн “Шинэ засгийн гол ёсон” зэрэг хэд хэдэн бүтээл гарсан нь /өнөөгийн байдлаар бидэнд мэдэгдэж байгаагаар/ тооны хувьд цөөн ч барууны хөгжилтэй орнуудын төрийн байгуулал, эрх зүйн тогтолцоог сонирхон судлах ... парламентат ёс, Үндсэн хуулийн байгуулал тогтоох эрмэлзэлтэйг илэрхийлсэн.²³ Богд хаант Монгол Улсын төр, эрх зүйн шинэчлэлийн хэтийн чиг хандлагыг тодорхойлсон, ач холбогдол өндөр, утга агуулга гүн бүтээлүүд байв.²⁴

Эрдэмтэн, мэргэдийн энэ мэт ажлын дүнд Монгол Улсын Үндсэн хуулийн анхны төслийг Богд хаант Монгол Улсын үед буюу 1911-1921 оны хооронд боловсруулж байсан талаар

²¹ Ж.Цэвээн. Улсын эрх. Эрх зүйт ёс сан. Улаанбаатар. 2014. 10 дахь тал

²² Эрдэмтэн Д.Даш “БНМАУ-ыг тунхагласан түүхээс” хэмээх бүтээлдээ энэ бүтээлийг 1915 оны үед бичигдсэн хэмээн тэмдэглэсэн байдаг. Түүнчлэн тэрээр, 1909 онд Харбин хотод хэвлэгдэж байсан “Монголын сонин бичиг” –ийн анхны дугааруудад “хэмжээт хууль” бүхий “дүрэмт засаг” байгуулах талаар бичиж байснаараа Монголчууд Үндсэн хууль бүгд найрамдах засаг тогтоох тухай үзэл санааг эртнээс судлаж байсан болохыг нотлохыг зорьсон байдаг.

²³ Supra 1.

²⁴ Энэ асуудлын хүрээнд бид, хятадыг Үндсэн хуульт хаант улс болгон өөрчлөх тухай Их хатан Цү Ши / Empress Dowager Cixi/- ийн 1907 онд хийсэн тунхаглал Богд Хаант Монгол Улсын Үндсэн хуулийн төслийг боловсруулах асуудалд нөлөөлсөн эсэх, хэрэв нөлөө үзүүлсэн бол уг нөлөөлөл нь ямар байдлаар байсан вэ гэсэн асуудлыг нарийвчлан судлах шаардлагатай юм

түүхэн эх сурвалжид хэд хэдэн баримт тэмдэглэгдсэн үлдсэнээс хоёрыг нь нэрлэн дурдвал:

1. Тэр үеийн Хаант Оросын хэвлэл “Дальний восток” сэтгүүлийн 1913 оны 9 дүгээр сарын 36 дугаар дугаарт: Өргөөгийн хутагтын /Богд хааны/ зарлигаар автономит Монголын Үндсэн хуулийг боловсруулсан²⁵ гэх мэдээ,

2.Оросын судлаач И.М.Майскийгийн “...1918 оны сүүлчээр Байгалийн цаадах Буриадуудын дунд атаман Семенов, түүний ард зогсож буй Япончуудын зүгээс маш хүчтэй дэмжлэгийг олсон панмонголын /нармай монгол/ хөдөлгөөний үр соёолж эхэлсэн бөгөөд ...Чит хотод 1919 оны 2 дугаар сарын 28-нд нээгдсэн монгол овогтны төлөөлөгчдийн бага хурал зарлан хуралдуулж²⁶, ...ирээдүйн “Их Монгол” улсын Үндсэн хуулийг боловсруулжээ”²⁷ гэх мэдээллийг дурдаж болох юм.

Түүхэн тодорхой учир шалтгааны улмаас хоёр дахь төсөлтэй холбоотой саналхийгээд, уг саналыг боловсруулагч бүлэглэлийг Богд хааны засгийн газар хүлээн зөвшөөрөөгүй болох нь түүхэнд нэгэнтээ тэмдэглэгдэн үлдсэн учир энэ төсөлтэй холбоотой асуудлыг энэ удаа орхин “Дальний восток” буюу “Алс дорнод” сэтгүүлийн 1913 оны 9 дүгээр сарын 36 дугаарт мэдээлсэн автономит Монголын Үндсэн хуулийн төсөлтэй холбоотой товч мэдээллийг “өдөөх төдий байдлаар”²⁸ дэлгэж байна.

²⁵ Дальний восток. Иркутск. 1913. 36. С.5-6.

²⁶ Supra 11. 288 дахь тал. Хуралд 15-16 төлөөлөгч Барга, Өвөр Монгол, Буриадаас оролцсон ба харин Монголын голомт Гадаад Монголоос нэг ч хүн байсангүй. Хурлаас Өвөр Монгол, Гадаад Монгол, Барга, Буриадыг нийлүүлсэн холбооны бүтэцтэй нэгдсэн Монгол Улс байгуулж байгааг зарлаж, Түр Засгийн газрыг Өвөр Монголын Нэйс гэгээнээр тэргүүлүүлэн буй болгов.

²⁷ Supra 12. 301 дэх тал

²⁸ Б.Чимид. Их Засгийн хуулийг эрэн сурвалжлах нь. “Их Засаг”-ийн эхийг эрэн сурвалжлах нь. Олон Улсын эрдэм шинжилгээний бага хурлын илтгэлийн эмхтгэл. Улаанбаатар. 2015. 21 дэх тал.

III. “Дальний Восток” сэтгүүлийн 1913 оны 36 дугаар дугаар дахь мэдээний тухайд

“Дальний восток” хэмээх энэхүү сэтгүүл нь тэр үеийн оросын болон зүүн Азийн улс орнуудын тогтмол хэвлэлд нийтлэгдсэн мэдээ, мэдээллийг түүвэрлэн сар бүр нийтэлдэг, Хаант Орос улсын Эрхүү мужийн цэргийн тойргоос эрхлэн гаргаж байсан тогтмол хэвлэл юм.

Энэхүү сэтгүүлийн 1913 оны 36 дугаар дугаарын “Монголиа” хэмээх нэгдүгээр хэсгийн эхний мэдээ нь “Слухи о будущей конституции автономной Монголии” буюу “Автономит Монголын ирээдүйн Үндсэн хуулийн талаарх сураг чимээ” гэсэн гарчигтай байх бөгөөд “Ост Ллойд”-д мэдээлснээр Өргөөгийн хутагтын зарлигаар Автономит Монголын Үндсэн хуулийг боловсруулжээ” хэмээн бичсэнээр энэхүү мэдээ эхлэх уг төслийн Богд хааны эрх хэмжээнд холбогдох 11 зүйлийг дараалуулан бичсэн байх аж.

Төслийн агуулгын тухай өгүүлэхээс өмнө Дальний восток сэтгүүлийн иш татсан эх сурвалжийн тухайд товч тэмдэглэхэд энэхүү “Ост Ллойд” хэмээх нь 1889 онд Шанхай хотноо үүсгэн байгуулагдсан, герман хэлээр хэвлэгдэн гардаг “Der Ostasiatische Lloyd” буюу “Зүүн азийн мэдээ” хэмээх өдөр тутмын сонин бөгөөд судлаач Хартмут Валпрэвенсийн тэмдэглэсэнчлэн энэ сонин нь тухайн цаг үед Хятад улсад герман хэл дээр гарч байсан цорын ганц бөгөөд хамгийн сайн мэдээллийн хэрэгсэл байжээ.²⁹

Der Ostasiatische Lloyd сонины 1913 оны 8 дугаар сарын дугаарт гарсан мэдээг үндэслэн Дальний восток сэтгүүлд гарсан энэхүү Автономит Монголын Үндсэн хуулийн төслийн Богд хааны эрх хэмжээнд холбогдох 11 зүйлийн агуулгыг товч сийрүүлбэл:

+

1/ Хутагтын угсаа – Монголыг мөнхөд захирах болно.

2/ Хутагтын бие - халдашгүй дархан.

3/ Хутагт нь парламентыг хуралдуулах, хаах, тараах эрхтэй.

4/ Хутагтын эрх мэдлээр Монголын бүх түшмэдийг томилно.

5/ Хутагт нь Монголын хуурай замын болон усан цэргийн хүчний ерөнхий командлагч мөн.

6/ Дайн зарлах, найрамдал тогтоох, гэрээ хэлэлцээр байгуулах болон дипломат албанд өөрчлөлт хийх тохиолдолд Орос Улсын саналыг урьдчилан авах шаардлагатай.

7/ Хутагт нь онцгой байдал тогтоох эрхтэй бөгөөд энэ талаар Орос улсад урьдчилан анхааруулна.

8/ Хутагт хэргэм цол олгож, өршөөл үзүүлнэ.

9/ Монгол дахь шүүн таслах үйл ажиллагаа тусгайлсан хуулийн дагуу явагдана.

10/ Монголын төрийн эрхийг баригчийн хангамжийн хэмжээг хутагт өөрийн үзэмжээр өөрөө тогтооно. Парламент энэ асуудалд оролцох ёсгүй.

11/ Хутагт парламентын дарга, дэд даргыг томилно гэсэн утгатай байна.

Энэ мэдээг үндэслэн түүхч Ж.Урангуа Богд Жавзундамба хутагтын эрхийг:

- Төрийн байгуулал, улсын хааны хэмжээгүй эрх мэдлийг баталгаажуулсан талаарх хутагтын бүрэн эрх,

- Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсыг батлан хамгаалах талаарх хутагтын бүрэн эрх,

- Гадаад харилцаа, олон улстай харилцах талаарх хутагтын бүрэн эрх,

- Дайн зарлах, найрамдал тогтоох, гэрээ хэлэлцээр тогтоох, дипломат албан өөрчлөлт хийх бүрэн

²⁹ H.Walravens. E.King. Newspapers In International Librar-
ianship: Papers presented by the Newspapers Section at
IFLA General Conferences. K.G. Saur. Munchen. 2003.P.90.

эрх гэсэн 4 хэсэгт хуваан авч үзэж болохоор байна³⁰

хэмээн дүгнэн энэ баримт нь зөвхөн төслийн хэмжээнд байсан байж болох юм учир нь эл үеийн эрх зүйн гол эх сурвалж болох “Зарлигаар тогтоосон Монгол Улсын хууль зүйн бичиг” болон “Жинхэнэ дагаж явах хууль дүрэм”-д Хутагтын бүрэн эрхийг үндсэндээ тогтоож өгөөгүй байдаг амуй хэмээн тэмдэглэжээ.

IV. Автономит Монголын Үндсэн хуулийн төслийн талаарх мэдээтэй холбоотой санал, сэдэмж

Судлаачийн зүгээс, эл үеийн Монгол Улс угсаа залгамжилдаг хүчтэй эзэн хаантай, парламентын бүгд найрамдах улсын зарим нэгэн үзэл санааг авсан Европ маягийн гэж хэлж болох засаглалын хэлбэрийг сонгож байгуулах чиг хандлага бүхий байсан³¹ гэх судлаачдын дүгнэлтийг үндэслэн Богд хаант Монголын Үндсэн хуулийн төслийн энэхүү 11 зүйлийг тухайн цаг үеийн монгол эрдэмтдийн туурвисан судалгааны бүтээл болон Америк, Европын зэрэг өрнийн хөгжингүй улсуудын “Үндсэн хууль”, бусад холбогдох эх сурвалжийг судлахыг даалгасан Богд хаанаас буулгасан зарлигийн хүрээнд хийгдсэн Англи, Америк, Норвеги, Япон зэрэг орнуудын Үндсэн хуулийг орчуулж эмхтгэсэн “Олон улсын үндсэн хуулийн оршил” нэрт бүтээлтэй харгуулан үзсэний үндсэн дээр тус 11 зүйл нь агуулгын хувьд 1889 оны Эзэн хаант Япон Улсын

Үндсэн хууль³² дахь эзэн хааны эрх хэмжээ болон эзэн хаан, парламент хоорондын харилцааны эрх зүйн асуудлыг тусгасан “Эзэн хаан” хэмээх I бүлгийн агуулгатай үндсэндээ дүйж байгаа нь сонирхол татаж байна.

Харьцуулалт.

Автономит Монголын Үндсэн хуулийн төслийн Богд хааны эрх хэмжээнд холбогдох 11 зүйл	1889 оны Эзэн хаант Япон Улсын Үндсэн хуулийн албан ёсны англи орчуулга ¹	Олон улсын үндсэн хуулийн оршил” нэрт бүтээл дэх Япон улсын Үндсэн хуулийн орчуулга
1/ Хутагтын угсаа – Монголыг мөнхөд захирах болно.	Article 1. The Empire of Japan shall be reigned over and governed by a line of Emperors unbroken for ages eternal.	1 зүйл. Японы их улсыг императорын угсааны императоруудаар тасралтгүй залгамжлан үүрд захирваас зохимуй.
2/ Хутагтын бие - халдашгүй дархан.	Article 3. The Emperor is sacred and inviolable.	3 зүйл. Императорын бие болбоос ариун бөгөөд халдаж үл болмой.
3/ Хутагт нь парламентыг хуралдуулах, хаах, тараах эрхтэй.	Article 7. The Emperor convokes the Imperial Diet, opens, closes and prorogues it, and dissolves the House of Representatives.	7 зүйл. Император улсын хурлыг зарламуй, нээмуй, хаамуй, хойшлуулмуй бас төлөөлөгчдийн хурлыг тараамуй.

³² K. Zweigert. H. Kotz, An Introduction to Comparative Law. 3rd edn. Oxford University press. New York. 1998. P.297. Пруссийн Үндсэн хуулийн загварт суурилсан энэхүү хуулиар Япон улс нь Үндсэн хуульд хаант засаглал бүхий улс болсон бөгөөд шийдвэр гаргах бүх эрхийг эзэн хаан эдлэх хэдий ч хүн амын 2 орчим хувийг эзэлж байсан чинээлэг иргэдийн эдлэх сонгуулийн эрхийн дүнд байгуулагдсан парламентын доод танхим болон угсаа залгамжилсан, эзэн хаанаас сайшаагдсан язгууртнаас бүрдэх дээд танхим хууль тогтоох эрхийг хэрэгжүүлэхээр хуульчилсан байдаг.

³⁰ Ж.Урангуа. Богд Жавзандамба хутагтын эрхийн тухай өгүүлэх нь. Associatum Millitarum Historicorum Mongoli Khar Suld. Tomus IV. Fasciculus 7. 58-59 дэх тал.

³¹ Supra 5. 109 дэх тал.

4/ Хутагтын эрх мэдлээр Монголын бүх түшмэдийг томилно.	Article 10. The Emperor determines the organization of the different branches of the administration, and salaries of all civil and military officers, and appoints and dismisses the same. Exceptions especially provided for in the present Constitution or in other laws, shall be in accordance with the respective provisions (bearing thereon).	10 зүйл. Императороос засгийн олон зүйлийн албан газруудыг зохион байгуулах, бичиг цэргийн албаны хүмүүсийн цалин хэрэглэлийг хэмжээ тогтоохуй ба байлгах эрх буй агууд гагцхүү энэ Үндсэн хуулийн ёсоор буюу бусад зүйлийн хууль ёсоор онц ялгаварласан нь буй аваас энэ зүйлд хамаарахгүй.	9/ Монгол дахь шүүн таслах үйл ажиллагаа тусгайлсан хуулийн дагуу явагдана.	Article 57. The Judicature shall be exercised by the Courts of Law according to law, in the name of the Emperor. (2) The organization of the Courts of Law shall be determined by law.	57 зүйл. Загра шийтгэх эрх баригчдыг албадан явуулахуйд Императорын нэрээр явуулж, загра шийтгэхүйн тухай тогтоосон хууль цаазыг журмлан дагамуй. Загра шийтгэх газруудыг хэрхэн байгуулах явдлыг тусгаар хуулинд тодорхойлон заажээ.
5/ Хутагт нь Монголын хуурай замын болон усан цэргийн хүчний ерөнхий командлагч мөн.	Article 11. The Emperor has the supreme command of the Army and Navy.	11 зүйл. Хуурай ба усан замын цэргүүдийг захирах дээд эрхүүд нь императорт буй.	10/ Монголын төрийн эрхийг баригчийн хангамжийн хэмжээг хутагт өөрийн үзэмжээр өөрөө тогтооно. Парламент энэ асуудалд оролцох ёсгүй.	Article 66. The expenditures of the Imperial House shall be defrayed every year out of the National Treasury, according to the present fixed amount for the same, and shall not require the consent thereto of the Imperial Diet, except in case an increase thereof is found necessary.	66 зүйл. Императорын өвгийн зарцуулах зүйлийг тухайд нэгэнт тогтоосон тоо ёсоор улсын сан хадгалах газар шууд тавин олгож байваас зохимуй. Хэрэв уг тогтоосон тооноос үл хэтрэх бөгөөс энэхүү дурдсан тоот мөнгийг гаргуулахуйд улсын хуралдаанаас зөвшөөрөл эрх хэрэггүй.
6/ Дайн зарлах, найрамдал тогтоох, гэрээ хэлэлцээр байгуулах болон дипломат албанд өөрчлөлт хийх тохиолдолд Орос Улсын саналыг урьдчилан авах шаардлагатай.	Article 13. The Emperor declares war, makes peace, and concludes treaties.	13 зүйл. Гадаад лугаа байлдахуйг олонд зарлах ба эвлэх найрамдах хийгээд гэрээ болзоо тогтоох явдлыг император өөрөө эрхлэн мэдмуй.		Article 67. Those already fixed expenditures based by the Constitution upon the powers appertaining to the Emperor, and such expenditures as may have arisen by the effect of law, or that appertain to the legal obligations of the Government, shall be neither rejected nor reduced by the Imperial Diet, without the concurrence of the Government.	67 зүйл. Нэгэнт тогтоосон ба эсхүл Үндсэн хуулийн ёсоор Императорын шууд мэдэх зарцуулах зүйлүүд ба Засгийн газраас хууль ёсоор хүлээж авсан ба эсхүл нэгэнт зарласан хуулийг дагаж зарцуулах зүйлүүд буй аваас Засгийн газраас зөвшөөрөлгүйгээр улсын хуралдаанаар халж, хасч болохгүй.
7/ Хутагт нь онцгой байдал тогтоох эрхтэй бөгөөд энэ талаар Орос улсад урьдчилан анхааруулна.	Article 14. The Emperor proclaims the law of siege. (2) The conditions and effects of the law of siege shall be determined by law.	14 зүйл. Императороос туйлын боогдолтой, түгшүүртэй цагийн байдлыг зарлах эрхтэй бөгөөд ийнхүү боогдолтой бүхүй цагийн үүсгэл, төгсгөлийг тусгай хуулинд заажээ.			
8/ Хутагт хэргэм цол олгож, өршөөл үзнэ.	Article 15. The Emperor confers titles of nobility, rank, orders and other marks of honor.	15 зүйл. Императороос тайж угсааны хэргэм ба зэрэг хийгээд эрдэнийн од зэргийн гавьяа тэмдгийг шагнан олгомуй.			

11/ Хутагт парламентын дарга, дэд даргыг томилно	Article 34. The House of Peers shall, in accordance with the Ordinance concerning the House of Peers, be composed of the members of the Imperial Family, of the orders of nobility, and of those persons, who have been nominated thereto by the Emperor.	34 зүйл. Угсаатны хуралд болбоос тухайд тогтоосон дүрмийн ёсоор императорын овогтны гишүүд ба тайж угсаатны гишүүд ба мөн императорын зарлигаар тушаагдсан хүмүүс суулцмуй. /10 зүйлийг үз./
--	---	---

Энэхүү харьцуулалтыг давхар батлах мэт Богд хаан 1914 оны II сард “улс төрийн аливаа хүнд хэргийг бүгдээр нийлж шүүмжлэн хэлэлцэж олны бодлогыг нийлүүлэх”³³ зорилгоор засгийн газрын дэргэд Европын орнуудын парламент (сенат) маягтай зөвлөх эрх бүхий улсын хурлыг байгуулсан бөгөөд хэдийгээр энэхүү хурлын ...эрх мэдэл тодорхойгүй өргөн, ... захирамж, хуулийн төсөл боловсруулахын хамт цаг үеийн асуудлыг хэлэлцэн зөвлөмжийн шинжтэй санал гаргах боловч Богд гэгээн төлөөлөгчдийн байгууллагуудын тогтоолуудыг голдуу баталдаг байсан³⁴ гэх мэдээ, 1914 онд бичигдсэн Ж.Цэвээний “Улсын эрх” бүтээлд Европын олон улсуудын төрийн тэргүүн нар парламентыг зарлан хуралдуулах, тараах, төрийн дээд цол, одон медаль, хэргэм зэргийг олгож, өршөөл уучлал үзүүлэх эрхтэй байсан талаар дурдсан байдаг хийгээд Цахар сайдын зөвлөн хэлэлцэх түшмэл Дандаа хэмээх Дэмчигдоржийн 1914 оны 5 дугаар сарын 14-ны өдөр Их

Хурлын сайд түшмэдэд барьсан “Түшмэл Дандаагийн улс төрийг засах гурван зүйлийн ёсны тухай өргөсөн бичиг”-т “...нарийвчлан шинжилбээс олон улсын хууль дотор гагцхүү Жи Би / Япон/ улсын хууль болбоос олон улсын хуулийн бичгийн нарийн нууц газрыг бүрнээ хураангуйлан багтаасан мэт тул тийнхүү энэ гурван зүйлийн хуулийн бичгийг хавсарч нийлүүлэн дундадыг барьж тогтоох болбоос сая алдагдал үгүй болмуй за”³⁵ хэмээн бичиж байсан зэрэг баримт нь тухайн цаг үед монголын эрдэмтэн мэргэд, ихэс дээдэс өрнийн эрх зүйн сэтгэлгээний ази тив дэх тусгал болсон Эзэн хаант Япон улсын Үндсэн хуулийн талаар хангалттай мэдээлэл, мэдлэгтэй байж, “авах гээхийн ухаанаар” асуудалд хандаж, үндэсний онцлогтой Үндсэн хуулийн төслийг боловсруулсан байх бүрэн боломжтойг илтгэн харуулж байна.

Гэвч түүхэн нөхцөл, шалтгааны улмаас энэ бүх таамаглал бодит амьдралд биеллээ олоогүй, энэхүү төслийн монгол эх бидэнд олдоогүй байгаа ч энэ мэт түүхэн баримт, мэдээ сэлтийг ул үндэстэй мөшгөн судалж, “бий” гэсэн итгэл найдвар, “олох гэсэн эрмэлзэл” –ээр ...түүхийн нуранги дотроос Богд хаант Монголын Үндсэн хуулийн “анхны” байж болох нэгэн төслийг бүрэн эхээр нь олох боломж байсаар байгаа юм биш биз гэсэн бодлын үүднээс эрдэмтэн судлаач, эх түүхээ сонирхогч хэн бүхэнд зориулан энэхүү сэдэмж бичгийг тэрлэв.

³³ Улсын хурлын газрыг байгуулахыг хүсч айлтгасныг Богд хаан зөвшөөрөн цохсон бичиг. Монгол Улсын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. II боть. Улаанбаатар. 2010. 110 дахь тал.

³⁴ Supra 12. 321 дахь тал.

³⁵ Дэлгэрэнгүйг Ч.Дэмчигдорж. Шинэ засгийн гол ёс. Эрх зүйт ёс сан. Улаанбаатар. 2015. 156 дахь тал.

ОРЧИН ҮЕИЙН КРИМИНАЛИСТИКИЙН НӨХЦӨЛ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭНИЙ ЧИГ ХАНДЛАГА, ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн
багш Б.Баяр

ТҮЛХҮҮР ҮГС

“Криминалистикийн нөхцөл байдлын шинжилгээ - ситуационная (ситуалогическая) экспертиза” адилтгалын болон оношилгоо зүйн шинжилгээ, дагнасан, хамтарсан, иж бүрэн шинжилгээ, тусгай шинжилгээ. Хэргийн газрын үзлэг. (Криминалистическая ситуационная экспертиза места происшествия.)

ТОВЧ АГУУЛГА

Манай улсын Шүүх шинжилгээний байгууллага нь үндсэн чиг үүргийнхээ дагуу хууль хяналтын байгууллагуудаас ирүүлсэн криминалистикийн болон бусад шинжилгээ хийлгэх тухай тогтоолыг үндэслэн тухайн гэмт хэргийг шинжлэх ухааны ололт амжилтын үндэслэл дээр тулгуурлан нотлон илрүүлэхийн тулд нотлох ажиллагааг шинжээчийн өмнө тавигдсан асуултын дагуу өөрийн эзэмшсэн мэдлэг

мэргэжил дээрээ тулгуурлан шинжлэн тогтоохдоо адилтгалын болон адилтгалын бус шинжилгээг хийдэг ч шинжилгээний чанар, стандартад орчин үеийн дэвшилтэд техникийн технологийн ололт амжилтуудыг ашиглан шинжилгээндээ ашиглах, шинжилгээний шинэ төрлүүдийг нэвтрүүлэх, шинжилгээний өөр бусад шинжлэх ухааны байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгохтой холбоотой тулгамдсан асуудлууд оршсоор байна.

Гэмт хэргийг бодитойгоор илрүүлэх, мөрдөн шалгах ажиллагаа явуулах хуульд заасан журмын дагуу цуглуулж, бэхжүүлсэн аливаа баримтат мэдээллүүдийг батлах эсхүл үгүйсгэх шаардлага аливаа гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны явцад зайлшгүй тулгардаг.

Эдгээр асуудлыг шийдвэрлэхэд орчин үед “криминалистикийн нөхцөл байдлын шинжилгээ” чухал үүрэгтэй. Энэ шинжилгээний төрөл криминалистикийн шинжлэх ухаанд төдийлөн судлагдаагүй ч эрдэмтэн судлаачдын анхаарлыг аль хэдийнээ татаж эхэлжээ.

“Криминалистикийн нөхцөл байдлын шинжилгээ /ситуационная (ситуалогическая) экспертиза/” гэсэн нэр томъёог ОХУ-ын эрдэмтэн Г.Л.Грановский¹ одоогоос 30-аад

¹ Грановский Г.Л.Криминалистическая ситуационная экспертиза места происшествия //Г.Л.Грановский // Рефераты науч.сообщений на теор.семинаре-Криминалистических чтениях 21 апреля 1977 г.ВНИИСЗ,1977.Вып 16.С.3-16.

жилийн өмнө криминалистикийн шинжлэх ухаанд анх оруулж ирсэн байдаг юм.

Манай орны шүүхийн шинжилгээний байгууллага болон эрдэмтэн судлаачид криминалистикийн нөхцөл байдлын шинжилгээний агуулга, мөн чанарын асуудлыг хангалттай хэмжээгээр авч хэлэлцсэн суурь судалгаа өнөө хир хийгдээгүй байна.

Өнөөдөр гадаадын зарим оронд жишээлбэл ялангуяа “ОХУ-ын шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч эмч нарын дунд нөхцөл байдлын шинжилгээг онолын хувьд ухамсарлах оролдлогыг хийж байгаа ч судалгааны үр дүнгээ хараахан өгөөгүй байна” гэж зарим эх сурвалжид дурдсан байна.

Криминалистикийн нөхцөл байдлын шинжилгээний ойлголт, аргачлал, үе шат, шинжлэх онцлогийн талаар дорвитой асуудал криминалистикийн шинжлэх ухаанд хангалттай хөгжиж, тайлбарлагдаагүй байгаа нь өнөөдөр хуульч, эрдэмтэн судлаачдын анхаарлыг татсаар байна.

Энэ талаар ОХУ-ын криминалистикийн нэрт эрдэмтэн Н.П.Майлис “Өнөөг хүртэл “Криминалистикийн нөхцөл байдлын шинжилгээ”-ний төрөл түүний эзлэх байр суурь, шийдвэрлэх зорилтууд болон ашиглагдах арга барилуудын асуудал зөвхөн хэлэлцүүлгийн түвшинд байсаар байна” гэж онцлон тэмдэглэсэн байдаг.³

Ийнхүү ОХУ-д уг нэр томъёог криминалистикийн шинжлэх ухааны ном, бүтээлд төдийгүй практикт харьцангуй саяхнаас буюу 2000 оноос

эхлэн⁴ хэрэглэх болсон⁵ нь бидний хийсэн судалгаанаас харагдаж байна. Дийлэнх эрдэмтэд, судлаачдын үзэж буйгаар нөхцөл байдлын шинжилгээ нь шүүх шинжилгээний нэг төрөл бөгөөд түүнийг шүүхийн практикт зайлшгүй хэрэглэх шаардлагатайг онцлон тэмдэглэсэн байдаг.

ҮНДСЭН ХЭСЭГ

Нөхцөл байдлын шинжилгээг уламжлалт адилтгалын болон оношилгоо зүйн шинжилгээнүүдээс / бичиг судлалын, мөр судлалын, зэвсэг судлалын гм/ бүтэц тогтолцоогоор ялгагдах хэдий ч эдгээрийн хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарлыг хамтатган авч үзэх шаардлагатай бөгөөд энэ утгаараа иж бүрэн шинжилгээ, эсхүл тусгай мэдлэг шаардагдаж байвал тусгай шинжилгээ гэж үзэж тусгайлан ангилж болох юм.⁶

Харин нөхцөл байдлын шинжилгээний тогтолцоо бүрдүүлэгч зарчмаараа адилтгалын, оношилгооны, ангилалтын тогтоодог харилцаа холбооны шинж чанараараа эсвэл шийддэг зориулалтуудаасаа ялгаатай байдаг. Нөхцөл байдлын шинжилгээг нь болж өнгөрсөн үйл явдлын бодит дүр зураглалыг сэргээх зорилгоор гэмт хэрэг үйлдэгдсэн газрын нөхцөл байдал, түүнд үүссэн ул мөрийн цогцолбор байдаг⁷.

⁴ Г. Л. Грановский, 1965; Р. С. Белкин, 1986; В. Ю. Владимиров, 1995.

⁵ 2000 оны 11 сарын 30-нд ОХУ-ын хууль зүйн яамны №363 тогтоолоор ОХУ-ын хууль зүйн яамны шүүх шинжилгээний байгууллагуудад хийгдэж буй шинжилгээг адилтгалын болон адилтгалын бус шинжилгээ гэж салангид төрөл гэж тодорхойлсон байдаг

⁶ Примерный Перечень видов экспертиз, выполняемых в судебно-экспертных учреждениях Министерства юстиции Российской Федерации : приказ Министерства юстиции Российской Федерации от 30 ноября 2000 г.№363 .[Электронный ресурс] Режим доступа: <http://www.businesspravo.ru/Docum/ DocumShow-DocumID-14924.html>.

⁷ Балашов Д. Н. Криминалистика : учебник / Д. Н. Балашов, Н. М. Балашов, С. В. Маликов. М. ИНФРА-М. 2005. С.479.

² Попов В. Л. Судебно-медицинская баллистика. / В. Л. Попов, В. Б. Шигеев, Л. Е. Кузнецов. СПб. : Гиппократ, 2002. С.522.

³ Майлис Н. П. О функциях общей теории судебной экспертизы и о ситуационной экспертизе / Н. П. Майлис // Вестн. криминалистики / отв. ред. А. Г. Филиппов. М. : Спарк, 2009. Вып. 1 (29).

Үнэхээр нөхцөл байдлын шинжилгээ нь өөрийн мөн чанараараа хамтарсан шинжилгээтэй төстэй байдаг. Энэ нь өөрийн мөн чанар, зүй тогтлоороо хамтарсан шинжилгээтэй төстэй ч тэдгээрийн хооронд томоохон ялгаа бий.

Тухайлбал: Хамтарсан шинжилгээ хийгдэх үед мэргэжил тус бүрийн шинжээчид тусгай мэдлэгийнхээ хүрээнд үндэслэн судалгаа хийж, шинжээчийн өмнө тавигдсан асуултад хариулт өгч ерөнхий дүгнэлтэд хүрдэг.

Харин нөхцөл байдлын шинжилгээ нь шинжээчийн тусгай мэдлэгээс гадна эсхүл түүнээс үл хамааран хэргийн газрын бүх эд зүйл, ул мөр үүсэх зүй тогтол, тухайн нөхцөл байдлыг орчин үеийн техник технологийн дэвшлүүдийг ашиглан сэргээн тогтоож улмаар ерөнхий дүгнэлтийг томьёолдог.⁸

Дээр дурдсан нөхцөл байдлын шинжилгээг болсон үйл явдлыг сэргээн тогтоох, түүнд нөлөөлсөн бүхий л үйл баримтуудыг хэлхээ холбоонд нь хамтатган авч үзэх, шинжилгээний зорилго, чиг үүргээс хамаараад адилтгалын, оношилгооны болон ангиллын шинжилгээ хэмээн ангилж болох юм⁹. Нөхцөл байдлын шинжилгээ нь болж өнгөрсөн үйл явдалтай холбоотой хувилбаруудыг батлах эсвэл үгүйсгэх гэсэн үндсэн зорилготой байдаг¹⁰.

Түүнчлэн хууль зүйн үр дагавар бүхий гэмт үйлдэлийн механизмыг бүхэлд нь эсвэл түүний элементүүдийг тогтоон илрүүлэхэд анхаарах шаардлагатай юм.

⁸ Бордюгов Л. Г. Интегративный характер ситуалогической экспертизы // Л. Г. Бордюгов /Теория та практика судебной экспертизы и криминалистики : зб.наук. праць./ Право, 2009. Вип. 9. С. 207.

⁹ Винберг А. И. Судебная экспертиология (Общетеоретические и методологические проблемы судебных экспертиз) : учеб. пособ. / А. И. Винберг, Н. Т. Малаховская ; отв. ред. Б. А. Виктор. Волгоград: ВСШ МВД СССР 1979. С. 155–169.

¹⁰ Драпкин Л. Я. Значение судебно-медицинской экспертизы в системе раскрытия и расследования преступлений / Л. Я. Драпкин, П. П. Грицаенко // Рос. юрид. журнал/ 2006. № 1, С. 141.

Нөхцөл байдлын шинжилгээний объект нь тухайн гэмт хэрэг үйлдэгдсэн нөхцөл байдал түүнийг нотлон тогтоосон гол нотлох баримтуудын шинж байдлуудыг цогц байдлаар хоорондын уялдаа холбоо, харилцан хамааралд нь судлах ажиллагаа мөн¹¹.

Үүнээс дүгнэж үзэхэд криминалистикийн нөхцөл байдлын шинжилгээг дараахь байдлаар тодорхойлж болох юм.

- Гэмт хэргийн механизмыг ул мөрөөр

- Нөхцөл байдлын шинж тэмдгүүдээр нь эдгээрийг цогц байдлаар нь судлах шүүх шинжилгээний өвөрмөц төрөл мөн.

Нөхцөл байдлын шинжилгээг тодорхой төрлийн гэмт хэрэг дээр тухайлбал: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг /Эрүүгийн хуулийн тусгай ангийн 27 дугаар бүлэг/ тээврийн хэрэгслийг жолоодож яваа этгээд Хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон түүнд нийцэж гарсан замын хөдөлгөөний дүрмийн ямар заалт, хэсгийг хэрхэн зөрчсөн асуудлаар замын шинжээч, мөн жолоодож явсан тээврийн хэрэгслийн ашиглалтын байдлыг хангасан, бүрэн бүтэн эсэхэд авто техникийн шинжээч мэргэжилтэн, эдгээрийг зөрчсөний улмаас хохирогчид ямар гэмтэл учирсан эсхүл хохирогч нас барсан талаар шүүх эмнэлгийн шинжээч эмч тус тус дүгнэлт гаргаж хэргийг шийдвэрлэдэг. Харин уг гэмт хэрэгт замын нөхцөл байдал эвдрэл гэмтэл, стандарт шаардлагыг хангаагүй замыг барьсан, халтиргаа гулгаа, гэрэлтүүлэг гэх мэт орчны бодит нөхцөлүүд нөлөөлсөн эсэх дээр “нөхцөл байдлын шинжилгээг” хийж ингэснээр гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэх болон хохирогчид гэмтэл учруулах

¹¹ Энэ талаар Г.Л.Грановский “Криминалистикийн шинжээч, мэргэжилтнүүд шинжилгээний объектод хандах хандлагаа бүхэлд нь өөрчлөх шаардлагатай” онцлон тэмдэглэж байсныг дурьдах нь зүйтэй.

зэрэг шалтгаан нөхцөлийг үнэн зөв бодитойгоор тогтоосноор гэм буруутай этгээдэд шударгаар ял шийтгэл оногдуулах нөхцөлийг бүрдүүлэх юм.

Энэ бүхнийг зөвхөн ганц жолоочид хамааруулж шийтгэж буй нь хүний эрхийг зөрчиж гэм буруутай хэн нэг нь ял завших боломжийг бүрдүүлж байна.

Гадаадын хөгжингүй зарим оронд /АНУ, ОХУ, Япон г.м/ эхлээд нэгдүгээрт шалтгаан нөхцөлийг буюу дээрх тохиолдолд шаардлага хангаагүй зам барьж ашиглалтанд оруулсан, зураг төслийг дур мэдэн өөрчилснөөс үүдэн осол гарсныг нөхцөл байдлын шинжилгээгээр давхар тогтоож ял хариуцлага оногдуулдаг, жолооч гагцхүү замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн үйлдэлдээ хариуцлага хүлээлгэдэг.

Энэхүү тогтолцоог манайд эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудад тусгах шаардлагатай. Энэ мэт олон хэрэг дээр жишээлэн тэмдэглэж болох юм.

Нөхцөл байдлын шинжилгээг хийхэд нотлох баримтууд болон ул мөрийн шинж тэмдгүүдийн цогцыг зүгээр л нэг нийлбэр эсхүл конгломератын хувьд биш харин бүрэн цогц тогтолцооны зүй тогтлоор авч үзэх ёстой.

Тогтолцооны ерөнхий онолыг үндэслэгчдийн нэг болох Л.Фон Берталани¹² тогтолцоо /систем/-г "харилцан үйлчлэгч бүрэлдэхүүний цогц эсхүл өөр хоорондоо болон орчинтойгоо тодорхой харилцаанд оршдог эмх цэгц бүхий элементүүдийн нийлбэр" гэж тодорхойлжээ.

Орчин үеийн криминалистикийн шинжлэх ухаанд тогтолцоо /систем/-н

ойлголтыг эрдэмтэд, судлаачид дараахь байдлаар тодорхойлсон байна.

1.Өөр хоорондоо уялдаа холбоо бүхий бөгөөд эдгээр нь нэгдэн нийлж бүхлийг бүрдүүлдэг элементүүдийн олонлог¹³

2.Урьдаас тодорхойлогдсон шинж чанарууд бүхий өөр хоорондоо харилцан уялдсан олон объект¹⁴

3.Систем нь шинэ элементийг бий болгох, өөрчлөх, хасах зэрэг тодорхой үйл ажиллагааны нийлбэр¹⁵

4.Нотлох баримтуудын цогц бөгөөд эдгээр объектуудын харилцан үйлчлэл нь интегратив шинэ чанаруудыг үүсгэх явдлыг буй болгодог¹⁶ гэсэн тодорхойлолтуудыг өгчээ.

Тогтолцоо нь тодорхойлогч элементээс бүрдэх бөгөөд тэдгээр нь хоорондоо уялдаа холбоотой байхын зэрэгцээ субстанц байдлаар солилцож байдаг.

Энэхүү систем тогтолцооны талаар дурдахын гол утга учир нь нөхцөл байдлын шинжилгээг цогцоор хийх аль нэг асуудалд илүү ач холбогдол өгөх бус тодорхойлогч бүхий элементүүдийг харилцан уялдаа холбоонд нь авч үзэхийг чухалчилдгийг дурдах нь зүйтэй.

Өөрөөр хэлбэл аливаа хэрэг маргааныг олон талаас нь тал бүрээр нотлон тогтоох, ганц нэг дүгнэлт гаргаад орхих бус уг дүгнэлтийг өөр бусад ямар нэг шинжилгээгээр давхар, эсхүл нэгэнт гарсан шинжилгээг үгүйсгэх өөр ямар шинжилгээ байж болохыг нотлох зэрэгт нөхцөл байдлын шинжилгээ чухал ач холбогдолтойг харуулж байна.

¹³ Садовский В. Н. Основания общей теории систем. /логико-методологический анализ/ М: Наука, 1974. хуудас. 77–106

¹⁴ Уемов А. И. Системный подход и общая теория систем. М: Мысль, 1978. С.103–118.

¹⁵ Топоров В. Н. Из области теоретической топониматики / В. Н. Топоров /Вопросы языкознания/. 1962. № 6, С. 9–10.

¹⁶ Афанасьев В. Г./ О целостных системах / В. Г. Афанасьев Вопр. философии. 1980. № 6. С. 66.

¹² Bertalanffy L. von. General System Theory – A Critical Review / L. von Bertalanffy // General Systems.1962. Vol. VII. P. 1–20; Берталани Л. фон. Общая теория систем – критический обзор / Л. фон Берталани; перев. Н. С. Юлиной [Электронный ресурс]. — Режим доступа : <http://www.evolbiol.ru/bertalanfi.htm>; Берталани Л. фон. История и статус общей теории систем / Л. фон Берталани /Системные исследования/ М. Наука, 1973. хуудас 29.

Дээрхээс үзэхэд нөхцөл байдлын шинжилгээний объектын мөн чанар нь харилцан холбоо бүхий олон элементүүдийн нийлбэр бөгөөд тэдгээр нь харилцан үйлчлэлд орохдоо шинэ системийн мөн чанарыг төрүүлдэг. Нэг үгээр хэлбэл судлагдаж байгаа объектуудын бүрэн цогц байдал түүний хэсгүүдийн онцлог шинж тэмдгүүдийн уялдаа холбоо, харилцан үйлчлэлийн улмаас шинэ системийг бүрдүүлж улмаар хэргийг бодитойгоор үнэн зөв шийдвэрлэх боломж бүрдүүлнэ гэсэн үг юм.

Тухайн гэмт хэрэгт авагдсан нотлох баримтуудад дүн шинжилгээ хийхдээ тэдгээрийн дотоод, гадаад шинж, харилцан хамаарал, ерөнхий болон хувийн онцлог шинж тэмдгүүдийг тодорхойлох шаардлагатай бөгөөд өөрөөр хэлбэл судлагдаж буй объектууд хүрээлэн буй орчинтойгоо хэрхэн уялдаж, харилцан үйлчилж байгааг тогтооход анхаарлаа хандуулах ёстой.

Иймээс нөхцөл байдлын шинжилгээг үр дүнтэй явуулах боломжгүй болж улмаар хүнийг хилсээр шийтгэх эсхүл ял завшуулах боломж бүрдэх юм.

Тухайлбал: Санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдаж хүнийг санаатай алах /ЭХТА.10.2 дугаар зүйл/ гэмт хэргийг ангилан зүйлчлэхэд уг гэмт хэргийн объектив, субъектив шинжийг бодитойгоор тогтооход нөхцөл байдлын шинжилгээ чухал үүрэгтэй. Тодруулбал гэмт этгээдийн санаа сэтгэл гэнэт хүчтэй цочрон давчдсан субъектив онцгой нөхцөл байдлыг объектив бодит шалтгаан нөхцөлтэй уялдаатайгаар авч үзэх шаардлагатай.

Уг зүйлээр хэргийг шийдвэрлэж буй шүүхийн практикийг судлан үзэхэд ихэнх гэмт хэрэгт зөвхөн хэрэгт авагдсан хохирогчийн буруутай үйлдлийг нотолсон нотлох баримтад ач холбогдол өгч мөрдөн байцаагч, прокурор, шүүгчид дотоод итгэлээр үнэлж улмаар шүүх ял хариуцлага хүлээлгэж байна.

Өөрөөр хэлбэл гэмт этгээд аффектын нөхцөлд хүнийг санаатай алсан эсэхэд дүгнэлт хийлгүйгээр зөвхөн объектив шинж буюу хохирогчид хүчээр дарлагдсан, хүндээр доромжлогдсоны улмаас өөрт нь эсхүл ойр дотны хүнд хүнд хор уршиг учирсан, учрах байсан нөхцөлийг гол шалгуур болгон хэргийг шийдвэрлэж байгаа нь учир дутагдалтай. Уг гэмт хэргийн хувьд субъектив заавал байх шинж нь тухайн зүйлийн диспозицид хууль тогтоогчийн тодорхойлсноор “гэмт этгээдийн санаа сэтгэл нь гэнэт хүчтэй цочрон давчдсан байх шинж” буюу аффектэд орсныг тодорхойлох явдал юм.

Энэ нь мэргэжлийн шинжээчийн дүгнэлтээр тогтоогдох бөгөөд нөхцөл байдлын шинжилгээгээр объектив, субъективийн шинжүүдийн уялдаа холбоо, харилцан үйлчлэл, өөр бусад нөхцөл байдлуудыг тодруулан тогтоож хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Дээр дурдсан шинэ системийг бүрдүүлэгч элементэд

-гэмт үйлдэл, түүнээс үүссэн ул мөр

-гэмт хэрэг үйлдэгдсэн газар орон, цаг хугацаатай ул мөр тохирч буй эсэх

-уг гэмт хэрэгт нэгэнт хийгдсэн шинжилгээ дүгнэлтүүд өөр хоорондоо нийцэж буй эсэх эдгээрийг уялдуулж холбох зэрэг ажиллагаа орох юм.

Ийнхүү нөхцөл байдлын шинжилгээгээр тухайн хэрэгт дэвшүүлсэн сэжиг таамаглалд тулгуурлан тухайн нөхцөл байдлыг тодорхойлохдоо бодит нөхцөл байдлын эд зүйлсийн мөн чанар, үйл явдлын механизмын тогтолцоог тал бүрээс нь судалж тогтоох бөгөөд эцэст нь

а/ тухайн тохиолдол байж болно

б/ байх боломжгүй

в/ байх боломжтой байсан

гэсэн асуудлуудыг шийдвэрлэж дүгнэлт гаргана. Жишээ нь: тухайн

хэрэгт зөвхөн мөр үүсэх зүй тогтлоос гадна мөр хүлээн авагчийн гадаргууд үүссэн ул мөрийг судалж шинжилснээр мөр үүсэхээс өмнөх объектын бодит байдлыг тогтооход нөхцөл байдлын шинжилгээ ашиг тустай.

Нөхцөл байдлын шинжилгээг явуулахад “бодит нөхцөл байдлыг” зөв тодорхойлохоос эхлэх ёстой. Бодит нөхцөл байдал гэдгийг хэрхэн тодорхойлж болох талаар авч үзвэл:

- Бодит нөхцөл байдлын хамгийн гол шинж чанар конкретность буюу тодорхой байдал юм. Өөрөөр хэлбэл бодит нөхцөл байдал нь цаг хугацаа болон орон зайн тодорхой нөхцөлд оршин байдаг. Жишээ нь: маш богино хугацаанд тодорхой орон зайг хамарсан байх / жишээ нь зам тээврийн осол хэдхэн секундйн дотор л болж өнгөрдөг/

- Дахин давтагдах боломжгүй. Гэхдээ ерөнхий зүй тогтлоороо аль ч талаараа дахин давтагдах шинж чанартай үзэгдэл үйл явдал байж болдог.

- Бүх бодит нөхцөл байдалд зайлшгүй байх зүйл бол цаг хугацаа, орон зайн асуудал юм. Бодит нөхцөл байдалд болж өнгөрсөн цаг хугацааг бүхлээр эсхүл хэсэг хэсгээр салган авч тодорхойлж болох бөгөөд тухайн цаг хугацааны аль хэсэгт уг үйлдэл хийгдсэнийг уялдаатайгаар авч үзэх явдал.

- Бодит байдалд тухайн субъектийн шийдвэр, өөрийн үзэл бодол, хүмүүжил, мэдлэг боловсролоос гадна биологийн болон сэтгэл зүйн байдал хэрхэн нөлөөлснийг зөв тодорхойлох шаардлагатай.

Бодит байдал хэчнээн нарийн төвөгтэй байх тусам энэхүү бодит байдлыг буй болгосон өөр хоорондоо уялдаа холбоотой шалтаг шалтгаанууд төдийчинээ төвөгтэй байна гэсэн үг. Товчхондоо гэмт хэрэг үйлдэнэ гэдэг нь гадаад шалтгаануудаас гадна дотоод

чанаруудын харилцан үйлчлэлийн үр дүн байдаг.

Ийнхүү нөхцөл байдлын шинжилгээгээр гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнөх бодит байдал, үйлдэгдэх үеийн бодит байдал, үйлдэгдсэний дараахь бодит байдлуудыг нягт уялдаа холбоотойгоор хэрхэн бие биенийхээ үргэлжлэл болсныг нарийвчлан тогтоосноор шинжилгээ үр дүнтэй үнэн зөв болох боломжийг бүрдүүлнэ. Харин шинжилгээний явцад гэмт хэрэг үйлдэгдэхээс өмнөх бодит нөхцөл байдлаас кирминогений буюу гэмт хэрэг үйлдэгдэх хамгийн тохиромжтой бодит нөхцөл байдал аль нь болохыг зөв тогтоож ингэснээр шинжлэх ухааны үндэслэлтэй үнэн зөв дүгнэлт гарах үндэслэл болох юм.

Орчин үед гадаадын хөгжингүй орнууд зохион байгуулалттай гэмт хэрэг, террорист халдлага зэрэгт төдийгүй үйлдвэрлэл, техникийн осол, сүйрлийн газарт криминалистикийн шинжээчид нөхцөл байдлын шинжилгээний арга зүйг өргөн ашиглаж байгаа нь гадаадын орнуудын практик туршлагаас харагдаж байна.

ДҮГНЭЛТ

Эцэст нь дүгнэхэд тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, эрх зүйн үндэслэлтэйгээр хэрэгт зүйлчлэл хийх, улмаар хүний эрхийг зөрчихгүй, ял завшуулахгүй байх өөрөөр хэлбэл шүүхээс үнэн зөв бодитой шийдвэр гарахад шинжлэх ухааны мэдлэгт тулгуурлан нөхцөл байдлын шинжилгээ хийх нь чухал ач холбогдолтой юм.

Криминалистикийн шинжлэх ухаанд шинээр нэвтэрч буй энэхүү шинэлэг судлагдахууныг манай улс саяхан батлагдсан эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуультай уялдуулан шүүхийн практикт өргөн хэрэглэх шаардлага зүй ёсоор тулгарч буйг тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Иймээс орчин үеийн криминалистикийн шинжлэх ухаанд нэвтэрч буй шинэлэг судлагдахуун болох “Криминалистикийн нөхцөл байдлын шинжилгээг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусган шүүхийн практикт өргөн хэрэглэхдээ орчин үеийн техникийн технологийн ололт амжилтуудыг ашиглан программын¹⁷ тусламжтайгаар хэргийн

газрыг нөхцөл байдлыг дүрслэн зураглал /схем/ үйлдэх, мөн түүн дээр түшиглэн /ялангуяа авто осол, хүн амь г.м/ бодит нөхцөл байдалд шинжилгээ хийхдээ байгаль, техникийн нарийн мэргэшсэн шинжээчдээр бүрдсэн лабораториудыг байгуулснаар нөхцөл байдлын шинжилгээгээр объектив, субъективийн шинжүүдийн уялдаа холбоо, харилцан үйлчлэл, өөр бусад нөхцөл байдлуудыг тодруулан тогтоож хэргийг үнэн зөвөөр шийдвэрлэх боломж бүрдэх юм гэсэн саналыг дэвшүүлж байна.

¹⁷ Гэмт хэргийн газрыг дүрслэн үзүүлэхдээ Reconstruction, SceneVision-3D, 3D- Crime Scene Mapping программыг хөгжингүй орнууд ашиглаж эхэлжээ.

---o0o---

“WWW.E-KHUTUCH.MN” ЦАХИМ ХУУДАСНЫ ТАНИЛЦУУЛГА, ТУРШИЛТ, СУДАЛГААНЫ АЖЛЫГ ХЭНТИЙ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧИД, ИРГЭДИЙГ ХАМРУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛЛАА



2018 оны 6 дугаар сарын 21, 22-ны өдрүүдэд Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн “www.e-khutuch.mn” цахим сангийн ажлын албаныхан “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн агуулга, хөтөлбөрийн хүрээнд хийхээр төлөвлөж буй ажил болон “www.e-khutuch.mn” цахим хуудасны танилцуулгыг Хэнтий аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг, байгууллагын төлөөлөл 40 төрийн албан хаагчдад хүргэж, тэдний санал, зөвлөмж, асуулгыг хуудсаар хүлээн авав.

Хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл, сурталчилгааны цахим сан “www.e-khutuch.mn” ашиглалтын явцыг туршиж үзэх, хэрэглэгчдийн сэтгэгдлийг сонсох, цаашид сайжруулах ажлын зорилгоор аймгийн 80 иргэнийг хамруулан тодорхой цагийн хуваарьтайгаар тусгайлан бэлтгэсэн төвийн интернет орчин бүхий танхим, компьютеруудад суулгаж “www.e-khutuch.mn” цахим хуудсаар зочлуулж хэрэглэгчдийн санал, сэтгэгдлийг ярилцлагын аргаар болон санал, асуулгыг хуудсаар авах ажлыг хийв.

ТАРИФ ХУДАЛДААНЫ ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭРИЙН ХҮРЭЭНД БҮС НУТГИЙН ХУДАЛДААНЫ ХЭЛЭЛЦЭЭРИЙГ БАЙГУУЛАХ АСУУДАЛ



МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш
Э. Туулайхүү (LL.M)

ТҮЛХҮҮР ҮГ

Бүс нутгийн худалдааны хэлэлцээр, Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн XXIV дүгээр зүйл, олон талт худалдааны систем, Үндэсний нэн таатай дэглэм, гаалийн нэгдэл, чөлөөт худалдааны бүс

ТОВЧЛОЛ

Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)-ийн XXIV зүйлд зааснаар Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын гишүүн орнуудад зөвхөн байгуулсан улсууд өөр хоорондоо илүү хөнгөлөлттэй нөхцөлөөр харилцан худалдаа эрхлэх боломжийг бий болгодог бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг байгуулахыг зөвшөөрдөг. Гол асуудал нь энэ төрлийн хэлэлцээрийн хэлэлцэн тохирогч ДХБ-ын гишүүд өөр хоорондоо олгож байгаа хөнгөлттэй дэглэмийг тухайн бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн гишүүн бус ДХБ-ын бусад гишүүнд олгох үүрэг хүлээдэггүй. Үүний улмаас ДХБ-

ын нэг гишүүн нь бусад ДХБ-ын гишүүн улсад олгосон худалдааны таатай дэглэмийг бусад бүх ДХБ-ын гишүүнд нөхцөлгүйгээр олгоно гэсэн Үндэсний нэн таатай дэглэмийн суурь үзэл санаа хөндөгддөг. Бүс нутгийн худалдааны хэлэлцээр өсөн нэмэгдэхийн хэрээр уг асуудал улам бүр олон талт худалдааны системд учруулах эрсдэл дагуулах болсон. Энэхүү судалгаанд ДХБ-ын эрх зүйн үүднээс бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг ойлгох хандлага, ДХБ-ын олон талт худалдааны системийн үл ялгаварлах гол зарчмын нэг болох Үндэсний нэн таатай дэглэмд бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн үзүүлэх нөлөөлөл, тус хэлэлцээрийг ТХЕХ-ийн XXIV дүгээр зүйлийн хүрээнд байгуулахад тавигдах шаардлагыг тусгайлан шинжлэн судлав

УДИРТГАЛ

Бүс нутгийн худалдааны хэлэлцээр байгуулах явдал 1990-ээд оны эхнээс эрчимжиж эхэлсэн бөгөөд одоогийн байдлаар Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын гишүүн улс бүр доод тал нь нэг ийм хэлэлцээртэй байна.¹ Монгол Улс нь Япон улстай 2015 онд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр байгуулж энэ тухайгаа албан ёсоор 2016 оны 6 дугаар сард ДХБ-д мэдэгдсэнээр энэ төрлийн эдийн засгийн интеграцид нэгдсэн ДХБ-ын сүүлийн гишүүн улс болсон. Манай орон цаашид бусад олон оронтой бүс нутгийн худалдааны хэлэлцээр байгуулах сонирхолтой байгаа бөгөөд одоогоор Бүгд Найрамдах Солонгос улстай байгуулах асуудлаар яриа

¹ Энэ тухай https://www.wto.org/english/news_e/news16_e/ta_02jun16_e.htm цахим холбоосоор нэвтэрч үзнэ үү.

хэлэлцээ хийгдэж эхлээд байна. Иймээс манай улсад бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг ДХБ-ын эрх зүйн хүрээнд хэрхэн ойлгож, тайлбарлах асуудлыг нарийвчлан судлаж эрдэм шинжилгээний эргэлтэд оруулах шаардлагатай юм. Энэхүү судалгааны өгүүллийн хүрээнд ДХБ-ын барааны худалдааг зохицуулсан гол хэлэлцээр болох Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр (ТХЕХ)-ийн хүрээнд бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг байгуулах асуудлыг товч авч үзэх болно. Судалгааны эхний хэсэгт бүс нутгийн худалдааны хэлэлцээр гэх нэр томъёоны агуулгыг, удаах хэсэгт ДХБ-ын олон талт худалдааны системийн үл ялгаварлах гол зарчмын нэг болох Үндэсний нэн таатай дэглэмд бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн үзүүлэх нөлөөллийг, гуравдугаар хэсэгт бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг ТХЕХ-ийн XXIV дүгээр зүйлийн хүрээнд байгуулахад тавигдах шаардлагыг тус тус судлав. Судалгаанд ДХБ-ын маргаан шийдвэрлэх байгууллагад гарсан хэд хэдэн маргаантай холбоотойгоор ТХЕХ-ийн XXIV дүгээр зүйлийг тайлбарлахад учирч буй бэрхшээлийн асуудлыг дурдаагүй бөгөөд энэ асуудлыг тусгайлан судлах шаардлагатай гэж үзсэн болно.²

I. Бүс нутгийн худалдааны хэлэлцээр гэх нэр томъёоны тухайд

ДХБ-ын байгууллагын гэрээ хэлэлцээрт “Бүс нутгийн худалдааны хэлэлцээр (Regional Trade Agreement)” гэх нэр томъёог хэрэглээгүй боловч тус байгууллагаас гаргаж буй тайлан, мэдээ, судалгаа зэрэгт тус нэр томъёог хэрэглэдэг.³ Мөн ДХБ-ын дэргэд

Бүс нутгийн худалдааны хэлэлцээр хариуцсан хороо (The Committee on Regional Trade Agreements) ажилладаг бөгөөд тус хороо нь ДХБ-ын гишүүдээс ТХЕХ-ийн XXIV дүгээр зүйл болон Үйлчилгээний худалдааны ерөнхий хэлэлцээрийн V дугаар зүйлийн дагуу байгуулж байгаа худалдааны хэлэлцээрийн ил тод байдал, олон талт худалдааны системд үзүүлэх нөлөөллийг хянан зохицуулах чиг үүргийг гүйцэтгэдэг.⁴

Газар зүйн хувьд ойр, хөрш зэргэлдээ оршдог, нэг бүс нутгийн улс орнуудын хооронд байгуулагдах үзэгдэл байснаас ийнхүү нэрийдэж эхэлсэн. Үүнд жишээлбэл Хойд Америкийн Чөлөөт худалдааны хэлэлцээр (North American Free Trade Agreement), АСЕАН-ы Чөлөөт худалдааны бүс (ASEAN Free Trade Area), Өмнөдийн Нийтлэг зах зээл (Southern Common Market/MERCOSUR) зэргийг дурдаж болох юм.⁵

Гэхдээ сүүлийн жилүүдэд газар зүйн хувьд өөр өөр бүсийн орнууд энэ төрлийн хэлэлцээрийг ихээр байгуулах болжээ. Тухайлбал Европын Холбоо—Өмнөд Солонгос хоорондын Чөлөөт худалдааны хэлэлцээр (European Union—South Korea Free Trade Agreement), Энэтхэг—МЕРКОСУР-ын Давуу эрхтэй худалдааны гэрээ (India—MERCOSUR Preferential Trade Agreement) зэргийг нэрлэж болно. Мөн “мега” гэх тодотголтой, ялгаатай бүс нутгийн улсуудыг эгнээндээ нэгтгэсэн худалдааны хэлэлцээрүүдийг байгуулах яриа хэлэлцээ явагдаж байна. Жишээлбэл Транс Номхон далайн түншлэлийн хэлэлцээр (The Agreement on Trans-Pacific Partnership (TPP)), Транс Атлантын Худалдаа, хөрөнгө оруулалтын түншлэлийн хэлэлцээр

² Энэхүү эрдэм шинжилгээний өгүүлэл нь судлаачийн бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн эрх зүйн асуудлаар хэвлүүлж буй хоёр дахь судалгааны бүтээл бөгөөд цаашид тухайн чиглэлээр хэд хэдэн судалгааны өгүүлэл, нэг сэдэвт бүтээл гаргахаар төлөвлөөд байгаа болно.

³ Rohini Ancharia (ed.), *Regional Trade Agreements and the Multilateral Trading System* (Cambridge: Cambridge University Press, 2016), P. 230-291

⁴ Дэлгэрэнгүй мэдээллийг https://www.wto.org/english/tra-top_e/region_e/regcom_e.htm цахим холбоосоор нэвтэрч үзнэ үү.

⁵ Peter Van den Bossche and Werner Zdouc, *The Law and Policy of the World Trade Organization: Cases and Materials* (Cambridge: Cambridge University Press, 2013), P. 671-672

(The Transatlantic Trade and Investment Partnership Agreement (TTIP)), Эдийн засаг, худалдааны хэлэлцээр (The Comprehensive Economic and Trade Agreement (CETA)) гэх мэт. Үүнтэй холбоогоор “Бүс нутгийн худалдааны хэлэлцээр” хэмээх нэр томъёоны зохистой эсэх асуудал яригдах болсон. Гэвч ДХБ энэ нэр томъёог нэг газар зүйн бүсийн болон өөр өөр бүсийн улсуудын хооронд байгуулагдаж байгаа чөлөөт худалдааны бүс, гаалийн нэгдлийг аль алиныг нэрлэхэд хэрэглэсэн хэвээр байна.⁶

II. Бүс нутгийн худалдааны хэлэлцээр ба Үндэсний нэн таатай дэглэм (Most-favored nation treatment)

Дэлхийн худалдааны байгууллагын эрх зүйгээр ДХБ-ын гишүүн орнууд өөр хоорондоо чөлөөт худалдааны бүс (free trade area), гаалийн нэгдэл (customs union) байгуулах замаар бүс нутгийн худалдааны хэлэлцээр байгуулахыг зөвшөөрдөг.⁷ Энэ нь 2 буюу хэд хэдэн хэлэлцэн тохирогч талаас бүрдэх худалдааны гэрээ бөгөөд зөвхөн байгуулсан улсууд өөр хоорондоо хөнгөлөлттэй нөхцөлөөр худалдаа эрхлэх боломжийг бий болгодгийн хувьд ДХБ-ын олон талт худалдааны системийн үл ялгаварлах зарчим болох Үндэсний нэн таатай дэглэм (Most-favored nation treatment)-д харшилдаг.⁸ Учир нь бүс нутгийн худалдааны хэлэлцэн тохирогч талууд өөрсдөдөө олгож байгаа хөнгөлөлттэй дэглэмийг тухайн бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн хэлэлцэн тохирогч тал бус ДХБ-ын бусад гишүүнд олгох үүрэг

хүлээдэггүйн хувьд энд ДХБ-ын гишүүн нь аливаа улсад олгосон худалдааны таатай нөхцөлийг бусад бүх ДХБ-ын гишүүнд нөхцөлгүйгээр олгоно гэсэн Үндэсний нэн таатай дэглэмийн суурь үзэл санаа хөндөгддөг.⁹ ДХБ-ыг байгуулах тухай Марракешийн хэлэлцээр болон ДХБ-ын барааны худалдааны олон талт үндсэн гэрээ болох ТХЕХ-т зааснаар “олон улсын худалдаанд ялгаварлах явдлыг арилгах нь олон талт худалдааны системийн гол зорилт”¹⁰ бөгөөд энэхүү зорилтыг хангах үүднээс Үндэсний нэн таатай дэглэм нь дээрх агуулгыг илэрхийлдэг. ТХЕХ-ийн XXIV дүгээр зүйлд заасан тодорхой урьдчилсан нөхцөлийн үндсэн дээр бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг Үндэсний нэн таатай дэглэмийн дүрмийн бус тохиолдол байдлаар хүлээн зөвшөөрснийг энд дурдах нь зүйтэй юм. Судалгааны дараагийн хэсэгт энэ тухай тайлбарлана.

III. Бүс нутгийн худалдааны хэлэлцээр ба Тариф худалдааны ерөнхий хэлэлцээрийн XXIV зүйл

ТХЕХ-ийн XXIV дүгээр зүйлд чөлөөт худалдааны бүс (free trade area), гаалийн нэгдэл (customs union) гэсэн 2 төрлийн бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг зохицуулсан. Энэ хэсэгт тус зүйл дэх зохицуулалтыг авч үзье.

Гаалийн нэгдэл, чөлөөт худалдааны бүс нь хэлэлцэн тохирогч талуудын хоорондын худалдааг дэмжихийн зэрэгцээ хэлэлцэн тохирогч бус талтай хийх худалдаанд учрах саадыг өсгөхгүй.¹¹ Бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн мөн чанар нь ялгаварлах шинжтэй (хэлэлцээрт хамаарах талуудад худалдааны хөнгөлөлттэй дэглэм олгох хэдий ч

⁶ Ibid.

⁷ ТХЕХ-ийн XXIV зүйлийг үзнэ үү.

⁸ Robert E. Hudec and James D. Southwick, “Regionalism and WTO Rules: Problems in the Fine Art of Discriminating Fairly”, in M. Rodriguez Mendoza, P. Low and B. Kotschwar (eds.), Trade Rules in the Making: Challenges in Regional and Multilateral Negotiations (Washington DC, OAS: Brookings, 1999), P. 49

⁹ ТХЕХ-ийн I дүгээр зүйлийг үзнэ үү.

¹⁰ Дэлхийн худалдааны байгууллагыг байгуулах тухай Марракешийн хэлэлцээрийн болон ТХЕХ-ийн оршил хэсэг

¹¹ ТХЕХ, XXIV зүйл, 4 дэх хэсэг

хэлэлцээрийн гадна орших улсад ийнхүү олгодоггүй гэдэг утгаараа) нь хувьд энд дурдсан 2 дахь нөхцөлийг зэрэг хангах боломжгүй гэж тайлбарлах нь бий.¹²

XXIV дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт тодорхойлсноор Гаалийн нэгдэл болон чөлөөт худалдааны бүс нь гаалийн татвар болон худалдаан дахь бусад хязгаарлалтыг гаалийн нэгдэлд оролцогч улсуудын хоорондох болон тухайн улсуудаас гарал үүсэлтэй бүтээгдэхүүний ("хангалттай" хэмжээний) худалдаа (substantially all the trade) -нд арилгасан 2 буюу хэд хэдэн гаалийн нутаг дэвсгэрийн нэгдэл юм. Худалдаан дахь бусад хязгаарлалт гэдэгт юуг ойлгох тухайд маргаантай. Эндээс харахад гаалийн нэгдэл болон чөлөөт худалдааны бүс байгуулж байгаа талуудын хувьд дотоод худалдаандаа баримтлах стандарт нь ижил болно.

Гаалийн нэгдлийн чөлөөт худалдааны бүсээс ялгагдах гол онцлог нь нэгдлийн гишүүдээс гуравдагч (гаалийн нэгдэлд үл хамаарах) улстай худалдаа хийхдээ нийтлэг ижил татвар, худалдааны бусад зохицуулалт хэрэглэхэд оршдог.¹³ Өөрөөр хэлбэл гадаад худалдаандаа эдийн засгийн хувьд нэг нэгж (a single economic unit) болно гэж үздэг. Үүнээс ялгаатай нь Чөлөөт худалдааны бүс байгуулж байгаа талууд хэлэлцээрийн тал биш улсуудтай хийх худалдаандаа тус тусдаа бие даан худалдааны татвар, бусад зохицуулалтаа хэрэгжүүлнэ.¹⁴ Ийнхүү гаалийн нэгдлийн хувьд

түүнийг байгуулж буй улсуудын бүрэн эрхэт байдал тодорхой хэмжээнд хөндөгддөг. Энэ шалтгаанаар өнөөгийн байдлаар ДХБ-д бүртгэгдээд буй Бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн 10 хүрэхгүй хувийг гаалийн нэгдэл эзэлдэг.¹⁵ Мөн гаалийн нэгдлийн тоо цөөн байгаа нь чөлөөт худалдааны бүстэй харьцуулахад өдөр түвшний эдийн засаг, худалдааны нэгдлийг илэрхийлдгийн хувьд ийнхүү байгуулах нь төвөгтэй хэмээн дүгнэдэгтэй холбоотой.

Ийнхүү ТХЕХ-ийн XXIV зүйлээр бүс нутгийн худалдааны хэлэлцээрийг байгуулахыг дээрх байдлаар зөвшөөрсөн боловч энэ нь ХХI зуун гарснаас хойш Үндэсний нэн таатай дэглэм үйлчлэхгүй байх тохиолдлуудаас хамгийн их маргаан дагуулах болсон. Энэ нь дараах учир шалтгаантай. Үүнд:

1. Бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн тоожил ирэх бүр нэмэгдэж байгаа хэдий ч ТХЕХ-ийн XXIV зүйлд нийцэж байгаа эсэх нь тодорхойгүй. ДХБ-ын Бүс нутгийн худалдааны хэлэлцээр хариуцсан хороо нь гишүүн орнуудын хооронд байгуулагдаж байгаа ийм төрлийн хэлэлцээрийг агуулгын талаас хянадаггүйгээс гадна Олон талт худалдааны системд бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн үзүүлэх үр дагавар болон бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн ил тод байдлыг хариуцсан ДХБ-ын Бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн хороо (The Committee on Regional Trade Agreements (CRTA)) энэ чиглэлд үр дүнтэй үйл ажиллагаа явуулж чадахгүй байна.

2. ТХЕХ-ийн XXIV зүйлд заасан урьдчилсан нөхцөл хэт ерөнхий бөгөөд түүнийг ДХБ-ын маргаан шийдвэрлэх байгууллага тодорхой тайлбарлаагүй байна. Үүний улмаас ийм төрлийн хэлэлцээрийн ДХБ-ын эрх зүйд нийцэж байгаа эсэх талаар судлаачдын дунд олон янзын үзэл бодол, байр суурь байдаг.

¹² Tuulaihuu Enkhee, A Legal Analysis on Article XXIV of the GATT from the Perspective of Non-Application of the WTO Safeguard Measures to Members of Regional Trade Agreements (Master Thesis), Nagoya University Graduate School of Law, 2017, P. 11

¹³ Peter Van den Bossche and Werner Zdouc, The Law and Policy of the World Trade Organization: Cases and Materials (Cambridge: Cambridge University Press, 2013), P. 680

¹⁴ Robert E. Hudec and James D. Southwick, "Regionalism and WTO Rules: Problems in the Fine Art of Discriminating Fairly", in M. Rodriguez Mendoza, P. Low and B. Kotschwar (eds.), Trade Rules in the Making: Challenges in Regional and Multilateral Negotiations (Washington DC, OAS: Brookings, 1999), P. 49

¹⁵ Дэлгэрэнгүйг <http://rtais.wto.org/UI/PublicAllIRTAList.aspx> цахим холбоосоор нэвтэрч үзнэ үү.

3. 2001 онд Катарын Доха хотод эхлүүлсэн ДХБ-ын олон улсын худалдааны яриа хэлэлцээ (Дохагийн үе шатны яриа хэлэлцээ гэж нэрлэдэг) амжилт олоогүй нь олон талт гэрээ хэлэлцээрээс цөөн тооны оролцогч бүхий бүс нутгийн худалдааны хэлэлцээр байгуулах нь илүү хялбар гэх хандлагыг ДХБ-ын гишүүдэд бий болгосон нь улмаар бүс нутгийн худалдааны хэлэлцээрийн огцом өсөлтийг түргэтгэх гол хүчин зүйл болсон байж болох талтай.

Эндээс ДХБ-ын бүх гишүүн доод тал нь нэг Бүс нутгийн худалдааны гэрээ байгуулаад байгаа (энэ тоо улам өсөх хандлагатай) нь ирээдүйд "Үндэсний нэн таатай дэглэм" -ийг бодит утгаар хэрэгжих боломжийг хязгаарлаж болзошгүй гэх асуудлыг үүсгэж, үүний үр дүнд олон талт худалдааны систем цаашид оршин тогтнох эсэх хүртэл асуудал яригдах болсон. Ийнхүү бүс нутгийн худалдааны хэлэлцээр нь ХХI дүгээр зууны олон улсын худалдааны эрх зүйн харилцаанд түгээмэл үзэгдэл болоод байна. Үүний зэрэгцээгээр ДХБ-ын эрх зүйгээр нэгэнт тодорхой урьдчилсан нөхцөл хангагдсаны үндсэн дээр Үндэсний нэн таатай дэглэм үйлчлэхгүй байх тохиолдол байдлаар зохицуулсан тул хэдийгээр бүс нутгийн худалдааны хэлэлцээр өсөн нэмэгдэж байгаа ч ТХЕХ-ийн XXIV дүгээр зүйлд нийцсэн эсэх нь тогтоогдож байж бодит

асуудал үүсгэнэ гэж үзэх нь ч бий¹⁶. Энэ хүрээнд бүс нутгийн худалдааны хэлэлцээр нь ТХЕХ-ийн XXIV дүгээр зүйлд заасан урьдчилсан нөхцөлийг хангах нь ихээхэн бэрхшээлтэй хэмээн тайлбарладаг.¹⁷

Дээрхээс дараах байдлаар дүгнэлт хийж болохоор байна.

1. ДХБ-ын өнөөгийн практикт бүс нутгийн худалдааны хэлэлцээр гэдэгт нэг газар зүйн төдийгүй өөр өөр газар зүйн бүсийн улсуудын хооронд байгуулагдаж байгаа худалдааны гэрээг ойлгож байгаа бөгөөд энэ нь ДХБ-ын үндсэн зарчмын нэг болох Үндэсний нэн таатай дэглэмийн дүрмийн бус тохиолдолд тооцогддог.

2. Ерөнхий дүрэм (Үндэсний нэн таатай дэглэм) үйлчлэхгүй байх тусгай тохиолдол байдлаар ТХЕХ-т анх оруулсан боловч ХХ дугаар зууны 2 дугаар хагасаас хойш ДХБ-ын гишүүд бүс нутгийн худалдааны гэрээ байгуулах явдал өсөн нэмэгдсэний дүнд бүс нутгийн худалдааны систем нь ДХБ-ын олон талт худалдааны системтэй зэрэгцэн орших болсон.

3. Ийнхүү зэрэгцэн орших болсноор олон талт худалдааны системийн суурь болсон Үндэсний нэн таатай дэглэмийн өргөн хүрээнд үйлчлэх боломжийг хязгаарлаж буй эсэх асуудал хөндөгдөж байна.

¹⁶ James H. Mathis, "The Legalization of GATT Article XXIV – Can Foes Become Friends?", in Kyle W. Bagwell and Petros C. Mavroidis, *Preferential Trade Agreements: A Law and Economic Analysis* (Cambridge: Cambridge University Press), P. 31-39

¹⁷ Ibid.

ЁС ЗҮЙ БА ХУУЛИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ



ШУА-ийн Философийн хүрээлэнгийн
Улс төр, эрх зүйн салбарын эрдэм
шинжилгээний дэд ажилтан
М.Долгорсүрэн

ТҮЛХҮҮР ҮГ

Ёс суртахуун, эрх зүй, хэм хэмжээ, нийгмийн үнэт зүйлс, уялдаа холбоо

ТОВЧЛОЛ

Энэхүү өгүүллээр ёс зүй ба хуулийн онолын үзэл баримтлал, ёс зүй ба хуулийн харилцан хамаарлыг судалж, хуулийг ёс зүйд үндэслэх, хүн хүнтэйгээ харьцах ёс зүй, хууль нийгмийн үнэт зүйлсийг амьдралд зөв ашиглах, зөв амьдрах, ёс зүйн үнэт чанарыг эзэмшүүлэх, нийгмийн харилцааны бүхий л хүрээнд мөрдөх хэм хэмжээг ухамсарлуулах, эрх зүйн үндсийг зөв тодорхойлох талаар санал дэвшүүлэхийг зорьсон.

I. ЁС ЗҮЙ БА ХУУЛИЙН ОНОЛЫН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Ёс гэдэг бол хүний өөрийн амьдралын “хууль” юм. Ёс зүй гэдэг нь нийгэм, хамт олон, бүлгийн баримтлах бичмэл болон бичмэл бус зан үйлийн хэм хэмжээ болно. Ёс зүй хэмээх

ойлголтыг Эртний Грекийн (ethos) гэдэг үгнээс гаралтай гэж үздэг бөгөөд харин Я.Цэвэлийн “Монгол хэлний тайлбар толь”-д “юмны зайлшгүй зүй тогтол жам тавилан” гэж тайлбарлажээ. Эрт үед ёс зүйг хожим нь бүхий л харилцааны үндэс шашин, үзэл суртлын тулгуур, төр, түмний шинж чанар болно гэж төсөөлөөгүй бизээ.

Ёс зүй нь угтаа хүмүүний сэтгэл дотор байдаг нэг ёсны бичигдээгүй хууль юм. Хүний ухамсарт ёс зүйтэй байх төрөлхийн шинж оршиж, хүн сайн байх ёстой нь түүний уураг тархин доторх нэг ёсны хууль юм. Ёс зүй нь “хүн хүний нийгэмд өөрийгөө зохицуулж, үйлийн агуулга, хэм хэмжээг тогтоох оюун сэтгэлийн чанар юм”. Хүний уураг тархинд ёс зүйн эрхэм чанар заавал оршдог байгалийн хууль байдаг. Аливаа хүний эрхэм чанар өөрөөр хэлбэл, шударга ёс, ичих эмээх сэтгэл, эр зориг, үүрэг хариуцлага, ёс жудаг, нинжин өрөвч сэтгэл, нэр төр, үнэн итгэл, найрсаг эелдэг зан, тэсвэр тэвчээр, өгөөмөр сэтгэл, үл шуналтах, өс хонзон, атаа жөтөө эс өвөрлөх зэрэг нь ёс зүйн дотоод хуулийн хэм хэмжээ юм. Ёс зүй нь хууль аливаа хүний сэтгэл дотор байдаг төрөлх шинж болохоос биш үүсмэл өгөгдөл огтхон ч биш. Тухайн хүн өөрийн ёс зүйн төлөвшлөө дагаж бусадтай харилцах энэ харилцааны онцлогийг бичигдээгүй хууль гэлцдэг².

Ёс зүйгээс хууль урган гардаг гэж үзэж болно. Европ тивд агуу Аристотель одоогоос 2500 жилийн өмнө бичихдээ

¹ Д.Бямбасүрэн. Орчлонгийн хүрд.(сэргэн мандахын гүн ухааны товчоо). УБ., 2000 он. 190 дэх тал

² Н.Цагаанхүү. Монгол түмний ёс зүй, ёс суртахууны тухай ойлголт. УБ., 2017 он. 9 дэх тал

“хууль нь сайн үйлийг л тогтоодог”³ хэмээн бичиж байжээ. Энэ нь хуулиар ёс зүйг хамгаалдаг болохыг хэлжээ. Тэрээр “Хууль тогтоогчид болбоос дадал зуршлынхаа дүнд сайн үйлийн тал руу нэгэнт хэлбийн одчихсон хүмүүс дагана хэмээн ойлгосны үндсэн дээр үлэмж сайны нэрийн өмнөөс тэднийг сайн үйл рүү уриалан шахах хэрэгтэй, харин дуулгаваргүй бөгөөд харьцангуй нуруу муутай хүмүүсийг залхааж, цээрлүүлж байвал зохино”⁴ хэмээсэн нь угтаа мөн чанар нь албадлага болсон хуулийн хүчээр ёс зүйг сахин хангуулах ёстой гэсэн санаа юм. Ёс зүйг гажуудуулвал хуулиар шийтгэх ёстой гэсэн санааг дэвшүүлжээ.

Хуулийн амин сүнс нь өндөр ёс зүй юм. Өндөр ёс зүйд шударга ёс, жудаг, эр зориг, үнэн, нэр төр, нинжин нигүүлсэнгүй сэтгэл эдгээр багтана. Манай УИХ-ын батлан гаргаж байгаа хуулиуд дандаа хэлбэрийн шинжтэй. Монголын нийгэмд энэ олон хуулиуд уг нь шударга ёсыг тогтоочих цаг болсон. Нөгөө талаас хуулийг тогтоогчид, хуулийг хэрэглэгчид, хуульчид өөрсдөө ёс зүйгүй байна. Тиймээс хуулиас яаж тойрч гарах уу, хуулийг яаж зөрчиж болох уу гэдэг талаас нь мөнгөн дээр үндэслээд асуудлыг шийддэг болсон учраас хууль нийгмийн амьдралд үзүүлэх бодитой жинхэнэ ёсны нөлөөгөө үзүүлж чадахаа больсон.

Монголын нийгмийг нэн түрүүнд ёс зүйтэй болгох ёстой. Чингис хааны Монголын эзэнт гүрэн бол хуулийг ёс зүйг хамгаалах, ёс зүйг ноцтой зөрчсөн бол хүлээлгэх ёстой шийтгэл, хариуцлагыг нь тооцдог байдлаар хэрэглэж ирсэн. УИХ-аас нийт ард түмэн, мэргэжлийн хүмүүсийн оролцоотойгоор монголчуудын ёс зүйг хэвийн болгох үндэсний хөтөлбөрийг хэлэлцэж батлаад, тэрийгээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Хоёр хөрш маань ёс зүйг дээд зэргээр төлөвшүүлж байна. Жишээ нь, БНХАУ өөрийнхөө уламжлалдаа Күнзийн ёс зүйн номлолт тулгуурлаад төрийн бодлогын хэмжээнд хүргэж, төрийн үзэл баримтлал болгож чадсан. ОХУ сүүлийн 20 гаруй жил бүх салбартаа ёс зүйг маш өндөрт өргөж, соён гэгээрүүлэх, танин мэдүүлэх олон талтай арга хэмжээг нийгмийн бүх хүрээнд зохион байгуулж чадсан. Монголын нийгэмд төрийн бодлогын үзэл баримтлал нь эх орон ард түмнийхээ эрх ашгийн төлөө хүчин зүтгэх, ард түмнээ аз жаргалтай сэтгэл тэнүүн амьдруулах ийм нөхцөлийг бий болгох ёстой. Хүнийхээ ёс зүйг ариусгаж улс орон хөгжинө⁵.

Орчин үеийн төрөлх хуулийн сэтгэлгээнд жинтэй хувь нэмэр оруулсан хүн бол Лон Фуллер (1902-1978 он) юм. Тэрээр эртний үеийн натурал хуулийн үзэл санааг гаргагчидтай санал нэгдэж, харин ХҮИ-ХҮИИ зууны үеийн рационалист хуулиас татгалзсан байна. Түүний авч үзсэн гол санаанууд нь Аристотельтай нэн төсөөтэй нь ажиглагддаг. Фуллер төрөл бүрийн натурал хуулиудын “овог, аймгийн ялгааг” онцгойлон авч үзээд энэ бүхэн нийгмийн дэг журмын тухай асуудал хэмээн үзсэн байна. Тэрээр натурал хуулийн бүх онолд ёс зүйн шинэ зүйл гарч ирэх нь нийгмийн нэгэн үзэгдэл ба янз бүрийн ижил зорилго бүхий хүмүүс зорилго нь улам бүр боловсронгуй болохын хэрээр түүнд хүрэх шинэ зорилгууд тодорхойлогдох үед энэ нь илэрнэ гээд төрөлх хуулийн хамгийн гол зарчим нь хууль дэг журмын шалтгааныг авч үзэх явдал хэмээжээ. Фуллер дээрх үзлээс гадна хуульд хамгийн өргөн хэмжээнд мөрдөгддөг зарчмын талаар авч үзсэн. Эдгээр нь: “Хүний зорилго бий болгох үйл явцыг эрүүл саруул байлга”, “Хүмүүсийн хоорондын харилцааны сувгийг нээлттэй байлга” гэсэн зарчмууд болно. Хожим нь тэрээр жам ёсны хуулийн

³ Аристотель. Никомахын ёс зүй. 319 дэх тал. УБ., 2008 он.

⁴ С.Нарангэрэл. Чингис хааны сүр хүч. УБ., 2013 он. 227 дахь тал

⁵ <http://itoim.mn.2018.5.11>

цорын ганц, үл маргахуйц төвлөрсөн зарчмыг дэвшүүлсэн. Тэрээр хүний харилцаана дахь “зөв дэг журам”-ын об’ектив тодорхойлолт гаргасан гэдгийг дурдахад илүүдэхгүй. Зарим асуудалд учир шалтгааны зарчмыг гаргасан нь хүний мөн чанартай холбоотой. Фуллер хууль зүйн зарчим болон ёс зүйн үнэ цэн хоёрын хоорондох холбоог Германы социологч Симмелийн үзэлд тулгуурлан авч үзсэн байна. Фуллерийн үзснээр боловсруулсан хууль нь хангалттай ерөнхий, олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, дэвшилттэй, тодорхой, ухаалаг, төрөл бүрийн эсэргүүцэлгүй, цаг хугацааны хувьд тогтвортой, боломжгүй зүйлс шаарддаггүй, хүмүүсд хүлээн зөвшөөрсөн үг хэллэгтэй байх ёстой. Эдгээр зарчмуудыг тэрээр хуулийн “дотоод ёс зүй” хэмээн нэрлэжээ. Эдгээр зарчмуудыг дотоод гэж үзэх шалтгаан нь хуулийн үзэл баримтлалыг бүхэлд нь тусгасанд орших ажээ. Үүнийг мөн “ёс зүйн” гэж хэлж болно. Учир нь, энэ нь албан ёсоор мөрдөх үнэлгээний стандартыг тогтоон өгч байгаа юм. Хуулийн аливаа систем дээрх зарчим нөхцөлийн зарим нэгийг нь хангахгүй байвал ямар үр дүн үүсэх вэ? Фуллерийн үзэж байгаагаар хуулийн дотор зөрчил бий болно. Нөгөөтээгүүр эдгээр зарчмын аль нэг нь үгүйсгэгдвэл тухайн хуулийг хууль гэх боломжгүй болно.

Хууль тогтоохдоо хуулийн “дотоод ёс зүйн”-ны зарчмыг үл харгалзвал дараахь алдаа гарч болох аюултай. Юуны өмнө хамгийн энгийн бөгөөд ойлгомжтой алдаа нь маргаантай асуудал бүхнийг тухай бүрт нь шийднэ гэсэн нь хууль, дүрэм, журам бий болгох үндсэн зорилго шууд алдагдахад хүрсэн⁶.

Ази тивд суут Күнз одоогоос 2500 жилийн өмнө “өөрийн бие шударгуу байваас зарлиг эс буулгасан ч хэрэг бүтэюү, өөрийн бие шударгуу бус байваас зарлиг хэдий буулгавч эгэл ард

эс дагаюу”⁷ хэмээсэн байна. Эдгээрээс үзэхэд Европ тивд Аристотель, Ази тивд Күнз нар манай эринээс өмнө ойролцоо цаг хугацааны үед хууль ба ёс зүй хоёрын ёс зүй нь анхдагч гэсэн санааг дэвшүүлж байсан нь харагдана.

Монгол ардын цэцэн үгэнд “хуулиас хүн эмээдэг, чононоос хонь үргэдэг”⁸ хэмээн зүйрлэл байдаг. Эдгээрээс үзэхэд хууль бол ёс зүйг сайн дураараа биелүүлэхгүй зөрчиж буй этгээдийг төрийн албадлагын хэрэгслээр албадан биелүүлдэг болгох хэрэглүүр болох нь тодорхой байна. Хууль хүнийг хүн хэвээр нь тогтоон барьдаг төрийн албадлагын хэрэглүүр ажээ. “Түмэнд ёс бий, төрд хууль бий” гэсэн монгол ардын мэргэн үг бас үүнийг л хэлсэн болов уу.

Тэмүжин их хаан сууринд өргөмжлөгдсөнөөс хойш түүний гаргасан шийдэл болгон хууль болж чадсан. Чингис хааны Их Засаг хууль нь гол төлөв Чингис хааны тушаал, сургаал үг, зарлиг, айлдвар, цэргийн сахилга зэргийг тэмдэглэн дэвтэрлэж уламжилсан зүйл юм⁹. Чингис хаан энэ бүгдийг сэтгэл хөдлөлөөрөө дур зоргоор гаргаагүй. Түүний уураг тархинд заяамал байсан ёс зүйн эрхэм чанарт тулгуурлан гаргажээ. Энэ бол шударга ёс, үүрэг ба хариуцлага, жудаг, нинжин нигүүлсэхүй сэтгэл, үнэн, итгэл, эв эе зэрэг байсан юм. Ёс зүйн эрхэм чанарыг хүн бүр адилхан ойлгодог учраас түүнд тулгуурласан хууль нь тэдэнд хэрэгтэй гэдэг үүднээс хүмүүс өөриймсгөөр хүлээн авдаг. Эзэн Чингис хааны хүмүүний ёс зүйд тулгуурласан шударга хуульд заасан бүхнийг Монголчууд төдийгүй дэлхий дахин бишрэн дагажээ. Чингис хаан “хуучин үгийг хууль болго” хэмээн айлдсан нь ард олны өдөр тутмын амьдралаар гарцаагүй болох нь маргахын аргагүй

⁷ Күнз. Шүүмжлэл, өгүүлэл. УБ., 2013 он.124 дэх тал.

⁸ Монгол ардын зүйр цэцэн үгийн гурван мянган дээж. УБ., 1999 он.158 дахь тал

⁹ Чингис хааны товчоон. 394 дэх тал

⁶ <https://www.coursehero.com>. 2018.5.11

батлагдсан ёс суртахууны хэм хэмжээнд үндэслэн хуулиа гарга гэсэн нэн гайхамшигт санааг илэрхийлжээ¹⁰.

“Их засаг” хуульд ёс зүйн эрхэм чанар суурь нь болсон зүйл, заалт цөөнгүй байна. Тухайлбал, “баян ядуу ба эрхэм доордоор ялгаж үл болмой, өтгөсийг хүндэлж, ядуучуудыг тэтгэх хэрэгтэй, мэргэд ба бясалгагчдыг хүндлэх хэрэгтэй, үл харгис, үнэнч шударга, чигч журамтай, эрдэм гүн, билиг хурц хүмүүсийг эрхбиш сайшаан хүндлэх хэрэгтэй бөгөөд зусар харгис ба элбэрэл журамгүй этгээдийг жигшин занах хэрэгтэй” гэсэн нь ёс зүйн эрхэм чанарт суурилсан хууль тогтоох үйл ажиллагааг хийж байсан.¹¹ Их эзэн Чингис хаан ёс суртахуунд суурилсан Их засаг хуулийг дагаж мөрдүүлж, хүн ардыг ирээдүйдээ итгэлтэй, аз жаргалтай, амар жимэр аж төрөх аятай нөхцөлийг бүрдүүлж өгчээ.

Чингис хааны ёс зүй, засаг хуулийг өөрчлөлгүйгээр сахивал тэр гүрэнд мөнх тэнгэрээс аврал бууж, хэзээ ямагт баяр баясгалантай, аз жаргалтай байх болно гэж Рашид-ад-дин бичсэн нь ийм л нөхцөлд хүн төрөлхтөн аз жаргал дүүрэн, амар жимэр аж төрнө гэсэн гайхамшигтай санаа байна. Хаана ёс зүй өндөр байна тэр улс оронд ард түмэн нь аз жаргалтай амьдардаг. Бүшидо¹² ёсонд суурилсан япон ард түмний ёс зүй буюу шударга ёс, туйлын ажилсаг хөдөлмөрч чанар, хатуужил тэвчээр, нинжин, өрөвч сэтгэл, эелдэг зан, нэр төрөө эрхэмлэх, сэтгэлийн хөөрлөө нууж ил гаргадаггүй чанар...энэ бүхэн нь Япон улсыг дэлхийн шинжлэх ухаан, технологийн тэргүүлэгч гүрэн болгосон.

Ёс зүйд суурилсан дэлхий ертөнц хүн төрөлхтөнд чухлаар шаардагдсаар байгаа өнөө үед Чингис хааны үлдээсэн ёс зүйг үнэлж баршгүй том өв юм.

Ертөнцөд Байгалийн хууль (жам), Нийгмийн хууль (дүрэм, журам), Ёс суртахууны (ухамсар, оюунаар) хууль гэсэн гурван Үндсэн хууль үйлчилж байдаг гэж сэтгэгчид үзжээ.

Эрх зүй, ёс зүй нь онолч И.Бентам жам ёсны эрх ба мэдрэмжийн ёс зүйг шүүмжилсэн “Хууль тогтоомж ба ёс суртахууны удиртгал” бүтээлдээ ёс зүйн уг сурвалж, үндсийг амьдрал дотроос олж тайлбарлах зорилго тавьсан. Хууль тогтоох үйл ажиллагааны гол судлагдахуун нь хүмүүсийн нийтээр дагаж мөрдөх ёсыг тодорхой болгож журамлаж цэгцлэх асуудал байх болно гэж үзэж байв. Хууль тогтоомж бүх нийтийн сайн сайхан амьдрал, нийтийн ашиг тусын тулд л зохиогдож байх учиртай. Сэтгэл ханамжтай байхыг хүсч тэмүүлсэн эрмэлзэл хүсэлд л ёс зүйн уг үндэс агуулагдаж байна гэж И.Бентам үзжээ¹³. Нийгэмд мөрдөгдөж буй хууль тогтоомж, хүлээн зөвшөөрөгдсөн дэг журмын хүрээнд хувь хүн эрх чөлөөтэй байхын зэрэгцээгээр эрх зүйгээр баталгаажсан эрх чөлөө, хувь хүнийг төр засгийн аливаа дарамт шахалтаас ангид байлгагдаараа үнэ цэнэтэй юм. Хууль нь нийгмийн удирдлагыг төгөлдөржүүлж, хувь хүний эрх ашгийг хамгаалсан дэг журам тогтоодог.

Хууль яагаад гууль болдог вэ?. Бидний хууль гэж яриад байгаа зүйлийн хамгийн муу тал нь хүмүүс түүнийг зохиодогт оршино. Ийм хуулийг хүссэн цагтаа биелүүлж, хүсээгүй цагтаа үл тоомсорлож болдог учраас энэ нь «хууль биш гууль» болдог аж. Жинхэнэ хуулийг хэн ч зохиодоггүй бөгөөд түүнийг дагахгүй бол бүгд сүйрнэ, үүнд л хүчтэй тал нь оршдог. Энэ бол жинхэнэ байгалийн хууль юм. Бидний хууль гээд байгаа тэр зүйл бол цаасан дээр буулгасан хоосон үг, хэн нэгний ажил хийж байгаа нэр төдий зүйл, түүнийг хүссэн үедээ хэрэгжүүлээд, хүсээгүй үедээ уландаа гишгэчихэж болдог «гурав хоногийн

¹⁰ С.Нарангэрэл. Чингис хааны ёс суртахуун-эрх зүйн шастир. Уб., 2014 он. 230 дахь тал.

¹¹ Монголчуудын түүх. 24-25 дахь тал

¹² Нитобэ Иназо. Бушидо япон үндэстний ёс зүйн цогц. Ниппон ньос сонины газар. Уб., 2007 он.

¹³ Б.Галиндэв. Хүн байх ухаан. Уб., 2016 он. 61 дэх тал

настай зүйл» юм. Тийм ч учраас жирийн иргэдээс эхлээд төрийн хамгийн дээд өндөрлөгтөө хүртэл хуулиа зөрчиж байдаг. Ёс зүйн бат итгэл үнэмшилтэй хүнийг хууль, эрх мэдэл, мөнгөний аль нь ч дийлэхгүй, ганцхан ёс зүй нь (дотоод итгэл үнэмшил нь) дийлнэ.

Хүнийг хүн болгож байдаг зүйл бол ёс зүй. “Гельвеций” Хуулиас биш өөрөөсөө айдаг хүн бол ёс зүйтэй хүн. Өөрийн хийсэн үйлдэлд өөрөө дүгнэлт хийх чадвараас тэр хүний ёс зүй их харагддаг. Ямар ч үйлдэл хийсэн огтхон ч шаналдаггүй хүмүүс байх, “хууль л зөрчихгүй бол боллоо” гэсэн мөнөөх олхиогүй бодолтой тэр хүмүүс хамгийн аймшигтай.

Өнөөгийн нийгэмд хууль биш ёс зүй дутагдсанаас болж аймшигт гэмт хэрэг гарч тэдгээрийг үйлдэгч гэмт хэрэгтэн өсч бойжсоор байна. Тэгэхээр хуулийг ёс зүйтэй хүнд хэрэглэх юм бол тэр нь “хууль ёсны хууль” болно. Хууль хэрэгтэй юу? гэвэл хэрэгтэй. Хууль бол зайлшгүй хэрэгтэй. Гэхдээ хуулийг хууль болгодог хууль хэрэгтэй. Тэр хууль нь хүний ёс зүйтэй байдал юм. Хуульчдын хувьд хууль нь Үндсэн хуульд таарч байвал хууль болдог харин бидний хувьд хууль нь ёс зүйтэй зөрчилдөхгүй байж хууль болно.

II. ЁС ЗҮЙ ХУУЛИАС ДЭЭГҮҮР

Нэгэнтээ Монгол Улсын гавьяат хуульч С.Нарангэрэл “Эрхэм чанараа сайтар сахидаг, өндөр ёс зүйтэй хүнд хуулийн хэрэг гэж байхгүй. Ёс зүй бол хуулиас илүү хүчтэй” гэж хэлсэн нь та бидний өдөр тутмын амьдралд тохиолдож байгаа зүйл бөгөөд хүний мөн чанар, нинжин сэтгэл, бие биенээ гэх халуун дулаан хайр, нийгмийн ороо бусгаа амьдрал, хүний хөгжлийн төлөөх бодлогоо гэсэн төр засгийн буруугаас болж олон гэр бүл салж сарнин, үр хүүхэд өнчрөн, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх талбар болж буйг нүдээрээ харж байна.

Хүний амьдралын нэгэн үе улирч нийгмийн өөрчлөлт шинэчлэлт ч уламжлалт гэр бүлийн амьдралыг чухалчлахаа больж аль болох өөрийгөө бодсон, дөрвөн хана, дугуй гэрийнхээ дотроос үл гарах бодлого нь өнөөдөр хүмүүсийн ёс зүйтэй, зөв явдал, зөөлөн сэтгэлийг үгүй болгож эцэг, эхчүүдийг ажлын мал, мөнгөний боол болгосон нь ирээдүйгээ баллах эхлэл болж буйг та бид өнөөдөр олж харж чадсан нь сайшаалтай.

Дж Мур “Ёс зүйн хүрээ хуулийн хүрээнээс илүү өргөн байдаг. Манай орны хуулиар хориглоогүй, заагаагүй үйлдлийг бид ёс зүйн хувьд хийж гүйцэтгэх эсвэл хийхгүй ч байх үүрэгтэй”¹⁴ гэж эрх зүйн зохицуулалтаас ёс зүйн зохицуулалт хавьгүй илүү өргөн хүрээний зан үйлдлийг хамарч зохицуулдаг болохыг заажээ.

Хууль нь хүний гадагш чиглэсэн үйлдэл дээр үйлчилдэг бол ёс зүйн хүний гадагш гарсан үйлдэл дээр төдийгүй дотоод оюун санаанд нь үйлчилж байдаг. Өөрөөр хэлбэл, ёс зүйн хүмүүсийг оюун санаандаа ч тийм нүгэлт бодол агуулахыг зөвшөөрдөггүй гэсэн үг. Ёс зүйн итгэл үнэмшилтэй хүнийг хууль, эрх мэдэл, мөнгөний аль нь ч дийлэхгүй, ганцхан ёс зүй дийлнэ. Ёс зүйн хүчтэй тал бол ердөө л энэ.

Ёс зүй хуулиас илүү. Ер нь юу зөв, буруу болохыг эрүүл, логиктой сэтгэдэг хүн хуультай хуульгүй ойлгож байдаг. АНУ-д “тангарагтны шүүх” гэж хуулийн боловсрол, мэдлэггүй атлаа шүүх дээр хамгийн гол шийдвэр гаргадаг хүмүүсээс бүрдсэн нэгэн институт ажилладаг. Тэд хуулийн мэдлэг боловсролгүй ч, ажил амьдралын их туршлагатай, хэвийн сэтгэдэг, шударга зан чанартай хүмүүс байдаг. Тэд тухайн яллагдагчийн «буруутай» (эсвэл буруугүй) болохыг шийдэх бөгөөд шүүгч зөвхөн тэр шийдвэрийг хуулийн өмнөөс хэлбэржүүлнэ. Тэгэхээр “тангарагтны

¹⁴ Джордж Эдвард Мур. Природа моральной философии. М., С. 328.

шүүх” гэдэг бол бидний ярьж буй зүйлтэй логикийн хувьд утга авцалдах сайн процедур мөнөөсөө мөн.

Хуулиас дээгүүрх хууль гэдэг бол ёс зүй (жинхэнэ хууль бол ёс зүй) гэдгийг хүн бүр ухамсарлавал энэ нийгэмд эрүүгийн гэмт хэрэг төдийгүй бусад ёс бус байдал багасна. Ёс зүй нь зарим тохиолдолд эрх зүйгээс ч хүчтэй байдаг нь хүмүүс түүнийг ямар нэгэн албадлагагүйгээр өөрсдөө тогтоож, урт удаан хугацааны туршид зан үйлээрээ журамлан зохицуулж ирсэнд оршдог.

III. ЁС ЗҮЙ БА ХУУЛИЙН ХАРИЛЦАН ХАМААРАЛ

Ёс зүй, хууль хоёр нь үүсэл хөгжлийн хувьд хоорондоо ямагт холбоотой байдаг. Ёс зүй нь үүслийн хувьд хуулиас өмнө үүссэн бөгөөд нийгмийн хөгжлийн явцад ёс зүйн хэм хэмжээний агуулга, хэлбэр өөрчлөгдөн хөгжиж иржээ.

Ёс зүй, хууль аль аль нь хүмүүсийн зан байдлыг зохицуулах талаар адил төстэй бас нэг нь нөгөөгөөсөө ялгаатай талууд ч байдаг. Ёс зүй нь гүн ухааны нэгэн салбар бөгөөд ёс зүйн талаар асуултуудыг (сайн эсвэл муу, зөв эсвэл буруу, сайн үйл эсвэл муу үйл, хууль дүрэм эсвэл гэмт хэрэг гэх мэт) судална. Ёс зүйн хэм хэмжээ нь нийгмийн амьдралд хэрэгжүүлэхэд итгүүлэх болон олон нийтээр гэмшүүлэх арга ажиллагаанд тулгуурладаг. Харин эрх зүйн хэм хэмжээг хуулиар урьдчилан тогтоосон төрийн албадлагын аргын баталгаатай хэрэглэдэг.

Эрх зүйн хэм хэмжээ хууль, зарлиг, тогтоол, дүрэм, тушаал зэрэг хэлбэрүүдээр илэрдэг. Ёс зүйн хэм хэмжээ нь эрх зүйн адил урьдчилан тогтоосон тодорхой хэлбэрээр илэрдэггүй.

Ёс зүй ба хуулийн харилцан холбооны тухай асуудал нь эрх зүйн философийн үндсэн асуудлын нэг юм. Ёс зүй, хууль хоёр нь нийгмийн

амьдралд хэрэгжихдээ харилцан бие биедээ нөлөөлөх үндсэн дээр цаашид хөгжиж байна. Ёс зүй, эрх зүйн хэм хэмжээ бие биедээ ойртох, харилцан нөлөөлөх явдал зүй тогтол бүхий үзэгдэл юм. Ёс зүй, хууль хоёр нь үүсэл хөгжлийн хувьд хоорондоо ямагт холбогдож ирсэн байдал нь түүх, ном сударт олонтаа тэмдэглэн бичсэн байдаг. Хууль, ёс зүйн аль аль нь хүмүүсийн зан байдлыг зохицуулах талаар адил төстэй.

Ёс зүй, хуулийн асуудлаар Сократ, Платоноос эхлээд олон арван сэтгэгчдийн бүтээлээс ялангуяа Гегелийн философийн ёс зүйн сургаалынх нь баялаг өвөөс суралцах, эзэмших нь нийгмийн сэтгэлгээний нэн чухал асуудал болж байна.

Ёс зүй нь гэмт хэрэг хийгээгүй ч оюун санаандаа тийм нүгэлт зүйл бодсоных нь төлөө тухайн хүнийг яллаж байдаг. Ёс зүй, хууль хоёрын ялгаа эндээс тод харагдана. Хууль хүний гадагш гарсан үйлдэл дээр үйлчилдэг бол ёс зүй нь хүний гадагш гарсан үйлдэл дээр төдийгүй дотоод оюун санаанд нь үйлчилж байдаг. Өөрөөр хэлбэл, ёс зүй нь хүмүүсийн дотор оюун санаандаа ч тийм нүгэлт бодол агуулахыг ч зөвшөөрдөггүй гэсэн үг.

Хууль нь нийгмийн бусад хэм хэмжээ, ёс зүйн хэм хэмжээтэй холбоотойгоор нийгмийн харилцааг зохицуулдаг. Эрх зүйн харилцаанд оролцож байгаа субъектүүдийн эдлэх эрх, биелүүлэх үүргийн төрийн хуулиар тодорхой тогтоосон байдаг. Ёс зүйн хэм хэмжээгээр зохицуулж байгаа субъектүүдийн эдлэх эрх, биелүүлэх үүргийн эрх зүйн адил тодорхой заадаггүй.

Ёс зүй биет ахуйгаас хуулбарлагдсан субъектив санаа болох формаль эрх зүй нь туйлын санааны хөгжлийн эхний үе шат болох бөгөөд аль аль нь үзэл санааны төгс биеллийг илэрхийлдэггүй байна.

Хууль, ёс зүй хоёрын төстэй чанар нь тухайн хүнийг хүссэн хүсээгүй захирагдахыг шаарддаг. Чиний итгэл үнэмшил юуг шаардаж байна түүнийхээ дагуу хийхийг шаардана. Хүний зан төлөвийг зохицуулж хийх үйлдлийг нь чиглүүлж өгдөг. Хувь хүнээс бусад хүн, байгууллага, нийгэмтэйгээ харилцах харилцааг зохицуулдаг. Хууль, ёс зүй хоёрт нэгэн төстэй чанар байна. Хууль, ёс зүй хоёр хүний зан төлвийг зохицуулж байдаг. Өөрөөр хэлбэл, хувь хүнээс бусад хүн, байгууллага, нийгэмтэйгээ харилцах харилцааг зохицуулдаг. Гэтэл энэ хоёрт маш том ялгаа бий. Нэг нь (хууль) тухайн хүнийг хүссэн хүсээгүй захирагдахыг шаарддаг бол нөгөө нь (ёс зүй) чиний итгэл үнэмшил юуг шаардаж байна түүнийхээ дагуу үйлд хэмээнэ. Бидний хууль гэж яриад байгаа зүйлийн хамгийн муу тал нь хүмүүс түүнийг зохиодогт оршино. Жинхэнэ хуулийг хэн ч зохиодоггүй түүнийг дагахгүй бол бүгд сүйрнэ, үүнд л хүчтэй тал нь оршдог. Ийм зүйлийг үнэхээр хууль гэхээс өөр юу гэхэв. Хуулийг хууль болгох арга замын тухай Кант «Тухайн хүн бусад маань ч гэсэн над шиг хийгээсэй гэсэн байдлаар үйлдэх» нь сайн хуультай байх үндэс¹⁵ гэж үзсэн. Хууль, ёс зүй хоёр зөрчилдөх үед иргэн ёс зүйгээ дагах уу, хуулийг дагах уу гэсэн хүнд асуудалтай тулгардаг.

Хүн ёс бол хамгийн дээд хууль гэсэн ойлголтгүй тэр хүмүүс л хууль ёс ярьдаг. Хүн ёсыг баримталдаг бүх хүн хэн нэгний зовж байж бүтээсэн зүйлийг хулгайлаад авчихаж болохгүй гэдгийг мэддэг.

Хуулийг дээдэлдэг хүн хуулиас өөр юунд ч итгэхгүй. Ажил хэрэг явуулахын тулд тэр хүнд *“би нэр төрөөрөө тангараглая”* гэж хэлэх юм бол ёстой хөх инээдийг нь хүргэнэ. Нэр төр, итгэлцэл гэдэг бол угаасаа ёс зүйн ойлголт, нэр төр, итгэлцэл байдаггүй учраас хууль гарч ирдэг. Тэгэхээр тэд хууль, тогтоол, шүүхийн шийдвэр

гээд албан ёсны баримт л шаардана. Түүнийг нь дагаад нөгөө хүнд суртал, авлига гээд хүнд ёстой харшилсан зүйлс гарч ирдэг.

Хүнийг хүн болгож байдаг зүйл бол ёс зүй. Ёс зүй гэдэг бол хүн ёс юм гэсэн санааг хэлэх гээд байгаа юм. Ёс зүйгүйчүүд нэгэнт ёс зүйгүй учраас энэ асуудал тэдний хувьд ойлгоход үнэхээр хэцүү зүйлийн нэг мөн.

Наад зах нь хуулиас биш өөрөөсөө айдаг хүн бол ёс зүйтэй хүн. Гудамжинд ядарсан нэг хүнд туслах бололцоотой байсан хирнээ туслахгүй өнгөрчхөөд ядахад нэг цаг ч гэсэн шаналж байвал *“хүн”* болж байгаа нь тэр. Өөрийн хийсэн үйлдэлд өөрөө дүгнэлт хийх чадвараас тэр хүний ёс зүй их харагддаг.

Тэгэхээр Гельвецийн хэлснээр *«Хүнийг хүн болгож байдаг зүйл ёс зүй»* юм бол *“Хүнийг хүн биш болгож байдаг зүйл бол хууль”*¹⁶. Түүхэн уламжлал, зан заншлаараа ёс зүйг бий болгож чадсан ард түмэн хүмүүнлэг байж чаддаг.

Нийгэмд *“rule of law”* биш, *“rule of justice”* ноёрхож байх ёстой юм шиг санагддаг. Өөрөөр хэлбэл, нийгэмд хууль ёс биш, зүй ёс ноёрхох ёстой. Гэтэл амьдралын утга учир, хуулийн амин сүнсийн талаар гүн гүнзгий мэдлэгтэй хүнийг цагдаа гудамжинд зогсоочоод, биеэ хэрхэн авч явах талаар зааж сургаж, зандарч айлгаж байдаг хачирхалтай нийгэмд бид амьдарч байна. Ухаандаа хууль, ёс журам мэддэг хүн *«ёс журамгүй хүндээ»* хэрхэн амьдрахыг зааж өгч байна.

Хүн төрөлхтний оюуны амьдрал, үйл ажиллагааны эрхэм үнэ цэнэ болох ёс зүй гэх юу болох түүний зарчим хууль, хууль хэмээх онолын үндэстэй эзэмших практикт хэрэглэн хэвшил сургахад чухал ач холбогдлоо өгөхөд оршино.

И.Кант ёс зүй агаад улс төрийн жинхэнэ нэгдмэл байдал зөвхөн эрх зүйд үндэслэж баймааж л бололцоотой

¹⁵ Ф.Бастиа. Хууль. УБ., 2007 он. 93 дахь тал.

¹⁶ Мөн тэнд. 97 дахь тал.

болно. Харин энэ бололцоо хэрэгжих баталгаа нь ил тод байдал ажээ¹⁷. Улс орныхоо сайн сайхны төлөө ёс зүйтэй зүтгэдэг, зарчимд зорилгоо захируулдаг жинхэнэ манлайлагчид л бидэнд хэрэгтэй.

Дэлхийн олон нэрт гүн ухаантан, сурган хүмүүжүүлэгчид *“хүн өөрөө ямагт зөв сайн үйл хийх, сайн зүйл бүтээх эрмэлзэлтэй байх нь хамгийн чухал”*, харин нийгэм бол *“хүний ёс зүйн төлөвшилийн шалгуур”*, ёс зүйн боловсрол нь хүүхэд залуучууд, бие хүнээс өөрсдөөс нь, гэр бүлээс эхэлж явагддаг прагматик байх ёстой гэсэн санааг дэвшүүлсэн.

Аристотель бол хуулийн учир холбогдлыг анхлан сайтар тодорхойлогч юм. Тэрээр *“төр улсын сайн сайхан байдал хуулиас хамаардаг, хууль бол төрийн ажил хэрэг дэх ур чадварын бүтээл, хууль бол албадлагын шинжтэй, сайн зохиогдсон хуулиуд гол нь боломжийн хэрээр, бүхнийг өөрөө тодорхойлсон байх ёстой, шүүгчийн дур зоргод аль болох бага зүйл үлдээсэн байх учиртай”*¹⁸ гэжээ. Учир нь *“төрийн хуулиа улсынхаа онцлогт тохируулж хийх, хууль тогтоохдоо зөвхөн мэргэшсэн шударга хуульчдын санааг авах, хууль тогтоогчид гаргаж буй хуулиа улсынхаа төлөө гэж хийх ёстой, өчүүхэн хувийн эрх ашгаа хууль тогтоогчид гол зүйлд бодож болохгүй”*¹⁹ ингэж ёс зүй, хууль хоёр нэгдмэлээр холбогддог. Гэтэл энэ уялдаа холбоо манай одоогийн хуулиудад хэрэгжиж чадаж байгаа эсэх нь хуулийн давхардал, хийдэл, зөрчил хуулиудад тодорхойгүй байдал их байна эдгээрийг арилгах, нарийвчлах, хууль цэвэрлэх ажлыг хийх хэрэгтэй байна. Үндсэн хуулиас гадуур эрх зүй, ёс зүй гэж байж таарахгүй билээ.

IV. ДҮГНЭЛТ

Эрх зүйт төртэй хамгийн сайн засаглалтай орон байхыг хүсвэл улс орон бүр ёс зүйн хэм хэмжээг иргэн бүрд ялангуяа балчирхан үрсүүддээ бид нар заан сургаж, хүмүүнлэг иргэний ардчилсан нийгмийг байгуулах өсвөр залуу үеийнхэндээ ёс зүй, хууль гэх мэт нийгмийн үнэт зүйлс болон тулгуур ойлголтууд түүнийг амьдралд зөв ашиглах, зөв амьдрах зэргийг заан сургаснаар эрх зүйн үндсийг бид зөв хөрсөнд суулгаж чадна.

Хүнийг хүн болгож төлөвшүүлэх цогц арга хэмжээ буюу цэцэрлэг, сургуулийн тоог нэмж, эцэг, эхийг ажилтай болгох, бүх шатны сургалтад гэр бүл, ёс зүйн хичээлийн хөтөлбөрийг нэмэх, сэтгэл зүйчдийн баг ажиллуулах, хууль сахиулах байгууллагын анхан шатанд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шатны хэлтсүүд бий болгох, шинээр гэр бүл бологсдод гэр бүлийн үүрэг, хариуцлага, төлөвшил суулгах богино хэмжээний сургалтуудыг зохион байгуулж боловсролыг ёс зүйд үндэслэх нь өнөөгийн цаг үеийн хэрэгцээ, шаардлага бий болсон байна.

Монгол хүүхдийг Монгол хүн болгон хүмүүжүүлж, ёс суртахууныг нь төлөвшүүлэхийн тулд монгол хүний, гэрийн, төрийн ёсны уламжлал, тухайн хүний ухамсар, соёлын хэмжээг илтгэдэг нийтийн ёс горим, ёс зүйн эгэл хэм хэмжээ, зарчим, үндсэн ойлголтуудын талаарх суурь мэдлэгийг төрхөөс нь эхлээд гэр бүлд нь, цэцэрлэг, сургуульд нь уян хатан, прагматик хувилбартай эзэмшүүлэн *“...хүмүүнлэг, үндэсний дэвшилтэт ёс заншил, ёс зүйн соёлыг эзэмшсэн, эх оронч, хууль ёсыг дээдэлдэг үзэл төлөвшсөн”* иргэн болгох нь бид бүхний үүрэг билээ.

Ёс зүй нь хүний үйлдэл, сэтгэл оюуныг зөв замд чиглүүлэх, ёс бус буруу үйлдлээс урьдчилан сэргийлэхэд тусалдаг учраас хүн ёст, зөв сайн, ёс зүйтэй, оюунлаг, хүнлэг *“зөв хүн”* иргэн төлөвшихийн суурь юм. Хүн

¹⁷ А.Гулыга.Кант.М., с.1981, С. 239.

¹⁸ Б.Даш-ёндон.Эртний грекийн философи сэтгэлгээний эх сурвалж.эмхтгэл III боть. УБ., 2012 он. 477 дахь тал.

¹⁹ Б.Даш-ёндон. Монголын хөгжлийн философи (асуудал, аргачлал, ашиг тус). УБ., 2017 он. 131 дэх тал

хүнтэйгээ харьцах ёс зүйн үнэт чанарыг эзэмшүүлэх, нийгмийн харилцааны бүхий л хүрээнд мөрдөх хэм хэмжээг ухамсарлуулах хэрэгтэй байна.

Ёс зүйн эрхэм чанарт үндэслэн хууль гаргах шаардлагатай байна.

Ёс зүйн эрхэм чанарыг иргэн бүр адилхан ойлгодог учраас түүнд тулгуурласан хууль нь тэдэнд хэрэгтэй гэдэг үүднээс хүмүүс өөриймсгөөр хүлээн авч хууль хэрэгждэг.

---o0o---

**ҮНДЭСНИЙ ИХ БАЯР НААДМЫГ ТОХИОЛДУУЛАН ЭРХЭЛСЭН АЖИЛДАА
АМЖИЛТ ГАРГАСАН АЖИЛЧДЫГ ШАГНАЛАА**



Үндэсний их баяр наадам, Тулгар төрийн 2227, Их Монгол Улсын 812, Ардын хувьсгалын 97 жилийн ойг тохиолдуулан Монгол улсын Ерөнхийлөгчийн зарлигаар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал С.Энхцэцэг "Хөдөлмөрийн хүндэт" шагнасныг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж гардуулан өглөө.

Мөн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн захирал С.Энхцэцэг нь хууль зүйн үндэсний хүрээлэнгийн шагналын журмын 1 дүгээр зүйл 1.2 дахь заалт, 3 дугаар зүйл 3.1 дэх заалт, 5 дугаар зүйл, 5.1.2 дахь хэсэг, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн дүрмийн 3 дугаар зүйл, 3.7.4 дэх хэсгийг тус тус үндэслэн Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн нэрэмжит шагналаар шагнах тухай 2018 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн Б/62 тоот тушаалаар тус хүрээлэнд олон жил үр бүтээлтэй, тууштай, эрхэлсэн ажилдаа идэвхи, санаачлагатай ажиллаж буй эрдэм шинжилгээний ажилтан Г.Халиунаа, эрх зүйн сургалт хариуцсан мэргэжилтэн Д.Мөнхжаргал, В.Оюун-Эрдэнэ, эрх зүйн мэдээллийн нэгдсэн системд мэдээлэл оруулагч мэргэжилтэн Б.Хулан, үйлчлэгч Д.Оюунсайхан нарыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн "Хүндэт тэмдэг"-ээр, Эрх зүйн мэдээллийн нэгдсэн системийн сүлжээний зохицуулагч инженер Б.Баянмөнхийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн "Хүндэт өргөмжлөл"-өөр тус тус шагналаа.

“PUBLIC TRUST DOCTRINE” БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ӨМЧЛӨЛ, АШИГЛАЛТЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНОЛЫН ГОЛ БАРИМТЛАЛ БОЛОХ НЬ

МУИС-ХЗС-ийн ахлах багш

Д.Батболд (LL.M, MPA)

Ашигт малтмал өмчлөл, ашиглалтын эрх зүйн зохицуулалтыг тогтоох болон түүний талаархи эрдэм шинжилгээний ажлыг эхлэхийн өмнө энэ чиглэлийн онолын судалгаанд анхаарал хандуулах нь зүй билээ. Дэлхийн орнуудын ашиг малтмалын хууль тогтоомж өөр өөрийн агуулга, онцлогтой боловч нийтлэг баримталдаг зарчим, онол гэж бий юу? гэсэн асуулт тавигдана.

Энэ талаар тодорхой эрэл хайгуул хийж эрдэмтэд, судлаачдын бүтээлийг үзвэл “The public trust doctrine” (the PTD) буюу нийтийн итгэмжит өмчийн номлол¹ нь байгалийн баялаг өмчлөл, ашиглалтад баримталдаг онолын гол баримтлал гэж үнэлэгдэх аж. Тухайлбал: нийтийн итгэмжит өмчийн номлол (the PTD) нь орчин үеийн байгалийн баялгийн болон хүрээлэн буй орчны эрх зүйн суурь зарчим болон 50 гаруй жил үйлчилж байна² гэж АНУ-ын профессор Micheal C. Blumm, Mary Christina Wood нар бичсэн бол “нийтийн итгэмжит өмчийн номлол (the PTD) нь хуулиуд, бодлогууд, төсөл, хөтөлбөрийн үзэл баримтлалын

хүрээнд (program framework), мөн тодорхой үйл ажиллагаа (activity)-нд, шинжлэх ухааны судалгаанд гэх мэт бүхий л тулгуур баримт бичиг, төрийн ажил хэрэгт Канад болон АНУ-ын хүн амын онгон дагшин байгалийг хамгаалах, хадгалах, сэргээх гол бөгөөд суурь үзэл болдог”³ гэж уг номлолын хүлээн зөвшөөрөгдсөн байдал, байр суурийг тодорхойлогдсон нь буй.

Нийтийн итгэмжит өмчийн номлол нь байгалийн баялгийн удирдлага (management), хяналт, хамгаалалтыг засагладаг нэн эртний уламжлалтай өмчийн эрх зүйн номлол юм⁴. Уг номлол нь VI зууны үеийн Грек, Ромын Civil Law-оос эхтэй гэж тооцогддог. VI зууны Ромын “Civil Law”- д хамаарах Юстинианы институтэд “Байгалийн хуулиар дараахь зүйл бүх хүн төрөлхтөнд зориулагдсан нийтлэг (common) зүйл мөн. Үүнд: хуурай газар, агаар, урсгал ус, далай, далайн эрэг орно”⁵ гэж тодорхойлсон нь уг номлолын эхлэл гэж тооцогддог байна. Энэхүү хэм хэмжээ нийтлэг өмч болсон байгалийн баялаг нь хэн нэгний өмч биш тул бүхий л хүн түүнийг ахуйн хүрээнд болон хувийн хэрэгцээнд хэрэглэх

¹ PTD гэдгийг нийтийн “итгэмжит өмчийн номлол” гэж нэрлэж болох юм. “Trustee”-ийг итгэмжит этгээд гэж орчуулж болно. “Итгэмжлэгдсэн” гэж орчуулж болох ч энэ нь манай улсын иргэний эрх зүй дэх ижил нэр томъёотой давхцах тул ялгаатай байдлыг тодруулахын тулд “итгэмжит” гэж тэмдэглэх нь зүйтэй юм-Д.Б.

² Blumm, M, Wood, M. (2013). The Public trust doctrine in environmental and natural resources law. Carolina Academic Press. P. 3.

³ The Wildlife Society. (2010). The Public Trust Doctrine: Implications for Wildlife Management and Conservation in the United States and Canada. P. 9.

⁴ Номлол гэдэг нь системчлэгдсэн санаа бодлоос (ideas) тогтсон итгэл үнэмшлийн бүрдэл юм. Номлол нь хууль зүйн, улс төрийн, шашны гэх мэт олон төрлүүдтэй бөгөөд үндсэн шинж нь бодож тунгаагдсан, хүлээн зөвшөөрөгдсөн байдаг оршино. Хууль зүйн номлолын гол онцлог нь эрх зүйн эх сурвалж болдог.-Д.Б.

⁵ The Institute of Justinian. Title second. (<https://www.gutenberg.org/files/5983/5983-h/5983-h.htm>) Зочилсон огноо: 2018.01.10.)

(access) ⁶ эрхтэй гэсэн үндэслэлийг үүсгэдэг бөгөөд энэхүү үндэслэл нь “энэ байгалийн баялаг бол хүнийг хаана байгаагаас үл хамаарч түүнд хамгийн их хэрэгцээ шаардлагатай амин чухал ач холбогдолтой зүйл”⁷ юм гэсэн нийтийн итгэмжит өмчийн номлолын тулгуур үзэл санаа (notion) болон тогтсон ажээ.

Нийтийн итгэмжит өмчийн номлолын эх үндсийг илэрхийлж байсан Ромын “Civil Law” нь 1215 оны Английн Магна Хартад анх тусгагдсан бөгөөд Английн “Common Law”-оор 1641 онд дахин тодорхойлогдсон гэдэг. Энэ явцад нийтийн итгэмжит өмчийн номлол нь Ромоос бага зэрэг ялгаатай хуульчлагдаж өмчлөлийн шинж нь ялимгүй өөрчлөгдөв. Англид нийтлэг (common) өмчийг хаан өмчилдөг боловч хаан хувийн зорилгодоо түүнийг ашигладаггүй. “Grown” олон нийтийн төлөө, тэдний итгэлийн доор (in trust) байгалийн баялгийг өмчилдөг аж⁸. Ийнхүү нийтийн итгэмжит өмчийн номлол Ромын эрх зүйгээс эх авч, Англид нутагшиж, цаашид Английн колончлолын нөлөөгөөр дэлхийн олон оронд тархаж, тухайн улс орныхоо улс төр, эрх зүй, түүх, соёлын өөр өөр хандлагыг тусгасан төрөл зүйлүүд болж хөгжсөн ажээ. Чингэхдээ итгэмжит өмч буюу “trust” гэх шинж чанараа ямагт хадгалсан байдаг.

Тухайлбал АНУ-д загасчлах, байгалийн баялгийн худалдаа (commerce-жимс, загас, давс гэх мэтийг худалдах) далайгаар зорчих зэргийг уламжлалт байдлаар нийтийн ашиг

сонирхол гэдэгт хамруулж нийтийн итгэмжит өмчийн номлолын хүрээнд хамгаалж байсан боловч 21 дүгээр зуун гарсаар сүүл үеийн “case law” нь нийтийн итгэмжит өмчийн номлолыг гарч болох орчин үеийн бүхий л тохиолдлуудад хэрэглэж болно гэж тодорхойлсон⁹. Жишээлбэл, онгон байгалийг хадгалан хамгаалах, далайг хамгаалж, хадгалах, далайг нээлттэй байлгах, хүрээлэн байгаа орчны хөгжил дэвшил болон амьтан, ургамалд зориулагдсан хүний гараар үүсгэгдсэн зориудын хиймэл орчин үүсгэх, амралт чөлөөт цагаа өнгөрүүлэх газрууд, тухайлбал усанд сэлэх газар, амралт зугаалгын паркууд, түүхийн дурсгалт газрыг үүсгэх, нийтийн эрүүл мэндийн зорилгоор нийтийн усанд орох газар, мөн орчин үеийн усны хамгаалалт, гоо сайхны шинжлэх ухааныг хөгжүүлэх, дотоодын усан хангамжийг түгээх зорилгоор, үйлдвэр, аж ахуйн газрыг үүсгэх, хөдөө аж ахуйг хөгжүүлэх зорилгоор, шашин болон соёлын зорилгоор, цахилгаан соронзон орон зайг бий болгох гэх мэт бүхий л үйл ажиллагаа “The PTD”-ийн хүрээнд байна гэдгийг тогтоож өгсөн¹⁰.

Нийтийн итгэмжит өмчийн номлолын дагуу нийтийн өмчлөлд байдаг байгалийн нөөц баялгийг засаг төрд (government)-д хариуцуулж, засаг төр нь байгалийн баялгийн үр ашгийг хүртэгчид болсон олон нийтийн өмнөөс удирдлагыг хэрэгжүүлэх үүрэг хариуцлагыг хүлээдэг. Энэхүү номлол ёсоор засаг төрийн аливаа нэг байгууллага нь итгэмжит өмчийн өмчлөгч биш бөгөөд харин байгалийн баялаг нь олон нийтийн өмчлөлд байдаг. Олон нийт байгалийн баялгаас урт хугацаанд үр ашгаа хүртэх боломж, нөхцөлөөр засаг төр нь хангаж, түүний хамгаалалтыг үүсгэж, байнгын зүй зохистой удирдлагаар хангах үүрэг хариуцлагыг үүрсэн байдаг гэж ойлгож

⁶ “Access” гэдэг үгийг байгалийн баялгийн хүрээнд “ашиглах” гэж дангаар оноож хэрэглэх нь тохиромж муутай төдийгүй төөрөгдөл үүсгэнэ. Харин ахуйн хүрээнд болон хувийн хэрэгцээнд байгалийн баялгийг хэрэглэх гэж буулгавал болох мэт. Учир нь “access” гэдэг нь “нэвтрэх” гэсэн үндсэн утгатай. Ашиглах гэдэг нь хууль зүйн хувьд тухайн баялгийн үр шимийг хүртэх, эдийн засгийн ач холбогдлыг гарган авах гэсэн өргөн утгатай-Д.Б.

⁷ The Wildlife Society. (2010). The Public Trust Doctrine: Implications for Wildlife Management and Conversation in the United States and Canada. P. 9.

⁸ The Wildlife Society. (2010). The Public Trust Doctrine: Implications for Wildlife Management and Conversation in the United States and Canada. P. 11.

⁹ The Wildlife Society. (2010). The Public Trust Doctrine: Implications for Wildlife Management and Conversation in the United States and Canada. P. 12-13.

¹⁰ Мөн тэнд.

болно. Энэхүү өөр хоорондоо уялдсан нэг бүхэл тогтолцоожсон харилцааг тодорхойлж, бэхжүүлж байгаа номлол бол нийтийн итгэмжит өмчийн номлол (the PTD) юм.

Итгэмжит өмч (trust) гэдэг нь бусдын ашиг сонирхлын дор тухайн өмчийг хамгийн сайн нөхцөлөөр тасралтгүй удирдлагаар хангах, арчлах хүнд хэцүү ажил, түүний үүрэг хариуцлагыг өөр этгээд буюу trustee хүлээдэг эд хөрөнгийн бүрдэл (asset) юм¹¹. Хэдийгээр энэ өмч хөрөнгийг тасралтгүй удирдлагаар хангаж байгаа этгээдийг итгэмжит өмчийн давуу талыг эзэмшигч гэж үзэж болох боловч тухай өмч хөрөнгийг арчлах, хамгаалах хариуцлагатай, амаргүй ажил үүрэг хүлээсэн этгээдийнх нь хувьд түүнийг тухайн өмчид хяналт тавигч, хяналтыг хэрэгжүүлэгч этгээд гэж тодорхойлдог¹². Манай улсын эрдэмтдээс академич С.Нарангэрэл “Public trust”-ийг “нийтийн сайн сайхны зорилгоор бататгасан итгэмжилсэн өмч”¹³ гэж тайлбарласан нь буй.

Public буюу олон нийт гэдэг бол итгэмжит өмч (trust)-ийн үр ашгийг хүртэгчид (beneficiaries) бөгөөд тэдний төлөө уг хөрөнгө бусдын удирдлага, хяналт, хамгаалал дор оршдог. Иймд итгэмжит өмчийн харилцаанд хамгийн хүндтэй байр суурьтай субъект нь олон нийт буюу ард түмэн юм. Харин итгэмжит этгээд (trustee) гэдэг нь итгэмжит өмч хөрөнгийн төлөө хариуцлага хүлээх бөгөөд энэ нь “PTD”-ийн үр нөлөөтэй байдлыг хадгалдаг уг номлолын зайлшгүй элемент мөн. Дурдан буй хариуцлагатай байдал нь тухайн асуудлыг хариуцах завгүй боловч түүний талаар их хэмжээний мэдээлэлтэй олон нийтэд үйлчлэх үндэслэлийг үүсгэдэг. Олон нийт

шийдвэр гаргах ажиллагаанд үзэл бодлоороо, идэвх зүтгэлээрээ уул ажлыг амжилтад хүргэхийн тулд оролцох бөгөөд энэ нь итгэмжит өмчлөгчид орчин цагийн хэрэгцээ шаардлагын дагуу өмчийг хэрхэн удирдах ёстойг хэлж чиглүүлэх үүргийг гүйцэтгэдэг¹⁴.

Барууны орнуудад итгэмжит өмчийн үр ашгийг хүртэгчид буюу олон нийт засаг төрийн хариуцлагатай байдлыг сахиулах (хэрэгжүүлэх)-даа хуулийн хүч, албадлагыг ашиглах эрхтэй байдаг аж. Жишээлбэл, энэхүү эрх нь “шүүхэд нэхэмжлэл гаргах, зарим тохиолдлуудад сонгууль болон “ballot initiatives” механизмаар хэрэгждэг”¹⁵ гэж судлаачид тэмдэглэжээ.

Ийнхүү нийтийн итгэмжит өмчийн номлол (the PTD) нь олон нийт буюу ард түмний тусын тулд байгалийн баялгийг засаг төрд хариуцуулж гагцхүү зөв удирдлага, хяналт, хамгаалалтын үүрэг хариуцлагыг түүнд тохоож энэ бүхний оюун санааны болон хууль зүйн баталгаа болон олон зуун жилийн турш өв уламжлагдан иржээ. Уг номлолыг хөгжүүлэхэд Ромын хуульч Justinian, Английн хуульч Matthew Hale, АНУ-ын шүүгч Paula Nakayama, Presbitero Valasco, Gisela Triana болон профессор Joseph L. Sax нар гол үүрэг гүйцэтгэсэн

¹⁴ The Wildlife Society. (2010). The Public Trust Doctrine: Implications for Wildlife Management and Conversation in the United States and Canada. P. 15.

¹⁵ The Wildlife Society. (2010). The Public Trust Doctrine: Implications for Wildlife Management and Conversation in the United States and Canada. P. 14.

“Ballot initiative” гэдэг нь албан ёсоор боловсруулж бэлдсэн хуулийн төсөл болон хууль, Үндсэн хуулийн нэмэлтийн асуудлаар олон нийтийн санал хураалгахаар хуулиар тогтоосон тодорхой тооны сонгуулийн эрх бүхий иргэдээс гарын үсэг зурах ажиллагаа. Үүнийг “initiative”, “popular initiative”, “voter initiative”, “citizen initiative” гэх мэтээр улс орон бүрт харилцан адилгүй нэрлэх аж. –Д.Б.

¹¹ The Wildlife Society. (2010). The Public Trust Doctrine: Implications for Wildlife Management and Conversation in the United States and Canada. P. 10.

¹² Мөн тэнд

¹³ С.Нарангэрэл. Монголын эрх зүйн латин, англи, орос хадмал эх толь бичиг. 4 дэх хэвлэл, УБ., 2015 он. 232 дахь тал.

гэж үнэлэгдэн хүндлэгдэх ажээ¹⁶.

Нэр дурдагдсан шүүгчид нь нийтийн итгэмжит өмчийн номлолыг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн хэрэг маргааныг шийдвэрлэсэн уульхдид юм. New Jersey мужийн дээд шүүхэд 1821 онд шийдэгдсэн Арнольдын эсрэг Манди (Arnold v. Mundy)-ийн хэрэг, Нэгдсэн Улсын дээд шүүхэд 1842 онд шийдэгдсэн Мартины эсрэг Уоделл (Martin v. Waddell)-ийн хэрэг, Америкийн Нэгдсэн Улсын Дээд шүүхэд 1892 онд шийдэгдсэн Illinois-ийн төв төмөр замын компанийн эсрэг Illinois (Illinois Central Railroad Co. v. Illinois)-ийн хэрэг, Connecticut мужийн дээд шүүхэд 1896 онд шийдэгдсэн Коннектикут мужийн эсрэг Гир (Geer v. Connecticut)-ийн хэрэг, 1971 онд Калифорн муж улсын Дээд шүүх дээр шийдэгдсэн Марксын эсрэг Уитни (Marks v. Whitney)-гийн хэрэгүүд нь нийтийн итгэмжит өмчийг хөгжүүлэхэд гол үүрэг гүйцэтгэсэн кейсүүд юм. Профессор Joseph L. Sax (Professor of law, University of Michigan)-ийн хувьд “The Public Trust Doctrine in Natural Resource law: Effective Judicial Intervention” гэх том хэмжээний өгүүлэл 1969 онд “68 Mich.L.Rev.471 (1969)”-д нийтлүүлсэн бөгөөд энэхүү өгүүлэл уг номлолын гол асуудлыг бүхэлд нь хөндсөн байна Д.Б.

Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлд “Байгалийн баялаг нь ард түмний мэдэлд, төрийн хамгаалалт, өмчлөлд байна... Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно” гэж заасныг нийтийн итгэмжит өмчийн номлолтой харьцуулбал Үндсэн хуулийн дурдсан хэм хэмжээ нь хүн төрөлхтний хууль зүйн соёлын өв болсон нийтийн итгэмжит өмчийн номлолтой зарчмын хувьд зөрүүгүй төдийгүй ижил төстэй гэж дүгнэж болохоор байна.

---o0o---

**“ХУУЛЬ ЗҮЙН НЭР ТОМЬЁОНЫ СУДАЛГАА, ХЭРЭГЛЭЭ” СЭДЭВТ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ БОЛЛОО**



Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулиас санаачлан Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Хууль зүйн яам, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Хуульчдын холбоо, Шинжлэх ухааны академийн Философийн хүрээлэн хамтран “Хууль зүйн нэр томьёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлыг 2 дахь жилдээ зохион байгууллаа.

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ГУБЕРНАТИВ БА АДМИНИСТРАТИВ ҮЙЛ АЖИЛЛАГАА



*МИУС-ийн Хууль зүйн сургуулийн
Нийтийн эрх зүйн тэнхимийн багш,
хууль зүйн магистр Т.Мөнх-Эрдэнэ*

ТҮЛХҮҮР ҮГ

Нийтийн захиргаа, захиргааны байгууллага, губернатив үйл ажиллагаа, административ үйл ажиллагаа.

ТОВЧ УТГА

Монгол Улсын Их Хурлаас 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр Захиргааны ерөнхий хууль (цаашид “ЗЕХ” гэх)-ийг баталснаар анх удаа Монгол Улсын захиргааны эрх зүйн ерөнхий анги бие даасан материаллаг хуультай болсон билээ.

Уг хуулийн 5 дугаар зүйлд захиргааны байгууллагыг тодорхойлсон бөгөөд энэхүү тодорхойлолтын хүрээ хязгаарыг тогтооход тус болохуйц захиргааны эрх зүйн шинжлэх ухааны онолын тойм судалгааг энэхүү өгүүлэлээр хийхийг зорьсон болно. Орчин үеийн захиргааны эрх зүйн онолд нийтийн захиргаа гэж хэн болох, ямар аспектаар түүнийг тодорхойлдог эсэх, захиргааны байгууллагын үйл ажиллагааг губернатив ба административ шинжээр ялган заагладаг тухай энэхүү өгүүлэлээр авч үзнэ.

ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ГУБЕРНАТИВ БА АДМИНИСТРАТИВ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Нийтийн захиргааг тодорхойлох онолын үндэс

Үндсэн хуулийн эрх зүйн үүднээс авч үзвэл төрийн эрх мэдлийг хуваарилах тухай Монтескье-ийн боловсруулсан онолын дагуу төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх хэмээх гурван эрх мэдэлд хуваарилж, тэдгээр нь өөр хоорондоо харилцан тэнцвэртэй хяналтыг хэрэгжүүлэх учиртай гэж үздэг¹ бөгөөд энэ ч агуулгаар 1992 оны Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олж, хэлбэржин баталгаажсан.

Орчин үеийн захиргааны эрх зүйн онолын хүрээнд ч Үндсэн хуулийн дээрх үзэл баримтлал, эрх мэдлийн хуваарилалтын дотор захиргааны байгууллагыг авч үздэг бөгөөд ингэж үзэхдээ дараах зураглалаар² нийтийн захиргаа буюу захиргааны байгууллагыг нарийвчлан ойлгодог болно. Үүнд:

Дээрх зураглалыг тайлбарлахын тулд юуны өмнө орчин үеийн захиргааны эрх зүйн онолд нийтийн захиргаа³ гэдэг ойлголтыг тайлбарладаг аспектыг авч үзэх шаардлагатай байна. Нийтийн захиргааг тодорхойлдог үндсэн 3 аспект бий.⁴

¹ Энэ талаар гадаад, дотоодын олон эрдэмтдийн ном зохиол дээр тэмдэглэсэн байдаг. Тухайлбал, Creifelds Rechtswörterbuch, 19. Auflage, Verlag C.H.Beck, 509 дэх талаас үзэх.

² Alfred Katz, Staatsrecht Grundkurs im öffentlichen Recht, 12. überarbeitete Auflage, Verlag C.F.Müller, P. 190.

³ Монголд “төрийн захиргаа” гэх ухагдахуунаар түгээмэл хэрэглэдэг, Т.М.

⁴ Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, P. 1-2.

1) Захиргааг зохион байгуулалтын бүтэц талаас нь тодорхойлох;

2) Захиргааг материаллаг утгаар тодорхойлох;

3) Захиргааг формаль утгаар тодорхойлох.

Захиргааг зохион байгуулалтын бүтэц талаас нь тайлбарлавал: нийтийн захиргаа гэдэгт захиргааны үйл ажиллагаа явуулж байгаа захиргааны байгууллага, захиргааны байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлж байгаа бусад этгээдийг хамтад нь ойлгох буюу захиргааны байгууллагуудыг ойлгодог.

Захиргааг материаллаг утгаар нь тайлбарлавал: нийтийн захиргаа гэдэгт захиргааны үйл ажиллагааг, өөрөөр хэлбэл, захиргаанд оногдуулсан чиг үүргийг (=хуулийг) амьдрал дээр хэрэгжүүлж буй төрийн үйл ажиллагааг ойлгодог. Тодруулбал, зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа гэж үздэг.

Захиргааг формаль утгаар нь тайлбарлавал: нийтийн захиргаа гэдэгт материаллаг утгаар хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхээс үл хамаарч захиргааны байгууллагаас явуулж буй бүхий л үйл ажиллагааг ойлгодог.

Захиргааг материаллаг болон формаль утгаар тодорхойлсон дээрх хоёр аспектын хоорондын ялгааг авч үзэхдээ төрийн эрх мэдэл хуваарилалтын хүрээг шалгуур хийдэг. Формаль утгаараа захиргаа нь хуулийг хэрэгжүүлж байгаа эсэхээс үл хамаардаг захиргааны шинжтэй үйл ажиллагаа байдаг тул зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагууд төдий бус, хууль тогтоох болон шүүх эрх мэдлийн дотор ч захиргааны шинжтэй үйл ажиллагаа явагддаг гэж үздэг. Тухайлбал, парламентын ажлын алба буюу УИХ-ын Тамгын газрын захиргааны шинжтэй үйл ажиллагаа, шүүхийн ажлын алба буюу Шүүхийн Тамгын газрын захиргааны шинжтэй үйл ажиллагаа гэх мэт нь хэдийгээр хууль тогтоох хийгээд шүүх эрх мэдлийн

дотор оршин байгаа боловч нийтийн захиргаа болно гэж үздэг.

Харин материаллаг утгаараа захиргаа нь хуулийг амьдрал дээр хэрэгжүүлэх үйл ажиллагаа буюу цэвэр гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа гэж үздэг тул энэ аспект нь өөрөө онол-практикийн маргаан ихээхэн дагуулдаг.⁵ Гэвч энэхүү аспектын хүрээнд Германы захиргааны эрх зүйн эрдэмтэд нийтийн захиргааг тодорхойлох дараах 2 аргыг хөгжүүлсэн.⁶

1) Эерэг арга

2) Сөрөг арга

Эерэг аргаар нийтийн захиргааг тодорхойлоход нийтийн захиргаанд байх нийтлэг шинжүүдийг нэг бүрчлэн тоочих замаар илэрхийлдэг. Тухайлбал:

- Төрийн зорилт, хууль тогтоогчийн хүсэл зоригийг тухайн тохиолдолд хэрэгжүүлдэг

- Засгийн газраас гаргасан улс төрийн шийдвэрийн хүрээнд үйл ажиллагаа нь тодорхойлогддог ба хязгаарлагддаг

- Тухайн тохиолдолтой холбогдол бүхий шийдвэр гаргаж, удирдан чиглүүлдэг

- Үйл ажиллагаандаа ихэвчлэн захирамжилсан арга хэрэглэдэг

- Тодорхой чиг үүргийг эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлдэг

- Төрийн үйлчилгээ үзүүлдэг гэх мэт.

Дээрх шинжүүд нь хийсвэр бөгөөд ойлгоход хүндрэлтэй гэдгээс

⁵ Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, P. 2.

⁶ Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, 2-4 дэх талаас үзэх. Мөн энэ талаар профессор, доктор П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн ерөнхий анги, 3 дахь хэвлэлт, 2016, 28 дугаар талаас үзэж болно. Гэхдээ Германын захиргааны эрх зүйн эрдэмтэд одоог хүртэл дээрх хоёр аргыг төгс гэж үздэггүй бөгөөд аль аль нь асуудалтай хэмээн тэмдэглэдэг. Энэ нь захиргааны байгууллагын үйл ажиллагаа олон талтай бөгөөд тэдгээрийн чиг үүрэг ирээдүйд хувьсан өөрчлөгдөх боломжтой байдагтай холбоотой гэж тайлбарладаг.

гадна хувьсан өөрчлөгдөх боломжтой буюу тогтворгүй гэж шүүмжлэгддэг болно. Иймд захиргааны эрх зүйн нэрт эрдэмтэн Волфф болон Бахоф нар дээрх шинжүүдийг нэгтгэн “Захиргаа нь материаллаг утгаараа нийгмийн гишүүдийн олон талт, нөхцөл болзол бүхий, эсхүл тодорхой зорилгод чиглэсэн нийтийн үйл хэргийг хэрэгжүүлэхэд тусгайлан зориулагдсан, үйл ажиллагаагаа бие даан явуулж, шийдвэр гаргадаг, түүнийгээ биелүүлж хариуцдаг нийгмийн үйл хэргийг гардан хэрэгжүүлэгч юм”⁷ хэмээн тодорхойлолт өгөх оролдлого хийсэн байдаг.

Сөрөг аргаар нийтийн захиргааг тодорхойлоход нийтийн захиргаанд үл хамаарах хэсгийг нь тоочих байдлаар буюу хүрээг нь хязгаарлах замаар нийтийн захиргааг тодорхойлдог. Захиргааг сөрөг аргаар тодорхойлбол “Захиргаа гэдэг нь хууль тогтоох болон шүүх эрх мэдлээс бусад төрийн үйл ажиллагаа юм”.⁸

Дээрх тодорхойлолтыг төрийн эрх мэдэл хуваарилах онолтой холбон тайлбарлавал захиргаа нь зөвхөн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаа хэмээн ойлгож болно. Гэвч дээр дурдсанчлан хууль тогтоох болон шүүх эрх мэдлийн байгууллагаас тодорхой тохиолдолд захиргааны хяналтын үйл ажиллагаа явуулдаг гэдгийг мартаж болохгүй юм. Тийм учраас энэхүү аргыг мөн л асуудалтай гэж үздэг.

Ийм учраас орчин үеийн захиргааны эрх зүйн онолд нийтийн захиргаа буюу захиргааны байгууллагыг тодорхойлохдоо формаль болон материаллаг аспектыг аль алиныг нь хослуулах чиг хандлагатай болсон.⁹

2. Захиргааны байгууллагын губернатив ба административ үйл ажиллагаа

Дээр дурдсанаар нийтийн захиргааг формаль болон материаллаг аспектыг хослуулан тодорхойлохдоо төрийн гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагааг дотор нь губернатив¹⁰ болон административ гэж хоёр ангилан авч үзнэ. Тодруулан тайлбарлавал, гүйцэтгэх эрх мэдлийн губернатив үйл ажиллагааг гүйцэтгэх эрх мэдлийн административ буюу захиргааны үйл ажиллагаанаас салган зааглах учиртай.¹¹ Губернатив үйл ажиллагаа нь Засгийн газрын үйл ажиллагаа байх хэдий ч нарийвчлан тодорхойлох шаардлагатай байна. Тиймээс энэ өгүүллийн хүрээнд губернатив ба административ үйл ажиллагааг тодорхойлохдоо Засгийн газрын үйл ажиллагааг сонгож, түүнд тулгуурлан бичлээ.

Губернатив үйл ажиллагаа гэдэгт төрийн үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлдог, тодорхойлсон чиглэлийнхээ хүрээнд төрийн үйл ажиллагааг уялдуулан зохицуулдаг, ингэхдээ төрийн үйл ажиллагааг улс төрийн удирдлагаар хангах замаар улс төрийн хувьд удирддаг Засгийн газрын улс төрийн шинжтэй үйл ажиллагааг ойлгоно.¹² Тухайлбал, Засгийн газраас үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, үндэсний болон бүс нутгийн бодлого, салбарын бусад бодлогын баримт бичиг боловсруулж батлах, түүнийгээ хэрэгжүүлэхдээ доод шатны байгууллагууддаа удирдамж, чиглэл өгөх, улс төрийн удирдлагаар хангах, Төрийн албаны тухай хуульд заасан улс төрийн албан тушаалтнуудыг эрх хэмжээнийхээ хүрээнд томилж, чөлөөлөх гэх мэт Засгийн газрын улс

⁷ Wolff/Bachof, Verwaltungsrecht I, §2 III дахь хэсэгт

⁸ Hartmut Maurer, Allgemeines Verwaltungsrecht, 16. Auflage, Verlag C.H.Beck, P. 3.

⁹ Мөн тэнд

¹⁰ Улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагаа, Т.М.

¹¹ Alfred Katz, Staatsrecht Grundkurs im öffentlichen Recht, 12. überarbeitete Auflage, Verlag C.F.Möller, P. 192.

¹² Мөн тэнд.

төрийн шинжтэй¹³ үйл ажиллагаа нь губернатив үйл ажиллагаа болно.

Засгийн газрын губернатив үйл ажиллагаа нь нэгэнт захиргааны үйл ажиллагаа биш тул Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гадуур байна. Гэтэл манай улсын өнөөгийн шүүхийн практикаас авч үзэхэд Захиргааны хэргийн шүүх Засгийн газрын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг түүний захиргааны үйл ажиллагаанаас тодорхой зааглахгүйгээр захиргааны хэрэг үүсгэх, улмаар улс төрийн болон бодлогын шинжтэй Засгийн газрын шийдвэрийг хянах тохиолдол цөөнгүй гарсан байна. Өөрөөр хэлбэл, ЗЕХ-ийн 3 дугаар зүйлийн 3.1.7¹⁴ дахь заалтад заасан захиргааны байгууллагын улс төрийн шийдвэр гаргах ажиллагаа захиргааны үйл ажиллагаа биш гэсэн заалтыг анхаарахгүйгээр, эсхүл түүнийг буруу тайлбарлан хэрэглэж байгаа асуудал захиргааны хэргийн шүүхийн практикт байгааг анхаарах хэрэгтэй байна.

Харин административ буюу захиргааны үйл ажиллагаа гэдэг нь хууль тогтоогчийн баталсан хууль болон Засгийн газраас гаргасан шийдвэрийн хүрээнд тодорхойлогдсон буюу зохицуулагдсан, хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх хүрээнд хууль, эрх зүйтэй холбогдсон үйл ажиллагааг ойлгоно.¹⁵ Тодруулбал, энд Засгийн газрын болон бусад захиргааны байгууллагын хууль биелүүлж байгаа захиргааны шинжтэй бүх үйл ажиллагаа хамаарна.

¹³ Политика буюу улс төр гэх ухагдахууны хүрээнд нийгмийн амьдралыг удирдан зохион байгуулах төрөл бүрийн бодлогыг ойлгодог. Жишээ нь: Хууль зүйн бодлого, эдийн засгийн бодлого, соёлын бодлого, бүс нутгийн бодлого гэх мэт. Энэ талаар Wolff/Bachof, Verwaltungsgesetz I, § 18 b дахь хэсэгт.

¹⁴ Зарчмын хувьд уг заалтын гол зорилго бол аливаа захиргааны байгууллагын улс төрийн болон бодлогын шинжтэй үйл ажиллагааг захиргааны үйл ажиллагаа биш гэж тооцож, энэ хүрээнд Захиргааны хэргийн шүүх иргэн, хуулийн этгээдийн эрхийн зөрчил бий болсон эсэхийг хянах шаардлагагүй байхаар хуульчилсан ач холбогдлыг анхааран үзэх шаардлагатай юм, Т.М.

¹⁵ Wolff/Bachof, Verwaltungsgesetz I, 76 дахь талаас эхлэн үзэх.

Нэгэнт энэ харилцаанд хууль тогтоогчийн батлан гаргасан хуулийг Засгийн газар болон бусад захиргааны байгууллагууд хэрэглэж, хэрэгжүүлдэг тул иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн, эсхүл зөрчсөн шийдвэр гаргадаг. Тийм учраас Засгийн газар болон бусад захиргааны байгууллагууд нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн, эсхүл зөрчсөн бол шүүхээс тэдгээр иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг сэргээх ёстой¹⁶ тул Засгийн газрын болон бусад захиргааны байгууллагын административ буюу захиргааны шинжтэй үйл ажиллагаа нь иргэний эрхийг зөрчсөн бол тэрхүү зөрчигдсөн эрхийг шүүх сэргээх нь зайлшгүй бөгөөд гарцаагүй байх учиртай болдог. Тийм ч учраас хууль тогтоогч Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ”, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 дэх заалтад “Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлд зааснаас бусад байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа болон тэдгээрийн гаргасан захиргааны актын талаар гаргасан гомдол”-оор иргэний хэрэг үүсгэх тухай зааж өгчээ. Дээрхээс дүгнэвэл, Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол захиргааны болон иргэний хэргийн шүүх тус тусын хэргийн харьяаллын дагуу маргааныг шийдвэрлэх нь тодорхой байх бөгөөд хэрэв аль ч шүүх тухайн маргааныг авч хэлэлцэхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн цэц аль нэг шүүхэд хэргийн

¹⁶ Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2, 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт иргэний зөрчигдсөн эрхээ шүүхээр сэргээлгэх үндсэн эрхийг баталгаажуулж өгсөн байдгийг анхаарах.

харьяалал тогтоож өгнө¹⁷. Энэ бол эрх зүйт төрийн суурь зарчим юм.

Монгол Улсын Засгийн газар тодорхой иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн шинжтэй шийдвэр гаргах хууль зүйн боломж бусад улсын Засгийн газартай харьцуулахад маш өндөр байдаг.¹⁸ Жишээ нь: Тамхины хяналтын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт заасны дагуу “Тамхи үйлдвэрлэх, тамхины ургамал тарих үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүнс, хөдөө аж ахуйн, тамхи импортлох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг тус тус үндэслэн Засгийн газар олгоно”, Газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалтад заасны дагуу “улсын тусгай хэрэгцээнд авахтай холбогдуулан газрыг солих буюу эргүүлэн авах тохиолдолд нөхөх олговор олгох”, 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт заасны дагуу “Газар зохион байгуулалт хийх тухай Засгийн газрын ... шийдвэрийг холбогдох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага биелүүлэх үүрэгтэй”, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсэгт заасны дагуу “Засгийн газар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга газар эзэмшигч, ашиглагчтай урьдчилан тохиролцож, гэрээ байгуулсны үндсэн дээр бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг тодорхой хугацаатайгаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглаж болно”, 46.2 дахь хэсэгт заасны дагуу “Засгийн газар нийгмийн зайлшгүй шаардлагыг үндэслэн бусдын эзэмшил, ашиглалтад байгаа газрыг уг шаардлага арилтал захиргааны журмаар нийтийн эдэлбэрт болон тусгай хэрэгцээнд төлбөртэй буюу төлбөргүйгээр ашиглах

тухай шийдвэр гаргаж болно”, Хөрөнгө оруулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт заасны дагуу “Засгийн газар 500 тэрбум төгрөгөөс дээш хэмжээний хөрөнгө оруулалт хийх хөрөнгө оруулагчтай түүний гаргасан хүсэлтийн дагуу үйл ажиллагаа явуулах орчныг нь тогтвортой байлгах зорилгоор хөрөнгө оруулалтын гэрээ байгуулна”, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу “Засгийн газар нь ... иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн Засаг даргын саналыг харгалзан өмчийнх нь хэлбэрийг үл харгалзан зогсоох” гэх мэтчилэнгээр холбогдох салбарын хуулиудаар иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн захирамжилсан шийдвэр гаргах хууль зүйн боломж Монгол Улсын Засгийн газарт маш их байна.

Тиймээс үүнийг тодруулахын тулд Монгол Улсын Засгийн газар Захиргааны хэргийн шүүхэд хариуцагчаар оролцсон тохиолдлыг судалж үзсэн бөгөөд ЗЕХ хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн хугацаанаас хойш нийт 21¹⁹ кэйс гарсан байна. Түүнчлэн, Монгол Улсын Засгийн газраас 2017 онд гаргасан нийт шийдвэрүүдээс 106 шийдвэрийг түүвэрлэн авч, тэдгээрт эзлэх захиргааны акт, захиргааны хэм хэмжээний акт болон улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэрийн хувийг тодорхойллоо. Тус 106 шийдвэрийн **8.55%** хувь буюу **9** нь захиргааны акт, **42.4%** хувь буюу **45** нь захиргааны хэм хэмжээний акт, **49.05%** хувь нь буюу **52** нь улс төрийн болон бодлогын шинжтэй шийдвэр байна.

¹⁷ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 14 дүгээр зүйл.

¹⁸ Тухайлбал, ХБНГУ, Австри зэрэг орнуудын Холбооны Засгийн газар нь шууд иргэн, хуулийн этгээдэд чиглэсэн шийдвэр гаргах тохиолдол түгээмэл бус буюу тийм хууль зүйн боломжийг хууль тогтоогч олгохгүй байхыг анхаардаг, Т.М.

¹⁹ Шүүхийн шийдвэрийн цахим санд нээлттэй байгаа шийдвэрийг түүж судалсан болно. Энэ тайлангийн Хавсралт 3-т хавсаргав. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн судалгаа, мэдээлэл, сургалтын хүрээлэнгийн гаргасан “Засгийн газрын шийдвэр шүүхийн хяналтад байх нь: Үндсэн хуулийн цэц болон ердийн шүүхийн харьяаллын асуудал” сэдэвт судалгааны тайланд 35 кэйс байгаа тухай дурджээ https://drive.google.com/file/d/19bHUiDJ0QOQ4Qig_7qOhL0KErYzjlCsn/view

Дээрх бүгдээс дүгнэж хэлбэл, Засгийн газар нь эртний Грекийн Янус бурхан²⁰ мэт хоёр нүүртэй субъект гэж хэлж болох бөгөөд губернатив болон административ үйл ажиллагааг аль алиныг нь явуулдаг. Гагцхүү Засгийн газрын губернатив үйл ажиллагаа нь улс төрийн бодлогын шинжтэй удирдлагын үйл ажиллагаа байдаг тул Захиргааны хэргийн шүүхийн хяналтаас гадуур байна. Харин Засгийн газрын хуулийг биелүүлж буй захиргааны шинжтэй үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтад байх учиртай байна.

3. Монгол Улсын Засгийн газар ба Үндсэн хуулийн цэцийн шийдвэр

Монгол Улсын Засгийн газар захиргааны байгууллага биш тухай маргаан практикт байдгийг үгүйсгэхгүй²¹ бөгөөд энэхүү маргаан нь Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээс улбаатай юм.²²

Тухайн маргааны хүрээнд Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан нэр бүхий иргэд "... Монгол Улсын Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д Монгол Улсын Засгийн газраас гаргасан шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянан үзэхээр зааж, уг хуулийн 8.1.2-т заасны дагуу хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч болохоор заасан нь Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1, 45

дугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн. Учир нь, Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 1-д: "Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн", мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1-д: Засгийн газар нь "Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах" бүрэн эрхтэй гэж заасан. Ийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуулийн 41 дүгээр зүйлд "1.Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг УИХ-ын өмнө хариуцна. 2.Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана", 45 дугаар зүйлийн 2-т: "Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно" гэж хуульчилсан" гэж өөрсдийн мэдээллийн шаардлагыг үндэслэсэн байна.

Харин тухайн үед УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдон оролцсон УИХ-ын гишүүн Р.Эрдэнэбүрэн, С.Баярцогт нар мэдээлэл гаргасан иргэдийн үндэслэлийг няцааж "... Захиргааны байгууллага, албан тушаалтан нь нийтийн ашиг сонирхлыг илэрхийлсэн хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр бусдыг захирамжилсан, иргэн, хуулийн этгээдийн Үндсэн хууль, бусад хууль, олон улсын гэрээнд заасан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн олон тооны шийдвэр гаргаж байгаа боловч практикт захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хяналт тавих, тэдний гаргасан захиргааны актын хууль зүйн үндэслэлийг хянах механизмыг оновчтой тогтоох зорилгоор Засгийн газраас 2001 оны 5 дугаар сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн төслийг өргөн мэдүүлсэн бөгөөд энэ хуулийн төсөлд захиргааны хэргийн шүүх нь Монгол Улсын Ерөнхийлөгч,

²⁰ Янус бурхан – Эртний Грекийн домогт гардаг хоёр нүүртэй бурхан, Т.М.

²¹ Тухайлбал Хурдан морины бүсийн уралдааны 2017 оны хуваарийг тогтоох тухай Засгийн газрын 2017 оны 63 дугаар тогтоолын хүрээнд практикт маргаан гарч, Захиргааны хэргийн шүүхээр уг маргаан нь шийдвэрлэгдсэн билээ. Тухайн үед Монгол Улсын Засгийн газар захиргааны байгууллага мөн/биш гэсэн байр суурь хуульчдын дундаас гарч, энэ талаар 2017 онд "Шүүхийн хяналт ба Засгийн газар" сэдэвт хуульчдын нээлттэй хэлэлцүүлгийг Монголын хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос зохион байгуулж байсан байна, Т.М.

²² С.Магнайсүрэн, Б.Энхбаяр нарын мэдээллийн дагуу "2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 болон 4.1.6 дахь заалт нь Үндсэн хууль зөрчсөн" гэж дүгнэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлт. <http://www.legalinfo.mn/law/details/997?lawid=997>

Монгол Улсын Засгийн газар, Засгийн газрын гишүүн /Ерөнхий сайд, сайд/, Монгол Улсын яам, Сонгуулийн ерөнхий хороо гэх мэт нийтийн эрх зүйн 17 субъекттэй холбогдсон маргааныг хянан шийдвэрлэхээр тусгасан байв. Улсын Их Хурлын чуулганаар Ерөнхийлөгчөөс эрх зүйн үр дагавар шууд бий болгодог захирамжилсан шийдвэр гаргах явдал бараг тохиолдохгүй мөн Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчсөн бол огцруулах асуудлыг нэгэнт Үндсэн хуулиар зохицуулсан учир хуулийн “Монгол Улсын Ерөнхийлөгч” гэсэн заалтыг хасч, харин гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болсон Засгийн газрын шийдвэр нь шүүхийн журмаар хянагдаж байх нь зүйтэй гэж үзэж хуулийн төсөлд хэвээр үлдээжээ. Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2-ийн “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа; хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна. Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 12-т Монгол Улсын иргэн “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй”, мөн зүйлийн 14-т “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх... шударга шүүхээр шүүлгэх... эрхтэй” гэсэн заалтыг иш үндэс болгож, улмаар Монгол Улсын нэгдэн орсон олон улсын конвенцийн, тухайлбал, Хүний

эрхийн түгээмэл тунхаглалын “Үндсэн хууль бусад хуулиар олгосон эрх нь зөрчигдвөл хүн бүр эрх мэдэл бүхий үндэсний шүүхээр эрхээ бүрэн сэргээн тогтоолгох эрхтэй” гэсэн Наймдугаар зүйл, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын “Хүн бүр хуулийн өмнө адил тэгш бөгөөд ямар ч ялгаварлан гадуурхалтгүйгээр хуулиар адилхан хамгаалуулах эрхтэй...” гэсэн Хорин зургадугаар зүйлийн заалтуудыг баримтлан захиргааны хэргийн шүүхээс Монгол Улсын Засгийн газрын гаргасан захиргааны хууль бус акттай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэх тухай асуудлыг хуульчилсан...” хэмээн үндэслэл бүхий тайлбар өгч байжээ.²³

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц дээрх маргааныг хянан шийдвэрлэж, 2005 оны 02 дугаар дүгнэлтийг гаргасан бөгөөд тухайн үеийн Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалт нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1, Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсгийн заалтыг зөрчсөн байна гэж шийдвэрлэсэн байдаг. Ийнхүү шийдвэрлэхдээ дэвшүүлсэн үндэслэл нь “Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Засгийн газар төрийн гүйцэтгэх дээд байгууллага болохынх нь хувьд түүний шийдвэр хуульд нийцээгүй тохиолдолд хүчингүй болгох эрх бүхий субьектийг Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон байна. Улсын Их Хурал, Засгийн газар Үндсэн хуульд заасан үүргээ биелүүлээгүй тохиолдолд Үндсэн хуулийн цэцэд хандаж шийдвэрлүүлж болох нь нээлттэй байна. Хууль тогтоогчоос Засгийн

²³ Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээс үзэх.

газрын шийдвэрийг Захиргааны хэргийн шүүх хянаж байхаар хуульчилсан нь Үндсэн хуулиар тусгайлан тогтоосон Засгийн газар, Улсын Их Хурлын эрх хэмжээнд халдсан гэх үндэслэл тогтоогдож байна” гэсэн байдаг.²⁴

Гэвч Үндсэн хуулийн цэц дээрх дүгнэлтээ гаргахдаа УИХ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч нарын гаргасан тайлбарт байсан “... Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно” гэсэн заалт нь нэгдүгээрт, төрийн гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллага болох Засгийн газарт гаргасан алдаагаа өөрөө засах боломж олгож байгаа; хоёрдугаарт, хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах бүрэн эрхийнхээ хүрээнд Улсын Их Хурлаас Засгийн газрын гаргасан алдааг залруулах явдлыг зохицуулсан зүйл гэж үзэж байна...” гэсэн үндэслэлтэй тайлбарт огт дүгнэлт хийгээгүй, түүнчлэн Засгийн газар Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн, тэрхүү шийдвэр нь иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг зөрчсөн бол ямар шүүх хянах вэ гэдгийг бодолцохгүйгээр рациональ бус шийдвэр гаргасан байдаг.

1992 оны Үндсэн хуулийн эх баригч, нэрт эрдэмтэн Б.Чимид багш дээрх маргааныг шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтийг хурцаар шүүмжилж 2005 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр сонинд ярилцлага өгсөн байдаг бөгөөд түүнд “... Захиргааны хэргийн шүүх “дараах байгууллага, албан тушаалтнаас гаргасан захиргааны хууль бус актад холбогдох маргааныг хянан шийдвэрлэнэ” гэсэн уг хуулийн IY зүйлийн нэг дэх хэсгийн заалт буюу хариуцагч байгууллагын нэрийн жагсаалтаас “Монгол Улсын Засгийн

газар”, “Сонгуулийн ерөнхий хороо” гэсэн (4.1.1, 4.1.6) заалтыг Үндсэн хууль зөрчсөн гэж үзсэн юм. Ойлогмжгүй, мэргэжлийн бус энэ дүгнэлтийг нь парламент нухацтай хэлэлцэлгүй уухайн тас гэсэн мэт шууд л хүлээн зөвшөөрсөн. Ингэснээр Монголд үүсгэн төлөвшүүлж буй ардчиллын чухал механизм, хүний эрх, шүүх эрх мэдлийн хүрээнд болон хуульд эдлэх ёсонд харш ноцтой хохирол учруулах үр дагавар бий болгосон юм. Уг асуудал нарийн мэргэжлийн нэлээд эдрээтэй зангилаа учраас олон түмэн төдийлөн анхаарч, учрыг нь ойлгоогүй байж болох юм. Хураангуйлж дүгнэвэл Үндсэн хуулийн цэц, УИХ-ын эл шийдвэр нь нэгдүгээрт, гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох Засгийн газар, түүний гишүүд, яам болон Засгийн газрын гишүүний тэргүүлсэн агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын хийгээд сонгуулийн хууль биелүүлэх үүрэгтэй гүйцэтгэх байгууллагын засаг захиргааны үйл ажиллагааг шүүхийн хяналтаас гаргаж дархаллаа. Хоёрдугаарт, аливаа хэрэг, эрх зүйн маргааныг эцсийн дүнд гагцхүү шүүх хянан төгс шийдвэрлэнэ гэсэн агуулга бүхий Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хөсөрдүүлж, шүүхийн хараат бус байдалд халдан нэг шүүх (Цэц) нь нөгөө шүүхийнхээ Үндсэн хуульчлагдсан бүрэн эрхийг хасч хязгаарлалаа. Гуравдугаарт, Цэц, УИХ хоёрын шийдвэрийн хамгийн ноцтой бөгөөд нэлээд далд мэт гажуудал нь “төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх”, “Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах”, “шударга шүүхээр хэргээ шүүлгэх” зэрэг Үндсэн хуулиар олгогдсон улс төрийн эрхүүдээ иргэд Захиргааны хэргийн шүүхээр хамгаалуулах эрх, боломжоо хэрэг дээр хасууллаа” гээд мөн түүнчлэн “... Засгийн газар нь долоо хоногт дор

²⁴ Үндсэн хуулийн цэцийн 2005 оны 02 дугаар дүгнэлтээс үзэх.

хаяж нэг удаа хуралдаж эрх зүйн бүх салбарт хамаатай, захирамжилсан болон хэм хэмжээ тогтоосон олон зуун шийдвэр гаргадаг. Тухайлбал, 2001-2004 онд 1,000 гаруй тогтоол, 600 шахам захирамж гаргасан байна лээ. Мөн эгзэгтэй асуудлаар Засгийн газар “тэмдэглэл” буюу протокол гаргадаг. Одоогийн хуулиар гаргасан шийдвэр нь тогтоол, протоколын алин байхаас үл хамааран “захирамжилсан л бол захиргааны акт” гэх болсон. Засгийн газраас гаргаж буй акт нь зөвхөн Үндсэн хуулийн холбогдолтой асуудлыг биш хүний болон тэдгээрийн хамтлаг (хуулийн этгээд)-ийн эрх, хууль ёсны ашиг сонирхлын асуудлыг ямар нэг байдлаар хөндөхүйц үр дагавартай, үүгээрээ эрх зүйн бүх салбарт холбогдолтой байдаг. Гэтэл Цэц маань Засгийн газрын аливаа шийдвэр УИХ-аас цааш явахгүй, эсвэл Цэц л бүгдийг нь шийдэх юм шиг “гэндсэн” буюу мэдэн будилсан байна. Цэц ийм шийдвэр гаргахдаа “Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө болон УИХ хүчингүй болгоно” гэсэн заалтыг үндэслэл болгожээ. Энэ заалтыг юм юмнаас салгаад дангаар нь урдаа барьчихвал нээрэн шүүх биш УИХ хүчингүй болгох ёстой юм байна гэж жирийн хүмүүс бодмоор. Гэтэл алдаагаа болж өгвөл өөрөө сайн дураар залруулах, эсхүл шууд хяналт тавьдаг дээд байгууллага нь хүчээр зогсоож арилгах хоёр боломжийг засаг захиргааны байгууллагад хуулиар олгосоор ирсэн юм. Байцаагч буруу шийдвэр гаргаж торгосон байвал ахлах байцаагч нь, шууд захирах дарга нь түүнийг хүчингүй болгож болдгоо доо. Энэ бол захиргааны буюу гүйцэтгэх эрх мэдлийн байгууллагуудын шатлан захирагдах зарчмын онцлог билээ. Үүнийг дэлхий дахинаа мэдэж бурхан ч зөвшөөрдөг ...”²⁵ гэх мэтээр Засгийн

газрын захиргааны шинжтэй үйл ажиллагаа нь Захиргааны хэргийн шүүхийн хяналтын дотор байх ёстой тухай Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн онол дээр тулгуурлан тайлбарласан байна.

Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хууль зөрчсөн гэж 2005 онд дүгнэсэн 2002 оны Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль өнөөдрийн байдлаар бүхэлдээ хүчингүй болсон бөгөөд 2016 онд батлагдаж, одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэгт “Захиргааны хэргийн шүүх Үндсэн хуулийн цэц болон өөр шүүхэд харьяалуулснаас бусад нийтийн эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэнэ”, мөн зүйлийн 13.2 дахь хэсэгт “Захиргааны ерөнхий хуулийн 3.1-д заасан үйл ажиллагаа нь захиргааны хэргийн шүүхийн хянан шийдвэрлэх маргаанд хамаарахгүй” хэмээн Үндсэн хуулийн цэцэд харьяалуулснаас бусад маргааныг, тухайлбал, Засгийн газрын захиргааны шинжтэй үйл ажиллагаа нь Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх маргааныг Захиргааны хэргийн шүүх хянан шийдвэрлэхээр зааглан тогтоосон болно.

4. ДҮГНЭЛТ

Өгүүлэлд дурдсан зүйлсийг нэгтгэн дүгнэвэл:

1. Засгийн газрын үйл ажиллагааг губернатив буюу улс төрийн-бодлогын, административ буюу захиргааны үйл ажиллагаа гэж хоёр ангилан авч үздэг бөгөөд Засгийн газрын захиргааны үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол нь зөрчигдсөн бол ердийн шүүх (тэр дундаа Захиргааны хэргийн шүүх) тэрхүү зөрчигдсөн эрхийг сэргээх учиртай гэдэг нь үндсэн хуульт ёс, эрх зүйт төрийн зарчмын зүй ёсны нэгэн шаардлага болно.

²⁵ Б.Чимид “Цэцийн шийдвэр буруу нь мэдсээр атлаа дуугүй байгааг нь гайхаж сууна” гарчиг бүхий ярилцлага. <https://ikon.mn/n/19xu>

2. Монгол Улсын Засгийн газар нь бусад орны Засгийн газартай харьцуулахад иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, эрх зүйн үр дагавартай шийдвэр гаргах хууль зүйн өргөн боломжтой болох нь холбогдох салбарын хуулиудад иргэн, хуулийн этгээдэд шууд чиглэсэн, тухайлсан шинжтэй шийдвэр гаргах болон нийтээр дагаж мөрдөх олон тооны захиргааны хэм хэмжээний актыг батлан гаргах боломжийг олгосон байгаагаар нотлогдож байна. Тухайлбал, 2017 онд Засгийн газраас гаргасан 106 шийдвэрийг түүвэрлэн үзэхэд 8.55% хувь буюу 9 нь захиргааны акт, 42.4%

хувь буюу 45 нь захиргааны хэм хэмжээний акт байгаа нь Засгийн газрын энэхүү захиргааны үйл ажиллагааг шүүхээс хянах үндэслэл болж байна.

3. Монгол Улсын Засгийн газрын шийдвэр, үйл ажиллагаагаар иргэн, хуулийн этгээдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдсөн бол захиргааны болон иргэний хэргийн шүүх тус тусын хэргийн харьяаллын дагуу маргааныг шийдвэрлэх нь тодорхой байх бөгөөд хэрэв аль ч шүүх тухайн маргааныг авч хэлэлцэхгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн цэц аль нэг шүүхэд хэргийн харьяалал тогтоож өгнө. Энэ бол эрх зүйт төрийн суурь зарчим юм.

---o0o---

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН АЖИЛТНУДАД СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛЛАА

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс эрхлэн Улсын Их Хурлаас шинээр баталсан хуулийг танилцуулах олон нийтэд хүргэх ажлын хүрээнд “Захиргааны ерөнхий хуулийн хэрэгжилт, анхаарах асуудал” сэдэвт сургалтыг Эрүүл мэндийн яамны харьяа байгууллага болон төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, аймаг нийслэлийн эрүүл мэндийн газрын хуульч, хүний нөөцийн мэргэжилтнүүдэд зохион байгууллаа. Сургалтыг Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Хууль зүйн сургалт, мэдээлэл, сурталчилгааны төвийн эрхлэгч А.Түвшинтулга хөтлөн явуулав.

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ БА ЭРҮҮЛ МЭНДИЙН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА



*МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн
тэнхимийн багш, судлаач
О.Чулуунцэцэг*

ТҮЛХҮҮР ҮГ

Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эрүүл мэндийн даатгал, нөхөн үржихүй, ахмад настан

ТОВЧЛОЛ

Шинжлэх ухааны үсрэнгүй хөгжил хурдтай өрнөж буй одоо үед анагаахын шинжлэх ухааны нээлтүүд удаа дараалан гарч, тодорхой туршилт судалгаанууд хийгдэж байгаагийн улмаас улс орон бүр иргэдийнхээ эрүүл мэндийг хамгаалах бие даасан хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлж байна.

Улс орон хөгжлийнхөө гарцыг тодорхойлохдоо иргэдийнхээ эрүүл мэнд, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд онцгой анхаарал хандуулдаг болжээ.

Монгол Улсын иргэд нь суурин соёл иргэншилтэй бусад орнуудаас

ялгарах гол онцлог нь нүүдлийн соёл иргэншил давамгайлсан, байгаль экологид ойрхон амьдрах боломж нь бидний эрүүл амьдрах үндсийг тавьж байна.

Иймд экологийн цэвэр бүтээг-дэхүүнээр иргэдийг хангаж, эрүүл мэнд, биеийн эсэргүүцлийн чадвар, амьдралын хэв маяг, зан заншлын уламжлалыг дээдлэн үндэсний хөтөлбөр, арга хэмжээг бие даан хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Манай улсын хуульд хүн өвчин, эмгэггүй, бие бялдар, оюун санаа, нийгмийн амьдралын хувьд сайн сайхан байхыг эрүүл мэнд гэж тодорхойлсон. Эрүүл мэнд бол хувь хүний үнэт зүйл төдийгүй эрүүл мэндээ хамгаалах нь иргэн бүрийн үндсэн үүрэг байдаг.

УДИРТГАЛ

Нийгмийн даатгалын төрлийн салшгүй хэсэг бол эрүүл мэндийн даатгал бөгөөд эмнэлгийн тусламж, үйлчилгээ авах эрх хангагдах үндсэн шалтгаан болдог.

Хөгжингүй улс орнууд эрүүл мэндийн философийг хөгжүүлэх, түүний хүрээнд нийгмийн хамгаалал болон эрүүл мэндийн хамгааллын бодлогыг хэрэгжүүлэх арга замыг илүүтэйгээр судалж, асуудлыг шийдвэрлэх болсон төдийгүй манай орны хувьд монгол ахуй, ёс заншлыг эргэн харж, эрүүл мэндийн бодлого боловсруулал, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үйлдвэрлэлд эмийн ургамал, байгалийн цэвэр бүтээгдэхүүнийг орчин үеийн технологиор үйлдвэрлэж хэрэглэх хэрэгцээ гарч ирсэн.

1. Эрүүл мэндийн хамгааллын философийн үзэл баримтлал

Эрүүл мэндийг хамгаалах философийн үндсэн суурь таван зарчим байдаг. Үүнд:

I. Эрүүл мэндийг хамгаалахын тулд үндэсний эрүүл мэндийн бодлогыг төлөвлөх

II. Төрийн халамж үйлчилгээнд найдахаас аль болохоор зайлсхийж, хувь хүний хариуцлагыг нэмэгдүүлэх

III. Олон улсын стандартад нийцсэн эрүүл мэндийн үйлчилгээгээр хангах

IV. Иргэд эмч, эрүүл мэндийн байгууллагыг сонгож үйлчлүүлснээр чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, чанар, иргэдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх

V. Иргэний эрүүл мэндийг хамгаалах, эрсдэлээс сэргийлэхийн тулд төрийн оролцоо, хяналтыг бий болгох

Дээрх зарчмын хүрээнд эрүүл мэндийн хамгааллын үндсэн тусламж нээлттэй байх, эрүүл мэндийн үйлчилгээний хангамж, эрүүл мэндийн болон эрүүл мэндийн тусламж үзүүлж байгаа байгууллагуудын санхүүжилт, үйл ажиллагааны чиглэл, анагаах ухааны судалгаа шинжилгээ, боловсрол сургалтыг явуулдаг байна.

Эрүүл мэндийн философийг хамгаалснаар нийгмийн үйлчилгээний тэгш байдлыг хангах, улс орны аюулгүй байдал, хүн амын хөгжлийн өсөлтийг дэмжих томоохон алхам болно. Үүний үр дүнд салбар шинжлэх ухаан хөгжиж, оюун ухааны үнэлэмж дээшилснээр хөгжлийн бодлого тодорхойлогддог. Төрийн бодлого, зохицуулалтыг оновчтой болгохын тулд эрүүл мэндийн талаар авч хэрэгжүүлж буй шийдвэр, үйл ажиллагааг үр дүнтэй тодорхой болгох шаардлагууд тулгарч байна. Манай орны хувьд салбарын хууль эрх зүйн орчин бүрдэж байгаа хэдий ч хууль хэрэгжилтийн үйл явцыг иргэдэд таниулах, мэдээлэх, судалгаа хийн

сайжруулах шаардлага үүсч байна. Гадаад улс орны амжилттай хэрэгжүүлж буй зарим эрх зүйн зохицуулалтын арга хэмжээний талаар дурдаж болно. Тухайлбал,

1) Их Британи Оксфордын толь бичиг буюу гарын авлагад шинжлэх ухаан түргэн хурдацтай хөгжлийн үр дүнд өвчин ба эрүүл мэндийн талаарх бидний ойлголт сайжрахын хэрээр өвчнөөс урьдчилан сэргийлэх, эмчлэх шинэ арга хэлбэр бий болсоор байна. Хэдий тийм боловч нөөц хязгаарлагдмал нөхцөлд эрүүл мэндийн дээд зэргийн үр дүнд хүрэхийн тулд эрүүл мэндийн бодит хэрэгцээнд суурилсан тэгш, хүртээмжтэй эрүүл мэндийн тогтолцоог бий болгох шаардлагатай байдаг талаар тэмдэглэжээ. Түүнчлэн дэлхий нийтийн чиг хандлага нь ялангуяа хөгжиж буй орнуудын хувьд иргэдээс эрүүл мэндэд шаардлагатай хөрөнгийг бага багаар урьдчилан төвлөрүүлэх замаар эрүүл мэндээс үүдэлтэй санхүүгийн эрсдэлээс хамгаалах, ядуурлыг бууруулахад чиглүүлэх ёстой гэж үзсэн¹. Мөн хүмүүс эрүүл мэндийн тусламж үзүүлж байгааг мэддэг, хамрагдах боломжтой гэдгээ ойлгосон, хол явж, удаан хүлээж, эсвэл их хэмжээний төлбөр төлдөггүй байх хэрэгтэй² гэсэн чиг хандлагыг баримталдаг байна.

2) Олон улсын туршлагаас үзвэл урьдчилан сэргийлэх эмнэлгийн албад нь өвчнөөс урьдчилан сэргийлэх, экологийн байдлыг тандах, хүнс, хоол тэжээл, ус агаар, салхины хяналт зэрэг асуудлыг хариуцдаг байна. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх анагаах ухааны мэргэжилтнийг магадлан итгэмжилдэг тогтолцоотой төдийгүй эрүүл мэндэд нөлөөлдөг нийгмийн ба зан үйлийн хүчин зүйл зэрэг эрүүл мэндийн анхдагч (өвчин эмгэг, осол гэмтэл үүсэхээс өмнө авах арга

¹ Эрүүл мэндийн эдийн засгийн үндсэн ойлголтууд. ЭМЯ, АХБ. УБ. 2006 он. 36 дахь тал.

² Нийгмийн эрүүл мэндийн Оксфордын гарын авлага. Эрүүл мэндийн яам, ЭМСХ-2 төсөл. УБ., 2001 он. 347 дахь тал.

хэмжээ), хоёрдогч (өвчин эмгэг үүссэн буюу үүсэх эмгэгт байдал бий болсон, хөдөлмөрийн чадвар алдалт, хөгжлийн бэрхшээл үүсэхээс өмнөх арга хэмжээ), гуравдагч (хөгжлийн бэрхшээл нэгэнт бий болсон бол даамжирч бусдын хараат болохоос өмнө арга хэмжээ) урьдчилан сэргийлэлтийн стандарт шаардлагыг тавьдаг.³ Тухайлбал, ямар нэгэн өвчин хавдар болохоос өмнө, нөхөн сэргээх эмчилгээ хийх гэх мэт.

3) Узбекистанд эрүүл хооллолт, идэвхтэй хөдөлгөөнийг сурталчилдаг бол Канадад эмнэлгийн тусламж авсныхаа төлөө шууд төлбөр төлдөггүй, тэдэнд даатгалын гэрээгээр зарлагыг нь өгөх бөгөөд тусламж авсны янз бүрийн баримт бичиг бөглөх шаардлагагүй байдаг байна.

4) Япон Улсын хуулиар эмнэлгийн байгууллагууд үйлчлүүлэгчээс татгалзах эрх байхгүй бөгөөд иргэн эмнэлгээ өөрөө сонгон үйлчлүүлэх эрхтэй байдаг. Даатгуулагч эсхүл даатгуулагч байсан этгээд нь өөрийн санаатай үйлдлийн улмаас эрүүгийн гэмт хэрэг, эсхүл тэтгэмж авах шалтгааныг санаатайгаар бий болгосон тохиолдолд үйлдсэн үйлдэлд холбогдон үүссэн даатгалын тэтгэмжийн хөнгөлөлт үзүүлдэггүй байна⁴.

5) Германд үнэ төлбөргүй эмнэлгийн тусламж үзүүлэх, өвчилсөн үед мөнгөн тэтгэмж олгох, даатгал төлсөн бол аль ч эмнэлэгт үйлчлүүлэх эрх нь нээлттэй байдаг.

6) Казахстан Улсад өвчтөний хувийн мэдээллийг агуулж буй цахим мэдээллийн нөөцийг бүрдүүлэх хувийн мэдээллийг боловсруулах, засахыг өвчтөн буюу түүний хууль ёсны төлөөлөгчийн зөвшөөрлөөр гүйцэтгэх ба өвчтөний түүх болон хувийн мэдээллийг тухайн эмчилж буй эмнэлэг эмчилж эхэлсэн цагаас хадгалах

үүргийг хүлээдэг. Тухайн эмнэлгийн байгууллага нь эмчлүүлж буй өвчтөний хувийн мэдээллийг ашиглан өөр ашигтай байдал үүсгэхийг хориглодог⁵. Иргэд өөрийнхөө эрүүл мэндэд санаа тавих үүрэгтэй бөгөөд өөрийн болон хамаарал бүхий этгээдүүдийн эрүүл мэндэд байнга анхаарал тавьж байхаар хуульчлагджээ. Мөн тээгч эх болон тээлгүүлэгч гэр бүлийн хооронд харилцан тохиролцож гэрээ байгуулсны дагуу тодорхой шан харамж, үнээр тээж төрүүлэх ба тээх явцад гарсан эрсдэлийг тээлгүүлэгч болох гэр бүлийн хүмүүс хариуцахаар зааж Гэр бүлийн болон Гэрлэлтийн тухай хуулиар зохицуулдаг байна.

7) БНСУ-д иргэдийн амьдралын суурийг баталгаажуулахдаа эрүүл мэндийн болон соёлын хамгийн бага амьжиргааны түвшинд хүрч хамгаалах бөгөөд эрүүл мэндийг хамгаалах байгууллага нь амьжиргаа, орон гэр амьдрах газрын, эмчилгээний, боловсролын, амаржих, бүтээлийн, бие даан амьдрах олговрыг тогтоодог байна⁶.

8) ОХУ-д эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэхэд өвчтөний эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтлах, биеийн байдал, соёлыг харгалзан ёс суртахууны стандартыг сахин биелүүлэх, эмнэлгийн ажилтан болон эмнэлгийн байгууллагын бусад ажилтнуудын зүгээс хүндэтгэлтэй, хүнлэг хандлагатай байх, өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эрт илрүүлэх, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлдэг⁷.

9) БНХАУ-д эрүүл мэндийн байгууллага нь иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэхдээ гэрлэлтийн өмнөх эрүүл

⁵ Кодекс Республики Казахстан о Здравье народа и системе здравоохранения. 2018. Статья 28.

⁶ БНСУ-ын Иргэдийн амьдралын суурийг хамгаалах тухай хууль. 1997 он

⁷ Федеральный закон Об основах охраны здоровья граждан в Российской Федерации. 2011.

³ А.Дамдинсүрэн, Г.Ганчимэг. Зах зээлийн нөхцөл дэх эрүүл мэндийн тогтолцоо, эмнэлгийн тусламжийн чанар. УБ, 2015 он, 27 дахь тал.

⁴ Японы Эрүүл мэндийн даатгалын тухай хууль. 2017 он

мэндийн талаарх зөвлөгөө болон эмнэлгийн үзлэг хийлгэхийг шаарддаг ба анхан шатны оношилгоо, эмнэлгийн үйлчилгээ нь эрүүл мэндийн даатгалын үндсэн сангаас төлөгддөг⁸.

Улс орон бүр иргэдээ эрүүл байлгаж татвар төлөгч байхыг шаарддаг бөгөөд нийгмийн хамгааллын халамж, үйлчилгээ үзүүлэх бодлогоос зайлсхийдэг. Энэ нь тухайн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэнд хүндрэл учруулахгүй байх нөхцөл бололцоог төрөл бүрийн даатгалын аргаар зохицуулдаг. Үүгээрээ иргэдийн ажил хөдөлмөр эрхлэх, насжилтыг уртасгах боломжоор хангадаг. Иргэдийг хамгаалах эрх зүйн зохицуулалт нь тухайн засгийн газрын хэр оновчтой шийдвэр гаргаж байгаагаас хамааран зохистой зан үйлийг хэвшүүлж, хүн амаа өсгөх, улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлоход томоохон алхам болдог байна. Мөн нийгмийн даатгалын сан дээр төвлөрсөн мөнгөн орлогоос эрүүл мэндийн даатгал, халамж үйлчилгээ, тэтгэвэр тэтгэмжийн зардал хяналттайгаар хуваарилагдаж, захиран зарцуулагддаг.

2. Эрүүл мэндийн хууль тогтоомжийн хэрэглээний ойлголт

1. 2016-2030 оны Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд⁹ эрүүл мэндийн салбарт залуу гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүй, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, хөгжлийн бэрхшээлтэй иргэн болон өндөр настанд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэхээр заалтууд тусгагдсан. Тухайлбал, амьдралын эрүүл, зөв хэв маяг, зан үйлийг төлөвшүүлэх, эрүүл мэндийн боловсрол олгох, иргэд өөрсдийгөө хамгаалах, хөгжлийн бэрхшээл

үүсэхээс урьдчилан сэргийлэх¹⁰, хүнсний аюулгүй байдлыг сайжруулж, эрүүл хооллолтыг дэмжих, өсвөр үе, залуучууд гэр бүл төлөвлөлт, нөхөн үржихүйн үйл ажиллагааны чиглэлээр эмнэлгийн тусламж үйлчилгээний тоног төхөөрөмж, чанар аюулгүй байдлын цогц үйлчилгээгээр хангаж, нийгмийн хамгааллын үйлчилгээг сайжруулах, хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх, цус ойртолтыг бууруулахад чиглэгдсэн.

Дээрх төрийн бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд эрүүл мэндээс урьдчилан сэргийлэх, нөхөн үржихүйн боловсрол олгох, гэр бүл төлөвлөж буй эцэг эхчүүдэд 6-12 сарын хугацаанд халдварт болон халдварт бус өвчлөлийг бүрэн эмчилж эрүүлжүүлэх, удамшлын өвчтэй (дауны болон саа өвчин гэх мэт) хүүхдийг төрүүлэхгүй байх, эх хүүхдийн эрүүл мэнд, ургийг хамгаалснаар засгийн газрын бодлого, төлөвлөлт хэрэгжинэ. Хүүхдийн бие даасан эмнэлгийн тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх төвүүдийг ажиллуулах, шинээр баригдаж байгаа түлэнхийн эмнэлэг гэх мэт эмнэлгүүдэд зохицуулалт хийж хэрэгцээтэй эмчилгээ, оношилгоо, үйлчилгээнд чиглэгдсэн үйл ажиллагааны зохицуулалтын хэлбэрт оруулж ашиглах шаардлагатай. Түлэгдэлт өвчин нь үйлдвэрийн осол, хувь хүний хариуцлагагүй, хайхрамжгүй байдлаас үүсдэг бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өвчлөл нь олон хүчин зүйлээс шалтгаалдаг, байнгын тасралтгүй нөхөн сэргээх болон бусад эмчилгээг шаардаж байдаг.

(Иргэдийн нөхөн үржихүйн үйл ажиллагааг 20-иос дээш жилээр хяналтад бүртгэх, залуучууд, гэр бүл, нөхөн үржихүйн 18-45 насны хүүхэд төлөвлөж буй иргэдэд 6-12 сарын хугацаанд эрүүл мэндийн

⁸ Law of the People's Republic of China on medical practitioners. 1999

⁹ Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030. Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралт

¹⁰ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр. Засгийн газрын 2017 оны 321 дүгээр тогтоолын хавсралт

хяналтад оруулж, өвчлөлийг эмчилж, эрүүл мэндийн боловсролыг байнга дээшлүүлснээр өвчлөлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгож халдварт ба халдварт бус өвчин, удамшлын өвчлөлийг бууруулна).

II. Ахмад настанд чиглэсэн бодлого нь тэтгэвэр, орлогын баталгаагаар хангах, эрүүл, идэвхтэй насжилтын орчин бүрдэх, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох нөхцөлийг бүрдүүлэхээр хөтөлбөрт тусгагдсан. Энэ бодлогын хүрээнд эрүүл мэндийн өвчлөлөөс үүсч байгаа санхүүгийн эрсдэлийг бууруулах (эмийн хөнгөлөлт), ядуурлаас урьдчилан сэргийлэх, архаг хууч өвчин, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, мөн түүнчлэн хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулж, амьдралын нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн үр дүнгүүдийг бий болгоно. Ахмад настнуудад амьдралын нөхцөлийг сайжруулахад зориулан хийгдэх мэс заслууд (өвдөг, түнх, нуруу, хүзүү, үе мөч, протез гэх мэт)-ыг хийснээр тухайн өвчтөнийг хавсарсан өвчин, таргалалт үүсгэхгүй болон нийгмээс тусгаарлагдахгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ. Амьдралын нөхцөлийг сайжруулахад чиглэгдсэн эдгээр мэс заслуудыг хийхийн тулд хөдөө орон нутагт эрүүл мэндийн хуульд зааснаар тэгш, хүртээмжтэй хүргэх байдлаар хагалгааны өрөөнүүдийн тоог нэмэгдүүлэх, тээвэрлэлтийн зардлыг хэмнэх, иргэдэд хүндрэл чирэгдэл учруулахгүй, богино хугацаанд эмнэлгийн тусламж үйлчилгээг хурдан шуурхай авах, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдах нөхцөл боломжийг бүрдүүлэх хэрэгтэй. Үүний үр дүнд насжилтыг уртасгах, амьдралын чанарыг сайжруулах, нас баралтыг багасгах, хөдөлмөр эрхлэх бололцоогоор хангагдах боломжтой.

III. Хүн амын өвчлөл, нас баралтын шалтгаан болж байгаа өвчин, эмгэгийн оношилгоо, эмчилгээнд түлхүү анхаарч, тусламж, үйлчилгээний

чанар, хүртээмжийг сайжруулахаар зорилт тавьсан нь нэг талаас эмнэлгийн тусламж, үйлчилгээг дэмжиж байгаа хэдий ч нөгөө талаас нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг орхигдуулж байгааг анхаарах ёстой. Өөрөөр хэлбэл, Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-т нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хүн амын эрүүл мэндийн байдал, түүнд нөлөөлөх хүчин зүйлийг тандах, судлах, хянах, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, хүн амд эрүүл мэндийн боловсрол олгох үйл ажиллагаа хамаарна гэсэн ерөнхий заалтыг тусгасан. Хүн амын эрүүл мэндэд нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг судалж, дэмжиж байгаа үйл ажиллагааг явуулж байгаа хэдий ч иргэдийн өвчин эмгэг дорвитой буурахгүй, өвчлөл газар авч байгаа, мөн урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь төдийлөн үр дүнтэй хэрэгжихгүй байдлууд ажиглагдаж байна. Эрүүл мэндийн байгууллагууд нь өвчлөл үүссэний дараагаар нөхцөл байдлын шинжилгээ хийж, асуудал болгож тавихдаа эмнэлгийн тусламж үйлчилгээ хүрэлцэхгүй, тоног төхөөрөмж хүртээмжгүй, ажиллах нөхцөл буюу цалин хөлс бага, нийгмийн хангамж муу байна гэх зэргээр төрөөс санхүүжилт шаардах болжээ. Түүнчлэн хөдөө орон нутагт эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй байгаагаас нийслэл хотод хэт төвлөрөл бий болж хүн амын тоо ихсэж, эмнэлгүүдийн ачаалал нэмэгдэн, өвчлөл ихсэх хандлага ажиглагдаж, улмаар үзлэг, оношилгоо, шинжилгээ, үйлчилгээний дараалал нэмэгдэж байгаа нь хуулийн заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотой асуудал юм.

IV. Эмнэлгийн удирдлагын зохион байгуулалтад эмнэлгийн даргаас гадна удирдах зөвлөлтэй болгож, эрүүл мэндийн байгууллагын удирдлагын тогтолцоо, эмчилгээний чанарыг сайжруулахаар Эрүүл мэндийн тухай

хуулийн 17 дугаар зүйлийн 17.7-д төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлгийн төлөөлөн удирдах зөвлөл нь өмчлөгчийг төлөөлөх гурван гишүүн, тухайн эмнэлгийн хамт олныг төлөөлөх гурван гишүүн, олон нийтийг төлөөлөх гурван гишүүнтэй байх ба гишүүдийг Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.23-т эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, аймаг, дүүргийн засаг даргын тамгын газар нээлттэй сонгон шалгаруулахаар заасан нь тухайн эмнэлгийн удирдлага, үйл ажиллагаа, зохион байгуулалт, худалдан авалт, үйлчилгээнд бие даасан үйл ажиллагаа явуулахад нөлөөлөх магадлалтайг анхаарах хэрэгтэй. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.8-д эрүүл мэндийн даатгалын байгууллага болон эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагын хооронд байгуулсан гэрээгээр, тус хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3-т эрүүл мэндийн даатгалын байгууллагатай гэрээ байгуулсан өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудаас сонгож үйлчлүүлэх нь иргэдийн сонголт хийж үйлчлүүлэх эрх зөрчигдөх, эмнэлгүүдийн өрсөлдөх чадварыг бууруулахад нөлөөлнө.

V. Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4-т зааснаар даатгуулагчийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд түүний нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд үндэслэн тогтоосон товлोलт хугацаанд хамруулан, эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь санхүүжүүлэхээр заасны дагуу эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэхдээ иргэдэд үзүүлэх насны хязгаараас шалтгаалсан үзлэг, оношилгоо, шинжилгээнд бүрэн хамруулах болзлыг хангасан эмнэлгүүдтэй гэрээ хийх ёстой. Тус

хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.5-д эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд өөрөө шууд төлсөн төлбөрийн баримтыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагаас гаргуулах даатгуулагчийн эрхтэй бөгөөд мөн хуулийн 13 дугаар зүйлд зааснаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллага нь 13 дугаар зүйлийн 13.1.1-д даатгуулагчид үзүүлсэн энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлын төлбөрийг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх ба 13 дугаар зүйлийн 13.1.8-т даатгуулагчийг хэвтүүлэн эмчлэх үед өвчний түүхэнд бичигдсэн эм, тариа, материалын зардлыг өөрөөр нь гаргуулсан тохиолдолд зах зээлийн жишиг үнээр тооцон даатгуулагчид буцаан олгох үүрэгтэй байхаар хуульчлагдсан заалт нь иргэд, үйлчлүүлэгчдэд ойлгомжгүй байдлыг үүсгэсээр байна.

VI. Хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээгээр үнэ төлбөргүй, шуурхай үйлчлэх, эрүүл мэндийн нарийн мэргэжлийн тусламж, үйлчилгээг эх орондоо авах боломж, нөхцөлийг бүрдүүлэх нь төрийн бодлогын зорилт болон хэрэгжихээр тусгагдсан. Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.6-д иргэн нь эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэйгээс гадна иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтоохоор заасан. Мөн Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.4-т иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн зарим төрлийн тусламж, үйлчилгээний төлбөрийг төр хариуцах, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3-т эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 9 дүгээр зүйлд зааснаар эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж,

үйлчилгээний багцад хамаарах тусламж, үйлчилгээнд олгохоор зохицуулагдсан. Уг зохицуулалтын дагуу I шатлалын эмнэлгүүд буюу тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 ба 9.1.7-т зааснаар мэргэжлийн эмчийн бичсэн жороор эмийг олгох, хөнгөлөх, эрүүл мэндийн хяналтад байлгаж үйлчилгээ үзүүлж, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх байдлаар, II шатлалд тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.1, 9.1.2, 9.1.3, 9.1.5, 9.1.7-д хамаарах үйлчилгээ, III шатлалд нарийн мэргэжлийн эмнэлгийн тусламж үйлчилгээ болох 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.1.8-д заасан ба бусад нарийн мэргэжлийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, өндөр өртөгт эрхтэн шилжүүлэн суулгах хагалгааг стандартын дагуу гэрээ хийж санхүүжилтийг олгох нь зүйтэй юм.

ДҮГНЭЛТ

Нийгмийн хамгаалал болон Эрүүл мэндийн тухай багц хууль нь бүрэн хэмжээгээр хэрэгжвэл эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээ бүрэн хангагдах боломжтой юм. Монгол Улсад даатгалын систем хөгжөөгүйн улмаас эрүүл мэндийн тогтолцоо болон нийгмийн халамж үйлчилгээ үзүүлэх хэлбэрүүд нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд зөрчилдөөн үүсгэсээр байна. Жишээ нь: эрүүл мэндийн

даатгалын сангаас эмнэлгүүдийг санхүүжүүлэхдээ өвчний стандарт баримтлахгүйгээр эмнэлгийн ор хоног, өвчтөнд хугацаа зааж санхүүжилт өгдөг нь өвчлөлийг бүрэн эдгээхгүй, улам ихэсгэх, хүндрэх, эмнэлэг дамжин явах боломжийг бүрдүүлсээр байна. Энэ нь эрүүл мэндийн хууль бүрэн хэмжээгээр хэрэгжихгүй байгаагийн илрэл юм. Үүнийг шийдвэрлэх гарц нь хуулийг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэхэд даатгалын санхүүжилтийн бие даасан журам, эрүүл мэндийн яамны тогтоол, журам хуулиас давсан байгааг эргэн харах шаардлагатай болсон.

Хүний эрүүл мэндийг эмчлэх, эрүүлжүүлэх, урьдчилан сэргийлэх, хөдөлмөр эрхлэх, амьдралын чанарыг сайжруулах үйл ажиллагаанууд хэрэгжихгүй байгаагаас нийгмийн халамж үйлчилгээ, төрөөс гарах зардлыг нэмэгдүүлж байна.

Нийгмийн хамгаалал болон эрүүл мэндийн салбарт төрөөс үзүүлж байгаа зардлын хэмжээг бууруулахад өвчлөлийг бүрэн эдгэрүүлэх, амьдралын чанарыг сайжруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлогын хүрээнд эрүүл мэндийн үйлчилгээг тооноос чанарт шилжүүлэх шаардлагатай байна. Энэ нь олон иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсэн гэхээсээ илүү тухайн өвчлөлийг эмчлэх, урьдчилан сэргийлэхэд гол анхаарал хандуулахад чиглэгдэж байна.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН 1992 ОНЫ ҮНДСЭН ХУУЛИЙН ШИНЭЧЛЭЛ



Судлаач Б.Өлзийбаяр

ТҮЛХҮҮР ҮГ

Үндсэн хууль, Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдэл, Хөтөлбөр, Эрх мэдэл хуваарилах, Холимог дэглэм, Чиг үүрэг, Парламент, Зөвшилцөл, Хараат бус байгууллага.

ТОВЧЛОЛ

Өнөөдөр судлаачдын дунд “Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийг өөрчлөх шаардлагагүй, Үндсэн хуулийн нөөц бололцоо шавхагдаагүй” гэсэн үзэл бодолтой нэг хэсэг байхад, “нийгэм-эдийн засгийн хямрал нь үндсэн хуулийн оновчтой бус зарим зохицуулалтаас үүдэлтэй учир засаж, сайжруулах ёстой” гэх байр суурь бүхий судлаачид байна.

Иймээс 1992 оны Үндсэн хуулийг шинэчлэх шаардлагатай эсэх, хэрэв нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн найруулах үндэслэл байна гэж үзвэл аль хэсгийг өөрчлөх вэ? гэсэн улс орны хувь заяанд үлэмж үр дагавар бүхий асуултад хариулах зорилгоор энэхүү өгүүллийг бичиж байна.

Нэгдүгээрт, Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэв загварыг бүрэн эрхт байдлын бүлэгт хэрхэн тодорхойлсныг тайлбарлана.

Хоёрдугаарт, Хүний эрх, эрх чөлөө, хууль дээдлэх ёсны эрх зүйн эрх сурвалжийг тогтооно.

Гуравдугаарт, Төрийн байгуулалтын загварыг бүтээхдээ төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим болон системийн чиг-үүргийн зарчмын хоорондын харилцан шүтэлцээг хэрхэн тогтоосон тухай шинжлэн судална.

Дөрөвдүгээрт, Ардчилсан орнуудын төрийн байгуулалтын тэргүүн туршлагыг судалж, дүгнэлт гаргах болно.

НЭГ. УДИРТГАЛ

Дэлхий даяар 1990 оны эхэнд өрнөсөн ардчиллын гурав дахь давалгааны хаялага дор социалист тогтолцооноос ардчилсан нийгэмд шилжих эрх зүйн үндсийг бүрдүүлэх түүхэн захиалгаар Монголын ард түмэн бид 1992 оны шинэ Үндсэн хуулиа баталсан билээ.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиар хориглосон, хязгаарласан хүний эрхийг сэргээн тунхаглаж, төвлөрсөн нэг н а м ы н ноёрхлыг халж, улс төрийн олон ургалч үзлийг хүлээн зөвшөөрч, төрийн эрх мэдэл хуваарилах зарчмыг баримталсан зэрэг дэвшилтэд, түүхэн ач холбогдолтой баримт бичиг юм.

Гэвч өнөөдөр судлаачдын дунд Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийг өөрчлөх шаардлагагүй, үндсэн хуулийн нөөц бололцоо шавхагдаагүй гэсэн үзэл бодолтой нэг хэсэг байхад,

“нийгэм эдийн засгийн хямрал нь үндсэн хуулийн оновчтой бус зарим зохицуулалтаас үүдэлтэй учир даруй засах, сайжруулах нь зөв гэх байр суурь”¹ бүхий судлаачид байна.

Иймээс 1992 оны Үндсэн хуулийг шинэчлэх үндэслэл байгаа эсэх, хэрэв нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай бол чухам аль хэсэгт өөрчлөлт хийх вэ? гэдэг улс орны хойч ирээдүйд үлэмж үр дагавар бүхий асуултад сэтгэл хөдлөлөөр биш, зөвхөн шинжлэх ухааны арга зүйд тулгуурласан төвч байр сууринаас нийгэм соёлын, хүний эрхийн, төрийн байгуулалтын гэсэн гурван бүлгийг тус тусад задлан шинжилж, судалгааны үр дүнд тулгуурлан хариулах зорилго тавин энэхүү өгүүллийг бичиж байна.

Үндсэн хууль нь түүхэн хөгжлийн явцад тухайн ард түмний нийтлэг үнэт зүйл-зорилгыг тусгасан (1) нийгэм-соёлын, (2) хүний эрх, эрх чөлөөний, (3) төрийн байгуулалтын гэсэн 3-н үндсэн агуулгыг нэгтгэсэн “**нийгэм - улс төр - эрх зүйн**”² суурь эх сурвалж болсон байна.

Зураг 1: Үндсэн хуулийн бүтэц



Нийгэм соёл, эрх, эрх чөлөө, төрийн байгуулалтын дээрх гурван бүтцийг харьцуулан судалсан эрдэмтэд Үндсэн хуулийг Либерал (процедурын),

Хөтөлбөр (нийгмийн), Түгээмэл үзэл баримтлал давамгайлсан үндсэн хууль гэж гурав ангилдаг³.

Үндсэн хуулийн “**Либерал**” үзэл баримтлал нь хувь хүний эрх, эрх чөлөөг дээдлэх тухай чиг хандлага бөгөөд хүний эрх чөлөөг хамгаалахын тулд төрийн эрх мэдлийг хязгаарлах тухай номлол юм.

Либерал үзэл баримтлалтай үндсэн хууль нь хувь хүний эрх чөлөө - индивидуализмд суурилдаг учир Англи-Саксони эрх зүйн тогтолцоотой орнуудад нийтлэг тохиолдог.

Харин Үндсэн хуулийн “**Хөтөлбөр**” үзэл баримтлал нь хувийн эрх чөлөөг нийтийн эрх ашгаар эсвэл улс төрийн үзэл суртлаар хязгаарладаг бөгөөд эрх зүйн бүлийн Ром-германы тогтолцоонд хамаардаг.

Хөтөлбөр үзэл баримтлалтай үндсэн хууль нь нийтийн буюу төрийн эрх ашгийг тэргүүнд эрэмбэлдэг тул социалист тогтолцоо, эсвэл тоталитар дэглэм бүхий орнуудад ихэнхдээ тохиолдог.⁴

Үндсэн хуулийн “**Түгээмэл**” үзэл баримтлал нь либерал болон хөтөлбөр үндсэн хуулийн аль алины шинжийг хадгалсан дундын хувилбарууд бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хууль-тогтоомжийг өөрийн үндсэн хуулийн дээд эх сурвалж хэмээн үздэг байна.

1950-1970-аад оны хооронд колоничлолоос чөлөөлөгдсөн орнууд, мөн 1990 оны эхэнд ардчилалд шилжсэн пост-социалист орнууд түгээмэл үзэл баримтлал Үндсэн хууль бүхий дэлхийн тэргүүлэгч гүрнүүдийн жишгээр энэхүү загварыг сонгосон байдаг.

Монголд үндсэн хуульд ёс дэлгэрсэн 100 гаруй жилийн хугацаанд Монголын ард түмэн дөрвөн Үндсэн

¹ Д.Ламжав, Үндсэн хуулийг өөрчлөх санал-илтгэл, “Үндсэн хууль ба зөвлөлдөх ардчилал” онол практикийн бага хурал, 2015.05.03.

² Elliot Bulmer. What is Constitution?, 2017, P. 5

³ David S. Law, Constitutional Archetypes, Texas Law Review, 2016, P. 160-182.

⁴ Giovanni Sartori, Comparative Constitutional Engineering, 1994, P. 197-200.

хуулийн дор амьдарч ирсэн түүхтэй.

Иймээс 1992 оны Үндсэн хуулийн судалгааны суурийг тавьж, БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны үндсэн хуулиудын тухай товч авч үзье.

ХОЁР. БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулийн хэв загвар

Манай оронд үндсэн хуульт ёс төлөвших түүхэн хөгжлийн тодорхой үе шатад үйлчилж байсан БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны үндсэн хуулиудын хэв загварын тухай товч авч үзэх нь энэхүү судалгааны агуулгад багагүй ач холбогдолтой юм.

Монгол Улсын гавьяат хуульч, доктор, профессор Б. Чимид Монгол Улсын Үндсэн хуулийн түүхийг судалж үзээд (1) Социалист маягийн үндсэн хууль, (2) Ардчилсан маягийн үндсэн хуулийн үе гэсэн хоёр үндсэн⁵ үед хуваан авч үзсэн байдаг.

БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд нь Эв хамтын - социалист нийгэм журам байгуулах, түүний бүрэн ялалтыг хангах гэсэн хөтөлбөр шинж давамгайлсан нийтлэг агуулгатай болохыг эдгээр үндсэн хуулиудын оршил хэсгээс шинжлэн судалж болно.

1924 оны анхдугаар Үндсэн хуулийн хөтөлбөр хэсэгт тус улсын ирээдүйн 20 жилийн зорилгыг дараах байдлаар томьёолж байжээ:

Хоёрдугаар зүйл. “Бүгд Найрамдах Монгол Ард Улсын **зорилт бол хуучны эзэрхэг харгисын ёс суртлын үлдэгдлийг үндсээр устгаж, улс төрийн захиргааны явдлыг жинхэнэ ардын ёсонд нийцүүлж, шинэ ёсны Бүгд Найрамдах Улсын үндэс тулгуурыг бататган бэхжүүлнэ.**”

14. “Бүх дэлхийн жинхэнэ ард түмний зорилго нь одоогийн эзэрхэг хөрөнгөтний байдлыг

⁵ Б. Чимид, Төр, Нам, Эрх зүйн Шинэтгэлийн Эгзэгтэй асуудал, II дугаар дэвтэр, 2008 он, 175-180 дахь тал.

үндсээр нь устгаж, нийгэм журамт ба эв хамт ёс журмыг эрмэлзэх...⁶

1924 оны Үндсэн хууль нь анх удаа Монгол оронд төр-шашныг зааглаж, хэмжээгүй эрхт хаант засаглалаас бүгд найрамдах засаглалд шилжсэн, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх үзэл санаа агуулсан зэрэг дэвшилтэд үзэл баримтлалтай хэдий боловч ард түмнээ гарал угсаа, яс үндэс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан “...улс төрийн захиргааны явдлыг жинхэнэ ардын ёсонд нийцүүлж” “... нийгэм журамт ба эв хамт ёс журмыг эрмэлзэх” зэрэг зорилго тунхагласнаас үзэхэд энэхүү үндсэн хуулийн эх сурвалж нь 20 дугаар зуунд дэлхийг социалист, капиталист лагерьд хуваасан коммунист үзэл номлол байжээ.

Монголд 1921-1940 оны хоорондох өрнөсөн улс төрийн хэлмэгдүүлэлт нь ямар нэг зүүн барууны нугалаа, алдаа завхрал, тагнуул туршуул, урвагчийг илчлэх хэрэг гэхээс илүүтэй коммунист үзэл номлолын дагуу 1924 оны Үндсэн хуулиар баталсан дээрх хөтөлбөрөө шат дараатай хэрэгжүүлсэн төлөвлөгөөт үйл ажиллагаа байжээ гэж дүгнэх эрх зүйн үндэслэл байна.

Энэ тухай хожим тайлан, илтгэлд дурдахдаа “1925 онд хувийн аж ахуйтан ардууд 87 хувь, феодал болон бусад давхарга 13 хувь байсан бол эдүгээ манай орны хүн амын 58 хувийг ажилчин, албан хаагчид, 42 хувийг хоршоолсон ард эзлэх болов.”⁷ хэмээн дүгнэж байжээ.

1940 он гэхэд “жинхэнэ ард” гэсэн ангилалд багтах эрхгүй 36,0 мянган хүнийг хэлмэгдүүлэн буудан алах, хорих ялаар шийтгэснээр⁸ 1924 оны Үндсэн хуулийн “Улс төрийн хүрээний зорилт” биелсэн байна.

⁶ БНМАУ-ын Үндсэн хууль 1924, МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд, 1966, 124 дэх тал.

⁷ Д.Загасбалдан, БНМАУ дэлхийн эдийн засаг, соёлын хөгжилд, 1978, 4 дэх тал.

⁸ Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комисс, тайлан, 2016, 14 дэх тал.

Энэхүү 1924 оны Үндсэн хуулийн дээрх зорилт бүрэн биелсэн болохыг 1940 оны үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 1 дүгээр зүйлд:

“Бүгд Найрамдах Монгол Ард Улс бол эзэрхэг түрэмгий ба феодалын дарлалыг устгасан /малчин, ажилчин, сэхээтэн/ хөдөлмөрчдийн тусгаар тогтносон бөгөөд цаашид нийгэм журамд давшин орохын тулд тус орныг хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангагч улс мөн.” хэмээн тунхагласнаас тодорхой харагдаж байна.

БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуулиар цаашдын хөгжлийн хөтөлбөрөө төлөвлөхдөө *“цаашид нийгэм журамд давшин орохын тулд тус орныг хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангагч улс мөн.”*⁹ хэмээн тодорхойлжээ.

“Тус орныг хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх явдлыг хангагч” гэсэн дээрх зорилт нь 1959 он гэхэд нийт 24 сая малын сүргийн 17 сая буюу 74 орчим хувийг улс даяар 289 нэгдэлд нийгэмчлэн, хувийн өмчийг устгаснаар хөрөнгөтний бус замаар хөгжүүлэх хөтөлбөр амьдралд хэрэгжсэн байна.

Ийнхүү хувийн өмчийг нийгэмчлэх хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр БНМАУ-ын 1940 оны Үндсэн хуульд цохон тэмдэглэсэн *“Эдийн засгийн хүрээний зорилт”* бүрэн биелсэн гэж үзэж болно.

Энэ тухай 1960 оны үндсэн хуулийн хоёрдугаар бүлгийн *“Төрийн эдийн засгийн үндсэн зарчим ба үүрэг”* гэсэн наймдугаар зүйлд:

“Бүгд Найрамдах Монгол Ард Улсын эдийн засгийн үндэс бол хөдөлмөрчид олон жил шаргуу тэмцэн, үйлдвэрлэлийн хэрэгслийг хувьдаа өмчлөх журмыг халж хүн хүнээ мөлжих ёсыг устгасны үрээр тогтсон социалист системийн аж ахуй

*үйлдвэрлэлийн хэрэгслийн нийтээрээ өмчлөх социалист өмч мөн.”*¹⁰ хэмээн бататган өгүүлжээ.

1960 онд нам, засгаас өнгөрсөн 20 жилийн ололт амжилт, алдаа дутагдлаа дүгнэн, ирээдүйн хөгжлийн урт хугацааны хөтөлбөр боловсруулсан байдаг.

БНМАУ-ын ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг 1960 оны Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлд:

“Социалист төр нь нийгмийн социалист өмчийг хамгаалж бэхжүүлэх, аж ахуйн соёлын байгуулалтад нийгмийн бүх гишүүдийг идэвхтэй оролцуулах, хөдөлмөрийн социалист сахилгыг бүх аргаар бэхжүүлэх, улс орныг империалист түрэмгийллээс батлан хамгаалах явдлыг зохион байгуулна.” гэж тусгажээ.

БНМАУ-ын 1960-аас 1990 оны хөгжлийн үе бол нэг талаас 1960 оны Үндсэн хуульд заасан *“социалист ухамсар-сахилга”* бүхий иргэдийг төлөвшүүлэх, нөгөө талаас социализмын материал-техникийн бааз байгуулах гэсэн тав, таван жилээр төлөвлөсөн нийгэм-эдийн засгийн бодлогууд шат дараалалтай хэрэгжсэн түүхэн цаг үе юм.

Энэ тухай 1958 оны МАХН-ын гурав дахь программд *“тус орны эдийн засагт байгаа феодализмын үлдэгдлийг бүрмөсөн устгахад, хүн ардын мэдрэлд байгаа феодализмын үлдэгдэлтэй тэмцэж, улмаар нийгэм журамд орох явдлыг бэлтгэхийн тулд тус орныг капиталын ёсны биш замаар хөгжүүлэх явдлыг хангах”*¹¹ хэмээн тодорхойлж байжээ.

1960-аас 1990 оны хооронд хэрэгжүүлсэн нийгэм-эдийн засгийн бодлогуудын үр дүнд соёл-урлаг, боловсрол-мэргэжил, эрүүл мэнд,

¹⁰ БНМАУ-ын Үндсэн хууль 1960

⁹ БНМАУ-ын Үндсэн хууль 1940, МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд, 1966, 456 дахь тал.

¹¹ НТХ-ны суртал ухуулгын тасаг, Улс төрийн мэдлэгийн үндэс, 1968 он, 256 дахь тал.

эдийн засгийн салбарт хүрсэн амжилт-бүтээл нь 1990 оноос хойших Монгол улсын нийгэм-эдийн засгийн хөгжлийн бааз-суурь болсон юм.

Өөрөөр хэлбэл, БНМАУ-ын 1960 оны Үндсэн хуульд тусгагдсан **“Нийгэм-Соёлын хүрээний”** зорилтууд багагүй үр дүнд хүрсэн ажээ.

БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны эдгээр үндсэн хуулиуд хүний эрхийн тухайд хүнийг *“гарал угсаа, яс үндэс, нийгмийн байдал, хөрөнгө чинээ, шашин шүтлэг, үзэл бодлоор”* нь ялгаварлан, дан ганц социалист Марксист-Ленинист үзэл онол, ухамсар, зөвхөн ажилчин, малчин, сэхээтэн гэсэн нийгмийн давхаргыг хүлээн зөвшөөрдөг нийтлэг талтай байлаа.

Мөн төрийн байгуулалтын хувьд төрийн эрх мэдлийг эрх мэдэл хуваарилах зарчмаар биш, улс төрийн нэг намын удирдлагад төрийн эрх мэдлийг төвлөрүүлсэн, тоталитар (*дарангуй*) тогтолцооны эрх зүйн эх сурвалж болж байсны хувьд БНМАУ-ын Үндсэн хуулиуд нь социалист маягийн Хөтөлбөр үндсэн хууль байжээ гэж дүгнэх үндэслэлтэй байна.

Эцэст нь, БНМАУ-ын 1924, 1940, 1960 оны социалист Үндсэн хуулиуд нь Италийн Флоренцийн Их сургуулийн профессор Ж. Сарторийн ангиллаар *“хуурмаг үндсэн хуул”*¹²-ийн төрөлд хамаардаг боловч Монгол Улсын 1992 оны шинэ Үндсэн хуулийн бааз-суурь болсон түүхэн ач холбогдлыг үгүйсгэх эрхгүй билээ.

ГУРАВ. Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хэв загвар

А. Монголын ард түмний нийгэм-соёлын үнэт зүйл - зорилго

Аливаа улсын Үндсэн хууль бол тухайн ард түмний хүсэл зоригийн илэрхийлэл, хамтран амьдрах гэрээ

болохын хувьд нийтлэг үнэт зүйл-зорилгыг хамгийн эхэнд тусгасан байдаг.

Өөрөөр хэлбэл Үндсэн хуулийн оршил хэсэг нь тухайн ард түмэн ямар улс төр, эдийн засаг, нийгэм-соёл, хууль, ёс суртахууны үнэт зүйлийг эрхэмлэж байгааг тусгасан хөтөлбөр хэсэг юм.

Хөтөлбөр хэсэгт оршлоос гадна *“Бүхэн эрхт байдал”* хэмээх тухайн улсын онцлогийг (*identity*) тодорхойлсон бүлгийг багтаан авч үздэг.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь :

“Монголын ард түмэн бид:

- *улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,*

- *хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,*

- *төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,*

- *хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,*

- *эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно. Үүний учир Монгол Улсын Үндсэн хуулийг даяар олноо зарлан тунхаглаж байна”*¹³ гэсэн оршил хэсгээр эхэлдэг.

Үндсэн хуулийн оршил бол тухайн үндсэн хуулийн хураангуй агуулга юм.

Өнөөдрийн байдлаар дэлхийн 190 гаруй тусгаар улсын Үндсэн хуулийн 85 % гаруй хувьд оршил гэж үзэж болохоор агуулга бүхий хэсэг байна хэмээн судлаачид үздэг.

Үндсэн хуулийн оршил болон бүрэн эрхт байдлын агуулгаар үндсэн хуулийн хэв загварыг тогтоодог.

Иймээс судлаачид Үндсэн хуулийн үзэл баримтлалыг судлан дэлхийн улс орнуудыг (1) Либерал, (2) Хөтөлбөр,

¹² Albert H.Y. Chen, Constitutionalism in Asia in The Early Twenty-First Century, 2014, P. 10-14.

¹³ Монгол улсын Үндсэн хууль 1992

(3) Түгээмэл хандлага бүхий Үндсэн хуультай гэсэн гурван загварт хуваан авч үздэг.¹⁴

Хүснэгт 1: Үндсэн хуулийн хэв загвар

Либерал	Түгээмэл	Хөтөлбөр
Цэвэр Процедурын үндсэн хууль	Процедурын болон Хөтөлбөр Үндсэн хуулийн дундын хувилбар	Цэвэр Нийгмийн Үндсэн хууль

АНУ-ын Вашингтоны их сургуулийн профессор Дэвид С. Лоо дэлхийн улс орнуудын үндсэн хуулийг харьцуулан судалж, Либерал, Хөтөлбөр, Түгээмэл гэсэн хандлагад хуваах нөхцөл, шалгуур үзүүлэлтүүдийг програмчилж, өгөгдлөө “хиймэл оюун”-ны тусламжтай боловсруулах арга ашигласан байна.

Профессор Дэвид С. Лоогийн судалгааны ажлын үр дүнд Үндсэн хуулийн хандлага тус бүрийн дэлгэрэнгүй үнэлгээ гаргасан.

Хүснэгт 2: Үндсэн хуулийн Либерал хандлага¹⁵

Хамгийн их Либерал хандлага	
Англи	0.9959
Австрали	0.9912
Тонга	0.9705
Бруней	0.9227
Шинэ Зеланд	0.8891

Хүснэгт 3: Үндсэн хуулийн Хөтөлбөр (нийгмийн) хандлага

Хамгийн их хөтөлбөр хандлага	
Хятад	0.9897
Хойд Солонгос	0.9870
Вьетнам	0.9774
Куба	0.9039
Иран	0.8802

Хүснэгт 4: Үндсэн хуулийн Түгээмэл хандлага

Хамгийн их түгээмэл хандлага	
Фижи	0.9545
Гренада	0.9422
Орос	0.9311
Болгар	0.9293
Чех улс	0.9256

Улс орнуудын Үндсэн хуулийн хандлагыг тухайн орны Улс төрийн үзэл суртал, чиг баримжаатай харьцуулан судалж үзэхэд профессор Дэвид С. Лоогийн “хиймэл оюун” ашигласан судалгаатай маш төстэй үр дүн гарч байлаа.

Улс төрийн Либерал үзэл номлол Үндсэн хуулийн Либерал хандлагатай, Реалист үзэл номлол Хөтөлбөр хандлагатай¹⁶, Конструктивист үзэл номлол Түгээмэл хандлагатай тохирч байна.

Конструктивист үзэл номлол гэдэг нь мөн Үндсэн хуулийн түгээмэл хандлагатай адилхан Либерал болон Реалист үзэл номлолын давуу талуудын авч, албан бус хэлээр бол нэгтгэж угсарсан гэдэг утга илэрхийлдэг аж.

Профессор Дэвид С. Лоо Монгол улсын 1992 оны үндсэн хуулийн агуулгыг судлаад, түгээмэл хандлагатай үндсэн хууль гэж дүгнэжээ.

Хүснэгт 5: Монгол улсын Үндсэн хуулийн хандлага¹⁷

	Либерал	Нийгэм	Түгээмэл
Гурван хандлагын хамгийн өндөр	0.9959	0.9897	0.9545
Гурван хандлагын хамгийн бага	0.0013	0.0018	0.0023

¹⁴ David S. Law, Constitutional Archetypes, Texas Law Review, 2016, P. 160-182.
¹⁵ David S. Law, Constitutional Archetypes, Texas Law Review, 2016, P. 211-214.

¹⁶ Charles W. Kegley, Shannon L. Blanton, World Politics Trend and Transformation, 2011, P. 29-50.
¹⁷ David S. Law, Constitutional Archetypes, Texas Law Review, 2016, P. 240.

Гурван хандлагын дундаж үзүүлэлт	0.1238	0.3119	0.5643
Монгол Улс	0.0320	0.2962	0.6718

Дээрх харьцуулалтаас дүгнэхэд Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь либерал болон хөтөлбөр хандлагын дунджаас доогуур, харин түгээмэл хандлагын дунджаас дээгүүр оноо авчээ.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн оршилд "эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно." хэмээн заасан нь Үндсэн хуулийн "түгээмэл хандлага" буюу улс төрийн "Конструктивист" үзэл номлолын илэрхийлэл юм.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлал ямар учраас түгээмэл хандлага гэсэн ангилалд орсныг тайлбарлахын тулд Үндсэн хуулийн дараах заалтуудыг иш татъя.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн Бүрэн эрхт байдлын нэгдүгээр бүлгийн гуравдугаар зүйлийн 1-д :

"Монгол Улсад засгийн бүх эрх мэдэл ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ."

Тавдугаар зүйлийн 1-д:

"Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна." Мөн зүйлийн 2-т **"Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална."**...

хэмээн **улс төр - эдийн засгийн либерал зарчмуудыг** тунхаглажээ.

Гэтэл тавдугаар зүйлийн 4-д:

"Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна."

Зургаадугаар зүйлийн 2-д:

"Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн."

...гэсэн заалтаас үзэхэд Монголын ард түмэн 1992 оны Үндсэн хуулиар төрийн зохицуулалттай, олон хэвшил бүхий эдийн засагтай орон байхаар тунхагласан нь дан ганц хувь хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн **"цэвэр либерал"** болон зөвхөн төр-нийгмийн эрх ашгийг хамгаалсан **"туйлширсан хөтөлбөр"** үзэл баримтлал бүхий үндсэн хуулиас татгалзаж, харин энэ хоёр хэв загварын аль алины онцлогийг шингээсэн **"түгээмэл" хандлагыг** сонгожээ.

Үндсэн хуулийн "түгээмэл" загвар нь нийтээр хүлээн зөвшөөрсөн олон улсын хууль-тогтоомжийг өөрийн үндсэн хуулийн дээд эх сурвалж хэмээн үздэг.

Олон Улсын хууль-тогтоомжийн тухай Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн аравдугаар зүйлийн 1-д:

"Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна."

Мөн зүйлийн 3-д:

"Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ." хэмээн тус тус заажээ.

Аливаа улс төрийн үзэл номлолын цаана эцэстээ өмчийн харилцааны асуудал яригддаг.

Либерал Үндсэн хуультай улсад хувь хүний эдийн засгийн эрх чөлөө, тодорхой хэлбэл газар эзэмших өмчлөлийн эрх газрын гадаргуугаас гадна түүний хэвлийд буй баялаг мөн хамаардаг.

Эсрэгээрээ Хөтөлбөр Үндсэн хуультай буку Реалист улс төрийн номлолтой улсад амины өмчөөс бусад нь төр, олон нийтийн өмч хэмээн үздэг.

Харин Түгээмэл Үндсэн хуультай буку Конструктивист улс төрийн номлолтой оронд газрын гадаргуу л зөвхөн тухайн иргэний эзэмшил, өмчлөлд хамаараахаас биш, газрын хэвлий дор байгаа баялаг бол нийт ард түмний мэдэлд, төрийн хамгаалалтад байдаг.

Мөн эдгээрийн хандлагуудын холимог хувилбар цөөнгүй байна. Тухайлбал, БНХАУ бол улс төрийн Реалист үзэл номлол, Хөтөлбөр Үндсэн хуультай боловч эдийн засгийн хувьд Либерал бодлого баримталдаг орон юм.

Өмчийн харилцааны үүднээс авч үзвэл БНХАУ Түгээмэл (холимог) хандлагатай, улс төрийн хувьд нэг намын засаглалтай орон юм.

Монгол Улс 1990 оноос хойш Ардчилалд шилжсэн энэ хугацаанд улс төр, эдийн засгийн либерал бодлого баримталсан боловч либерал шинэчлэл өөрөө Монгол Улсын Үндсэн хуулиар хязгаарлагдаж байгаа юм.

Учир нь Монгол Улс бол нэг үндэстнээс бүрдсэн, суурин амьдрахын зэрэгцээ нүүдлийн соёл, уламжлалтай орон учраас газар эзэмших, ашиглах, өмчлөх болон бусад эрхийн асуудалд өвөрмөц холимог хандлага баримталж иржээ.

Монгол Улсын 1992 оны үндсэн хуулийн оршилд тунхагласан "эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно" хэмээх хөтөлбөр бодит амьдрал дээр биелэх эсэх нь

төрийн байгуулалтын бүлэгт улс төрийн системийн шийдвэр гаргах институцийн чиг-үүргийн хуваарь, дэд системийн чиг-үүргийн чадамжаас шууд хамаарна.

Б. Хүний эрх, эрх чөлөө

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөний тухай бүлгийн үзэл баримтлал нь олон улсын эрх зүйн эх сурвалжид тулгуурласан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөний тухай хоёр дугаар бүлгийг бичихдээ: Францын Үндэсний хурлаар 1789 оны 8 дугаар сарын 26-ны өдөр баталсан "Хүний ба Иргэний Эрхийн Тунхаглал",

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1942 оны 12 дугаар сарын 10-нд баталсан "Хүний эрхийн түгээмэл тунхаглал",

1966 оны 12 дугаар сарын 19-д баталсан "Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт", болон "Эдийн засаг нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт"-ыг эх сурвалж болгосон байдаг.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн хүний эрх, эрх чөлөөний тухай бүлгийг судалсан доктор Ч. Өнөрбаяр "Үндсэн хууль ёсны хөгжил, түүний чиг хандлага" бүтээлдээ дараах 4 зүйлийг цохон тэмдэглэсэн байна.

"Нэгдүгээрт, хүний эрх, эрх чөлөөний бүлгийг төрийн байгуулалтын бүлгээс өмнө нь гаргаж, хүний эрх бол төрөлх, салшгүй зүйл, харин төрийн байгуулал нь түүнийг хүндэтгэж, хамгаалахын тулд ажилладаг гэдгийг **хууль зүйн техникийн хувьд шийдэж чадсан."**

"Хоёрдугаарт, хүний эрх, эрх чөлөөг дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим болохыг хүлээн зөвшөөрч, тус хуулийн 19 дүгээр зүйлийн 1-д : *Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг*

бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцан, хэмээн төр засагт анх удаа үүрэг хүлээлгэсэн."

"Гуравдугаарт, онц байдал дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлах тухай Үндсэн хуульт ёсны суурь зарчмыг хуульчлан тогтоож, амьд явах, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх, түүнчлэн эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахаас хамгаалагдсан байх **үндсэн эрхүүдийг үл хөндөгдөх эрх болохыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулсан.**

"Дөрөвдүгээрт, төрөөс үндсэн эрхийг хязгаарлахад зайлшгүй баримтлах ёстой Үндсэн хуульт ёсны нэг шаардлага бол **эрх зүйт ёсны үндсэн зарчмуудыг** Үндсэн хуулийн 26 дугаар зүйлийн 24-д: *өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах...* **эрхтэй, Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно.** хэмээн **бэхжүүлж өгсөн байна.**"¹⁸

Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь БНМАУ-н 1924, 1940, 1960 оны Үндсэн хуульд тунхаг шинжтэй байсан хүний эрх, эрх чөлөөг "үндэс, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхахгүй" эдлэх хууль зүйн бололцоог бүрдүүлснээрээ өмнөх социалист-хөтөлбөр үндсэн хуулиудаас үзэл баримтлалын ялгаатай юм.

Хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн, баталгаажуулсан заалт Үндсэн хуульд

тунхагласнаар тухайн орон ардчилсан орон гэсэн үг биш юм.

Төрөөс хүний эрхийг хамгаалах үүрэг хүлээхээс илүү хүний эрх, эрх чөлөөний баталгаа бодиттой эсэхийн гол хэмжүүр бол тухайн нийгэмд шударга ёс тогтсон уу, үгүй юу гэдэг асуудал юм.

Тухайннийгэмдэрх, эрхчөлөө, тэгш байдал, шударга ёс гэсэн ардчиллын үнэт зүйлийг бэхжүүлэхийн тулд **Нэгд, төрийн эрх мэдлийг хуваарилах, Хоёрт, эрх мэдэл хооронд чиг үүргийн хяналт-тэнцвэр тогтоох нь нэн чухал юм.**

1789 оны 8 дугаар сарын 26-ны өдөр батлагдсан Францын "Хүний ба Иргэний Эрхийн Тунхаглал"-ын арван зургаадугаар зүйлд:

*"Нийгэм нь тодорхой эрх мэдлийн хуваарилалтгүй, хүн эрхээ эдлэх нөхцөлийг үл хангасан бол үндсэн хуульгүй байна."*¹⁹ гэсэн үг хэмээн тунхаглажээ.

Энэхүү тунхаглалд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах нөхцлийг хангахын тулд үндсэн хуулийн төрийн байгуулалтын бүлэгт "төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим"-ыг баримтлан Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн институцийн эрх, үүргийг харилцан тэнцвэртэй, хяналт хязгаартай тогтоох шаардлага тавигдаг.

Өөрөөр хэлбэл, төрийн байгуулалтын бүлэгт хүний эрх, эрх чөлөөг хамгаалахын тулд төрийн тогтолцооны аль нэг институцид эрх мэдэл төвлөрөх гажуудлыг хязгаарлах, эрх мэдлийг тараах, хүч нөлөөг сулруулах арга зарчим хэрэгжүүлэх шаардлага урган гардаг.

Эсрэгээрээ, аливаа ард түмний улс төр, эдийн засаг, нийгэм-соёлын хүсэл зоригийн хөтөлбөр бодит амьдрал дээр биелэх эсэх нь төрийн байгуулалтын бүлэгт улс төрийн системийн шийдвэр гаргах институцийн чиг-үүргийн хуваарийг системийн зорилгод

¹⁸ Ч. Өнөрбаяр. Үндсэн хуульт ёсны хөгжил, түүний чиг хандлага. 2014, 151 дэх тал.

¹⁹ Францын "Хүний ба Иргэний Эрхийн Тунхаглал". 1789

зангидах, дэд системийн чиг-үүргийн чадамжийн чанарыг сайжруулах зэрэг дотоод хүчин зүйлсээс хамаарна гэдгийг өмнө дурдсан.

Дээрх хос зорилтоос дүгнэхэд төрийн байгуулалтын бүлгийн ач холбогдол үлэмж бөгөөд хэд хэдэн шинжлэх ухааны огтлолцол, чиглэлээс судлах, хэлэлцэх ёстой асуудал юм.

В. Төрийн Байгуулал

БНМАУ-н 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиуд нь улс төрийн нэг намд төрийн эрх мэдлийг төвлөрүүлсэн, тоталитар (дарангуй) тогтолцооны эрх зүйн эх сурвалж болж байсан бол Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль нь анх удаа олон ургалч үзэл, олон намын тогтолцоог хүлээн зөвшөөрсөн юм.

Монгол Улс 1921-1990 оны хооронд 70 гаруй жил нэг намын тогтолцоотой социалист орон байсан түүхтэй. Төрийн эрх мэдэл улс төрийн нэг намд төвлөрсөн тогтолцоотой нийгэмд нам төвтэй төрийн тогтолцоо байдаг бөгөөд ийм нийгэмд улс төрийн нам дараах дөрвөн үндсэн үүрэг гүйцэтгэдэг:

Нэг: улс төрийн бодлого боловсруулах, гүйцэтгэх,

Хоёр: хянан шалгах ажлыг хэрэгжүүлэх,

Гурав: боловсон хүчнийг (хүний нөөцийг) сонгох, томилох.

Дөрөв: улс төрийн сонгуульд ард түмний оролцоог хангах, идэвхийг өрнүүлэх ажлыг гардан зохион байгуулах,

Монгол Улсын 1992 оны үндсэн хуулиар нам төвтэй тогтолцооноос төр төвтэй улс төрийн байгуулалд шилжсэнээр улс төрийн нам улс орны хөгжлийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэх, хянах үүргээс утгаа чөлөөлөгджээ.

Мөн түүнчлэн Төрийн албаны тухай хууль батлагдсанаар төрийн боловсон

хүчнийг бэлтгэх сонгон шалгаруулах, томилох эрх, үүрэггүй болсон юм.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн үзэл баримтлалаас харвал улс төрийн нам нь ард түмний хүсэл зоригийг хууль тогтоох үйл ажиллагаанд тусгахын тулд сонгуулийн үйл ажиллагаанд олон түмний оролцоог хангах, хууль тогтоох байгууллагад олонхийн суудал авсан бол гүйцэтгэх засаглалын тэргүүнийг дэвшүүлэх зэрэг төр, ард түмнийг холбогч "гүүр"-ийн үүрэгтэй болов.

Энэхүү улс төрийн намын чиг үүргийн талаар Профессор Ханс Кельзен "Мөн чанарын хувьд улс төрийн намын зохион байгуулалт бий болохоос өмнө ард түмэн тогтвортой оршин тогтнох улс төрийн хүч гэж тооцоход хэцүү байлаа. Харин ардчиллын хөгжлийн шатанд төр тусгаарлагдсан иргэдээ намын зохион байгуулалт хэлбэрээр нийгмийн харилцаанд оролцуулах болсон учир ард түмэн бол нийгмийн хүч гэж тодорхойлдог нь огтхон ч санамсаргүй хэрэг биш юм."²⁰ хэмээн 100 гаруй жилийн өмнө тэмдэглэж байжээ.

1992 оны Үндсэн хуулиар Монголын төр нь бодлого, боловсон хүчний асуудлаа улс төрийн намаас ангид шийдвэрлэдэг парламентын тогтолцоог сонгосон боловч төр нь бүхэл цогц систем гэдэг утгаараа хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн салаа мөчир, тэдгээрийн дотоод чиг-үүргийн тэнцвэрийг хангах хяналтын институцийн асуудалд нэн ерөнхий хандсан дутагдал ажиглагдах.

Энэхүү төрийн эрх мэдлийн салаа мөчир, тэдгээрийн дотоод чиг-үүргийн тэнцвэрийг хангах хяналтын институцийн бүтэц тодорхой биш байдалтай орхигдсон сул орон зайг (хийдлийг) парламентад олонхийн суудал авсан нам эзэлснээр, төрийн

²⁰ Ханс Кельзен, Ардчиллын мөн чанар ба үнэт зүйл, 1920 (орч Д. Оргил, 2015) 39 дэх тал

эрх мэдэл улс төрийн намд хэт төвлөрч, хуучин хүчирхэг нам төвтэй тогтолцоо дахин сэргэжээ.

Өөрөөр хэлбэл, Монголын Улсын төрийн тогтолцоо албан бус хэлбэрээр буцаад хуучин нэг намын ноёрхлын үетэй адил улс төрийн нам, бүлэг төрийн бодлогыг тодорхойлох, боловсон хүчнийг сонгох, томилох эрхийг өөртөө төвлөрүүлсэн байна.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн гуравдугаар бүлгийн 24 дүгээр зүйлд заасан УИХ-ын “18-н онцгой бүрэн эрх”²¹ бодит амьдрал дээр УИХ-д олонхийн суудал авсан **намын онцгой бүрэн эрх** болж хувирсан юм.

Товчоор хэлбэл, төр, эрх зүйн шинжлэх ухааны профессор Ханс Кельзений хэлсэн “улс төрийн нам ердөө л сонирхлоор нэгдсэн хүмүүсийн нэгдэл, холбоо учраас хувийн ашиг сонирхолд суурилна гэсэн үг, харин төр бүх нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэх учир бүлгийн сонирхол буюу улс төрийн намын сонирхлоос дээгүүрт тавигдаж, тэднийг зохицуулах ёстой”²² гэсэн төрөөс улс төрийн намтай харилцах зарчмыг гажуудуулсан байна.

Монголчууд бид 1992 онд хөтөлбөр үндсэн хуулиас татгалзаж, түгээмэл үндсэн хуульд шилжих үедээ өмнөө тодорхой зорилго бүхий системийн хувьд төрийн тогтолцооны бүтэц, чиг-үүргийг шинэ үзэл баримтлалд нийцүүлсэн шинэчлэл хийх ёстой байжээ.

1992 оны шинэ Үндсэн хууль бүтээхдээ хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн Ш. Л. Монтескьюгийн төрийн эрх мэдлийг хуваарилах зарчмыг баримталсан боловч системийн онолын талаас авч үзвэл Монгол төр нь бие даасан системийн хувьд төрийн тогтолцооны дэд системүүдийн чиг-

үүрэг, хоорондын харилцан шүтэлцээ, уялдааг хангах асуудлыг орхигдуулжээ.

Монгол Улсын 1992 оны Үндсэн хуулийн гуравдугаар бүлэгт төрийн байгуулалтыг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэсэн салаа мөчирт тусгаарлаад орхилгүй, цааш нь төрийн нийгмийн удирдлагыг (менежмент) гүйцэтгэх чиг-үүргийг тодруулж, шийдвэр гаргах процессын бүтээмжтэй загварыг институцлэх шаардлагатай байсан юм.

Хүснэгт 6: Төрийн байгуулалтын механизм

Үндсэн хуулийн зорилго	Төрийн байгуулалтын улс төр, хууль зүйн механизм
“Хүний эрх, эрх чөлөө”	Төрийн эрх мэдлийн хуваарилалт
“Хөтөлбөр”	Төрийн байгууламжийн функциональ чиг үүргийн тэнцвэр

Үндсэн хуулийн төрийн байгуулалтын бүлэгт “хүний эрх, эрх чөлөө”-г хамгаалах зорилгоор төрийн эрх мэдэл хуваарилах “хяналт-тэнцвэр”-ийн (check and balance) зарчимд илүү ач холбогдолтой хандсан бол “Түгээмэл” шинж давамгайлсан гэж үздэг.

Харин хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн тус тусын дотоод бүтцийг үндсэн хуульд тунхагласан “хөтөлбөр-зорилго”-ыг хэрэгжүүлэх чадамжийг харгалзан чиг-үүргийн тодруулсан тогтолцоог “функциональ” шинж давамгайлсан²³ байна гэдэг.

Төрийн эрх мэдлийг хуваарилах тухай, төр нь бүхэл систем гэдэг утгаар түүний дэд системүүдийн чиг-үүргийг хэрхэн харилцан тэнцвэртэй тогтоох тухай онол, сургаалын түүхийг судлахгүйгээр төрийн байгууламжийн дотоод үйл ажиллагааны зарчим, механизмыг задлан шинжлэх боломжгүй юм.

Иймээс төрийн эрх мэдлийг хуваарилах тухай, төр нь бүхэл систем

²¹ Монгол Улсын Үндсэн Хууль 1992, Гуравдугаар бүлэг, Хорин дөрөвдүгээр зүйл.

²² Ханс Кельзен, Ардчиллын мөн чанар ба үнэт зүйл, 1920 (орч Д. Оргил, 2015) 37 дахь тал.

²³ Mila Versteeg, Unpopular constitutionalism, 2014, Indiana Law Journal, vol 89, P. 1180.

гэдэг утгаар түүний дэд системүүдийн чиг-үүргийг хэрхэн харилцан тэнцвэртэй тогтоох тухай онол, сургаалаар энэхүү судалгааны ажлаа цааш үргэлжлүүлэе.

ДӨРӨВ. Монгол Улсын 1992 оны Үндсэн хууль дахь төрийн эрх мэдлийг хуваарилах зарчим болон системийн чиг, үүргийн зарчмын харилцан уялдаа

Монгол Улсын 1992 оны үндсэн хуулийн төрийн байгуулалтын бүлэгт Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн хооронд эрх мэдлийг хуваарилахдаа ямар онол, зарчмыг удирдлага болгосон бэ? гэдэг асуултад хариулахын тулд төрийн эрх мэдэл хуваарилах онол, сургаалын тухай товч авч үзье.

Төрийн эрх мэдлийг хуваарилах онол, сургаалыг цаг хугацаа, агуулгаар нь Эртний болон Орчин үеийн гэсэн хоёр төрөлд ангилж үзэж болно.

Эртний грекийн гүн ухаантан Аристотелийн төрийн эрх мэдлийг нийгмийн ангиуд хооронд хуваарилж, нийгмийн анги бүр өөр өөрсдийн чиг-үүргийг төрийн тогтолцоонд гүйцэтгэсэн засаглал нь хамгийн шилдэг төр гэсэн номлолыг төрийн эрх мэдэл хуваарилах эртний сургаал гэдэг.

Харин төрийн эрх мэдлийг хуваарилах орчин үеийн онол, сургаал нь анх Английн улс төр судлаач Жеймс Харрингтоны төрийн эрх мэдлийг нийгмийн анги хооронд биш, төрийн тогтолцоог үйл ажиллагааны төрлөөр нь ангилж хуваарилах ёстой гэсэн үзлээс эхлэн, Английн гүн ухаантан Жон Локкын төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх засаглалд хуваах нь зүйтэй гэсэн сургаалаар баяжин, эцэст нь Францын хуульч Ш.Л. Монтескью шүүх эрх мэдлийг хууль тогтоох болон гүйцэтгэх эрх мэдлээс тусгаарлан, эдгээр гурван эрх мэдлийн хооронд “хяналт-тэнцвэр”-ийн (*check and balance*) зарчмаар тэнцвэржүүлэх

тухай 1748 онд “Хуулийн Амин Сүнс” бүтээлдээ цэгцтэй боловсруулснаар улс төр, үндсэн хуулийн эрх зүйн шинжлэх ухааны эргэлтэд орсон байна.

Ш.Л. Монтескьюгийн төрийн эрх мэдлийг хуваарилах онолын гол цөм нь эрх мэдэл хоорондын “хяналт-тэнцвэр”-ийн зарчим юм.

Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн хооронд хяналт-тэнцвэрийн зарчим үйлчилж байгаа эсэхийг тогтоохын тулд дараах гурван нөхцөлийг шалгуур болгодог.

Үүнд:

(1) “Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн аль нэг эрх мэдэлд давуу эрх олгохгүй байх,”

(2) “Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийн аль нэгийн нь эрх нөгөө хоёртоо шилжихгүй байх,”

(3) “Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлүүд харилцан нэг нэгнээ хянаж байх ёстой.”²⁴ гэсэн нөхцөлүүд багтдаг.

Эндээс Ш.Л. Монтескьюгийн “эрх мэдлийг эрх мэдэл л хязгаарладаг” гэсэн алдарт зарчим урган гардаг бөгөөд дээрх нөхцөлүүдийн дагуу төрийн эрх мэдэл хооронд хяналт-тэнцвэр тогтоохыг “**төрийн эрх мэдэл хуваарилах онол**” (*Seperation of power*) гэж нэрлэдэг.

Судлаачид АНУ-н Ерөнхийлөгчийн засаглалыг “**төрийн эрх мэдэл хуваарилах**” онолын практик загвар гэж үздэг.

Гэтэл хууль тогтоох байгууллагаас Засгийн газрыг байгуулж, Засгийн газар түүний өмнө хариуцлага хүлээдэг парламентын засаглалыг “**төрийн эрх мэдлийг нэгтгэсэн**” (*Fusion of power*) загвар гэдэг.²⁵

Парламентын засаглал нь эрх мэдэл хуваарилах зарчмыг бүрэн биш,

²⁴ Монтескью, Хуулийн Амин Сүнс, 1748 (орч. Т.Төмөрхүлэг, 2008) 173 дахь тал.

²⁵ Riccardo Pelizzo, Improving Democratic Accountability Globally, 2013, P. 9.

заримдаг байдлаар ашигладаг эрх мэдлийг нэгтгэсэн өвөрмөц загвар юм.

Өөрөөр хэлбэл, парламентын засаглал нь дээрх төрийн эрх мэдэл хуваарилах “хяналт-тэнцвэр”-ийн нөхцлүүдийг харилцан адилгүй олон янзын хувилбараар ашигласан байдаг.

Өнөөдөр дэлхийн 190 гаруй тусгаар улсуудаас өрсөлдөх чадварын жагсаалтаар эхний 60 байр²⁶ эзэлсэн буюу “Шинэ санаачилга-Инновацид тулгуурлан хөгжиж байгаа орнуудыг засаглалын аль ангилалд хамаарч байгааг судалж үзэхэд дараах харьцаатай үр дүн гарч байна.

Зураг 2: Засаглалын хэлбэр

Парламентын Засаглал	41
Хагас Ерөнхийлөгчийн Засаглал	3
Супер Ерөнхийлөгчийн засаглал	1
Ерөнхийлөгчийн Засаглал	11
Хаант Засаглал	4
Нийт дүн	60

Тэгэхээр улсын хөгжил - засаглал хоёрын хооронд шалтгаант холбоо байна гэж үзвэл парламентын засаглал нь төрийн байгуулалтын хувьд эрх мэдэл хуваарилах “хяналт-тэнцвэр”-ийн зарчмаас “гадна” ямар аргаар, хэрхэн төрийн эрх мэдэл аль нэг эрх мэдэлд төвлөрөхөөс сэргийлж чадаж байна вэ? гэсэн асуулт урган гарна.

Аливаа улсын төр-засгийн тогтолцоо нь системийнхээ хувьд ард түмнийхээ нийтлэг хүсэл зоригийг биелүүлэх, мөн иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хамгаалах гэсэн үндсэн хоёр зорилгыг харилцан тэнцвэртэй хэрэгжүүлэхийн тулд дан ганц төрийн эрх мэдэл хуваарилах онолын “хяналт-тэнцвэр”-ийн зарчмыг баримталдаггүй болохыг “**төрийн эрх мэдлийг нэгтгэсэн**” (*Fusion of power*) парламентын засаглалтай улс

орнуудын туршлага харуулж байна.

Судалгааны явцад ихэнх амжилттай хөгжиж байгаа парламентын засаглалтай орнууд эрх мэдэл хуваарилах “хяналт-тэнцвэр”-ийн зарчмыг бүрэн биш, заримдаг ашигладаг өвөрмөц талаа институцийн функциональ чиг-үүргүүдийг системийн зорилгод нэгтгэсэн зарчмаар орлуулж, нөхөн зохицуулж байна.

Функциональ чиг-үүргийн зарчим нь эртний грекийн гүн ухаантан Аристотелийн **Полити** засаглалын загвар дээр тулгуурладаг улс төрийн системийн онолын зарчим юм.

Аристотель Улс төр зохиолдоо **Полити** гэж нэрлэсэн засаглалын хэлбэрийг орчин үеийн судлаачид “Холимог дэглэм” гэж нэрлэдэг.

Аристотель хаант (*Монархи*) засаглалын үндэс нь **сайн үйл**, аристократ засаглалын үндэс нь **сайн нэр**, демократын үндэс нь **эрх чөлөө** бөгөөд эдгээр гурван засаглалын сайн талуудыг нэгтгэсэн засаглалыг **Полити** буюу “Холимог дэглэм”²⁷ гэжээ.

Зураг 3: Аристотелийн шилдэг төрийн гурван шинж



Аристотелийн **Полити** буюу Холимог дэглэм нь нийгмийн “анги” хоорондын **ашиг сонирхлыг тэнцвэржүүлж**, нийгмийн нэг ангийн эрх ашиг нөгөө ангийн эрх ашгаар

²⁶ The Global Competitiveness report, 2016-2017.

²⁷ Аристотель, Улс төр, (Орч. Б. Даш-Ёндон, 2015), Дөрөв дэх хэвлэл, 180 дахь тал.

хязгаарлагдаг засаглалын хэлбэр байсан юм.

Гэхдээ түүхэн хөгжлийн явцад улс төрийн шийдвэр гаргах процесст *ард түмний оролцоог хангах, мэргэн шийдвэр гаргах, тогтвортой цомхон-чадварлаг бүтцээр гүйцэтгэх* гэсэн гурван чиг, үүрэг нь цагийн шалгуурт шүүгдэн орчин цагийн улс төрийн системд өвлөгдөн иржээ.

Төрийн тогтолцоо нь зорилго бүхий бие даасан системийн хувьд дээрх Аристотелийн “Холимог дэглэм”-ийн гурван чиг-үүргийг хариуцан гүйцэтгэх бүтэцтэй байж гэмээн өмнөө тавьсан “Хөтөлбөр”-өө биелүүлдэг байна.

Холимог дэглэм”-ийн гурван чиг-үүргийг улс төрийн системийн үе шатуудад байршуулж үзье.

Улс төрийн систем нь **Оролт - Боловсруулалт - Гаралт - Эргэх Холбоо**²⁸ гэсэн дөрвөн орчилтой байдаг.

Зураг 4: Улс төрийн системийн бүдүүвч



ОРОЛТ нь олон түмний шаардлага, дэмжлэг, ГАРАЛТ нь шийдвэр үйлдэл.

ШААРДЛАГА нь эдийн засгийн, нийгэм-соёлын зэрэг нийгмийн бусад хүрээнээс улс төрийн системээр шийдвэрлүүлэхээр тулгаж буй хүсэл-захиалга.

Харин ДЭМЖЛЭГ нь улс төрийн системээс гарсан шийдвэр, үйлдэл нь нийгмийн захиалгад нийцсэн үед нийгмийн гишүүдийн зүгээс тухайн улс төрийн системийг дэмжсэн үйлдэл, үйл ажиллагааг хэлдэг.

Энэхүү Шаардлага, Дэмжлэгээр буцаж ирж буй ЭРГЭХ ХОЛБОО улс төрийн системээс гарсан шийдвэр зөв, буруу болохыг илэрхийлдэг.

Тэгэхээр улс төрийн системээс гарсан шийдвэрийн зөв, буруу болон систем өөрөө цаашид оршин тогтнох эсэх нь “Оролт”-ын шатанд дахь олон нийтийн оролцоо (*ардчилал*), “Боловсруулалт”-ын шатны хяналт-шүүлтүүр (*улс төр, хуулийн хяналт*), “Гаралт”-ын шатны тогтвортой гүйцэтгэл (*цомхон-чадварлаг*) гэсэн хүчин зүйлээс хамаарна.

Хүний эрх, эрх чөлөөний баталгааг бүх талаар хангасан, хүн төрөлхтний хөгжил-дэвшлийн тэргүүн эгнээг хошуучлагч парламентын засаглалтай улс орнуудын улс төрийн тогтолцоо нь системийн **Оролтын үе шатанд** нийгмийн сонирхлын бүлгээс аль болох олон төлөөллийн оролцоог хангах,

Боловсруулалтын үе шатанд системийн зорилгоор шалгуур (цензур) тавьж, Оролтоос ирсэн мэдээллийг шүүн, аль болох рациональ шийдвэр гаргах, **Гаралтын үе шатанд** шийдвэрийг шуурхай-чанартай гүйцэтгэх тогтвортой тогтолцоо бүтээх замаар амжилттай ажилладаг байна.

Иймээс төрийн байгууламжийн функциональ чиг-үүргийг зүй зохистой тогтоосон улс орнуудын төрийн тогтолцооны тэргүүн туршлагыг дэлгэрүүлэн судалж үзье.

ТАВ. Ардчилсан орнуудын төрийн байгуулалтын туршлага

Аливаа улсын төр-засгийн тогтолцоо нь системийнхээ хувьд ард түмнийхээ нийтлэг хүсэл зоригийг биелүүлэх, мөн иргэдийнхээ эрх, эрх чөлөөг хамгаалах гэсэн үндсэн хоёр зорилгыг харилцан тэнцвэртэй хэрэгжүүлэхийн тулд төрийн эрх мэдэл хуваарилах онолын “хяналт-тэнцвэр”-ийн зарчмаас гадна институцийн функциональ чиг-үүргүүдийг системийн

²⁸ David Easton, An Approach the analysis of Political Systems, World Politics, Vol. 9, No.3, 1957, P. 383-400.

зорилгод нэгтгэсэн зарчмыг давхар ашигладаг тухай өмнөх нийтлэлийн төгсгөлд дурдсан билээ.

Хүний эрх, эрх чөлөөний баталгааг бүх талаар хангасан, хүн төрөлхтний хөгжил-дэвшлийн тэргүүн эгнээг хошуучлагч парламентын засаглалтай улс орнуудын улс төрийн тогтолцоо нь системийн **Оролтын үе шатад** нийгмийн сонирхлын бүлгээс аль болох олон төлөөллийн оролцоог хангах, **Боловсруулалтын үе шатад** системийн зорилгоор шалгуур (цензур) тавьж, Оролтоос ирсэн мэдээллийг шүүн, аль болох рациональ шийдвэр гаргах, **Гаралтын үе шатад** шийдвэрийг шуурхай-чанартай гүйцэтгэх тогтвортой тогтолцоо бүтээх замаар амжилттай ажилладаг байна.

Иймээс төрийн байгууламжийн функциональ чиг-үүргийг зүй зохистой тогтоосон улс орнуудын төрийн тогтолцооны тэргүүн туршлагыг дэлгэрүүлэн судалж үзье.

А. Зөвшилцлийн ардчилал

Ардчилал бол олонхийн засаглал гэдэг²⁹. Тэгвэл улс төрийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд илүү олон нийгмийн гишүүд, бүлэг, давхаргын төлөөлөл оролцож байвал илүү ардчилсан нийгэм оршиж байна гэсэн үг юм.

Ард түмэн төрийн эрхийг барьж буйн илэрхийлэл нь нийтийн танхим Засгийн газрын тэргүүнийг сонгодог улс төрийн зарчмаар илэрдэг.

Парламентын засаглалын түүхэнд Засгийн газрыг сонгох ардчиллын хоёр хувилбарыг ашиглаж иржээ.

Нэгд, Вестминстрийн (Westminster) олонхийн ардчиллын загвар юм. Олонхийн ардчиллын загвар гэдэг нь парламентад 50+1 гэсэн олонхийн суудал авсан нам Ерөнхий сайдыг томилж, Засгийн газрыг байгуулахыг хэлдэг. Гол онцлог нь парламентад

олонх болохын тулд сонгогдсон гишүүдийн тоо эсвэл намын авсан саналын хувь 50 + 1 гэсэн олонх болох хамгийн бага, доод хязгаар, босго³⁰-ыг давсан байх юм.

Монгол Улс бол 1992 оноос хойш олонхийн ардчиллын зарчмаар Засгийн газраа бүрдүүлж байгаа орон юм.

Олонхийн ардчилалд бага санал авсан нам сөрөг хүчний үүрэг гүйцэтгэдгийг бид мэднэ. Энэ цөөнх болсон талд санал өгсөн сонгогчдын хүсэл-шаардлага төрийн бодлогын гадна гээгдэх үзэгдэл олонхийн ардчиллын сөрөг үр дагавар юм.

Энэхүү сонгогчдын тодорхой хэсгийн санал гээгддэг олонхийн ардчиллыг улс төр судлаачид хиймэл буюу бүтээмэл олонхийн³¹ загвар гэж нэрлэдэг.

Дашрамд сануулахад, Монгол Улсын тухайд Вестминстрийн (*Английн*) олонхийн ардчиллын тогтолцоог үлгэр-загвар болгож парламентын тогтолцоог бэхжүүлж байгаа боловч Англи Улсын төрийн тогтолцоонд олонхийн ардчиллаас гажсан, төрийн эрх мэдэл хуваарилах функциональ (*чиг, үүргийн*) шинжид тулгуурласан институц цөөнгүй байдаг улс юм.

Тухайлбал, Их Британийн (*Английн*) парламентын доод танхимын даргыг Лордын танхим томилдог бөгөөд лордын танхимын үндсэн зорилго нь доод танхимыг удирдан чиглүүлэх үүрэг байдаг нь сонирхолтой.

Мөн Лордын танхим нь доод танхимын баталсан хуулийн үйлчлэх хугацааг нэг жил хүртэл хойшлуулах эрхтэй юм.

2005 оны шинэчлэл хүртэл Лорд Канцлер буюу Лордын танхимын даргын албан тушаал нь Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдлийг нэгтгэн,

³⁰ Аренд Лийпхарт, Ардчиллын Хэв Загвар, 1999, (орч, Д. Ганбат, 2007.) 30 дахь тал.

³¹ Аренд Лийпхарт, Ардчиллын Хэв Загвар, 1999, (орч, Д. Ганбат, 2007.) 35 дахь тал.

²⁹ Alan Siaroff, Comparing Political Regimes, 2013, P. 77.

харилцан тэнцвэржүүлэх үүрэгтэй байлаа³².

Товчоор хэлбэл, агуулга талаасаа Англи Улс шиг институтгүй Монгол Улс Вестминстрийн олонхийн ардчиллын загварыг хэлбэрийн талаас нь хуулсан нь онол-арга зүйн ноцтой алдаа мөн гэж дүгнэж болох юм.

Хоёрт, Бид өмнө Ардчилал бол олонхийн засаглал гээд, шийдвэр гаргах процесст илүү олон нийгмийн гишүүд, бүлэг, давхаргын төлөөлөл оролцож байвал илүү ардчилсан нийгэм гэж үздэг гэсэн.

Тэгвэл парламентад суудал авсан намууд хамтарч засгийн газрыг байгуулах, түүний мөрийн хөтөлбөрийг батлах зэргээр байж болох хамгийн дээд (*maximum*) олонхийг бүрдүүлэх зорилгоор эвсэл байгуулахыг Ардчиллын Зөвшилцлийн загвар³³ гэдэг.

Өөрөөр хэлбэл олонхийн ардчиллын загвар нь 50 + 1 бол зөвшилцлийн ардчиллын загвар нь сонгогчдын санал, нийгмийн захиалгыг аль болох гээхгүй төрийн бодлогод тусгах гэсэн хувилбар юм.

Зөвшилцлийн ардчиллын зарчмаар улс төрийн намууд Эвсэл байгуулах олон хувилбар байдаг. Тухайлбал,

Хамгийн цөөн намын эвсэл (Minimal winning coalition), хамгийн олон намын эвсэл (Surplus majority), хамгийн том хоёр намын эвсэл (Grand coalition), хамгийн бага суудалтай намуудын эвсэл (Minority), мөн хамгийн улс төрийн байр суурь, үзэл баримтлал ойр намууд эвсэх гэсэн олон хувилбарыг ашигладаг.

Дэлхий 190 гаруй тусгаар улсаас хөгжлийн түвшнөөр эхний 30 байр эзэлсэн жагсаалтаас парламентын

засаглалтай баруун европын 17 улсын 1945-2010 оны хооронд, төв европын 10 улсын 1990-2010 оны хооронд олонхийн болон зөвшилцлийн аль хэлбэрээр Засгийн газраа байгуулж байсныг судалж үзэхэд дараах харьцуулалт гарч байна.

*Хүснэгт 9: 1945-2010 оны хооронд байгуулагдсан олонхийн болон зөвшилцлийн Засгийн газрын тоон харьцуулалт*³⁴

Улс орон	Нийт Засгийн газар	Олонхийн зарчмаар нэг намын Засгийн газрын тоо	Зөвшилцлийн зарчмаар олон намын эвслийн Засгийн газрын тоо
Австри	24	6	18
Бельги	37	3	34
Дани	34	0	34
Финланд	49	0	49
Франц	28	9	19
Герман	28	5	23
Грек	14	10	4
Исланд	30	0	30
Ирланд	25	6	19
Итали	55	3	52
Люксембург	18	0	18
Нидерланд	26	0	26
Норвеги	29	6	23
Португал	15	3	12
Испани	11	3	8
Швед	28	2	26
Их британи	23	22	1
Болгар	7	4	3
Чех	9	0	9
Эстон	11	0	11
Унгар	9	1	8
Латви	15	0	15
Литва	12	6	6
Польш	15	0	15
Румын	15	2	13
Словак	8	0	8
Словени	12	0	12
Нийт дүн	587	91	496

Австри, Бельги, Дани, Финланд, Франц, Герман, Грек, Исланд, Ирланд, Итали, Люксембург, Нидерланд, Норвеги, Португал, Испани, Швед, Их британи зэрэг 17 улсын 1945 оноос хойш, Болгар, Чех, Эстон, Унгар,

³² Richard Benwell and oonagh Gay, The Separation of Powers, 2015, P. 8.

³³ Аренд Лийпхарт, Ардчиллын Хэв Загвар, 1999, (орч. Д. Ганбат 2007,) 115 дахь тал.

³⁴ Torbjörn Bergman, Coalition Politics and Institutions: Bringing in Central and Eastern Europe. 2010, P. 22.

Латви, Литва, Польш, Румын, Словак, Словени зэрэг орнуудын 1990 - 2010 оны хооронд судалгаанд хамрагджээ.

Дээрх судалгаанаас ажиглахад нийт 587 удаа Засгийн газар байгуулах 85% хувьд нь зөвшилцлийн зарчмаар байгуулсан байхад дөнгөж 15% хувьд нь олонхийн зарчмаар нэг нам дангаараа Засгийн газраа бүрдүүлсэн байна. Грек 14-өөс 10 удаа, Их Британи 23-аас 22 удаа, Литва 12-оос 6 удаа Засгийн газраа олонхийн зарчмаар байгуулсан нь 50% хувиас давсан гуравхан тохиолдол байна.

Ардчиллын олонхийн загвар онцгойрох, өрсөлдөх, тэмцэлдэх шинжтэй байдаг бол зөвшилцлийн загвар эрх мэдлийг хуваарилах, задлах, хязгаарлахаас гадна оролцуулах, харилцан буулт хийх шинжтэй байдаг утгаараа “хэлэлцээрийн ардчилал” гэж нэрлэдэг.

Тухайн улсын ардчиллын чанарыг “эрх чөлөө, тэгш байдал, хяналтын тогтолцоо” гэсэн гурван тулгуур, *Хууль дээдлэх ёс, Хувь хүний эрх чөлөө, Хэвлэл нийтлэх эрх, Ил тод байдал, Оролцооны тэгш байдал, Сонгуулийн эрх, Засгийн газрын бие даасан байдал, Хяналт-тэнцвэр, Хариуцлагын хэвтээ тогтолцоо, Хариуцлагын босоо тогтолцоо*” гэсэн 9-н дэд үзүүлэлтээр хэмждэг³⁵ бөгөөд зөвшилцлийн ардчилал 68.9, олонхийн Ардчилал 56.9 оноо тус тус авчээ.

Судлаачид зөвшилцлийн ардчиллын сонгодог загварыг Швейцар улсын төрийн тогтолцоо гэж үздэг.

Парламентын засаглалтай бусад орноос ялгарах Швейцар улсын төрийн тогтолцооны онцлог нь Засгийн газрын гишүүдийг парламентаас нэгэнт томилсон бол улс төрийн хариуцлага хүлээлгэх, огцруулах асуудал гардаггүй, энэ харьцангуй бие даасан шинжээрээ ерөнхийлөгчийн засаглалтай адил юм.

Швейцарын парламентын тогтолцоо нь засгийн эрхийг олонхид төвлөрүүлэлгүй, эрх мэдлийг хуваарилах, тараах зэргээр аль болох хязгаарлах зөвшилцлийн загвар юм.

Швейцарын Холбооны Зөвлөлийн (*Засгийн газрын*) долоон гишүүд нь “Шидэт Жор” (*Magic formula*) хэмээх 2:2:2:1 гэсэн томьёоны дагуу хувь тэнцүүлсэн өргөн эвслээс томилогдог³⁶.

Швейцарын Үндэсний Зөвлөлийн (*нийтийн танхимын*) 200 суудлын дөрөвний нэгтэй (1/4) тэнцэх суудлыг авсан гурван нам тус бүр 2 төлөөлөл, наймны нэгийг (1/8) авсан намд 1 төлөөлөл хуваарилагддаг байна.

Тухайлбал, 1959 оноос хойш Христийн Ардчилсан нам 2, Социал Демократ нам 2, Радикал Демократ нам 2 төлөөлөл, Ардын намын 1 төлөөллөөс Холбооны Зөвлөлийн (*Засгийн газрын*) 7-н гишүүд бүрдэж иржээ.

Швейцарын улс төрийн байгууламж нь Аристотелийн “Холимог дэглэм”-ийн гурван чиг, үүрэг, Монтескьюгийн эрх мэдэл хуваарилах зарчмын төгс зохицол бөгөөд “Шидэт Жор” гэсэн өргөмжлөл нь хэтрүүлэг биш билээ.

Олонхийн ардчиллаас зөвшилцлийн ардчилал нь ирээдүйд илүү үр ашигтай байна гэдгийг хууль зүйн шинжлэх ухааны профессор Ханс Кельзен 1920 онд “*Засгийн газарт ганц бүлгийн сонирхол ноёрхож огт болохгүй бөгөөд олон сонирхол бүхий бүлгүүд нам болон зохион байгуулагдаж сонирхлын тэнцвэрийг хадгалж байх нь зохистой.*”³⁷ хэмээн сануулж байжээ.

Б. Парламентын дээд танхим

Парламентын доод танхимын эрх мэдлийг дахин хуваарилах эрх зүйн чадамжтай, улс төрийн системийн

³⁵ Wolfgang Merkel, Good and Bad Quality : The Multi Worlds of Democracy, 2009, P. 24.

³⁶ Аренд Лийпхарт Ардчиллын Хэв Загвар.1999. (Д. Ганбат 2007.) орч. 56 дахь тал.

³⁷ Ханс Кельзен, Ардчиллын мөн чанар ба үнэт зүйл, 1920 (орч Д. Оргил, 2015) 73 дахь тал

“Оролт”-оор дамжин ирсэн нийгмийн шаардлагыг хянан - нягтлах чиг, үүрэг бүхий институц бол парламентын Дээд танхим юм.

Парламентын дээд танхимын чиг үүргийн тухай АНУ Үндсэн хуулийн зохиогчдын тайлбар ойлгомжтой энгийн утга төгөлдөр байдаг.

Тухайлбал, Жеймс Мэдисон АНУ-ын сенатын танхим бол нэгдүгээрт: төрийн эрх мэдэл нийтийн танхимд төвлөрөх эрсдэлийг хязгаарлах, конгрессын дур зоригороо аашлах эрх мэдлийг хумих “Хашлага” гэж, хоёрдугаарт: гүйцэтгэх эрх мэдлийг хянах “Аргалж”-ийн чиг-үүрэгтэй байгууллага байна гэж тайлбарласан.

Жорж Вашингтон АНУ-ын сенатын танхим бол конгрессын танхимын популист халуурлыг төрийн бодлого, тогтолцооноос тусгаарлагч, “Хөргөх систем”-ийн чиг-үүрэгтэй³⁸ гэж онцлон тэмдэглэсэн байдаг.

Сенатын буюу дээд танхим нь эртний Грек, Ромын үеэс МЭ 17 зууныг хүртэл язгууртан ноёдын танхим байж ирсэн бөгөөд дундад зуунаас уламжлагдан ирсэн Их Британийн Лордын танхим сонгодог жишээ юм. Өнөөдөр язгууртны төлөөлөл бүхий сенатын танхим хэмжээгүй эрхт хаант засаглалтай цөөхөн улсад үлджээ.

Орчин үеийн улс төрийн тогтолцоонд дээд танхим нь бүс нутгийн, үндэстэн ястны төлөөллийг хууль тогтоох байгууллагад бүрдүүлэх, хуулийн чанарыг сайжруулах, доод танхимын популист бодлогыг хянах, парламентын эрх мэдлийн төвлөрлийг сааруулах, дахин хуваарилах зорилгоор байгуулагдаж байна.

Францын хуульч Ш.Л. Монтескью “Хуулийн амин сүнс” бүтээлдээ Хууль тогтоох засаглалын тухай дараах санааг онцлон тэмдэглэжээ.

Доод буюу нийтийн танхимын талаар хэлэхдээ:

“Төлөөлөгчид сонгогчдоосоо ерөнхий нэг заавар, бас үйл ажил бүрээр тусгай даалгавар авдаг байх шаардлагагүй.

Энэ маягаар бол депутатуудын үг нь үндэсний дуу хоолойн цуурай болдог нь үнэн. Энэ нь ажилд эцэс төгсгөлгүй саад учруулж, депутат бүр нөгөөдүүлдээ эрх мэдлээ тулган, хамгийн эгзэгтэй нөхцөлд улс үндэстний хүчин чадлыг хэн нэгний овилгогүй ааш араншингаар тамирдуулахад хүргэдэг.

Төлөөллийн хурлыг мөн л ямар нэг дайчин зоримог шийдвэр гаргуулахаар сонгох хэрэггүй. Төлөөллийн хурал энийг гүйцэтгэх чадвараар маруухан. Харин хууль гаргуулах, баталсан хууль нь хэрэгжиж байна уу, үггүй юу гэдгийг ажиглаж хянаж байхын тулд сонгодог байвал зохино. Энийг л зөвхөн төлөөллийн хурал сайтар гүйцэтгэж чадна.”

Дээд буюу сенатын танхимын талаар дараах санаа, бодлоо тодорхой хэлсэн байна.

“Аль ч улсад ...нэр хүндээрээ овойж товойсон хүмүүс байдаг. Хууль тогтооход тэдний хувь нэмэр байвал зохистой. Энэ нь ард олны шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй тусгай хурал байгуулснаар бүтнэ, ард олон ч тэдний шийдвэрийг халах эрхтэй лүгээ адил юм л даа.”

“Тийнхүү, хууль тогтоох эрх мэдэл бүхий хуралдаан язгууртнуудад ч, ард олонд ч ногдох болно, аль аль нь бие биеэсээ тусгай зөвлөлддөг хуралтай, ангид үзэл бодол, өөр өөр эрх ашигтай байна.” гэжээ.³⁹

Орчин үед парламентын дээд танхимыг “Үндсэн хууль болон хүний эрх, эрх чөлөөний баталгаа”⁴⁰ гэсэн үзэл

³⁸ Baker Richard. The Senate of the United States. 1988

³⁹ Монтескью.Хуулийн Амин Сүнс. (Орч. Т.Төмөрхүлэг 2008.)177 дахь тал.

⁴⁰ Dawn Oliver, Constitutional Guardians,2015, P. 28.

номлол түгээмэл дэлгэрсэн байна.

Дэлхийн улсууд (1) бүс нутгийн төлөөлөл, (2) мэргэжлийн болон нийгмийн бүлгүүдийн төлөөлөл, (3) уламжлалт язгууртны төлөөлөл бүхий гэсэн үндсэн гурван хэлбэрийн дээд танхимтай бөгөөд зарим тохиолдолд холимог байх нь бий.

Франц Улсын нийслэл Парис хотноо 2000 оны 3 дугаар сарын 14-нд хуралдсан дэлхийн Сенатын танхимуудын форумд 50 гаруй улсын дээд танхимын төлөөлөгчид оролцож, парламентын дээд танхимын 4-н үндсэн чиг-үүргийг тунхагласан байдаг. Үүнд:

- *хууль тогтоох байгууллагад бүс нутгийн, үндэстэн, хэлтний төлөөллийг бүрдүүлэх замаар төлөөллийн ардчиллыг бэхжүүлэх,*

- *холбооны болон орон нутаг - мужулсын хоорондын харилцан уялдааг хангаж, төвлөрлийг сааруулах,*

- *орчин үеийн эрх мэдэл хуваарилах онолыг төгөлдөржүүлэх, хууль тогтоомжийн чанар-бүтээмжийг дээшлүүлэх,*

- *олон нийтийн эрх ашгийг хууль тогтоомж, төрийн бодлого хэлэлцүүлэгт тусгах⁴¹* гэж тодорхойлжээ.

2017 оны байдлаар дэлхийн 190 гаруй тусгаар улсаас 70 орчим улс нь хууль тогтоох дээд танхимтай бөгөөд холбооны улсууд 100 хувь, нэгдмэл улс орнуудын 1/3 нь парламентын хоёр танхимтай байна.

Дээд танхимыг эрх мэдлийн хувьд хүчтэй, дунд зэрэг, сул гэсэн хэмжүүрээр ангилдаг бөгөөд хүчтэй дээд танхим нь доод танхимтай эрх мэдлийн хувьд тэнцүү, доод танхимын баталсан хуулийг хүчингүй болгох, эсвэл эцсийн шийдвэрийг хоёр танхимын хамтын хурлаар шийдвэрлэх эрх мэдэлтэй байдаг.

Харин сул эрх мэдэл бүхий дээд

танхим нь доод танхимын хууль-шийдвэрийг тодорхой хугацаагаар хойшлуулах эрх, зөвлөх мэдэлтэй байдгаараа онцлог юм.

Дээд танхим нь төсөв-санхүүтэй холбоотой асуудлыг хэлэлцэх эрхгүй, энэ эрх доод танхимд хадгалагдаг боловч хэрэв зээ доод танхим төсөв-санхүүгийн асуудлаа шийдвэрлэж чадахгүй бол дээд танхим өөртөө татан авч шийдвэрлэдэг тохиолдол байдаг.

Дээд танхимын нэг онцлог бол дэлхийд одоогоор дээд танхимыг тараах тухай заалттай Үндсэн хууль байхгүй байна. Энэ нь доод танхим болон гүйцэтгэх засаглалын хооронд харилцан тэнцвэр барих, мөн тэднийг хянах дээд танхимын онцгой чиг-үүргээс үүдэлтэй юм.

Харин доод танхимыг Ерөнхий сайд болон Ерөнхийлөгч нар дээд танхимтай зөвшилцөн тараах зохицуулалт цөөнгүй байдаг. Энэхүү зохицуулалт нь төрийн механизмыг доод танхимын популист бодлого-шийдвэр гацаахаас сэргийлсэн үндсэн хуулийн эрх зүйн зохицуулалт юм.

Манай улсын парламентын түүхэнд сонгуулийн санхүүжилтийг эс тооцвол өндөр шалгуур босго үггүй нийтийн танхимаас баталж байгаа хууль-тогтоомжийн чанар, ажлын бүтээмж жил өнгөрөх тусам уруудсан дүр зурагтай байгаа учраас “Дэлхийн Сенатын форум”-аас тунхагласан 3,4 дүгээр үүрэг бүхий, зохих мэдлэг, мэргэжил, ёс суртахуун, насны шалгууртай дээд танхим байгуулах эсэхээс Монгол улсын цаашдын хөгжлийн зам мөр хамаарна.

Нийтийн танхим нь мөн чанарын хувьд төрийн шийдвэрийн “Эргэх-холбоо”-г улс төрийн системийн “Оролт” хэсэгт төлөөлдөг үндсэн үүрэгтэй учир ямар нэгэн зохих мэдлэг, мэргэжил, насны шалгуур тавих шаардлагагүй байдаг.

⁴¹ Patrice Gélard. Parliamentary complexity or democratic necessity? 2006, P. 2.

Хэрэв нийтийн танхимд сонгогдох төлөөлөгчдөд өндөр болзол, шалгуур тавьж эхэлбэл улс төрийн системийн гадаад “Эргэх-холбоо” тасалдаж, систем хаалттай хэлбэрт шилжин, дарангуй эсвэл цөөнхийн (олигарх) засаглалын хэлбэр тогтоно.

Иймээс нийтийн танхимын төлөөлөгчдийг сонгоход өндөр босго шалгуур тавилгүйгээр үлдээж, зөвхөн сонгуулийн тогтолцоог нь боловсронгуй болгох шаардлагатай юм.

Харин дээд танхим бол энгийн үгээр хэлбэл төрийн оюун ухаан, улс төрийн системийн шийдвэр гаргах үе шатны гол цөм болохын хувьд тодорхой босготой байх нь зүйтэй юм.

Монгол Улсын хувьд мэргэжлийн дээд танхимтай байх нь улс орны онцлог, уламжлал, нийгэм-эдийн засгийн хямралыг даван туулах хэрэгцээ шаардлагад нийцнэ.

Манай оронтой олон талаараа төстэй Бүгд Найрамдах Ирланд Улсын мэргэжлийн сенатын танхимын загварыг өөрийн орны онцлог тохируулан нутагшуулах нь хамгийн оновчтой хувилбар байж болох юм.

Хүснэгт 11: Ирланд Улсын мэргэжлийн Сенатын танхимын гишүүдийг сонгох салбар, холбоо⁴²

Сонгох, томилох эрх бүхий этгээд	Сенатын тоо
Ерөнхий сайдын томилох	11
Их Сургуулиудын сонгох	6
Мэргэжлийн салбар, холбоо Сонгох сенатын тоо	
Төрийн захиргаа, үйлчилгээний байгууллагын Холбоо	7
Хөдөө, аж ахуйн Холбоо	11
Соёл, Боловсролын Холбоо	5

Үйлдвэрлэл, Худалдааны Холбоо	9
Үйлдвэрчний (хөдөлмөрийн) Холбоо	11
НИЙТ ДҮН	43

Ирландын Мэргэжлийн Холбоодын сонгууль нь хуучин БНМАУ-ын Ардын их хурлаас Улсын Бага хурлын гишүүдийг сонгодог байсан шиг эхлээд сонгуулийн Коллегийн төлөөлөгчид салбар, холбоо тус бүрдээ сонгогдож, тэдгээр төлөөлөгчид Сенатын танхимд нэр дэвшигчийг сонгодог тогтолцоо юм.

Ирландын дээд танхим нь төлөөллийн байгууллага биш гэдгийг тэмдэглэх нь зүйтэй юм. Учир нь ард түмний төлөөллийн байгууллага бол нийтийн танхим бөгөөд мэргэжлийн холбоодоос сонгогдсон Сенатын гишүүд ямар нэг салбар холбооны төлөөлөгч биш, зөвхөн дээд танхимыг бүрдүүлэх чиг-үүргээ гүйцэтгэж байгаа хэлбэр юм.

Төрийн бүх эрх ард түмний мэдэлд байгааг илэрхийлэх ардчиллын билэг тэмдэг болсон нийтийн танхимыг мэргэжлийн танхимаар солих гэсэн оролдлогууд 20 дугаар зууны эхэнд европын зарим орнуудад бүтэлгүйтсэний учир нь зэрэгцэн орших ёстой байгууллагуудыг нэгийн нөгөөгөөр солих гэсэн туйлшралд оршиж байсан юм.

Мэргэжлийн танхим нь нийтийн танхимыг орлох биш, харин дээд танхимын мөн чанарт тохирох бөгөөд ганц Ирланд улс зөв байранд нь ажиллуулснаар үр нөлөөтэй төрийн институт болж төлөвшсөн байна.

Сүүлийн үед Их Британийн нэгдсэн вант улс Лордын танхимаа шинэчлэх судалгаа шинжилгээний дорвитой ажил хийж байгаа бөгөөд Ирландын мэргэжлийн дээд танхимыг маш нухацтай судалж байна.

Судлаачид Ирландын Сенатын танхимыг “эрх мэдлийн хувьд сул болон улс төрийн намын оролцоо,

⁴² <https://www.kildarestreet.com/senators/>

нөлөө багагүй байдаг"⁴³ зэрэг хүчин зүйлс мэргэжлийн гэсэн онцлог талын бүдгэрүүлж, ач холбогдлын бууруулсан гэж үзэх нь бий.

Монгол Улсын хувьд дээд танхимын гишүүдийг сонгох уу, томилох уу гэдгийг шийдэх дээ өөрийн үндэстний төрт-ёсны институцийн түүхэн уламжлалын онцлогийг харгалзан байгуулбал Сенатын танхимын (*сенат - ахмадын зөвлөл гэсэн утгатай үг*) язгуур мөн чанар-агуулгад нийцэх биз ээ.

В. Хараат бус институт

Төрийн ой санамжийн залгамж чанарыг сонгуулийн замаар бүрэлддэг институцээс илүү улс төрөөс ангид, хараат бус институц тогтвортой "хадгалан" хамгаалдаг.

Сонгуульт байгууллага, албан тушаалтан сонгуулийн дараагийн мөчлөгт (циклд) дахин сонгогдож чадахгүй бол төрийн ой санамжийн залгамж чанар тасрахад хүрдэг аюултай.

Төрийн ой санамжийг хадгалж байдаг дараах хэд хэдэн институцийг товчхон авч үзье.

1. Хэмжээт эрхт хааны институц

Дэлхийн тэргүүлэгч парламентын засаглалтай гүрнүүдээс Бельги, Дани, Люксембург, Норвеги, Голланд, Испани, Швед, Шинэ Зеланд, Австрали, Их Британи, Канад, Япон зэрэг улсуудад хэмжээт эрхт хааны институц уламжлагдан үлджээ.

Эдгээр орнуудын улс төрийн тогтолцоонд хааны институц нь Хууль тогтоох, Гүйцэтгэх, Шүүх эрх мэдэлд оролцох эрх үндсэн хуулиар хязгаарлагдмал боловч бодит байдалд хаант засаглалын уламжлалд тулгуурласан нэр хүндээ ашиглан төрийн гурван эрх мэдлийг

тэнцвэржүүлэх чиг-үүрэг гүйцэтгэх нь түгээмэл юм. Улс орны эв нэгдлийн бэлгэдлийн хувьд парламентын баталсан хуулийг ёсчлох, нэр дэвшүүлсэн Ерөнхий сайдыг батлах, санал оруулсан шүүгчийг томилох зэрэг их, бага харилцан адилгүй эрхтэй байдаг.

Хэмжээт эрхт хаан төрийн гурван эрх мэдлийн институцтэй удаан хугацаанд харилцсан туршлага дээрээ тулгуурлан заримдаа улс төрийн хямралыг даван туулах гарц нээх чиг-үүргийг гүйцэтгэж чаддаг.

Яагаад гэвэл хэмжээт эрхтэй боловч хаан хийгээд түүний институц нь байнгын тогтвортой бүтэц тул асуудалд аль болох улс орны урт хугацааны эрх ашгийг тэргүүн ээлжид эрэмбэлдэг байна.

Харин парламентын засаглалтай орны ерөнхийлөгч сонгуульт албан тушаал учир алтан дунджийг баримталсан төвч байр сууриа хадгалах амаргүй байдаг. Учир нь дахин сонгогдохын тулд асуудалд популист байр сууринаас хандах магадлал бага биш.

Иймд парламентын засаглалтай орны ерөнхийлөгчийн эрх мэдлийг улс орны эв нэгдлийг илэрхийлэгч бэлгэдлийн түвшинд нь хязгаарлаж байх нь нийт улс орны эрх ашигт нийцнэ.

Хэрэв парламентын засаглалтай орны ерөнхийлөгчийн эрх мэдлийг нэмэгдүүлбэл хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын давхар бүтэц үүсэх бөгөөд системийн онол болон удирдлагын ухааны хувьд зөрчилд хүргэнэ.

2. Зөвлөх байгууллага

а) Нийгэм-эдийн засгийн зөвлөл.

Төрийн ой санамжийн залгамж чанарыг хадгалж парламент болон засгийн газрын үйл ажиллагаанд тусалдаг тусгай байгууллага зарим оронд байдаг.

⁴³ Meg Russell. A Vocationally Based Upper House? Lesson from Ireland. 1999, P. 11.

Тухайлбал, Франц, Ирланд,⁴⁴ Чех, Словени, Люксембург,⁴⁵ Мальт зэрэг улсуудын Нийгэм-эдийн засгийн зөвлөлийг нэрлэж болно.

Жишээ нь Францын Нийгэм-эдийн засаг, байгал орчны зөвлөл (2008 оноос өмнө Нийгэм-эдийн засгийн зөвлөл) нь нийгэм, эдийн засаг, байгал орчны чиглэлийн засгийн газрын бодлого, хөтөлбөр, үйл ажиллагаанд дүн шинжилгээ хийх, дүгнэлт гарах, санал зөвлөмж оруулах, мэргэжлийн дэмжлэг туслалцаа үзүүлэх үүрэгтэй 233 зөвлөхөөс бүрдэг байна.⁴⁶

Францын Нийгэм-эдийн засаг-байгаль орчны зөвлөл нь дараах салбарын төлөөлөгчдөөс бүрддэг.

Эдийн засаг, нийгмийн салбар, холбоодын 140 төлөөлөл:

Ажилтан, ажилчдын 69,

Аж үйлдвэр, худалдааны 27,

Газар тариалангийн 20,

Гар үйлдвэрийн 10,

Нийгмийн үйл ажиллагааны 4,

Эдийн засгийн салбарт мэргэжсэн хувь хүмүүсийн 10 төлөөлөл.

Нийгэм, бүс - орон нутгийн холбоодын 60 төлөөлөл:

Төрөл бүрийн үйл ажиллагаа эрхэлдэг 8 (аялал жуулчлал, экспорт, хоршоолол),

Газар тариалангийн бүтээгдэхүүн боловсруулах хоршоолол 4,

Гэр бүлийн холбоод 10,

Далайн чанаддахь департамент болон эзэмшил нутгийн эдийн засаг, нийгмийн үйл ажиллагааны 11,

Оюутан, залуучуудын 4,

Нийгэм, соёл, шинжлэх ухаан, хөгжлийн бэрхшээлтэй болон тэтгэврийн хүмүүсийн нийгмийн хамгааллын, орон сууц эзэмшигчдийн холбооны 15 төлөөлөл.

Байгаль орчин хамгаалах холбоодын 33 төлөөлөл:

Байгаль, орчин хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг холбоодоос 18,

Байгал орчин, тогтвортой хөгжлийн чиглэлээр мэргэжсэн хувь хүмүүсийн 15 төлөөллөөс бүрдэг байна.

б) Санхүүгийн хяналтын танхим

Мөн ХБНГУ-н Холбооны Тооцооны Танхимыг дурдаж болно. Энэхүү Холбооны Тооцооны танхим нь хараат бусаар ажилладаг санхүүгийн хяналтын бие даасан дээд байгууллага юм. Танхимыг Ерөнхийлөгч тэргүүлдэг бөгөөд гишүүдийг Ерөнхийлөгч, Дэд Ерөнхийлөгчийн саналаар томилдог.

Танхим чиг-үүргийнхээ хүрээнд төсвийн зарцуулалт үр ашигтай зөв явагдаж байгаа эсэхэд хяналт тавьж, орлого, зарлага, санхүүгийн жилийн төрийн өр, төрийн өмчийн байдлын тухай Сангийн сайдын Бундестаг, Бундесратад тавьсан тайланг шалган, эдийн засгийн удирдлагыг дүгнэсэн тусгай илтгэл⁴⁷ гаргадаг байна.

Мөн Япон улсын Шалган байцаах зөвлөл нь Засгийн газраас хараат бусаар улсын төсөв, зарлагыг хянаж, санхүүгийн жилийн эцэст орлого, зарлагыг хянасан тайланг танилцуулдаг⁴⁸ байна.

⁴⁴ https://www.taoiseach.gov.ie/eng/Work_Of_The_Department/Social_Policy_and_Public_Service_Reform/National_Economic_and_Social_Council_NESC.html

⁴⁵ <http://www.luxembourg.public.lu/en/le-grand-duche-se-presente/systeme-politique/institutions-politiques/ces/index.html>

⁴⁶ <http://www.lecese.fr/en/esec-overview>

⁴⁷ Ч. Энхбаатар, ХБНГУ-ын төрийн эрх зүй, 2010, 125 дахь тал.

⁴⁸ Ч. Энхбаатар, Япон улсын төрийн байгуулал, улс төрийн тогтолцоо, 2012, 70 дахь тал.

3. Үндсэн хуулийн шүүх

Дээд танхим нь нийтийн танхим болон гүйцэтгэх засаглалын үйл ажиллагаанд улс төрийн хяналт тавьдаг бол Үндсэн хуулийн шүүх нь Хууль тогтоох, Гүйцэтгэх эрх мэдлийн үйл ажиллагаанд хууль зүйн хяналтын чиг-үүрэг гүйцэтгэдэг бүтэц юм.

Үндсэн хуулийн шүүхийн бүтэц, чиг-үүргийг ерөнхийд **нэгдүгээрт**, ердийн шүүхийн (америк маягийн), **хоёрдугаарт**, дагнасан шүүхийн (эх газрын маягийн) гэсэн хоёр үндсэн хэв маягтай гэж ангилдаг байна.⁴⁹

Америк загварын онцлог нь Үндсэн хуулийн биелэлтэд тавих мэргэжлийн дээд хяналтыг Улсын дээд шүүхэд харьяалуулж, бүрэн эрх олгосон байдаг оршино.

Дагнасан шүүхийн хэв маяг дотор Австрийн, Францын гэсэн хоёр загвар бий.

Австрийн загвар нь Дээд шүүхээс тусдаа ажилладаг, зөвхөн Үндсэн хуулийн хяналтыг тусгайлан эрхлэх чиг-үүрэгтэй бие даасан шүүх юм.

Харин Францын загварыг Үндсэн хуулийн зөвлөл гэж нэрлэдэг.

Үндсэн хуулийн зөвлөлийн гол онцлог нь улс төрийн хяналтын шинжтэй, хууль болон бусад актуудыг Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг хүчин төгөлдөр болохоос өмнөх шатад хянан үздэг процесс юм. Энэ шинжээр нь Францын Үндсэн хуулийн зөвлөлийг шүүн таслах чиг-үүрэг хэрэгжүүлдэггүй,

⁴⁹ Д. Лүндээжанцан, Монгол улс дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт, 2014, хоёр дахь хэвлэл, 202 тал.

харин парламентын хууль тогтоох чиг-үүргийг хэрэгжүүлэхэд оролцогч гэж үзэж байна.

СУРГАА. Дүгнэлт

Хаана эрх мэдэл төвлөрч байна, тэнд хүний эрх, эрх чөлөө хязгаарлагдаж байдгийг бид мэднэ.

Монгол Улс нэн даруй төрийн байгууламжийн шинэчлэлийн асуудлыг хэлэлцэхгүй бол улс төрийн намаар дамжин төрийн тогтолцоог эзлэн авч буй “Клиентелизм” болон популист бодлого, шийдвэрийн сөрөг үр дагавар улс төр, эдийн засаг, нийгмийн бүх системээ сүйрүүлж, Үндсэн хуульд тунхагласан үнэт зүйл, тусгаар тогтнол, хүний эрх, эрх чөлөөний хамгаалалт нуран унаж байна.

Иймээс улс төрийн намд төвлөрсөн эрх мэдлийг Үндсэн хуульд дараах зарчмаар дахин хуваарилах, эрх зүйн үндсийг тогтоох улс төр, нийгэм, хууль зүйн шинэчлэл биднийг хүлээж байна.

НЭГД: Швейцарын Зөвшилцлийн ардчиллын зарчимд суурилсан нийтийн танхим,

ХОЁРТ: Ирландын мэргэжлийн зарчмаар байгуулдаг дээд танхим,

ГУРАВТ: Францын Эдийн засаг-нийгэм-байгаль орчны Зөвлөлийн чиг-үүрэг бүхий хараат бус институцийг байгуулах тухай Үндсэн хуулийн шинэчлэл бол Монгол улсын ойрын ирээдүйн хөгжлийг шийдвэрлэх дотоод Суурь Хүчин Зүйлс юм.

**“АЗИЙН ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН СҮЛЖЭЭ” (ALIN) ОЛОН УЛСЫН
БАЙГУУЛЛАГЫН 2018 ОНЫ ЭЭЛЖИТ УДИРДЛАГУУДЫН УУЛЗАЛТ,
ОЛОН УЛСЫН ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ ХУРАЛ АМЖИЛТТАЙ БОЛЛОО**



2018 оны 6 дугаар сарын 27, 28-ны өдөр “Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ” (ALIN) олон улсын байгууллагын 2018 оны ээлжит удирдлагуудын уулзалт, олон улсын эрдэм шинжилгээний хурлыг Хууль зүйн үндэсний хүрээлэн амжилттай зохион байгууллаа. 2018 оны байдлаар “Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ” олон улсын байгууллагын сүлжээнд нийт 17 орны 36 байгууллага нэгдээд байна. Сүлжээний гишүүн байгууллагууд эрх зүйн мэдээлэл, судалгааны хүрээнд туршлага солилцох, хамтарсан судалгаа, төсөл хэрэгжүүлэх зэргээр хамтран ажилладаг. Мөн ээлжит удирдлагуудын уулзалт, олон улсын эрдэм шинжилгээний хурлыг жилд нэг удаа, өмнөх хурлаар тухайлан сонгогдсон гишүүн оронд зохион байгуулдаг уламжлалтай тул энэ удаад Монгол Улсад зохион байгуулсан. Азийн эрх зүйн мэдээллийн сүлжээ” (ALIN) олон улсын байгууллагын 2018 оны удирдлагуудын ээлжит уулзалт Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн хуульчдын танхимд 6 дугаар сарын 27-ны өдөр боллоо.

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЖИЛТ, ШИНЖИЛГЭЭ

(Үндсэн хуулийн маргаан: Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг хэмээх судалгааны танилцуулга)

МУИС–ийн Хууль зүйн сургуулийн
докторант С.Номынбаясгалан

МУИС–ийн Хууль зүйн сургуулийн
оюутан Х.Мөнхчимэг

ТҮЛХҮҮР ҮГС

Монгол Улсын Үндсэн хууль, Үндсэн хуулийн цэц, Үндсэн хуулийн маргаан.

ТОВЧЛОЛ

Монгол Улсад Үндсэн хуулийн биелэлтэд тавих хяналтыг шинэ шатанд гаргаж, Үндсэн хуулийн цэцийг байгуулаад зогсохгүй түүний үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх талаар багагүй зүйл хийж иржээ. Шинэ Үндсэн хуулийн Үндсэн хуулийн шүүхийн үйл ажиллагааг зохицуулсан бүлэг нь түүний эрх зүйн үндэс болдог. Улсын Их Хурал 1992 онд Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, 1997 онд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх тухай хуулийг тус тус батлан гаргаж мөрдүүлсэн нь Үндсэн хуулийн цэцийг төрийн тогтолцоонд зохих байр сууриа эзлэн бэхжиж төлөвшихөд онцгой хувь нэмэр оруулсан төдийгүй хүлээсэн үүргээ биелүүлэх эрх зүйн орчинг бий болгожээ.

I. ОРШИЛ

Монгол Улсын хувьд, Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих чиг үүрэг бүхий Үндсэн хуулийн шүүхийн /"Үндсэн хуулийн цэц" гэсэн оноосон нэртэй/ эрх зүйн үндсийг үндсэн хууль өөрт нь бүрдүүлэн байгуулсан

билээ.¹ Ийнхүү Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт үндэслэсэн Монголын өнөөгийн хууль тогтоох байгууллага, бусад эрх мэдэл бүхий субъектын үйл ажиллагааны алдаа оноо, ажлын арга барилыг дүгнэх² төдийгүй үндсэн хуулийн хяналтыг эргэн харж, цааш зөв тууштай чиглэлд хөтлөхөд дөхөм үзүүлнэ гэж таамаглалаа. Энэ нь Үндсэн хуулийн цэцийн үндсэн хууль дахь чиг үүргийн мөн чанарт илүүтэйгээр ойртох болов уу гэсний үндсэн дээр энэ товч танилцуулгыг бичлээ. Үүний сацуу Үндсэн хуулийн шүүхийн гол зориулалт³ нь үндсэн хуулийг хамгаалах мэт боловч түүний тулах цэг нь иргэдийн үндсэн эрхийг хангах, хамгаалах

¹ Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар бүлэг буюу Жаран дөрөвдүгээр зүйлээс Жаран долдугаар зүйлд 1992.01.13., ТМ 1992 он №01, "БНМАУ–ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай" Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуулийн Гуравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль 1992.05.08., ТМ 1992 он №03, "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Бага Хурлын 1992 оны 5 дугаар сарын 15–ны өдрийн 34 дүгээр тогтоол ТМ 1992 он №03, "Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийг томилох тухай" Монгол Улсын Бага Хурлын 1992 оны 7 дугаар сарын 1–ний өдрийн 38 дугаар тогтоол ТМ : 1992 он №03 дугаарт тус тус нийтлэгдсэн.

² Ж.Амарсанаа. "Үндсэн хуулийн маргаан" (Анхны хэвлэл). УБ., 2012 он. 21 дэх тал.

³ Үндсэн хуулийн шүүхийн зориулалтыг (үндсэн хуулийг тайлбарлах болон үндсэн хуулийг шууд үйлчилдэг эрх зүй болгох) хэмээх хувааж судлаачид (Сарантуяа Ц. "Монгол Улс дахь Үндсэн хуулийн процессын эрх зүйн үүсэл, төлөвшил, тулгамдсан асуудал" (Хууль зүйн шинжлэх ухааны докторын зэрэг горилсон бүтээл) УБ хот, 2008, 94 дэх тал, Бямбажаргал А. "Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн үндэслэлгээ: эрх зүйн шинжилгээ" (Магистрын дипломын ажил) УБ., 2009 он, 23 дахь тал) үздэг.

асуудал болоод зогсохгүй түүнээс огт хөндийрэх учиргүй гэж үздэг.⁴ Тиймээс үндсэн эрхийн маргаанд ач холбогдол өгөх тухай тэмдэглэсэн байдаг.⁵ Энэ утгаараа түүнээс огт хөндийрэх учиргүй юм.

Энэ агуулгаар үндсэн хуулийг ард түмний хүсэл зоригийг илэрхийлсэн хууль гэж үзэх⁶ төдийгүй үндсэн хууль өөртөө аливаа хууль бус халдлагаас хамгаалах дархаллыг бий болгосон байдаг. Үндсэн хуулийн үүслийн уг сурвалж нь төр болон төрийн эрх мэдлийг хуулиар хязгаарлах гэсэн оролдлоготой холбоотой хэмээн үздэг. Хаант засгийн хэмжээгүй эрх мэдлийг хязгаарлах үзэл санаа үндсэн хуульд үүсэх эх сурвалж болсон бол парламентын засаглалын эрх мэдлээ хэтрүүлэх, өөртөө илүү эрх мэдэл тогтоох үйлдэл, санаархал нь үндсэн хуулийн хяналт бий болгох эх сурвалж болсон гэж үзэх үндэслэлтэй.⁷ Үндсэн хуулийн хяналтын тогтолцоог үндсэн хуулийн амин сүнс⁸ гэж нэрлэдэг учир энэ билээ.

Түүнчлэн үндсэн хуулийн хяналтын институт нь өөрөө үндсэн хуулийн эрх зүйн хүрээнд дэх ойлголт, агуулгыг өөртөө агуулдаг. Тиймээс үндсэн хуулийн хяналтын механизмын хүрээнд дэх Үндсэн хуулийн цэцийн шийдвэр нь өөрөө үндсэн хуулийн эрх зүйн судлагдахуун гэж үзэж болно. Энэхүү товч танилцуулга нь онол, танин мэдэхүйн асуудлыг гол болгосонгүй. Харин Үндсэн хуулийн эрх зүйн

зохицуулалтын хэрэгжилтийн талаарх асуудлыг Үндсэн хуулийн цэц судлалын үүднээс хөндөх төдий практик шинжтэй юм. Тиймээс танилцуулгыг ийнхүү нэрлэсний учир энэ билээ. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг маргаан зүйл, хандагч этгээд, хууль тайлбарлах аргаар төрөлжүүлэн ангилсан судалгаа хийгдсэн⁹ болохоос Үндсэн хуулийн бичвэр (зүйл, хэсэг, заалт) бүрийн хүрээнд төрөлжүүлэн авч үзсэн (Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн агуулгыг товч танилцуулсан) нь хомс байна.¹⁰ Тиймээс Монгол Улсын Үндсэн хуулийн хэрэгжилтийг зүйл бүрийнх нь хүрээнд цухас гаргахыг оролдсон нь шинэлэг юм. Үүний зэрэгцээ “Үндсэн хуулийн маргаан: Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг” хэмээх судалгаанд тухайлсан үндсэн хуулийн маргааны хувьд, **маргааны зүйл болон үндсэн хуулийн зүйл, заалтын харилцан хамаарлыг тэмдэгт ашиглан бичихийг оролдсон болно.¹¹ Ингэхдээ Үндсэн хуулийн цэцийн шийдвэрт дүн шинжилгээ хийх тодорхой

⁹ “Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах” (Гарын авлага). УБ., 2016 он.

¹⁰ П.Очирбат. “Монгол Улсын Үндсэн хууль: хэрэгжилт, хяналт, судалгаа”. УБ., 2017 он, “Монгол Улсын 1992 оны үндсэн хуулийн хэрэгжилтийн байдалд хийсэн дүн шинжилгээ”. УБ., 2016 он.

¹¹ Энэ нь Монгол Улсын Үндсэн хуулийн эсрэг (э.) маргааны зүйл, утгыг агуулах бөгөөд тухайлсан үндсэн хуулийн маргааны хувьд “...//...” буюу “...\\...”, эсхүл “...\\ //...” гэсэн тэмдэглэгээнийг дараах агуулгаар:

Жишээлбэл, “Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсэг // Монгол Улсын Их Хурлын тогтоол” гэснийг Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин долдугаар зүйлийн 3 дахь хэсгийг Монгол Улсын Их Хурлын тогтоол зөрчсөн гэж, Жишээлбэл, “Монгол Улсын Үндсэн хуулийн ... Гучин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэг // Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг” гэснийг Монгол Улсын Үндсэн Гучин гуравдугаар зүйлийн 3 дахь хэсэг болон бусад холбогдох зүйл, заалтыг Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг зөрчөөгүй гэж, Жишээлбэл, “Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйл // Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль” гэснийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван дөрөвдүгээр зүйлийг Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль зөрчсөн, зөрчөөгүй гэж тус тус ойлгоно. Харин “Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй болгосон хуулийн заалтыг агуулгаар нь дахин сэргээсэн эсэхийг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн маргааны” тухайд дээрх тэмдэглэгээг хэрэглээгүй.

⁴ Бямбажаргал А. “Үндсэн хуулийн шүүхээр үндсэн эрхийг хамгаалах арга зам” Эрх зүй сэтгүүл, 2016, №01(33), 164 дэх тал.

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Д.Ганзоригийн “Үндсэн эрхийн маргаан – Цэц шийдвэрлэх боломж, хандлага” сэдэвт илтгэлээс http://www.conscourt.gov.mn/?page_id=3255

⁶ Чимид Б. “Үндсэн хуулийн мэдлэг”. УБ., 2008 он. 40 дэх тал.

⁷ Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүн Н.Жанцангийн “Үндсэн хуулийн шүүх эрх мэдэл: тулгамдсан асуудал, хэтийн төлөв” сэдэвт илтгэлээс http://www.conscourt.gov.mn/?page_id=3245

⁸ Д.Гангабаатар. “Үндсэн хуулийн эрх зүй” (Төрийн байгуулал, зарчим, үзэл баримтлал). УБ., 2017 он. 148 дахь тал.

аргачлалыг ашиглахыг эрмэлзлээ.¹² Эл танилцуулгад Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг сургалт, судалгаанд хэрхэн эшлэж нэрлэх нь зохистой вэ гэсэн асуултад хариулах үүднээс санал төдий бичсэн болно.

Үүнийг хэрэгжүүлэх хэрэгсэл нь судалгааны онол, арга зүй гэж үзэж болох ч эрх зүйн онолууд нь уламжлагдан шинэчлэгдэх хандлагаас шинэчлэгдэн уламжлагдах чиглэлээр өөрчлөгдөн хувьсах учиртайг¹³ харгалзан үзсэн болно. Энэ судалгаанд тухайлсан үндсэн хуулийн маргаан бүрд Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг хялбарчлан эмхтгэсэн томъёолол, *дүгнэлт, тогтоолын нэр, хандагч этгээдийн өргөдөл, мэдээлэл, хүсэлтийн болон Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хариу тайлбарын товч агуулга, **маргааны зүйл, шийдвэрийн үндэслэл, үндсэн хуулийг тайлбарласан арга гэсэн дарааллаар танилцуулав. Үндсэн хуулийн цэцийн тогтоолтой холбогдох өмнө нь гарсан Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтэд үндсэн хуулийн маргааны тухай давхардуулан оруулаагүй. Энд онцлон тэмдэглэхэд, Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн товч агуулгыг “түлхүүр утга” гаргаж хураангуйлав. Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн маргааны зүйл нь хүчингүй болсон бол дундуур зураас тавьж бичив. Тодорхой албан тушаалтны үйлдэлд огноо тэмдэглэлгүй орхив. **Маргааны зүйлийг нэр, огноо, эх сурвалж гэсэн дарааллаар, бүрэн эхээр нь байрлуулав. Монгол Улсын Үндсэн хуулийг тайлбарласан хууль тайлбарлах аргыг шийдвэрийн үндэслэлийг ашиглан тодорхойлохыг оролдсон болно. Мөн түүнчлэн энд тухайн үндсэн хуулийн маргаанд

холбогдох Монгол Улсын Их Хурлын тогтоолыг давхар оруулав. Энэ тогтоолд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн талаарх байдлыг нэмж тэмдэглэв.¹⁴ Эл танилцуулгад хуудасны тоонд баригдан **маргааны товч агуулгыг авч үзсэнгүй. Судалгааны хүрээнд авч судлах асуудал нь Үндсэн хууль болон Үндсэн хуулийн цэцийн шийдвэр хоорондын харилцан хамаарлын тухай товч танилцуулахад оршино.

II. Монгол Улсын Үндсэн хууль ба Үндсэн хуулийн цэцийн шийдвэр хоорондын харилцан хамаарал

Танилцуулгын энэ хэсэгт Монгол Улсын Үндсэн хууль ба Үндсэн хуулийн цэцийн шийдвэр хоорондын харилцан хамаарлын тухай авч үзлээ. Судалвал Монгол Улсын Үндсэн хууль нь 70 зүйл, 201 хэсэг, 75 заалт нийтдээ 7559 тэмдэглэгээнээс бүрдсэн бөгөөд үүнээс үг 5977, тоо 323, цэг 471, таслал 625, тэмдэгт 163 байдаг.¹⁵ Энд 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Монгол Улсын Үндсэн хуулийг авч үзсэн бөгөөд энэ хуулийн бичвэрт (зүйлд) Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн (цаашид “Үндсэн хуулийн цэц” гэх) шийдвэр бүхий зүүлт хийлээ. “БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай” Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт

¹² О.Мөнхсайхан. “Цэцийн шийдвэрт дүн шинжилгээ хийх аргачлал УИХ э. Н.Хайдав [2007]” Шүүх эрх мэдэл сэтгүүл, УБ., 2015 он. №2, 77 дахь талаас дэлгэрүүлж үзнэ үү.

¹³ Баярсайхан Д. “Эрх зүйн онол”. УБ., 2010 он. 23 дахь тал.

¹⁴ Үндсэн хуулийн цэцээс дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй Монгол Улсын Их Хурлын тогтоолыг, Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэж шийдвэрлэсэн маргааны зүйлийг тус тус хүчингүй болгосон бол дундуур зураас тавьж бичив. Монгол Улсын Их Хурлын тогтоолыг Үндсэн хуулийн цэцийн шийдвэртэй адил *тогтоолын нэр, дугаар (№), батлагдсан огноо (Он. сар. өдөр.), эх сурвалж (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл) гэсэн дарааллаар кодлов. Монгол Улсын Их Хурлыг “МУИХ” гэж товчлов. Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийн дараа өнгөөр ялган ташуу – italic болгож оруулав.

Жишээлбэл, “МУИХ (Тогтоол №81/2014.12.19., ТМ 2015 он №02) гэснийг “Монгол Улсын Их Хурлын 2014 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 81 дүгээр тогтоол, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2015 оны №02 дугаарт нийтлэгдсэн” гэж ойлгоно.

¹⁵ “Хууль зүйн нэр томъёоны судалгаа, хэрэглээ” сэдэвт улсын хэмжээний эрдэм шинжилгээний хурлын илтгэлийн эмхэтгэл, УБ., 2016 он. 45 дахь тал.

хууль 1992 оны 1 дүгээр сарын 16–ны өдөр батлагджээ. Мөн энэ хавсралт хуульд бас шийдвэр бүхий зүүлт хийсэн болно. Монгол Улсын Үндсэн хуульд 2000 оны 12 дугаар сарын 14–ний өдөр нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Энэ хуулийн холбогдох зүйлд хамаарах 1992 оноос 2018 он хүртэлх хугацаанд “Үндсэн хуулийг зөрчсөн” гэж шийдвэрлэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоолыг дараах байдлаар танилцуулж байна. Үүнээс гадна эдгээр шийдвэрийн үндэслэлд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр судалгаанд хүрсэн үр дүнгээс зарим хэсгийг энд тэмдэглэлээ.

Энэхүү товч танилцуулгад Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг *шийдвэрийн нэр (Дүгнэлт, Тогтоол), дугаар (№), огноо (Он. сар. өдөр.), эх сурвалж (“Төрийн мэдээлэл” эмхэтгэл) гэсэн дарааллаар байрлуулав. Энд Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоолыг хуулийн тухайн зүйлд өнгөөр ялган ташуу – *italic* болгож оруулав. Эдгээр шийдвэрт **маргааны зүйл нь үндсэн хууль зөрчөөгүй байна гэж шийдвэрлэсэн дүгнэлт, тогтоолыг танилцуулгын үндсэн хэсэгт “ТАЙЛБАР” болгон оруулаагүй. Мөн энд маргааныг агуулгаар нь дахин сэргээсэн эсэхийг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн тогтоолыг тэмдэглэгээгүй.¹⁶ Үндсэн хуулийн цэцийн зарим дүгнэлт, тогтоол нь үндсэн хуулийн хэд хэдэн бүлэг, түүнчлэн зүйл, хэсэг, заалтыг хамаарч байгаа тул хоорондоо уялдаатай болохыг энд онцлон тэмдэглэж байна.

Жишээлбэл, “Энэ зүйлийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №01/1993.02.12.), (Тогтоол №04/2006.10.11.), (Дүгнэлт №03/2007.03.02., ТМ 2007 он №14), (Дүгнэлт №06/2007.05.23., ТМ 2007 он №21) шийдвэртэй холбон үзнэ үү.” гэснийг *(Дүгнэлт №03/2007.03.02., ТМ 2007 он №14) гэснийг “Монгол

Улсын Үндсэн хуулийн цэцийн 2007 оны 3 дугаар сарын 2–ны өдрийн 03 дугаар дүгнэлт, “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2007 оны №14 дугаарт нийтлэгдсэн” гэж ойлгоно.

Энэ хуулийн НЭГДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ¹⁷ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/2000.11.29., ТМ 2000 он №46), (Дүгнэлт №01/2004.04.21., ТМ 2004 он №17), (Дүгнэлт №05/2006.05.31., ТМ 2006 он №21), (Дүгнэлт №11/2006.12.13., ТМ 2006 он №48), (Тогтоол №02/2007.06.22.), (Дүгнэлт №03/2007.03.02., ТМ 2007 он №14), (Дүгнэлт №06/2007.05.23., ТМ 2007 он №21), (Дүгнэлт №08/2007.06.20., ТМ 2007 он №24), (Дүгнэлт №03/2008.02.27., ТМ 2008 он №12), (Тогтоол №02/2008.05.07., ТМ 2008 он №18), (Тогтоол №03/2009.06.10., ТМ 2009 он №32), (Дүгнэлт №02/2009.03.11., ТМ 2009 он №11), (Дүгнэлт №04/2010.07.07., ТМ 2010 он №36), (Тогтоол №03/2012.05.02., ТМ 2012 он №18), (Тогтоол №02/2015.02.11., ТМ 2015 он №07) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ГУРАВДУГААР ЗҮЙЛИЙГ¹⁸ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/2008.05.07., ТМ 2008 он №18), (Тогтоол №03/2012.05.02., ТМ 2012 он №18) зэрэг тогтоолтой холбож үзнэ үү.

Энэ хуулийн ТАВДУГААР

¹⁷ Энэ зүйлд “1.Монгол Улс бол тусгаар тогтносон, бүрэн эрхт, Бүгд найрамдах улс мөн.

2.Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж заажээ.

¹⁸ Энэ зүйлд “1.Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.

2.Төрийн эрх мэдлийг хууль бусаар авах, авахаар завдахыг хориглоно.” гэж заажээ.

¹⁶ “Тогтоол №01, 2008.01.24., Тогтоол №03, 2016.03.23., Тогтоол №02, 2017.12.20., Тогтоол №01, 2017.12.06.”

ЗҮЙЛИЙГ¹⁹ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №03/2002.11.13., ТМ 2002 он №44) тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн АРАВДУГААР ЗҮЙЛИЙГ²⁰ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №03/1993.05.26., ТМ 1993 он №03), (Дүгнэлт №01/1994.01.07., ТМ 1994 он №02), (Дүгнэлт №02/1994.01.12., ТМ 1994 он №03), (Тогтоол №01/1996.05.15., ТМ 1996 он №08), (Дүгнэлт №03/2005.04.13.), (Тогтоол №02/2009.05.27., ТМ 2009 он №30) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн АРВАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ²¹ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №02/1994.01.12., ТМ 1994 он №03), (Дүгнэлт №04/1996.05.29.), (Тогтоол №01/1998.06.17., ТМ 1998 он №07), (Дүгнэлт №02/1998.02.24., ТМ 1998 он №05), (Тогтоол №03/2002.11.13., ТМ 2002 он №44), (Тогтоол №02/2005.12.14., ТМ 2006 он №48), (Тогтоол №02/2006.06.15., ТМ 2006 он №25), (Тогтоол №03/2006.07.05., ТМ 2006 он №36), (Тогтоол №03/2009.06.10., ТМ 2009 он №32), (Дүгнэлт №01/2010.03.24., ТМ 2010 он №13), (Тогтоол №02/2012.02.15., ТМ 2012 он №09), (Тогтоол №03/2012.05.02., ТМ 2012 он №18), (Дүгнэлт №03/2014.03.12., ТМ 2014 он №12), (Дүгнэлт №12/2015.09.30., ТМ 2015 он №37), (Дүгнэлт №09/2016.09.21., ТМ 2016 он №38) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн АРВАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛИЙГ²³ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02 /1993.03.13., ТМ 1993 он №02), (Тогтоол №01/1994.02.04., ТМ 1994 он №04), (Дүгнэлт №02/1994.01.12., ТМ 1994 он №03), (Дүгнэлт №07/1994.07.25., ТМ

¹⁹ Энэ зүйлд "1.Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.

2.Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.

3.Өмчлөгчийн эрхийг гагцхүү хуульд заасан үндэслэлээр хязгаарлаж болно.

4.Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.

5.Мал сүрэг бол үндэсний баялаг мөн бөгөөд төрийн хамгаалалтад байна." гэж заажээ.

²⁰ Энэ зүйлд "1.Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.

2.Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.

3.Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

4.Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй." гэж заажээ.

²³ Энэ зүйлд "Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

1/ амьд явах эрхтэй. Монгол Улсын Эрүүгийн хуульд заасан онц хүнд гэмт хэрэг үйлдсэний учир шүүхийн хүчин төгөлдөр тогтоолоор ялын дээд хэмжээ оногдуулснаас бусад тохиолдолд хүний амь нас бусниулахыг хатуу хориглоно;

2/ эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй;

3/ хөдлөх, үл хөдлөх хөрөнгө шударгаар олж авах, эзэмших, өмчлөх, өв залгамжлуулах эрхтэй. Хувийн өмчийг хууль бусаар хураах, дайчлан авахыг хориглоно. Төр, түүний эрх бүхий байгууллага нь нийгм, ил зайлшгүй хэрэгцээг үндэслэн хувийн өмчийн эд хөрөнгийг дайчлан авбал нөхөх олговор, үнийг төлнө;

4/ ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, цалин хөлс авах, амрах, хувийн аж ахуй эрхлэх эрхтэй. Хэнийг ч хууль бусаар албадан хөдөлмөрлүүлж болохгүй;

²¹ Энэ зүйлд "1.Монгол Улсад хууль ёсоор оршин суугаа хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байна.

2.Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна." гэж заажээ.

ЗҮЙЛИЙГ²² Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02 /1993.03.13., ТМ 1993 он №02), (Тогтоол №01/1994.02.04., ТМ 1994 он №04), (Дүгнэлт №02/1994.01.12., ТМ 1994 он №03), (Дүгнэлт №07/1994.07.25., ТМ 1994 он №09), (Дүгнэлт №08/1994.08.29., ТМ 1994 он №10), (Тогтоол №01/1996.05.15., ТМ 1996 он №08), (Тогтоол №02/1996.06.19., ТМ 1996 он №10), (Дүгнэлт №02/1997.04.09., ТМ 1997 он №09), (Тогтоол №01/1998.06.17., ТМ 1998 он №07), (Дүгнэлт №02/1998.02.24.,

²² 5/ өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй;

6/ эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй. Иргэдэд эмнэлгийн төлбөргүй тусламж үзүүлэх болзол, журмыг хуулиар тогтооно;

7/ сурч боловсрох эрхтэй. Төрөөс бүх нийтийн ерэнхий боловсролыг төлбөргүй олгоно. Иргэд төрөөс тавих шаардлагад нийцсэн хувийн сургууль байгуулан ажиллуулж болно;

8/ соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах, бүтээл туурвих, үр шимийг нь хүртэх эрхтэй. Зохиогч, шинэ бүтээл, нээлтийн эрхийг хуулиар хамгаална;

9/ шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ. Сонгогдох насыг төрийн зохих байгууллага, албан тушаалд тавих шаардлагыг харгалзан хуулиар тогтооно;

10/ нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно;

11/ улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх няхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална;

12/ төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй;

13/ халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. Хэнд боловч эрүү шүүлт тулгаж, хүнлэг бус, хэрцгий хандаж, нэр төрийг нь доромжилж болохгүй. Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. Иргэний хувийн ба гэр бүл, захидал харилцааны нууц, орон байрны халдашгүй байдлыг хуулиар хамгаална;

ТМ 1998 он №05), (Тогтоол №01/2002.06.05., ТМ 2002 он №23), (Тогтоол №02/2002.06.06., ТМ 2002 он №15), (Тогтоол №02/2003.06.20., ТМ 2003 он №27), (Дүгнэлт №03/2003.10.29., ТМ 2003 он №43), (Тогтоол №01/2005.11.14., ТМ 2005 он №45), (Тогтоол №01/2006.01.11., ТМ 2006 он №06), (Дүгнэлт №09/2005.12.07., ТМ 2005 он №47), (Тогтоол №02/2006.06.15., ТМ 2006 он №25), (Дүгнэлт №07/2006.06.21., ТМ 2006 он №26), (Дүгнэлт №06/2008.05.14., ТМ 2008 он №19), (Тогтоол №03/2008.11.19., ТМ 2008 он №43), (Дүгнэлт №08/2008.10.29., ТМ 2008 он №41), (Тогтоол №01/2010.01.22., ТМ 2010 он №06), (Тогтоол №01/2011.01.05., ТМ 2011 он №04), (Тогтоол №01/2012.02.08., ТМ 2012 он №08), (Тогтоол №03/2012.05.02., ТМ 2012 он №18), (Тогтоол №01/2013.11.27., ТМ 2013 он №47), (Дүгнэлт №01/2014.01.15., ТМ 2014 он №04), (Дүгнэлт №03/2014.03.12., ТМ 2014 он №12), (Тогтоол №02/2014.12.12., ТМ 2014 он №47), (Тогтоол №02/2015.02.11., ТМ 2015 он №07), (Дүгнэлт №01/2015.01.28., ТМ 2015 он №05), (Тогтоол №04/2015.06.17., ТМ 2015 он №24), (Тогтоол №06/2015.10.28., ТМ 2015 он №41), (Тогтоол №11/2015.12.09., ТМ 2015 он №47), (Тогтоол №02/2016.03.16., ТМ 2016 он №12), (Дүгнэлт №16/2015.12.23., ТМ 2016 он №01), (Тогтоол №04/2016.06.17., ТМ 2016 он №24), (Дүгнэлт №04/2016.03.02., ТМ 2016 он №10) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн АРВАН ДОЛДУГААР ЗҮЙЛИЙГ²³ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол

²³ 14/ Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх, өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, хэргээ шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй. Өөрөө өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхийг шаардах, мэдүүлэг гаргуулахаар шахалт үзүүлэх, хүч хэрэглэхийг хориглоно. Гэм буруутай нь хуулийн дагуу шүүхээр нотлогдох хүртэл хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцож үл болно. Гэм буруутны ял зэмлэлийг түүний гэр бүлийн гишүүд, төрөл саданд нь халдаан хэрэглэхийг хориглоно;

15/ шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөөтэй;

16/ итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно;

№02/1993.03.13., ТМ 1993 он №02), (Дүгнэлт №11/2006.12.13., ТМ 2006 он №48) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн АРВАН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ²⁴ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №03/2006.03.29., ТМ 2006 он №15), (Дүгнэлт №01/2010.03.24., ТМ 2010 он №13), (Тогтоол №02/2014.12.12., ТМ 2014 он №47), (Тогтоол №02/2016.03.16., ТМ 2016 он №12) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ХОРЬДУГААР ЗҮЙЛИЙГ²⁵ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №01/1993.02.12.), (Тогтоол №04/2006.10.11.), (Дүгнэлт №03/2007.03.02., ТМ 2007 он №14), (Дүгнэлт №06/2007.05.23., ТМ 2007 он №21) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ХОРИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ²⁶ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/1996.06.19., ТМ 1996 он №10), (Дүгнэлт №06/2008.05.14., ТМ 2008 он №19), (Тогтоол №03/2012.05.02., ТМ 2012 он №18), (Дүгнэлт №05/2016.04.22., ТМ 2016 он №16) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон

үзнэ үү.

Энэхуулийн ХОРИНГУРАВДУГААР ЗҮЙЛИЙГ²⁷ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №07/2006.06.21., ТМ 2006 он №26), (Тогтоол №02/2007.06.22.), (Тогтоол №02/2008.05.07., ТМ 2008 он №18) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ХОРИН ТАВДУГААР ЗҮЙЛИЙГ²⁸ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/1993.03.13., ТМ 1993 он №02), (Дүгнэлт №01/2001.03.23., ТМ 2001 он №14), (Тогтоол №04/2006.10.11.), (Дүгнэлт

²⁷ Энэ зүйлд "1.Улсын Их Хурлын гишүүн бол ард түмний элч мөн бөгөөд нийт иргэн, улсын ашиг сонирхлыг эрхэмлэн баримтална.

2.Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрх нь Төрийн сүлдэндээ тангараг өргөснөөр эхэлж, Улсын Их Хурлын дараагийн сонгуулиар шинэ сонгогдсон гишүүд тангараг өргөснөөр дуусгавар болно." гэж заажээ.

²⁸ Энэ зүйлд "1.Улсын Их Хурал төрийн дотоод, гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэж болох бөгөөд дараахь асуудлыг өөрийн онцгой бүрэн эрхэд хадгалж шийдвэрлэнэ:

1/ хууль батлах, нэмэлт, өөрчлөлт оруулах;

2/ төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлох;

3/ Ерөнхийлөгчийн ба Улсын Их Хурал, түүний гишүүний сонгуулийг товлон зарлах;

4/ Улсын Их Хурлын Байнгын хороо, Засгийн газар, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүтэц, бүрэлдэхүүнийг тогтоох, өөрчлөх;

5/ Ерөнхийлөгчийг сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргах, чөлөөлөх, огцруулах;

6/ Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, хуульд зааснаар Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг бусад байгууллагын бүрэлдэхүүнийг томилох, өөрчлөх, огцруулах;

7/ төрийн санхүү, зээл, албан татвар, мөнгөний бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэлийг тодорхойлж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, улсын төсөв, түүний гүйцэтгэлийн тайланг батлах;

8/ хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн биелэлтийг хянан шалгах;

9/ улсын хил тогтоох;

10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, бүрэн эрхийг тогтоох;

11/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хуваарийг батлах, өөрчлөх;

12/ нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг тогтоох;

13/ улсын цол, одон, медаль, цэргийн дээд цол бий болгох, төрийн албаны зарим тусгай салбарын албан тушаалын зэрэг дэвийг тогтоох;

²⁴ Энэ зүйлд "1.Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.

2.Онц болон дайны байдал зарласан тохиолдолд Үндсэн хууль, бусад хуульд заасан хүний эрх, эрх чөлөөг гагцхүү хуулиар хязгаарлаж болно. Тийнхүү хязгаарласан хууль нь хүний амьд явах эрх, итгэл үнэмшилтэй байх, шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, түүнчлэн хэнд боловч эрүү шүүлт тулгах, хүнлэг бус, хэрцгий хандахыг хориглосон хуулийн заалтыг үл хөндөнө.

3.Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй." гэж заажээ.

²⁵ Энэ зүйлд "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална." гэж заажээ.

²⁶ Энэ зүйлд "1.Улсын Их Хурал нэг танхимтай, далан зургаан гишүүнтэй байна.

2.Улсын Их Хурлын гишүүнийг Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, чөлөөтэй, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж, дөрвөн жилийн хугацаагаар сонгоно.

3.Улсын Их Хурлын гишүүнээр Монгол Улсын хорин таван нас хүрсэн, сонгуулийн эрх бүхий иргэнийг сонгоно.

4.Улсын Их Хурлын сонгуулийн журмыг хуулиар тогтооно." гэж заажээ.

№03/2007.03.02., ТМ 2007 он №14), (Дүгнэлт №06/2007.05.23., ТМ 2007 он №21), (Тогтоол №03/2007.12.12., ТМ 2007 он №46) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэхуулийн ХОРИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛИЙГ²⁹ Үндсэн хуулийн цэцийн (МУҮХЦТ№04/2016.06.17., ТМ 2016 он №24) тогтоолтой холбон үзнэ үү.

²⁹ 14/ өршөөл үзүүлэх шийдвэр гаргах;

15/ Засгийн газрын өргөн мэдүүлснээр Монгол Улсын олон улсын гэрээг соёрхон батлах, цуцлах, гадаад улстай дипломат харилцаа тогтоох, цуцлах;

16/ ард нийтийн санал асуулга явуулах. Сонгуулийн эрх бүхий иргэдийн олонхи нь оролцсон ард нийтийн санал асуулгыг хүчинтэйд тооцож, олонхийн санал авсан асуудлыг шийдвэрлэгдсэн гэж үзнэ;

17/ Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалд бусад улсаас аюул занал учруулж, зэвсэглэн халдвал дайн бүхий байдал зарлах, цуцлах;

18/ энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөлд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, эсхүл энэ тухай гаргасан Ерөнхийлөгчийн зарлигийг батлах, хүчингүй болгох.

2.Дараахь онцгой нөхцөл бий болсон үед үр дагаврыг нь арилгах, хүн ам, нийгмийн амьдралыг хэвийн болгохын тулд онц байдал зарлаж болно:

1/ улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь оршин суугаа хүн амын амь нас, эрүүл мэнд, аж амьдрал, нийтийн аюулгүй байдалд шууд аюул учруулсан буюу учруулахуйц байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул тохиолдсон;

2/ Үндсэн хуулийн дэг журам, нийгмийн хууль ёсны тогтолцоо оршин тогтноход заналхийлсэн аливаа байгууллага, бүлэг хүний зохион байгуулалт бүхий хүч хэрэглэсэн хууль бус үйл ажиллагааны улмаас үүссэн нийтийн эмх замбараагүй байдлыг төрийн байгууллага эрх хэмжээнийхээ дотор ердийн арга хэрэгслээр тохионуулах боломжгүй болсон.

3.Улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь нийтийн эмх замбараагүй байдал үүсч, зэвсэгт мөргөлдөөнд хүрсэн, тийм мөргөлдөөн гарах бодит аюул бий болсон, бусад улсаас цэргийн хүчээр түрэмгийлэн халдсан, эсхүл тийнхүү халдах нь бодитой болсон үед дайны байдал зарлаж болно.

4.Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно." гэж заажээ.

²⁹ Энэ зүйлд "1.Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газар хууль санаачлах эрх эдэлнэ.

2.Иргэд, бусад байгууллага хуулийн төслийн тухай саналаа хууль санаачлагчид уламжилна.

3.Монгол Улсын хуулийг Улсын Их Хурал албан ёсоор нийтлэх бөгөөд хэрэв хуульд өөрөөр заагаагүй бол ийнхүү нийтэлснээс хойш арав хоногийн дараа хүчин төгөлдөр болно." гэж заажээ.

Энэ хуулийн ХОРИН ДОЛДУГААР ЗҮЙЛИЙГ³⁰ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №03/1997.12.17., ТМ 1998 он №01), (Тогтоол №03/2009.06.10., ТМ 2009 он №32) зэрэг тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ХОРИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ³¹ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №03/1994.01.12., ТМ 1994 он №04), (Дүгнэлт №06/1994.06.15., ТМ 1994 он №07), (Дүгнэлт №01/1995.01.04., ТМ 1995 он №02), (Тогтоол №03/1996.09.07.), (Тогтоол №03/1997.12.17., ТМ 1998 он №01), (Тогтоол №02/1998.11.24., ТМ 1998 он №12), (Дүгнэлт №07/2006.06.21., ТМ 2006 он №26), (Дүгнэлт №03/2008.02.27., ТМ 2008 он №12), (Тогтоол №03/2009.06.10., ТМ 2009 он №32), (Тогтоол №02/2012.02.15., ТМ 2012 он №09) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

³⁰ Энэ зүйлд "1.Улсын Их Хурал бүрэн эрхээ чуулган, зохион байгуулалтын бусад хэлбэрээр хэрэгжүүлнэ.

2.Улсын Их Хурлын ээлжит чуулган хагас жил тутам нэг удаа тавиас доошгүй ажлын өдөр чуулна.

3.Улсын Их Хурлын гишүүдийн гуравны нэгээс дээшхийн шаардсанаар, эсхүл Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын даргын санаачилгаар ээлжит бус чуулган чуулж болно.

4.Улсын Их Хурлын анхдугаар чуулганыг сонгууль явуулсан өдрөөс хойш гуч хоногийн дотор Ерөнхийлөгч, бусад чуулганыг Улсын Их Хурлын дарга товлон зарлана.

5.Ерөнхийлөгч онц болон дайны байдал зарлавал түүнээс хойш далан хоёр цагийн дотор Улсын Их Хурал онцгой чуулганаа тусгайлан товлонхгүйгээр чуулна.

6.Улсын Их Хурлын чуулганы болон Байнгын хорооны хуралдааныг гишүүдийн олонхи нь хүрэлцэн ирснээр хүчинтэйд үзэж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар асуудлыг шийдвэрлэнэ. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнийг томилох тухай асуудал, түүнчлэн хуульд өөрөөр заагаагүй бол бусад асуудлыг саналаа илээр гаргаж шийдвэрлэнэ." гэж заажээ.

³¹ Энэ зүйлд "1.Улсын Их Хурлын гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд улсын төсвөөс цалин авна. Улсын Их Хурлын гишүүн нь Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүнээс бусад, хуулиар тогтоосон үүрэгт нь үл хамаарах ажил, албан тушаал хавсарч болохгүй.

2.Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлыг хуулиар хамгаална.

3.Улсын Их Хурлын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ. Уул гишүүн гэмт хэрэг үйлдсэн гэж шүүх тогтоовол Улсын Их Хурал түүнийг гишүүнээс нь эгүүлэн татна." гэж заажээ.

Энэ хуулийн ГУЧИН ГУРАВДУГААР ЗҮЙЛИЙГ³² Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/1995.09.07., ТМ 1995 он №10–11), (Дүгнэлт №07/2005.09.30., ТМ 2005 он №37), (Тогтоол №03/2015.05.29., ТМ 2015 он №21), (Тогтоол №04/2016.06.17., ТМ 2016 он №24) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ГУЧИН ТАВДУГААР ЗҮЙЛИЙГ³³ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/1995.09.07., ТМ 1995 он

³² Энэ зүйлд "1.Ерөнхийлөгч дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Улсын Их Хурлын баталсан хууль, бусад шийдвэрт бүхэлд нь буюу зарим хэсэгт нь хориг тавих. Ерөнхийлөгчийн тавьсан хоригийг Улсын Их Хурлаар хэлэлцэж, чуулганд оролцсон нийт гишүүний гуравны хоёр нь хүлээж аваагүй бол уг хууль, шийдвэр хүчин төгөлдөр хэвээр үлдэнэ;

2/ Улсын Их Хуралд олонхи суудал авсан нам, эвслээс нэр дэвшүүлсэн хүнийг; аль ч нам, эвсэл олонхийн суудал аваагүй бол хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвслтэй зөвшилцөн нэр дэвшүүлсэн хүнийг; хэрэв хамгийн олон суудал авсан нам, эвсэл бусад нам, эвслтэй зөвшилцөж Ерөнхий сайдад нэр дэвшүүлж чадаагүй бол Улсын Их Хуралд суудал авсан нам, эвсэл зөвшилцөн олонхиороо нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг тав хоногийн дотор Улсын Их Хуралд оруулах;

3/ өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх. Энэ талаар Ерөнхийлөгч зарлиг гаргавал түүнд Ерөнхий сайд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно;

4/ гадаад харилцаанд улсаа бүрэн эрхтэй төлөөлж, Улсын Их Хуралтай зөвшилцөн Монгол Улсын нэрийн өмнөөс олон улсын гэрээ байгуулах;

5/ Монгол Улсаас гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг Улсын Их Хуралтай зөвшилцөн томилох буюу эгүүлэн татах;

6/ Монгол Улсад суух гадаад улсын бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг итгэмжлэх, эгүүлэн татах жуух бичгийг хүлээн авах;

7/ улсын цол, цэргийн дээд цол хүртээх, одон, медалиар шагнах;

8/ уучлал үзүүлэх;

9/ Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, тус улсад орогнох эрх олгох асуудлыг шийдвэрлэх;

10/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг тэргүүлэх;

11/ бүх нийтийн буюу хэсэгчилсэн цэргийн дайчилгаа зарлах;

12/ Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан онцгой нөхцөл бий болбол Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт, хойшлуулшгүй тохиолдолд улсын нийт нутаг дэвсгэрт буюу зарим хэсэгт нь онц болон дайны байдал зарлах, түүнчлэн цэрэг хөдөлгөөн захираж өгөх. Онц байдал, дайны байдал зарласан Ерөнхийлөгчийн зарлигийг Улсын Их Хурал уул зарлиг гарснаас хойш долоо хоногийн дотор хэлэлцэж батлах буюу хүчингүй болгоно. Хэрэв Улсын Их Хурал шийдвэр гаргаагүй бол уул зарлиг хүчингүй болно.

2.Ерөнхийлөгч Монгол Улсын эвсэлт хүчний ерөнхий командлагч байна.

3.Ерөнхийлөгч Улсын Их Хуралд болон ард түмэндээ хандан илгээлт гаргаж, чуулганд өөрийн тааллаар оролцон улс орны дотоод, гадаад байдлын нэн чухал асуудлаар мэдээлж, саналаа оруулж болно.

4.Ерөнхийлөгчид тодорхой бүрэн эрхийг зөвхөн хуулиар олгож болно." гэж заажээ.

³³ Энэ зүйлд "1.Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна.

2.Ерөнхийлөгч тангаргаасаа няцаж Үндсэн хууль, Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг зөрчвөл Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг үндэслэн Улсын Их Хурлаар хэлэлцэж чуулганд оролцсон нийт гишүүний дийлэнх олонхийн саналаар огцруулна." гэж заажээ.

№10–11) тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ГУЧИН НАЙМДУГААР ЗҮЙЛИЙГ³⁴ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №02/2005.03.31., ТМ 2005 он №14), (Тогтоол №01/2007.03.07., ТМ 2007 он №13), (Тогтоол №02/2007.06.22.) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ГУЧИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ³⁵ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №09/2015.11.25., ТМ 2015 он №45) тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ДӨЧИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ³⁶ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №09/2015.11.25., ТМ 2015 он №45) тогтоолтой холбон үзнэ үү.

³⁴ Энэ зүйлд "1.Монгол Улсын Засгийн газар бол төрийн гүйцэтгэх дээд байгууллага мөн.

2.Засгийн газар төрийн хуулийг биелүүлж, аж ахуй, нийгэм, соёлын байгуулалтыг удирдах нийтлэг чиг үүргийн дагуу дараахь үндсэн бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах;

2/ шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх;

3/ салбарын ба салбар хоорондын, түүнчлэн бүс нутгийн хөгжлийн асуудлаар арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх;

4/ хүрээлэн байгаа орчныг хамгаалах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;

5/ төрийн захиргааны төв байгууллагыг шуурхай удирдан, нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааг удирдан чиглүүлэх;

6/ улсыг батлан хамгаалах хүчин чадлыг бэхжүүлж, үндэсний аюулгүй байдлыг хангах;

7/ хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

8/ төрийн гадаад бодлого хэрэгжүүлэх;

9/ Улсын Их Хуралтай зөвшилцөж дараа соёрхон батлуулахаар Монгол Улсын олон улсын гэрээ байгуулах, хэрэгжүүлэх, түүнчлэн Засгийн газар хоорондын гэрээ байгуулах, цуцлах.

3.Засгийн газрын тодорхой бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно." гэж заажээ.

³⁵ Энэ зүйлд "1.Засгийн газар Ерөнхий сайд, гишүүдээс бүрдэнэ.

2.Монгол Улсын Ерөнхий сайд Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн, түүнд өөрчлөлт оруулах саналаа Ерөнхийлөгчтэй зөвшилцөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ. Ерөнхий сайд уул асуудлыг Ерөнхийлөгчтэй долоо хоногийн дотор зөвшилцөж чадаагүй бол Улсын Их Хуралд өөрөө өргөн мэдүүлнэ.

3.Засгийн газрын гишүүдийг Ерөнхий сайдын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал хүн бүрээр хэлэлцэж томилоно." гэж заажээ.

³⁶ Энэ зүйлд "1.Ерөнхий сайд Засгийн газрыг удирдаж, төрийн хууль биелүүлэх ажлыг Улсын Их Хурлын өмнө хариуцна.

2.Засгийн газар үйл ажиллагаагаа Улсын Их Хуралд тайлагнана." гэж заажээ.

Энэ хуулийн ДӨЧИН ТАВДУГААР ЗҮЙЛИЙГ³⁷ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №04/1998.04.27., ТМ 1998 он №05), (Дүгнэлт №02/2005.03.31., ТМ 2005 он №14), (Тогтоол №01/2007.03.07., ТМ 2007 он №13), (Дүгнэлт №04/2010.07.07., ТМ 2010 он №36) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ДӨЧИН ДОЛДУГААР ЗҮЙЛИЙГ³⁸ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №03/1993.05.26., ТМ 1993 он №03), (Дүгнэлт №08/1994.08.29., ТМ 1994 он №10), (Тогтоол №02/2006.06.15., ТМ 2006 он №25), (Тогтоол №01/2011.01.05., ТМ 2011 он №04), (Дүгнэлт №06/2013.12.18., ТМ 2014 он №01), (Тогтоол №08/2015.11.04., ТМ 2015 он №42) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ДӨЧИН НАЙМДУГААР ЗҮЙЛИЙГ³⁹ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/1994.11.09., ТМ 1994 он №11), (Дүгнэлт №03/2014.03.12., ТМ 2014 он №12), (Тогтоол №01/2015.01.30., ТМ 2015 он №06), (Тогтоол №04/2015.06.17., ТМ 2015 он №24), (Тогтоол №01/2016.01.28., ТМ 2016 он №06) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

³⁷ Энэ зүйлд "1.Засгийн газар хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ дотор тогтоол, захирамж гаргах бөгөөд төлөд Ерөнхий сайд, тухайн шийдвэрийн биелэлтийг хариуцсан сайд гарын үсэг зурна.

2.Засгийн газрын тогтоол, захирамж нь хууль тогтоомжид нийцээгүй бол Засгийн газар өөрөө буюу Улсын Их Хурал хүчингүй болгоно." гэж заажээ.

³⁸ Энэ зүйлд "1.Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ.

2.Ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно.

3.Шүүхийг зөвхөн Үндсэн хууль, бусад хуулийн дагуу байгуулна." гэж заажээ.

³⁹ Энэ зүйлд 1.Шүүхийн үндсэн тогтолцоо Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүх, сум буюу сум дундын, дүүргийн шүүхээс бүрдэх бөгөөд эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан байгуулж болно. Дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болно.

2.Шүүхийн зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

3. Шүүх улсын төсвөөс санхүүжинэ. Шүүх үйл ажиллагаагаа явуулах эдийн засгийн баталгааг төр хангана." гэж заажээ.

Энэ хуулийн ДӨЧИН ЕСДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ⁴⁰ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №01/1994.01.07., ТМ 1994 он №02), (Тогтоол №01/1994.02.04., ТМ 1994 он №04), (Дүгнэлт №02/2000.03.13., ТМ 2000 он №18), (Тогтоол №01/2002.06.05., ТМ 2002 он №23), (Тогтоол №01/2003.02.19., ТМ 2003 он №10), (Тогтоол №02/2010.06.09., ТМ 2010 он №27), (Тогтоол №01/2014.01.08., ТМ 2014 он №03), (Дүгнэлт №05/2015.04.29., ТМ 2015 он №18), (Тогтоол №05/2016.11.16., ТМ 2016 он №24) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ТАВЬДУГААР ЗҮЙЛИЙГ⁴¹ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №01/1995.01.04., ТМ 1995 он №02), (Дүгнэлт №03/2014.03.12., ТМ 2014 он №12), (Тогтоол №07/2015.10.30., ТМ 2015 он №42), (Тогтоол №04/2015.06.17., ТМ 2015 он №24), (Тогтоол №05/2015.06.24., ТМ 2015 он №25), (Дүгнэлт №16/2015.12.23., ТМ 2016 он №01), (Тогтоол №04/2016.06.17., ТМ 2016 он

⁴⁰ Энэ зүйлд "1.Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.

2.Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын ба Засгийн газрын гишүүн, төр, нам, олон нийтийн бусад байгууллагын албан тушаалтан, иргэн хэн боловч шүүгчээс шүүн таслах үүргээ хэрэгжүүлэхэд хөндлөнгөөс оролцож болохгүй.

3.Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангах зорилгоор Шүүхийн ерөнхий зөвлөл ажиллана.

4.Шүүхийн ерөнхий зөвлөл шүүх, шүүгчийн шүүн таслах ажиллагаанд оролцохгүйгээр, гагцхүү хуульчдаас шүүгчийг шилж олох, эрх ашгийг нь хамгаалах зэрэг шүүхийг бие даан ажиллах нөхцөлөөр хангахтай холбогдсон үүргийг биелүүлнэ.

5.Шүүхийн ерөнхий зөвлөлийн зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно." гэж заажээ.

⁴¹ Энэ зүйлд "1.Монгол Улсын дээд шүүх бол шүүхийн дээд байгууллага мөн бөгөөд дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ хуулийн харьяалуусан эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг анхан шатны журмаар хянан шийдвэрлэх;

2/ давж заалдах болон хяналтын журмаар доод шатны шүүхийн шийдвэрийг хянан үзэх;

3/ хууль, түүнд заасан хүний эрх, эрх чөлөөг хамгаалах талаар Үндсэн хуулийн цэц, Улсын ерөнхий прокуророос шилжүүлсэн асуудлыг хянан шийдвэрлэх;

4/ Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах;

5/ хуулиар эрх олгосон бусад асуудлыг шийдвэрлэх.

2. Улсын дээд шүүхийн шийдвэр шүүхийн эцсийн шийдвэр байх бөгөөд түүнийг бүх шүүх, бусад этгээд заавал биелүүлнэ. Хэрэв Улсын дээд шүүхийн шийдвэр хуульд харшилбал түүнийг Улсын дээд шүүх өөрөө хүчингүй болгоно. Улсын дээд шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлнэ.

3.Улсын дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй." гэж заажээ.

№24) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ТАВИН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ⁴² Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №02/2000.03.13., ТМ 2000 он №18), (Тогтоол №01/2000.09.08., ТМ 2000 он №37), (Тогтоол №02/2011.01.07., ТМ 2011 он №05), (Тогтоол №02/2015.02.11., ТМ 2015 он №07), (Тогтоол №07/2015.10.30., ТМ 2015 он №42), (Дүгнэлт №05/2015.04.29., ТМ 2015 он №18), (Тогтоол №06/2015.10.28., ТМ 2015 он №41), (Дүгнэлт №12/2016.12.02.) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ТАВИН ХОЁРДУГААР ЗҮЙЛИЙГ⁴³ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №01/1995.01.04., ТМ 1995 он №02), (Дүгнэлт №01/2004.04.21., ТМ 2004 он №17), (Тогтоол №05/2016.11.16., ТМ 2016 он №24) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ТАВИН ТАВДУГААР ЗҮЙЛИЙГ⁴⁴ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №03/2008.11.09., ТМ 2008 он №43) тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ТАВИН ЗУРГАДУГААР ЗҮЙЛИЙГ⁴⁵ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №07/1994.07.25., ТМ 1994 он №09), (Тогтоол №02/2003.06.20., ТМ 2003 он №27) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ТАВИН ДОЛДУГААР ЗҮЙЛИЙГ⁴⁶ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №01/1993.01.13., ТМ 1993 он №02) тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ТАВИН НАЙМДУГААР ЗҮЙЛИЙГ⁴⁷ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/2007.06.22.) тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ЖАРДУГААР ЗҮЙЛИЙГ⁴⁸ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №01/1997.03.26., ТМ 1997 он №08), (Тогтоол №02/1997.03.29., ТМ 1997 он №09), (Дүгнэлт №01/2009.03.04., ТМ 2009 он №09) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

⁴² Энэ зүйлд "1.Улсын дээд шүүх Ерөнхий шүүгч, шүүгчдээс бүрдэнэ.

2.Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар, бусад шүүхийн шүүгчдийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн санал болгосноор тус тус Ерөнхийлөгч томилно. Ерөнхий шүүгчийг Улсын дээд шүүхийн санал болгосноор гишүүдийнх нь дотроос зургаан жилийн хугацаагаар Ерөнхийлөгч томилно.

3.Хууль зүйн дээд боловсролтой, мэргэжлээрээ арваас доошгүй жил ажилласан, Монгол Улсын гучин таван нас хүрсэн иргэнийг Улсын дээд шүүхийн шүүгчээр; хууль зүйн дээд боловсролтой, гурваас доошгүй жил мэргэжлээрээ ажилласан, Монгол Улсын хорин таван нас хүрсэн иргэнийг бусад шүүхийн шүүгчээр томилж болно.

4.Үндсэн хууль, шүүхийн тухай хуульд заасан үндэслэл, шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийн дагуу огцруулах, эсхүл хүсэлтээр нь чөлөөлөхөөс бусад тохиолдолд аль ч шатны шүүхийн шүүгчийг огцруулахыг хориглоно." гэж заажээ.

⁴³ Энэ зүйлд "1.Бүх шатны шүүх хэрэг, маргааныг хамтын зарчмаар хянан хэлэлцэж шийдвэрлэнэ.

2.Анхан шатны шүүх хэрэг, маргааныг хамтран шийдвэрлэхдээ иргэдийн төлөөлөгчдийг хуульд заасан журмын дагуу оролцуулна.

3.Хуульд тусгайлан үзлчилж заасан зарим хэргийг шүүгч дангаар хянан шийдвэрлэж болно." гэж заажээ.

⁴⁴ Энэ зүйлд "1.Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй.

2.Шүүгдэгчид энэ эрхээ дэлгэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн тусалцаа үзүүлнэ." гэж заажээ.

⁴⁵ Энэ зүйлд "1.Прокурор хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавьж, шүүх хуралдаанд төрийн нэрийн өмнөөс оролцоно.

2.Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно.

3.Монгол Улсын прокурорын байгууллагын тогтолцоо, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно." гэж заажээ.

⁴⁶ Энэ зүйлд "1.Монгол Улсын нутаг дэвсгэр засаг захиргааны хувьд аймаг, нийслэлд, аймаг нь суманд, сум нь багт, нийслэл нь дүүрэгт, дүүрэг нь хороонд хуваагдана.

2.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх хот, тосгоны эрх зүйн үндсийг хуулиар тогтооно.

3.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийг өөрчлөх асуудлыг эдийн засгийн бүтэц, хүн амын байршлыг харгалзан тухайн нутгийн Хурал, иргэдийн саналыг үндэслэн Улсын Их Хурал шийдвэрлэнэ." гэж заажээ.

⁴⁷ Энэ зүйлд "1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг бол хуулиар тусгайлан олгосон чиг үүрэг, өөрийн удирдлага бүхий засаг захиргаа, нутаг дэвсгэр, эдийн засаг, нийгмийн цогцолбор мөн.

2.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэгийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал батална." гэж заажээ.

⁴⁸ Энэ зүйлд "1.Аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга хэрэгжүүлнэ.

2.Засаг даргыг тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Хурлаас нэр дэвшүүлж, аймаг, нийслэлийн Засаг даргыг Ерөнхий сайд; сум, дүүргийн Засаг даргыг харьяалах аймаг, нийслэлийн Засаг дарга; баг, хорооны Засаг даргыг харьяалах сум, дүүргийн Засаг дарга тус тус дөрвөн жилийн хугацаагаар томилно.

3.Ерөнхий сайд буюу дээд шатны нэгжийн Засаг дарга доод шатныхаа нэгжийн Засаг даргад нэр дэвшигчийг томилохоос татгалзвал энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар дахин нэр дэвшүүлж томилтол өмнөх Засаг дарга бүрэн эрхээ хэвээр хадгална." гэж заажээ.

Энэ хуулийн ЖАРАН ХОЁРДУГААР ЗҮЙЛИЙГ⁴⁹ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/2007.06.22.), (Дүгнэлт №01/2009.03.04., ТМ 2009 он №09), (Тогтоол №01/2009.05.20., ТМ 2009 он №24) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ЖАРАН ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛИЙГ⁵⁰ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №01/1995.01.04., ТМ 1995 он №02), (Тогтоол №02/2010.06.09., ТМ 2010 он №27), (Тогтоол №03/2016.03.23., ТМ 2016 он №13), (Тогтоол №04/2016.06.17., ТМ 2016 он №24) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ЖАРАН ЗУРГАДУГААР ЗҮЙЛИЙГ⁵¹ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/1995.09.07., ТМ 1995 он №10–11), (Тогтоол №01/1995.05.10., ТМ 1995 он №07), (Дүгнэлт №02/2005.03.31., ТМ 2005 он №14) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ЖАРАН НАЙМДУГААР ЗҮЙЛИЙГ⁵² Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/2000.11.29., ТМ 2000 он №46) тогтоолтой холбон үзнэ үү.

Энэ хуулийн ДАЛДУГААР ЗҮЙЛИЙГ⁵³ Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №02/2000.11.29., ТМ 2000 он №46), (Дүгнэлт №01/2001.03.23., ТМ 2001 он №14), (Тогтоол

⁴⁹ Энэ зүйлд "1.Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.

2.Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:

1/ хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

2/ ард нийтийн санал асуулга, Улсын Их Хурал, түүний гишүүний ба Ерөнхийлөгчийн сонгуулийн талаар сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;

3/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Үндсэн хууль зөрчсөн эсэх;

4/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасны дагуу оруулсан дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол Үндсэн хуулийн цэц дахин хянан үзэж эцсийн шийдвэр гаргана.

4.Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно." гэж заажээ.

⁵² Энэ зүйлд "1.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санаачилгыг хууль санаачлах эрх бүхий байгууллага, албан тушаалтан гаргах бөгөөд саналыг Үндсэн хуулийн цэц Улсын Их Хуралд өргөн мэдүүлж болно.

2.Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар Улсын Их Хурлын гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар ард нийтийн санал асуулга явуулж болно. Санал асуулгыг Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 16–д заасан үндэслэлийн дагуу явуулна." гэж заажээ.

⁵³ Энэ зүйлд "1.Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.

2.Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө." гэж заажээ.

⁴⁹ Энэ зүйлд "1.Нутгийн өөрөө удирдах байгууллага тухайн аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны нутаг дэвсгэрийн хэмжээний эдийн засаг, нийгмийн амьдралын асуудлыг бие дааж шийдвэрлэхийн хамт улс, дээд шатны нэгжийн чанартай асуудлыг шийдвэрлэхэд хүн амыг зохион байгуулж оролцуулна.

2.Нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээний асуудлыг дээд шатны байгууллага нь шийдвэрлэж үл болно. Хэрэв нутаг дэвсгэрийн амьдралын тодорхой асуудлыг шийдвэрлэх талаар хууль, төрийн зохих дээд байгууллагын шийдвэрт тухайлан заагаагүй бол нутгийн өөрөө удирдах байгууллага Үндсэн хуульд нийцүүлэн бие даан шийдвэрлэж болно.

3.Улсын Их Хурал, Засгийн газраас шаардлагатай хэмээн үзсэн тохиолдолд өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг шийдвэрлүүлэхээр аймаг, нийслэлийн Хурал, Засаг даргад шилжүүлж болно." гэж заажээ.

⁵⁰ Энэ зүйлд "1.Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.

2.Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.

3.Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана." гэж заажээ.

№03/2002.11.13., ТМ 2002 он №44), (Тогтоол №02/2007.06.22.), (Тогтоол №03/2007.12.12., ТМ 2007 он №46), (Тогтоол №02/2010.06.09., ТМ 2010 он №27), (Дүгнэлт №04/2010.07.07., ТМ 2010 он №36) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзнэ үү.

Харин өмнө тэмдэглэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн зүйлээс бусад (энэ хуулийн Дөрөвдүгээр зүйл, Долдугаар зүйл, Наймдугаар зүйл, Есдүгээр зүйл, Арван нэгдүгээр зүйл, Арван хоёрдугаар зүйл, Арван гуравдугаар зүйл, Хорин хоёрдугаар зүйл, Хорин зургадугаар зүйл, Гучдугаар зүйл, Гучин хоёрдугаар зүйл, Гучин дөрөвдүгээр зүйл, Гучин зургадугаар зүйл, Гучин долдугаар зүйл, Дөчдүгээр зүйл, Дөчин хоёрдугаар зүйл, Дөчин гуравдугаар зүйл, Дөчин дөрөвдүгээр зүйл, Тавин гуравдугаар зүйл, Тавин дөрөвдүгээр зүйл, Жаран нэгдүгээр зүйл, Жаран гуравдугаар зүйл, Жаран долдугаар зүйл) зүйлд “үндсэн хууль зөрчсөн тухай” маргаан гараагүй болно.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуулийн ЗУРГАДУГААР ЗҮЙЛИЙГ⁵⁴ Үндсэн хуулийн цэцийн (Дүгнэлт №02/1993.04.21.), (Тогтоол №03/1993.05.26., ТМ 1993 он №03), (Дүгнэлт №01/1996.03.27., ТМ 1996 он №05), (Дүгнэлт №03/2005.04.13.), (Тогтоол №02/2009.05.27., ТМ 2009 он №30) зэрэг дүгнэлт, тогтоолтой холбон үзэж болох юм. Энэ хавсралт хуулийн Зургадугаар зүйлээс бусад зүйлд хамаарах Үндсэн хуулийн цэцийн

шийдвэр алга байна.

Судалгааны тухайд цөөн үгээр илэрхийлбэл, Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлд “17” удаа, Гуравдугаар зүйлд “2” удаа, Тавдугаар зүйлд “1” удаа, Аравдугаар зүйлд “7” удаа, Арван дөрөвдүгээр зүйлд “16” удаа, Арван зургадугаар зүйлд “40” удаа, Арван долдугаар зүйлд “2” удаа, Арван есдүгээр зүйлд “5” удаа, Хорьдугаар зүйлд “4” удаа, Хорин нэгдүгээр зүйлд “4” удаа, Хорин гуравдугаар зүйлд “3” удаа, Хорин тавдугаар зүйлд “6” удаа, Хорин зургадугаар зүйлд “1” удаа, Хорин долдугаар зүйлд “2” удаа, Хорин есдүгээр зүйлд “10” удаа, Гучин гуравдугаар зүйлд “5” удаа, Гучин тавдугаар зүйлд “1” удаа, Гучин наймдугаар зүйлд “3” удаа, Гучин есдүгээр зүйлд “1” удаа, Дөчин нэгдүгээр зүйлд “1” удаа, Дөчин тавдугаар зүйлд “4” удаа, Дөчин долдугаар зүйлд “6” удаа, Дөчин наймдугаар зүйлд “5” удаа, Дөчин есдүгээр зүйлд “9” удаа, Тавьдугаар зүйлд “7” удаа, Тавин нэгдүгээр зүйлд “8” удаа, Тавин хоёрдугаар зүйлд “3” удаа, Тавин тавдугаар зүйлд “1” удаа, Тавин зургадугаар зүйлд “2” удаа, Тавин долдугаар зүйлд “1” удаа, Тавин наймдугаар зүйлд “1” удаа, Жардугаар зүйлд “3” удаа, Жаран хоёрдугаар зүйлд “3” удаа, Жаран дөрөвдүгээр зүйлд “4” удаа, Жаран зургадугаар зүйлд “3” удаа, Жаран наймдугаар зүйлд “1” удаа, Далдугаар зүйлд “7” удаа, Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хуулийн Зургадугаар зүйлд “5” удаа, Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд “2” удаа “Үндсэн хууль зөрчсөн тухай” Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоол гарсныг ийнхүү тоо баримт болгон тэмдэглэлээ.

Үүнээс гадна Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг маргааны зүйлээр нь “Татеарын ерөнхий хуульд /4 удаа/, Хүн амын орлогын албан татварын хуульд /3 удаа/, Улсын Их Хурлын сонгуулийн хуульд /15 удаа/, Шүүхийн тухай хуульд /8 удаа/, Төр, сүм хийдийн

⁵⁴ Энэ зүйлд “1.Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл даган мөрдөж ирсэн бөгөөд мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй БНМАУ –ын олон улсын гэрээг Монгол улс цаашид нэгэн адил дагаж мөрдөнө.

2.Монгол Улсын Үндсэн хуульд харшлаагүй БНМАУ–ын олон улсын гэрээ бусад хуулийн заалттай зөрчилдсөн тохиолдолд мөнхүү олон улсын гэрээний заалтыг баримтална.

3.БНМАУ–ын олон улсын гэрээ буюу түүний заалтууд Монгол Улсын Үндсэн хуульд харшилбал тэдгээрийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэх асуудлыг олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, тухайн гэрээнд заасан болзол, журмын дагуу 1993 онд багтаан шийдвэрлэнэ.” гэж заажээ.

харилцааны тухай хуульд /1 удаа/, Шүүх байгуулах тухай хуульд /5 удаа/, Прокурорын байгууллагын тухай хуульд /6 удаа/, Улсын Их Хурлын тухай хуульд /19 удаа/, Үндсэн хуулийн цэцийн тухай хуульд /2 удаа/, Иргэний хуульд /9 удаа/, Хөдөлмөрийн хамтын маргаан зохицуулах тухай хуульд /2 удаа/, Цагдаагийн байгууллагын тухай хуульд /4 удаа/, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд /2 удаа/, Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуульд /1 удаа/, Засгийн газрын тухай хуульд /1 удаа/, Өршөөл үзүүлэх тухай хуульд /1 удаа/, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд /5 удаа/, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд /2 удаа/, Хөдөлмөрийн тухай хуульд /1 удаа/, Банкны тухай хуульд /4 удаа/, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд /14 удаа/, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд /11 удаа/, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуульд /1 удаа/, Өмгөөллийн тухай хуульд /1 удаа/, Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуульд /2 удаа/, Гүйцэтгэх ажлын тухай хуульд /1 удаа/, Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд /2 удаа/, Захиргааны хариуцлагын тухай хуульд /4 удаа/, Захиргааны журмаар албадан хөдөлмөр хийлгэх тухай хуульд /1 удаа/, Компанийн тухай хуульд /3 удаа/, Нэгдсэн төсвийн тухай хуульд /1 удаа/, Төсвийн тухай хуульд /4 удаа/, Ашигт малтмалын тухай хуульд /2 удаа/, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд /2 удаа/, Онцгой албан татварын тухай хуульд /4 удаа/, Улс төрийн намын тухай хуульд /3 удаа/, Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмын тухай хуульд /2 удаа/, Даатгалын тухай хуульд /2 удаа/, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд

/1 удаа/, Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татварын тухай хуульд /2 удаа/, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд /5 удаа/, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд /1 удаа/, Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хуульд /1 удаа/, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд /5 удаа/, Эрүүгийн хуульд /2 удаа/, Төрийн албаны тухай хуульд /1 удаа/, Эрүүл мэндийн тухай хуульд /1 удаа/, Цөмийн энергийн тухай хуульд /1 удаа/, Гэр бүлийн тухай хуульд /2 удаа/, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд /1 удаа/, Хуульч сонгон шалгаруулах тухай хуульд /2 удаа/, Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд /1 удаа/, Авлигын эсрэг хуульд /1 удаа/, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд /10 удаа/, Шүүхийн иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдлын тухай хуульд /3 удаа/, Шүүгчийн эрх зүйн байдлын тухай хуульд /3 удаа/, Арбитрын тухай хуульд /1 удаа/, Хувь хүний нууцын тухай хуульд /2 удаа/, Хөрөнгө оруулалтын тухай хуульд /1 удаа/, Онц байдлын тухай хуульд /2 удаа/, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд /1 удаа/, Хүний хөгжил сангийн тухай хуульд /1 удаа/, Ард нийтийн санал асуулгын тухай хуульд /1 удаа/, Шүүхийн захиргааны тухай хуульд /1 удаа/, Татварын зарим хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийг хэрэгжүүлэх тухай хуульд /2 удаа/, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуульд /3 удаа/, Монгол Улсын Их Хурлын тогтоолд /17 удаа/, Ерөнхийлөгчийн зарлигт /2 удаа/, Засгийн газрын тогтоолд /15 удаа/, Сонгуулийн ерөнхий хорооны тогтоолд /4 удаа/, Ерөнхий сайдын захирамжид /2 удаа/, Өмч хувьчлах тухай хуульд /1 удаа/, Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлигт /2 удаа/, Улсын дээд шүүхийн тогтоолд /2 удаа/⁵⁵ гэсэн байдлаар

⁵⁵ Энд тухайлсан үндсэн хуулийн маргаанд хамаарах дүгнэлт, тогтоолыг оруулж тоолсон болно.

төрөлжүүлэн авч үзэж болох юм.

Эдгээр шийдвэрийн үндэслэлд Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Хүүхдийн эрхийн тухай олон улсын конвенц, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пакт, Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц, Аж үйлдвэрийн өмчийг хамгаалах тухай Парисын конвенц, Алагчилахгүй байх тухай (ажил мэргэжил, хөдөлмөр эрхлэлт) олон улсын хөдөлмөрийн байгууллагын 111 дүгээр конвенц, Дэлхийн худалдааны байгууллагын Тариф худалдааны ерөнхий хэлэлцээр, Олон улсын гэрээний эрх зүйн тухай Венийн конвенц зэргийг дурдсан байна. Үүнээс гадна Үндсэн хуулийн цэцийн (Тогтоол №01, 2008.01.24., Тогтоол №03, 2016.03.23., Тогтоол №02, 2017.12.20., Тогтоол №01, 2017.12.06.) шийдвэрүүд нь Монгол Улсын Үндсэн хуулийн зүйл, хэсэг, заалтад хамаарч гараагүй, харин Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хүчингүй болгосон маргааныг агуулгаар нь дахин сэргээсэн эсэхийг хяналтын журмаар хянан шийдвэрлэсэн⁵⁶ тул дээрх тоо баримтад ороогүй байна.

III. Дүгнэлт

Энэ судалгааг хийж гүйцэтгэсний төгсгөлд, үр дүнгийн зарим хэсгийг дүгнэлт хэлбэрээр танилцуулж байна. Энэ нь шүүмжлэл, онолын дүгнэлт, санал биш. Харин Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт, тогтоолтой танилцаад төрсөн хувийн сэдэлтэй сэтгэгдэл төдий зарим зүйлийг онцгойлон тэмдэглэлээ. Аливаа шүүхэд хандахаас гадна хянан шийдвэрлэх ажиллагааны явцад өөрийн шаардлагын үндэслэл, зүйлийг өөрчлөх, хэмжээг ихэсгэх, багасгах болон шаардлагаас бүхэлд нь буюу зарим хэсгээс нь татгалзах эрх диспозитив зарчмын агуулгад багтдаг суурь асуудал юм. Өөрөөр хэлбэл,

энэ зарчмыг нэг талаас эрх зүйн харилцаанд оролцогч талуудын эрх, үүргийн нийлбэрийг бүхэлд нь илтгэх өргөн ойлголт гэж үзэх боловч нөгөө талаас энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өргөдөл, мэдээлэл, гомдол, нэхэмжлэлийн шаардлагын хүрээгээр хязгаарлах гэсэн шууд агуулгатай.

Аливаа шүүх, түүний дотор Үндсэн хуулийн цэц хэрэг, маргаан шийдвэрлэхдээ хэргийн оролцогч (ялангуяа мэдээлэл, өргөдөл, нэхэмжлэгч) нарын гаргасан шаардлагын хүрээнд, эсхүл түүний хүрээнээс хальж шийдвэр гаргаж байх эсэх нь ихээхэн маргаантай, практикт (тухайн шүүх эрх мэдлийн) багагүй зөрчилтэйгээр явагддаг асуудал юм. Шаардлагын хүрээнд шийдвэрлэх, түүний зөрөг сөрөг тал, нийтийн эрх ашгийн болон бусад үндэслэлээр тодорхой хүрээнээс хальж шийдвэрлэхийн дутуу, сул тал гэж аль ч тохиолдолд бий. Диспозитив зарчим нь иргэн, эрүү, захиргааны процесст өөрийн гэсэн ялгаа, онцлогтойгоор хэрэгжих боломжтой боловч үндсэн хуулийн процесст түүнийг хязгаарлах шаардлага бодитоор оршдог. Үндсэн хуулийн шүүхийн хяналтад байдаг хэм хэмжээ тогтоосон аливаа шийдвэр зөвхөн маргагч талуудад биш, бүх нийтэд хамааралтай үйлчилдэг.

Иймд Үндсэн хууль зөрчсөн тухай өргөдөл, мэдээлэл, гомдлын шаардлагыг багасгах, татгалзах явдал нь маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлэх боломжгүй болгож буй өнөөгийн эрх зүйн зохицуулалт болон практик үндсэн хуульт ёсны утга агуулгад үл нийцнэ. Мөн иргэд Үндсэн хуулийн цэцэд хандаж өргөдөл гаргахаас гадна өөрт нь шууд хамааралгүй асуудлаар мэдээлэл гаргадаг, мөн түүнчлэн Үндсэн хуулийн цэц нилээд албан тушаалтныг үндсэн хууль зөрчсөн, тэдгээрийг эгүүлэн татах, огцруулах хуульд заасан үндэслэл байгаа

⁵⁶ Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйл.

эсэхийг шалгаж тогтоох (импичмент) боломжтой байдаг манай нөхцөлд улс төрийн эсхүл хөндлөнгийн бусад нөлөө, шалтгаанаас үүдэн мэдээллийн шаардлагаас татгалзах/татгалзуулах тохиолдол гарахыг үгүйсгэхгүй. Энэхүү танилцуулгад диспозитив зарчмыг чухамхүү энэ утгаар нь илүүтэй хөндөхийг эрмэлзлээ.

Энэ ажиллагаанд өргөдөл, мэдээлэл, хүсэлт гаргасан тал Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “онцгой эрх” эдлэх нь диспозитив зарчмын илрэл. Энэ ажиллагаанд диспозитив зарчим хэрхэн хэрэгжиж ирсэн байдалд

судалгаа (Үндсэн хуулийн маргаан: Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийн лавлах бичиг хэмээх номын Хоёрдугаар бүлгийн эшлэлийг үзнэ үү) хийхийг оролдсоны үндсэн дээр маргагч тал өргөдөл, мэдээлэл, хүсэлтээсээ татгалзаж болох ч энэхүү татгалзал нь Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох үндэслэл болж байгаа нь үндсэн хуульт ёс болон хууль дээдлэх зарчмыг хэрэгжүүлэхэд харшилж байна гэсэн дүгнэлтэд хүрлээ. Энэ нь дагнасан бусад шүүхээс Үндсэн хуулийн цэцийн үндсэн ялгаа зарчмаар нь илэрдэг болохыг зааглан тогтоолгоход чиглэгдсэн нь энэ судалгааны гол үр дүн билээ.

---o0o---

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

Үндсэн үйл ажиллагаа:

Хууль зүйн бодлогын судалгаа
Эрх зүйн албан бус болон захиалгат сургаалт
Эрх зүйн мэдээлэл, суртачилгаа
Эрх зүйн актын лавлагаа, мэдээллийн нэгдсэн сан
Эрдэм шинжилгээний номын сан
Хэвлэх үйлдвэр
“Хууль дээдлэх ёс” сэтгүүл
“Захиргааны хэм хэмжээний актын эмхэтгэл”
“Хууль зүйн мэдээ” цахим сонин
Бусад ном, товхимол



-ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ-

www. **LEGAL** .mn



www.legalinstitute.mn



www.twitter.com/legalinstitute



www.facebook.com/NLIInstitute

ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭНГИЙН ХЭВЛЭХ ҮЙЛДВЭР


ХЭВЛЭХ БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

- * НОМ, ГАРЫН АВЛАГА
- * СОНИН
- * СЭТГҮҮЛ
- * ТАНИЛЦУУЛГА
- * БРОШУР
- * ПЛАКАТ
- * АЛБАН БЛАНК
- * УРИЛГА, МЭНДЧИЛГЭЭ
- * ӨРГӨМЖЛӨЛ, ТАЛАРХАЛ
- * НЭРИЙН ХУУДАС
- * ДУГТУЙ

Үйлдвэрийн тоног төхөөрөмж

Офсет хэвлэлийн машин:

- * Үйлдвэрлэгч: Heidelberg
- * Загвар: Printmaster GTO 52-2-P
- * Өнгө: 2
- * Хэвлэх хамгийн том хэмжээ: В3 (360х520мм)
- * Хурд: 8000 дардас/цаг




Огтлооны машин:

- * Үйлдвэрлэгч: Polar
- * Загвар: 92
- * Огтлох өргөн: 92 см



Халуун цавуун наалтын машин:

- * Үйлдвэрлэгч: Heidelberg
- * Загвар: Euro-bind 500
- * Хурд: 500 цикл/цаг



Цуглуулгын машин:

- * Загвар: UCHIDA Collator UC-1100
- * Секцийн тоо: 10
- * Хурд: 40-60 хуудас/мин

